MINISTRY OF ENVIRONMENT AND TOURISM

REDD+ MONGOLIA

СӨРӨГ НӨЛӨӨЛЛӨӨС СЭРГИЙЛЭХ ЗАРЧМУУДТАЙ ХОЛБООТОЙ БОДЛОГО, ХУУЛЬ, ЖУРМЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчмууд ба сөрөг нөлөөллөөс сэргийлэх мэдээллийн систем

Огноо: 2018 оны 5 сар

UN-REDD PROGRAMME

Food and Agriculture Organization of the United Nations

UNDP

UNEP

Тайланг боловсруулсан

Ц.Банзрагч*, Д.Энхжаргал*, Д.Аннандэйл**, Ш.Хикс[1]., (2018) нар. Сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчмуудтай холбоотой Бодлого, хууль, журмуудын үнэлгээний тайлан. Монгол орны UN-REDD Хөтөлбөр, 2018 оны 5 сар.

Тайланг ашиглах зөвшөөрөл

Эх сурвалжийг бүрэн дурьдсан нөхцөлд энэхүү бүтээлийг сургалтын болон бусад арилжааны бус зориулалтаар бичгээр урьдчилан зөвшөөрөл авахгүйгээр хувилан олшруулж болно.

Энэхүү бүтээлд илэрхийлсэн үзэл бодол нь зөвхөн зохиогчдын үзэл бодол бөгөөд Монгол орны UN-REDD Хөтөлбөр болон тус хөтөлбөрийн бусад хамтрагч байгууллагуудын байр суурийг илэрхийлээгүй болно.

Талархал

Бидэнтай хамтран ажиллаж, санал, зөвлөгөө өгч буй Сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчим ба Сөрөг нөлөөллөөс сэргийлэх мэдээллийн системийн Техникийн ажлын хэсгийн гишүүдэд талархал илэрхийлж байна.

Холбоо барих

Тус тайлан болон холбогдох үйл ажиллагааны талаар нэмж мэдээлэл авахыг хүсвэл доорх хаягаар холбоо барина уу:

Монгол Улсын UN-REDD Хөтөлбөрийн Сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчмын асуудал хариуцсан үндэсний зөвлөх Дамдинсүрэнгийн Энхжаргал:enkhjargal.d@unredd.mn

Тайланг эрхлэн гаргасан байгууллагууд

*Монгол орны UNREDD Хөтөлбөр, ** Олон улсын зөвлөх, [1] НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөр, дэлхийн байгаль хамгаалал, хяналтын төв (UNEP-WCMC)

АГУУЛГА

1. УДИРТГАЛ БА ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ 6

2. REDD+-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР АШГИЙГ ДЭМЖИЖ, ЭРСДЛЭЭС ХАМГААЛАХАД СӨРӨГ НӨЛӨӨЛЛӨӨС СЭРГИЙЛЭХ ЗАРЧМУУДЫГ АШИГЛАХ ХЭРЭГЦЭЭ 6

3. СӨРӨГ НӨЛӨӨЛЛӨӨС СЭРГИЙЛЭХ ЗАРЧМУУДЫГ ҮНДЭСНИЙ ХЭМЖЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖИЛ 7

4. БХЖ-ЫН ҮНЭЛГЭЭНИЙ ЕРӨНХИЙ ТОЙМ 9

5. БХЖ-ЫН ҮНЭЛГЭЭГ ХИЙХЭД АШИГЛАСАН АРГА ЗҮЙ 9

6. БХЖ-ЫН ҮНЭЛГЭЭНИЙҮР ДҮН 12

6.1 Канкуны зарчмуудыг хууль журманд тусгах нь: Холбогдох БХЖ болон тэдгээрийг шинэчлэх талаарх зөвлөмжүүд 13

6.1.1 СНСЗ A 13

6.1.2 СНСЗ B 15

6.1.3 СНСЗ C: 17

6.1.4 СНСЗ D 20

6.1.5 СНСЗ E: 21

6.1.6 СНСЗ F: 23

6.1.7 СНСЗ G: 23

6.2 Тодорхой БХЖ-тай шууд холбоогүй боловч үнэлгээ хийх явцад хөндөгдсөн бусад чухал асуудлууд 24

6.3 Канкуны зарчмуудыг тусгасан БХЖ-уудын хэрэгжилт 25

7. БУСАД САНАЛ БА ДАРААГИЙН ХЭРЭГЖҮҮЛЭХ АЛХМУУД 29

7.1 Хууль эрхзүйн хүрээнд шинэчлэл хийх 30

7.2 Сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчмуудыг үндэсний нөхцөлд нийцүүлж хэрэгжүүлэх аргачлалаа цаашид боловсронгуй болгох талаар 30

7.3 СНСЗ-уудыг тусгаж, хэрэгжүүлэх бусад алхмууд 31

ХАВСРАЛТ 1: КАНКУНЫ ЗАРЧМУУД 33

ХАВСРАЛТ 2: ҮНЭЛГЭЭНИЙ ЯВЦАД АВЧ ҮЗЭЖ ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН БХЖ-УУД 34

ХАВСРАЛТ 3: БОДЛОГО, ХУУЛЬ, ЖУРМУУДЫН ҮНЭЛГЭЭ 37

ХАВСРАЛТ 3.1 37

ХАВСРАЛТ 3.2 45

ХАВСРАЛТ 3.3 66

ХАВСРАЛТ 3.4 80

ХАВСРАЛТ 3.5 89

ХАВСРАЛТ 3.6 110

ХАВСРАЛТ 3.7..... 121

ХАВСРАЛТ 4: REDD+-ИЙН СӨРӨГ НӨЛӨӨЛЛӨӨС СЭРГИЙЛЭХ ЗАРЧМУУДЫГ МОНГОЛД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ ЯВЦАД НӨЛӨӨЛӨХ ГОЛ БОДЛОГО, ХУУЛЬ, ЖУРМУУД БА ТЭДГЭЭРИЙГ САЙЖРУУЛАХ ТАЛААРХ САНАЛ, ЗӨВЛӨМЖҮҮД 1275

ХАВСРАЛТ 5: ЗӨВЛӨМЖҮҮДИЙГ ЭРЭМБЭЛСЭН НЬ..... 143

Бүлэг 1 (Ойн тухай хууль)..... 143

Бүлэг 2 (Ойн цэвэрлэгээ хөтөлбөр, Төрөөс ойн талаар баримтлах бодлого) 145

Бүлэг 3 (Газрын тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль)..... 146

Бүлэг 4 (Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн тухай хууль, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль) 146

Бүлэг 5 (Тодорхой БХЖ-д хамаарахгүй зөвлөмжүүд)..... 146

Бүлэг 6 (Авилгатай тэмцэх тухай хууль, Улсын болон орон нутгийн төсвөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль болон шинэ БХЖ-ууд)……148

ТОВЧЛОЛ

АХБ	Азийн хөгжлийн банк
ХБЗ	Хөгжлийн бодлогын зээл
ӨТЭ	Өрх толгойлсон эмэгтэй
ОЦХ	Ойн цэвэрлэгээ хөтөлбөр
ОН	Ойн нөхөрлөл
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар
БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
ҮСГ	Үндэсний статистикийн газар
ОНЗ	Орон нутгийн захиргаа
ТБОНТХБАҮХААТХ	Төрийн болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны тухай хууль
ЖҮХ	Жендэрийн үндэсний хороо
ТББ	Төрийн бус байгууллага
БНМ	Байгалийн нөөцийн менежмент
БАХ	Бодлого, арга хэмжээ
ЭҮТ	Экосистемийн үйлчилгээний төлбөр
REDD+	Ойн хомсдол, доройтлоос үүдэлтэй хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах үйл ажиллагаа
СНСМС	Сөрөг нөлөөллөөс сэргийлэх мэдээллийн систем
ЖДҮ	Жижиг, дунд үйлдвэр
ТАХ	Техникийн ажлын хэсэг

1. УДИРТГАЛ БА ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Энэхүү тайланд REDD+ хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэхээр санал болгож буй үйл ажиллагааны байгаль орчны болон нийгмийн үр ашгийг дэмжих, болзошгүй эрсдлийг бууруулахтай холбоотой байж болох Монгол Улсын бодлого, хууль, журамд (БХЖ) нарийвчлан үнэлсэн ажлын үр дүнг тусгав. Тэдгээр БХЖ-уудад хийсэн үнэлгээ нь Монгол Улсад REDD+-ийн сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчмуудыг хэрэгжүүлэх ажлын чухал хэсгийг бүрдүүлж байгаа юм.

НҮБ-ын Уур амьсгалын өөрчлөлтийн тухай Суурь Конвенц (НҮБУАӨСК)-ийн хүрээнд бий болсон REDD+ хөтөлбөр нь Монгол болон бусад хөгжиж буй орнуудад ойгоос ялгарах хүлэмжийн хийн ялгарлыг бууруулсан үр дүнгээс нь хамаарч хөгжингүй орнуудын санхүүжилтээр урамшуулал олгох механизм юм. Монгол Улс нь НҮБУАӨСК, Киотогийн Протокол болон Парисын Хэлэлцээрийг соёрхон баталж, ногоон хөгжлийн замыг тууштай дагаж байгаа билээ. REDD+ үйл ажиллагаа нь ойн нүүрстөрөгчийн нөөц болон биологийн олон янз байдлыг хамгаалах, газрын доройтлоос урьдчилан сэргийлэх, нөхөн сэргээх, нутгийн иргэдийн амьжиргааг сайжруулахыг дэмжих, мөн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицоход туслах замаар ногоон хөгжилд хувь нэмэр оруулах боломжтой юм. Монгол Улс 2011 онд умардын тайгын ихээхэн талбай бүхий орнууд дотроос хөгжиж байгаа орнууд дахь ойн хомсдол, доройтлоос үүдэлтэй хүлэмжийн хийг бууруулах НҮБ-ын хамтын ажиллагааны санаачилга (НҮБ-ын UN-REDD Хөтөлбөр)-д нэгдсэн анхны улс болсон юм.

2. REDD+ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЭЕРЭГ ҮР НӨЛӨӨГ ДЭМЖИЖ, ЭРСДЛЭЭС ХАМГААЛАХАД СӨРӨГ НӨЛӨӨЛЛӨӨС СЭРГИЙЛЭХ ЗАРЧМУУДЫГ АШИГЛАХ ХЭРЭГЦЭЭ

Ойн хомсдлыг бууруулж, ойн доройтлыг сэргээхэд чиглэгдсэн ямар ч санаачлага байгаль орчны болон нийгмийн үр ашиг авчирна гэж үзэх амархан. REDD+ санаачилгуудын хэтийн зорилго ч энэ гэдэг нь тодорхой. Гэхдээ ойн ашиглалт, менежмент, хамгаалал мөн ойд нөлөөлөх алтиваа үйл ажиллагаануудад олон оролцогч талууд хамрагдаж оролцох магадлалтай. Монгол Улсын хувьд малчид ба нүүдэлчид, ойгоос хамааралтай аж төрдөг нутгийн иргэд, бизнесүүд ба хөрөнгө оруулагчид, нийгэм ч бүхэлдээ тэдгээр оролцогч талуудад хамаарч болох ба үүгээр хязгаарлагдахгүй. Ийм өргөн хүрээний оролцогч талууд угаасаа өөр өөр ашиг сонирхолтой байх нь тодорхой бөгөөд үүнд: ой болон ойн нөөцийг хүртэх, шийдвэр гаргахад оролцох боломж, газар өмчлөл болон эзэмшлийн бусад хэлбэрүүдийг хүлээн зөвшөөрөх, мөн REDD+ үйл ажиллагааны үр ашгийг хүртэх боломжтой байх зэрэг сонирхол багтана.

Тэдгээр оролцогч бүлэг бүр REDD+-ийн үйл ажиллагаанаас үүдэлтэй үр ашиг ба эрсдлүүдийг өөр өөрөөр ойлгож хүлээн авдаг. Жишээ нь зарим оролцогч тал байгалийн

нөөц болон газар ашиглах эрхээ илүү тодорхой болгох, засаглалыг сайжруулах, орон нутгийн амьжиргааг илүү тогтвортой болгох зэрэг үр ашгийг чухалчилж үздэг. Харин нөгөө хэсэг нь газрын эрхийн маргаан, үр ашгийн тэгш бус хуваарилалт, мөн байгалийн ой тариалангийн талбай болон хувирах зэрэг болзошгүй эрсдлүүдээс болгоомжилж, илүү анхаарал хандуулна.

Эерэг үр нөлөө болон эрсдлүүдийг өөр өөр өнцгөөс хүлээж авах хандлагууд байдаг учраас санал болгож буй REDD+-ийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ сөрөг нөлөөллөөс сэргийлэх багц зарчмыг мөрдөх тодорхой хэрэгцээ байгаа ба эдгээр зарчим нь:

- REDD+ үйл ажиллагааны хэрэгжилтийн чанар болон тогтвортой байдлыг сайжруулах;
- REDD+-ийн үйл ажиллагаанууд нь үр ашиг дагуулж, аль болох эрсдэл бага учруулна гэсэн итгэлийг баталгаажуулах;
- Үндэсний хэмжээнд дэвшүүлсэн өргөн цар хүрээтэй зорилтуудад хувь нэмэр оруулахуйц байх ёстой юм.

Дээрх асуудлуудыг шийдвэрлэх үүднээс Мексик улсын Канкун хотод болсон НҮБУАӨСК-ийн Талуудын 16-р бага хурлаас REDD+-ийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх явцад бий болж болзошгүй эрсдлийг бууруулах, үр ашгийг дээшлүүлэхэд чиглэсэн Канкуны зарчмууд хэмээн нэрлэгдсэн долоон зарчмыг баталсан[1].

3. СӨРӨГ НӨЛӨӨЛЛӨӨС СЭРГИЙЛЭХ ЗАРЧМУУДЫГ ҮНДЭСНИЙ ХЭМЖЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Тухайн улс REDD+-ийн сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчмуудыг хэрэгжүүлэхдээ өөрийн орны онцлог, хэрэгцээ шаардлагад нийцүүлэх шаардлагатай гэдгийг хүлээн зөвшөөрдөг[2]. Сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчмуудыг үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх ажлын гол цөм нь сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчмуудыг тусгасан бодлого, хууль, журам, сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчмуудыг хэрэгжүүлж буй эсэхийг баталгаажуулах институтын эрх, үүрэг, дүрэм, чадавх, REDD+үйл ажиллагааны сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчмуудыг хэрхэн тусгаж, хэрэгжүүлж буй талаар мэдээллээр хангах, сөрөг нөлөөллөөс сэргийлэх мэдээллийн систем зэргийг бий болгох гэсэн хэсгүүдээс ихэвчлэн бүрддэг.

[1]Канкуны зарчмуудыг Хавсралт 1-д оруулав.
[2]UN- REDD Хөтөлбөр (2015), REDD+-ийн СНСЗ-уудыг үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх ажил ба олон улсын хэмжээнд хуримтлуулсан анхны туршлага, сургамж. СНСЗ-уудын талаарх аргазүйн гарын авлага, 2-р хэвлэл.

Улс орнууд хоорондоо ихээхэн ялгаатай хэдий ч өнөөг хүртэлх хугацаанд сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчмуудыг хэрэгжүүлэх ажлыг төлөвлөж боловсруулахад дараах нийтлэг алхмуудыг мөрдөж байгаа нь бусад улс орнуудын туршлагаас илэрхий байна. Зураг 1-т эдгээр алхмуудыг зохих дараалаллын дагуу жагсааж харуулав. Монгол орны REDD+ хөтөлбөрийн хүрээнд дараах алхмуудыг хийж гүйцэтгээд байна:

* Ойн хомсдол болон ойн доройтлын хүчин зүйлүүд болон ойн хамгаалалт, тогтвортой менежментэд учирч буй саад бэрхшээлийг тодорхойлсон;
* Тэдгээр хүчин зүйл болон саад бэрхшээлийг шийдвэрлэхэд чиглэсэн 10 бүлэг бодлого, арга хэмжээ (БАХ)[3]-г тодорхойлсон;
* Тэдгээр БАХ-нүүдийн болзошгүй үр ашиг, эрсдлийг үнэлсэн.

Зураг 1. СНСЗ-уудыг Монголд хэрэгжүүлэх аргачлалын ерөнхий алхму



СНСЗ-ЫГ ТУХАЙН УЛСАД ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ЗАМЫГ СТРАТЕГИ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ ҮЙЛ ЯВЦТАЙ УЯЛДУУЛАХ НЬ

[3] “REDD+-ийн үйл ажиллагаа” гэж мөн нэрлэдэг.

REDD+ хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэхээр тодорхойлон, санал болгож буй БАХ-ний эрсдлийг бууруулж, үр ашгийг дээшлүүлэхэд хамаатай байж болох БХЖ-уудыг Канкуны зарчмуудын хүрээнд онцолсон тусгай сэдвүүдийн дагуу үнэлэх ажлыг 2017-2018 онд хийж гүйцэтгэсэн бөгөөд уг үнэлгээний үр дүнг энэхүү тайланд тусгав.

4. БХЖ-ЫН ҮНЭЛГЭЭНИЙ ЕРӨНХИЙ ТОЙМ

НҮБУАӨСК-ийн Шийдвэр 12/CP.17-ийн 3-р зүйл, мөн Шийдвэр 9/CP.19-ийн 4-р зүйлд зааснаар үндэсний хэмжээнд REDD+ стратеги болон үйл ажиллагааны төлөвлөгөө хэрэгжүүлэхээр зорьж буй улс орнууд REDD+ үйл ажиллагааг хэрэгжүүлэх явцдаа Канкуны зарчмуудыг хэрхэн хууль тогтоомжид “тусгаж”, “хэрэгжүүлж” байгаа талаараа нэгдсэн тайлан хүргүүлэх ёстой. Нэгдсэн тайлангийн “тусгасан байдал” гэдэг хэсэгт ерөнхийд нь одоогийн холбогдох БХЖ болон тэдгээр нь сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчмуудыг бичиг баримтын түвшинд буюу “цаасан дээр” ямар хэмжээнд дэмжиж буй талаар хийсэн дүн шинжилгээ, мөн хууль журмын хийдэл буюу зохицуулаагүй орхисон аливаа цоорхойг нөхөхтэй холбоотой төлөвлөсөн алхмуудын талаарх мэдээллийг оруулсан гэж ойлгоно. БХЖ-д хэрхэн “тусгагдсан” талаарх дүн шинжилгээг “ширээний ард” буюу бичиг баримтуудын хүрээнд судалж хийв. Энэхүү ажил нь сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчмуудыг БХЖ-д хэрхэн тусгасан талаар тайлан бичих суурь болоод зогсохгүй, сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчмуудыг ирээдүйд илүү үр дүнтэй хэрэгжүүлэх үүднээс БХЖ-уудыг сайжруулахад шаардлагатай дараагийн алхмуудыг тодорхойлох мэдээллээр хангах ач холбогдолтой юм.

Сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчмуудыг ямар хэмжээнд “хэрэгжүүлж” буй талаар мэдээлэл гаргахын тулд одоогийн БХЖ-ын тогтолцоо амьдрал дээр хэрхэн хэрэгжиж буйд үнэлгээ өгөх (мөн REDD+-ийн БАХ-нүүд хэрэгжиж эхэлсэний дараа БХЖ-ын хэрэгжилт байгаль орчны болон нийгмийн чиглэлээр бий болгохыг зорьж буй үр дүнг биелүүлэхэд хэрхэн нөлөөлж буй талаар газар дээр нь үнэлгээ хийх) шаардлагатай. БХЖ-уудын хэрэгжилтийн талаарх үнэлгээг хийх ажил нь ихээхэн цаг хугацаа шаарддаг. Тухайлбал, холбогдох тайлан болон статистик мэдээг олж тогтоох, институцын чадавхийг үнэлэх шаардлагатай болдог. Институцын чадавхийг үнэлэхийн тулд БХЖ-уудыг хэрэгжүүлэх үүрэг хүлээдэг төрийн байгууллагуудын албан хаагчидтай уулзах, БХЖ-уудын хэрэгжилт (зарим тохиолдолд хэрэгжээгүйн улмаас)-ийн нөлөөлөлд өртдөг талуудтай уулзаж, зөвлөлдөх хэрэгтэй болдог билээ.

5. БХЖ-ЫН ҮНЭЛГЭЭ ХИЙХЭД АШИГЛАСАН АРГА ЗҮЙ

Санал болгож буй БАХ-ний үр ашиг болон эрсдлийн үнэлгээг өмнө хийсэн байсан бөгөөд энэ нь БХЖ-ын үнэлгээ хийх ажлын эхлэлийн цэг нь болсон. БХЖ-уудыг хянах, үнэлгээ хийх үйл явцын гол зорилго нь 2017 оны дундуур оролцогч талуудын анх

тодорхойлсон эрсдэл болон үр ашгийн талаарх мэдээлэлд тулгуурлан, Монгол Улсын хэмжээнд одоогоор хэрэгжиж буй БХЖ-ууд нь эрсдлийг хэрхэн тусгаж, үр ашгийг хэрхэн дэмжиж буй талаар үнэлгээ хийх явдал байв. Одоогийн нөхцөл байдлыг тайлбарлахын зэрэгцээ өөр бас нэгэн чухал зорилго нь REDD+-ийн СНСЗ-ын шаардлагуудыг илүү сайн хангах үүднээс БХЖ-уудын хүрээнд анхаарч, тусган цаашид засч, сайжруулбал зохих хийдэл, сул тал ба зөрчилтэй зохицуулалтуудыг тодорхойлох явдал байв. Хүснэгт 1 ба Хүснэгт 2-т (үнэлгээний хүснэгт) БХЖ-ын үнэлгээний бүтцийг тоймлон харуулав:

Хүснэгт 1: БХЖ-ын үнэлгээний бүтэц: Эрсдлийн жишээ

		Тусгах		Хэрэгжүүлэх	
Багана 1	Багана2	Багана 3	Багана 4	Багана 5	Багана 6
Холбогдох Канкуны зарчим (a – f)	Эрсдэл	Тухайн эрсдлийг тусгасан БХЖ-ууд, тэдгээр нь эрсдлийг яаж зохицуулж байна вэ?	Одоогийн БХЖ-уудын хийдэл, сул тал	БХЖ-ууд хир үр дүнтэй хэрэгжиж байна?	Хэрэгжилтийн явцад орхигдсон хийдэл, сул талууд
	→	→	→	→	→

Хүснэгт 2: БХЖ-ын үнэлгээний бүтэц: Үр ашгийн жишээ

		Тусгах		Хэрэгжүүлэх	
Багана 1	Багана 2	Багана 3	Багана 4	Багана 5	Багана 6
Холбогдох Канкуны зарчим (a – f)	Эерэг үр нөлөө	Тухайн үр ашгийг дээшлүүлэхэд чиглэсэн БХЖ, үр ашгийг хэрхэн дэмжиж байна?	Одоогийн БХЖ-уудын хийдэл, сул тал	БХЖ-ууд хир үр дүнтэй хэрэгжиж байна?	Хэрэгжилтийн явцад орхигдсон хийдэл, сул талууд
	→	→	→	→	→

БХЖ-ын үнэлгээ нь доорх дөрвөн алхмаас бүрдсэн:

1-р алхам: Анхны зөвлөлдөх уулзалт

2017 оны 6 дугаар сарын 19 өдөр болсон Сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчмууд ба сөрөг нөлөөллөөс сэргийлэх мэдээллийн системийн Техникийн ажлын хэсгийн (ТАХ) уулзалтын үеэр хүснэгт 1 ба хүснэгт 2-т харуулсан жишгээр БХЖ-ын үнэлгээний хүснэгтийг танилцуулан, санал солилцож баталгаажуулсан.

2-р алхам: Сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчмуудыг БХЖ-уудад хэрхэн "тусгасан" талаарх үнэлгээ:

Үнэлгээ хийх аргачлалаа ТАХ-ээр баталгаажуулсаны дараа үнэлгээний хүснэгтүүдэд анхны мэдээллийг оруулсан. Үнэлгээний хүснэгтийн зүүн талын баганад тодорхой БАХ-ний хүрээнд хэрэгжүүлэх дэд үйл ажиллагаа тус бүртэй холбоотой бий болох эрсдэл, үр ашгууд нь Канкуны 7 зарчмын алинтай нь хамаарч байгааг тогтоож, тухайн зарчмуудын дагуу ангилж байрлуулсан.

Дараагийн 2-р алхмын хүрээнд Монгол Улсын хэмжээнд тухайн үр ашиг болон эрсдэл тус бүрийг ямар БХЖ-аар зохицуулж байгаад үнэлгээ өгөв. Өөрөөр хэлбэл одоогийн нөхцөлд аль нэг БАХ-г хэрэгжүүлэхээр болбол үүнээс үүсэх эрсдлээс сэргийлэх, үр ашгийг нь дэмжиж чадахуйц БХЖ-уудыг тогтоосон. Үүнтэй холбоотой ажлууд нь: (i) Эрх зүйн болон бодлогын тогтолцооны холбогдох асуудлуудыг тодруулах; (ii) одоогийн БХЖ-уудад буюу "цаасан дээр" тусгагдаагүй, зохицуулагдаагүй орхигдсон хийдэл, сул талуудыг тодорхойлох зэрэг байв. Энэ нь бичиг баримтын судалгааны түвшинд гүйцэтгэсэн ажил бөгөөд үр дүнд нь хоёр хүснэгтийн 3 ба 4-р баганыг бөглөсөн болно. Энэхүү үнэлгээний явцад БАХ-тэй холбоотой үр ашгийг дээшлүүлж, эрсдлийг бууруулах, улмаар Канкуны зарчмуудын шаардлагыг хангахад ашиглаж болох 12 бодлого, 36 хууль, мөн 3 журмыг тодорхойлсон. Нийт 51 БХЖ-ыг тодорхойлсон ба тэдгээрийн жагсаалтыг Хавсралт 2-т харуулав. Энэ ажлыг 6 сарын сүүлээс 10 сарын эцэс хүртэл хугацаанд хийж гүйцэтгэв.

3-р алхам: Сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчмууд одоогоор хэр "хэрэгжиж" байгааг үнэлэх

Гуравдахь алхмын (БХЖ-уудын хэрэгжилт бодит байдалд хэрхэн "хэрэгжиж" байгааг үнэлэх) хүрээнд тухайн улсад мөрдөгдөж байгаа БХЖ-уудыг авч үзэн, одоогийн институцын чадавхийг үнэлсан. Институцын чадавхийг дараах асуултуудын дагуу үнэлж дүгнэлээ. Үүнд:

- Тухайн БХЖ-ын хэрэгжилтийг хариуцсан нэг ба түүнээс дээш тооны байгууллага байдаг уу?

- Байдаг бол тэдгээр байгууллага нь уг БХЖ-ыг хэрэгжүүлэх чиг үүрэгтэй юу эсвэл хэрэгжилтийг хангуулах үүрэгтэй юу?

- Тэдгээр байгууллага энэ чиг үүргээ хэрэгжүүлэхтэй холбоотой тусгай журам мөрддөг үү?

- Тэдгээр байгууллагад энэ журмыг мөрдөж ажиллахад шаардагдах зохих санхүүгийн /үйл ажиллагааны төсөв/ болон боловсон хүчний /сургалтан хамрагдсан ажилтнууд/ нөөц, бааз суурь байгаа юу?

Эдгээр асуултын дагуу өгсөн хариултуудыг хүснэгтийн 5,6 дугаар багананд оруулав.

<u>4-р алхам: Үнэлгээний эхний үр дүнгийн талаар санал солилцож, тайланг бичиж дуусгах</u>

БХЖ-ын үнэлгээний сүүлчийн алхам нь 2017 оны 11 дүгээр сарын 29 өдөр зохион байгуулсан ТАХ-ийн уулзалтын үеэр дээрх үнэлгээнээс гарсан үр дүнг танилцуулах байв. Дээрх уулзалтын үеэр БХЖ-ыг сайжруулахтай холбоотой гарсан зөвлөмжүүдийг оролцогчдод танилцуулж, тэдгээрийг эрэмбэлүүлж, шаардлагатай нэмэлт санал, зөвлөмжийг нь авсан. Зөвлөлдөх уулзалтын үр дүнг Хавсралт 5-д танилцуулав.

6. БХЖ-ЫН ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН

Тайлангийн 5-р хэсэгт заасанчлан, БХЖ-ын үнэлгээнд оролцогч талуудын тусламжтайгаар өмнө нь тодорхойлсон БАХ-ний үр ашиг ба эрсдлүүдийг нэгтгэсэн бөгөөд тэдгээрийг хамаарах СНСЗарчим тус бүртэй холбож өгсөн. Үүний дараагаар дээр тодорхойлсон эрсдлүүдийг зохицуулж, боломжит үр ашгийг дэмжиж чадахуйц БХЖ Монголд одоо байгаа эсэхийг тогтоохын тулд нарийвчилсан үнэлгээ хийсэн.

Үнэлгээний үр дүнд Монгол Улсад зарим нэг хийдлийг эс тооцвол ерөнхийдөө БАХ-ний болзошгүй эрсдлүүдийг зохицуулж, үр ашгийг дээшлүүлэхэд дэмжлэг болохуйц БХЖ-ууд бэлэн байна гэдэг нь харагдсан. Үүний зэрэгцээ, хуулийн цоорхой буюу хийдэл, зарим хууль хоорондын зөрчил, мөн хэрэгжилтийн илэрхий сул талуудыг онцолж тодруулсан. Үнэлгээний нэг чухал хэсэг нь БХЖ-ын цоорхой ба зөрчлүүдийг (“хууль, журамд тусгах” асуудлууд) зохицуулах мөн хэрэгжилтийг (“хэрэгжүүлэх” асуудлууд) сайжруулах талаар зөвлөмжүүд боловсруулах явдал байв.

Энэхүү нарийвчилсан үнэлгээний үр дүнг Хавсралт 3-т тоймлож үзүүлсэн ба үнэлгээний ажлыг бүрэн эхээр нь тусгай Excel хүснэгтээр боловсруулсан. Энэ бүлгийн сүүлийн хэсэг дараах бүтэцтэй байна. Тухайлбал, 6.1 хэсэгт одоогийн БХЖ-ууд нь Канкуны долоон зарчим тус бүртэй хамаатай үр ашиг ба эрсдлийг хэр сайн зохицуулж чадах эсэхийг

авч үзсэн. Ингэснээр БХЖ-ууд нь тэдгээр СНСЗ-уудыг хэр зэрэг тусгаж, зохицуулж чадахыг шалгах боломжтой болно[4]. Харин 6.2 хэсэгт үнэлгээ хийх явцад болон оролцогч талуудын санал солилцох үеэр хөндөгдсөн, тодорхой БХЖ-тай холбоогүй чухал асуудлуудыг авч хэлэлцсэн болно. Тэдгээр асуудлуудыг REDD+ -ийн БАХ-ний хэрэгжилт болон сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчмуудыг хууль, журамд тусгах болон хэрэгжүүлэхэд нөлөөлж болзошгүй тул товчхон авч хэлэлцэх нь чухал юм. Дараагийн 6.3 хэсэгт хэрэгжилттэй холбоотой асуудлуудыг авч үзсэн ба одоогийн БХЖ-ууд амьдрал дээр хэрхэн хэрэгжиж буйг нягталсан болно. Хамгийн сүүлийн 6.4 хэсэгт Техникийн ажлын хэсгийн гишүүд БХЖ-уудтай холбоотой зөвлөмжүүдийг ач холбогдлоор нь эрэмбэлсэн ажлын үр дүнг танилцуулсан байна.

6.1 Канкуны зарчмуудыг бодлого, хууль, журмуудад тусгасан байдал: Холбогдох БХЖ ба тэдгээрийг шинэчлэх талаарх зөвлөмжүүд

6.1.1 СНСЗ А:

(REDD+ үйл ажиллагаа нь ойн үндэсний хөтөлбөр, холбогдох олон улсын гэрээ, хэлэлцээрүүдийн зорилгод хувь нэмэр оруулахуйц буюу эсвэл тэдгээрт нийцсэн байна.)

Хавсралт 3.1-т СНСЗ А-н хүрээнд тодорхойлогдсон үр ашиг ба эрсдлүүдийг зохицуулахуйц гол БХЖ-уудыг харуулсан. Үүнд:

* Ойн цэвэрлэгээ хөтөлбөр (2014);
* Ойн тухай хууль (2012);
* Төрөөс ойн талаар баримтлах бодлого (2015)
* Тусгай хамгаалалттай газар нутгийн үндэсний хөтөлбөр (1998);
* Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн тухай хууль (1997);
* Байгаль орчныг хамгаалах тухай хууль (1995);
* Газрын тухай хууль (2002);
* Уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний хөтөлбөр (2011);
* Холбогдох олон улсын гэрээ хэлэлцээр зэрэг багтана.

Одоогийн БХЖ-ууд нь СНСЗ А-г “тусгасан байх” гэсэн шаардлагыг ерөнхийдөө хангаж байна. Хууль эрхзүйн шинэчлэл хийх шаардлага тулгарч магадгүй гол талбар бол ой бүхий газарт мал бэлчээхтэй холбоотой **Ойн тухай хууль болон Газрын тухай хууль хоорондын илэрхий зөрчилдсөн заалтууд** юм. Ойн тухай хуульд тарьц, суулгац ургуулж буй ой бүхий газарт мал бэлчээхийг хориглосон бол нөгөө хуулиар ой бүхий газарт нийтэд

[4]Хамгийн чухал ач холбогдол бүхий БХЖ-ыг мөн Хавсралт 4-т жагсаасан ба БХЖ тус бүртэй холбоотой зөвлөмжийг мөн тусгасан.

нь мал бэлчээхийг зөвшөөрсөн байна. Энэ байдал нь сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчмуудыг хэрэгжүүлэхэд хүндрэл учруулж байна. Жишээ нь орон нутгийн иргэдийн ойд малаа бэлчээх эрх нь тодорхой бус байна. Түүнээс гадна зарим БАХ-г хэрэгжүүлэхэд тодорхой бус байдал үүсч байна, жишээ нь ойн нөхөн сэргээлттэй холбоотой БАХ гэх мэт. Тиймээс дээрх хоёр хуульд нэмэлт өөрчлөлт оруулж, зулзаган ой бүхий газарт мал бэлчээхийг хориглохыг тодорхой зааж өгөх тухай **зөвлөмж гаргасан**.

Хавсралт 3.1-т мөн хууль, журамд өөрчлөлт оруулахтай холбоотой бусад зөвлөмжийг оруулав. Ойн сэргэн ургалтыг дэмжих үйл ажиллагааны санхүүжилт баталгаажсан цагт СНСЗ А-г хэрэгжүүлж чадсан гэж үзнэ. Үүнийг хэрэгжүүлэхийн тулд **хувийн хэвшлийн оролцоог** нэмэгдүүлэх шаардлагатай гэдгийг үнэлгээний дүн харуулж байна. Тиймээс **таримал ой худалдан авах тухай одоогийн журмыг шинэчилж зулзаган модыг тодорхой хугацаа өнгөрсний дараа улс, хувийн хэвшлээс баталгаатай худалдаж авах боломжийг бүрдүүлэх тухай заалт оруулахыг зөвлөж байна.** Ингэснээр ойн мэргэжлийн байгууллагуудын сонирхол илүү тодорхой болж, улмаар ойжуулалтын ажилд оролцох хувийн хэвшлийн оролцоо илүү мэргэжлийн болно гэж үзэж байна.

Эцэст нь тэмдэглэхэд байгалийн нөөцийн бодлогын зорилтуудад хувь нэмэр оруулахад чиглэсэн СНСЗ-ын шаардлагыг хангахын тулд Байгаль хамгаалал, Уур амьсгалын өөрчлөлтийн санг тойрсон хуулийн заалтуудыг тодорхой болгох шаардлагатай байж магадгүй. Байгаль орчныг хамгаалах тухай хууль болон Засгийн газрын тусгай сангийн тухай хууль нь дээр дурьдсан сангийн эрх зүйн орчинг зохицуулдаг. Уг сан нь 1998 оноос хойш үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд 10 хүртэл сая төгрөгийн (USD 4,000) байгаль хамгааллын төслүүдийг дэмждэг. Тус сангийн санхүүжилт нь аялал жуулчлалын зөвшөөрлийн төлбөр, ус бохирдуулсаны төлбөр, хууль бусаар мод бэлтгэсний торгууль мөн байгалийн нөөц ашигласаны төлбөрийн тодорхой хувь зэргээс бүрддэг. Оролцогч талуудын үзэж буйгаар сангийн санхүүжилтийг орон нутгийн төсвөөс салгасан тохиолдолд тус сан нь байгаль орчныг хамгаалах, менежмент явуулах тал дээр илүү сайн ажиллаж, REDD+ БАХ-ний болзошгүй үр дүн ба эрсдлийг хамгийн сайн зохицуулж чадна гэжээ. Одоогийн байдлаар Байгалийн нөөц ашиглалтын төлбөрийн тухай хуулийн дагуу орлогын ихэнхийг орон нутгийн нэгдсэн төсөвт төвлөрүүлдэг. Тиймээс байгаль орчин хамгаалах зориулалтаар зарцуулах боломжгүй болж байгаа юм. **Тус сантай холбоотой хуулийн заалтуудыг тодорхой болгож, сангийн төсвийн хуваарилалтыг орон нутгийн төсвөөс салгах нь зүйтэй гэсэн зөвлөмж гаргасан болно**.

6.1.2 СНСЗ В:

(Хууль эрхзүй, бие даасан байдлыг харгалзан үзсэн ил тод, үр дүнтэй үндэсний ойн засаглалын бүтэцтэй байх)

Хавсралт 3.2-т Зарчим В-н хүрээнд тодорхойлогдсон үр ашиг ба эрсдэлд хамгийн их хамаарч болох БХЖ-уудыг харуулсан ба үүнд:

* Ойн тухай хууль (2012);
* Төрийн болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны тухай хууль (2005);
* Байгаль орчныг хамгаалах тухай хууль (1995);
* Төрийн хяналтын тухай хууль (2003);
* Төрөөс ойн талаар баримтлах бодлого (2015);
* Авлигын эсрэг хууль (2006);
* Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль (2011)

багтана.

* Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх тухай хууль (1995)
* Захиргааны хууль (2016)
* Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комиссын тухай хууль (2000)
* Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль (2011) зэрэг багтана.

СНСЗ В-тэй холбоотой дөрвөн бүрэлдэхүүн[5] хэсгийн шаардлагыг хангахын тулд холбогдох журмыг шинэчлэх шаардлагатай байж магадгүй. Нэгдүгээрт, ойн менежментийн холбогдолтой зохистой мэдээлэл цуглуулах, төлөвлөлт хийх эрдэм шинжилгээний чадавхийг сайжруулахын тулд **Ойн тухай хуулийг шинэчилж орон нутгийн иргэдийг ойн хяналт шалгалт болон эргүүлд оролцуулахыг зөвшөөрөх тухай зөвлөмж гаргасан**. Одоогийн байдлаар ойн хяналт ба эргүүлийг ойн нөхөрлөлүүд Байгаль орчны хяналтын байцаагчтай (МХЕГ-тай) хамтран гүйцэтгэж байна. Хэдийгээр хуулинд хяналт тавихад орон нутгийн иргэд болон иргэний нийгмийг оролцоог хангах тухай тусгасан боловч урамшуулал эсвэл санхүүжилтийн эх үүсвэрийн талаар тодорхой заалт байхгүй байна. **Тиймээс тус хууль эсвэл холбогдох журмыг шинэчилж урамшууллын талаар тусгасан заалтуудыг оруулж, хэрэгждэг болгох зөвлөмж гаргасан. Өөр нэгэн зөвлөмж гаргасан**

[5] UN-REDD хөтөлбөрөөс REDD+-ийг хэрэгжүүлэхээр зорьж буй орнуудад зориулж боловсруулсан удирдамжид тухайн СНСЗ бүрийг “бүрэлдэхүүн хэсэг буюу элемент” –ээр нь задалсан байдаг. Эдгээр элементиүүдийг Хавсралт 3-т бүрэн эхээр нь оруулаа.

нь мод бэлтгэлд тавих хяналтын үйл ажиллагаанд иргэний нийгмийн оролцоог хангах тухай болно.

СНСЗ В-ийн өөр нэгэн чухал бүрэлдэхүүн хэсэг нь авилгын эрсдэл юм. Авилга болон буруу менежменттэй холбоотой эрсдлүүд үр ашиг болон эрсдлийн үнэлгээнд болон одоогийн хуулийн хэлэлцүүлгийн үеэр олон удаа дурьдагдсан. Авилгын эсрэг хууль (2006) болон Төрийн болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны тухай хууль (2005), ойн болон байгаль орчны менежментийн салбар дахь авилгыг зогсооход чиглэх ёстой. Журмыг шинэчлэх талаарх зөвлөмж нь худалдан авалтын үйл ажиллагааг, тэр дундаа тендерийн үнэлгээг нийтэд ил тод болгох тал дээр анхаарсан. Жишээ нь Худалдан авалтын тухай хуулийг шинэчилж эсвэл шинээр журам гаргаж **тендерийн үнэлгээний шалгуурыг нийтэд ил тод болгох** болон **орон нутгийн иргэд ба ойн нөхөрлөлүүдийг заавал оролцуулах тухай тендерийн бичиг баримтад тусгах** талаар **зөвлөмж гаргасан**. Хүний оролцоог аль болох багасгахын тулд **програм хангамж** боловсруулахыг **зөвлөсөн болно**. Байгалийн сэргэн ургалтын үйл ажиллагааны хяналт болон тайланд **иргэний нийгмийг татан оролцуулснаар** авилгатай илүү үр дүнтэй тэмцэж болно гэдгийг зөвлөсөн. Энэ асуудлыг өмнө нь Ойн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хэлэлцүүлгийн үеэр дэвшүүлсэн юм.

Гуравдугаарт, зарчмын үнэлгээний үеэр дэвшүүлж байсан өөр нэгэн чухал асуудал бол шударга ёсны асуудал ба үр ашгийн хуваарилалт, зохицуулалт болон баялаг ашиглалтын талаарх маргаан гарсан үед **гомдол барагдуулах/маргааныг таслах систем** бий болгохтой холбоотой. Энэ асуудлаар СНСЗ В болон С хоорондоо давхацдаг. Энэ тайлангийн зорилготой уялдуулаад уг асуудлыг СНСЗ В—ийн хүрээнд авч үзэв. Монголд одоогоор гомдол барагдуулах ерөнхий механизмууд байдаг. Тухайлбал, Захиргааны хууль (2016)-д аливаа хэм хэмжээний актын талаар шийдвэр гаргахаас өмнө ямар алхмуудыг хэрэгжүүлэх ёстойг заасан байдаг. Үүнд урьдчилан мэдэгдэх, мэдээлэл өгөх, шинэ хууль, журмуудын талаар зөвлөлдөж байх явцад холбогдох санал гомдол хүлээн авах арга замыг бий болгох талаар хуульчилсан байна. Үүнээс гадна, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх тухай хууль (1995) нь иргэдэд төрийн байгууллагатай холбоотой асуудлаар өргөдөл, гомдол гаргах арга замыг хуульчилж өгсөн. Аль ч байгууллагад ямар ч төрлийн өргөдөл, гомдол ирж болно. Ирсэн гомдлыг холбогдох байгууллагууд руу нь илгээх ёстой. Өргөдөл гомдлыг баримтжуулж, дүн шинжилгээ хийх үүрэгтэй Өргөдлийн байнгын хороо мөн ажиллаж байна. Иргэд, олон нийт эдгээр систем, механизмуудаар дамжуулан өргөдөл, санал, гомдлоо чөлөөтэй хүргүүлж, санал гомдол хаана, ямар шатанд явж байгаа талаар мэдэх боломжтой юм. Мөн Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комиссын тухай хууль (2000) болон уг хуулийг хэрэгжүүлэгч байгууллага (Үндэсний комисс) нь хүний эрхийн зөрчилтэй холбоотойгоор аж ахуйн нэгж, байгууллага, иргэдээс ирүүлсэн гомдлыг зохицуулах эрх, үүрэгтэй .

Гомдол барагдуулах тодорхой механизм байгаа боловч эдгээр нь ойн салбартай хэрхэн холбогдож байгаа талаар **цаашид судлах шаардлагатай байж болох юм.** Ойн нөөцийн үр ашгийн хуваарилалт, зохицуулалт, нөөцийн ашиглалтын талаар зөрчил маргаан гарсан тохиолдолд түүнийг шийдвэрлэх тодорхой БХЖ байхгүй байгаа энэ үед судалгаа маш чухал.

СНСЗ В-ийн дурьдвал зохих сүүлийн бүрэлдэхүүн хэсэг бол газар эзэмшлийн асуудал юм. Ойн бодлого болон бэлчээрийн менежмент хоорондоо тодорхой холбоотой. Монголын байгаль орчны хамгийн тулгамдсан асуудлуудын нэг нь бэлчээрийн доройтол юм. Бэлчээрийн чанар муудсан үед малчид/нүүдэлчид малаа үргэлж илүү шим тэжээл сайтай газар бэлчээх хандлагатай байдаг. Бэлчээрийн талбайн тухайн шинэ хуулийг сүүлийн 20 орчим жилийн турш хэлэлцсээр байна. Уг хууль батлагдах эсэх нь эргэлзээтэй тул **Газрын тухай хуулийн "Ойн сан бүхий газрыг зохих хууль тогтоомжийн дагуу бэлчээрт ашиглаж болно" гэж заасан 52.3 заалтыг цуцлах хэрэгтэй гэж зөвлөсөн.** Түүнээс гадна Ойн тухай хуулийг шинэчилж ой бүхий талбайд мал бэлчээхийг хориглох ёстой. Хууль, журамд энэ чиглэлээр нэмэлт өөрчлөлт оруулахын тулд, мал бэлчээхийг хязгаарлах талаар журам батлахаасаа өмнө малчидтай зөвшилцөх нь зүйтэй.

Төрийн байгууллагуудаас мэдээлэл авах боломжийг "Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль" (2011)-иар хуульчилсан. Уг хуулийн 11.1 дэх заалтад "Иргэн, хуулийн этгээд нь хүний эрх, эрх чөлөө, үндэсний аюулгүй байдал, байгууллагын хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор хууль тогтоомжид нийтэд мэдээлэхийг хориглосноос бусад дараах мэдээллийг авах эрхтэй" гэсэн байна. Энэ хууль нь олон нийтэд мэдээллийг хүртээмжтэй хүргэх үндсийг сайн тавьж чадсан боловч REDD Хөтөлбөрийн мэдээллийг холбогдох талуудад, ялангуяа алслагдсан болон интернэт холбоо сул хөгжсөн орон нутагт хэрхэн шуурхай, цагт нь хүргэж байх талаар авч үзэх шаардлагатай.

6.1.3 СНСЗ С:

Олон улсын өмнө хүлээсэн үүрэг, үндэсний нөхцөл байдал, хууль тогтоомж, мөн НҮБ-ын Ерөнхий Ассемблейн баталсан Уугуул иргэдийн эрхийн тухай НҮБ-ын Тунхаглалыг харгалзан үзэж, уугуул иргэдийн болон орон нутгийн нөхөрлөлийн гишүүдийн мэдлэг, эрхийг хүндэтгэх

Хавсралт 3.3-т СНСЗ С-н хүрээнд тодорхойлогдсон үр ашиг ба эрсдэлд хамгийн ойр хамаарч болох БХЖ-г харуулсан ба үүнд:

* Ойн цэвэрлэгээ хөтөлбөр (2014);
* Ойн тухай хууль (2012);
* Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль (2011);
* Байгаль орчны салбарын жендерийн стратеги (2014);

* Усны тухай хууль (2012);
* Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн тухай хууль (1997);
* Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль (1994) зэрэг багтана.

СНСЗ С-тэй холбоотой хоёр бүрэлдэхүүн хэсгийн шаардлагыг хангахын тулд хууль журмыг шинэчлэх шаардлага тулгарч магадгүй. Нэгдүгээрт, шийдвэр гаргахад оролцох эрхийн тухайд **Ойн тухай хууль эсвэл холбогдох журмыг өөрчилж ойн нөхөрлөлүүдэд ойтой холбоотой үйл ажиллагаанаас илүү орлого хүртэх боломжоор хангасан цагт** олон тооны үр ашиг болон эрсдлүүдийг илүү үр дүнтэй зохицуулах боломжтой болж магадгүй юм. Ингэснээр ойн нөхөрлөлүүд дэд бүтцийн хөгжилд шууд хөрөнгө оруулалт хийх бололцоогүй байгаа байдлыг өөрчилж чадна. О**йн менежментэд талуудыг оролцуулах** тухай заалт хэд хэдэн өөр өөр хууль, журмуудад тусгагдсан байна. Энэ заалтуудыг нэгтгэхэд цаг хугацаа ихээхэн шаардлагатай байж болох ч, үүнийг хоёр үе шаттайгаар хэрэгжүүлж болох юм. Нэгдүгээрт, ойрын хугацаанд боловсруулж байгаа Үндэсний REDD+ Стратегид тусгасан оролцоог хангахтай холбоотой заалт нь зөвхөн REDD+ -ийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд талуудыг оролцуулах зорилготой байж болно. Хоёр дахь шатны буюу урт хугацааны ажлын хүрээнд Ойн тухай хуульд, эсвэл байгалийн нөөцийн удирдлагыг салбар хооронд зохицуулах шинэ журмын дотоод агуулгад ойн салбартай холбоотой талуудын оролцоог хангах заалтуудыг нэгтгэж болох юм.

СНСЗ С-ийн эрх зүйн шинэчлэл шаардагдаж магадгүй өөр нэг чухал бүрэлдэхүүн хэсэг нь үр ашиг хуваарилах эрхтэй холбоотой. 6.1.2 -т үр ашиг хуваарилахтай холбоотой маргааныг зохицуулах шинэ журам хэрэгтэй байгаа талаар авч хэлэлцсэн. Мөн **урамшууллын системийг шинэчлэх шаардлагатай** байгаа нь харагдлаа. Оролцогч талуудын хэлэлцүүлгийн үеэр санхүүжилт болон түүнтэй холбоотой урамшууллын асуудал голлох байр суурьтай байв. Мөн ойн менежменттэй холбоотой зөрчлийг мэдээлсэн иргэдэд урамшуулал олгож байгаа урамшууллын системийн талаар нилээд нухацтай авч үзлээ. Урамшууллын санхүүжилтийг ойн нөөц ашигласны төлбөрийн орлогын тодорхой хувиас бүрдүүлж, мэдээлэл өгсөн иргэдийн төлбөрийг хурдан шуурхай олгодог болгох тухай санал гарч байсан. **Эдгээр өөрчлөлтийг Ойн тухай хуулийн хүрээнд эсвэл шинэ хуулийн холбогдох журмын хүрээнд хийхийг зөвлөсөн болно.** Талуудын оролцоотойгоор хийсэн REDD+-ийн үйл ажиллагааны эрсдэл, үр ашгийн үнэлгээний явцад талууд жендерийн тэгш байдалтай холбоотой үр ашиг, эрсдлүүдийг онцгойлж дурьдаагүй. Гэхдээ, REDD+-ийг хэрэгжүүлэх явцад ажил эрхлэлтэд жендерийн зөрүүтэй байдал үүсэх эрсдэл байж болохыг анхааруулсан. Монгол орны UN-REDD хөтөлбөрийн хийсэн "Нийгмийн бүлгүүдийн оролцоо ба жендерийн динамик"[6] судалгааны тайланд дурьдсанаар ажиллах хүч болон боловсролын үйл ажиллагаанд эмэгтэйчүүдийн оролцоо харьцагуй өндөр байгаа ч эрэгтэй,

[6] UN-REDD Mongolia National Programme. 2017. Analysis of Social Inclusion and Gender Dynamic for REDD+ in Mongolia.

эмэгтэй хүмүүсийн хөдөлмөрийн хуваарийг авч үзэхэд жендерийн зөрүү байсаар байгаа бөгөөд хөдөлмөрийн зах зээл нь жендерийн ялгааг тод харуулж байна. Монгол эмэгтэйчүүд эрэгтэйчүүдтэй ижил хөдөлмөр эрхлээд бага цалин авч "голдуу эмэгтэйчүүд ажилладаг" салбар буюу үйлчилгээ, эрүүл мэндийн салбарт ажиллаж байгаа бөгөөд олон нийтийн болон хувийн хэвшлийн салбарт удирдах, шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн төлөөлөл бага байж, албан бус эдийн засгийн салбарт түлхүү ажиллаж байгааг тэмдэглэжээ. Ойн салбарт мөн жендерийн ялгаатай үүрэг, хариуцлага, оролцоо илт ажиглагдсан бөгөөд энэ нь эрэгтэй, эмэгтэй хүиүүст ялгаатай нөлөө үзүүлж байна. Жишээлбэл, ойн нөхөрлөлд эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн оролцоо харьцангуй тэгш байх хэдий ч шийдвэр гаргах үйл явцад эрэгтэйчүүд давамгайлах хандлагатай байна. Судалгаанд хамрагдсан 109 ойн нөхөрлөлөөс зөвхөн 2 нь эмэгтэй ахлагчтай байв. **Ойн салбарт жендерийн тэгш байдлыг хангах шаардлагатай байхын зэрэгцээ ойн болон байгалийн нөөцийн менежментэд оролцох замаар үр ашиг хүртэх боломж тэгш бус байгааг олж тогтоохын тулд дан ганц хүйсийн харьцаа бус үүнээс цааш илүү өргөн хүрээнд авч үзэх шаардлагатай байна.**

Монгол орны UN-REDD хөтөлбөрөөс хийсэн судалгаанд мөн Монгол Улсад жендерийн тэгш байдлыг хангахтай холбоотой хууль эрх зүйн орчин харьцангуй сайн бүрдсэний дотор олон улсын жендэр, хүний эрхийн гэрээ, конвенцийн дагуу үүрэг хүлээж, үндэсний болон олон улсын хэмжээнд тогтвортой хөгжлийн зорилтуудыг хангахад идэвхтэй оролцож байгааг дурьдсан. Жишээ нь, "Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал хэтийн төлөв -2030"-д тогтвортой хөгжлийн үйл явцад хүн бүрийн оролцоо, хувь нэмэр чухал болохыг онцолсон байна. Мөн "Жендерийн тэгш байдлыг хангах тухай хууль" (2011) нь нийгмийн бүхий л хүрээнд түүний дотор хөдөлмөрийн харилцаанд жендерийн тэгш байдлыг хангах зорилт тавьсан. Жендерийн тэгш байдлыг хангах тухай үндэсний хөтөлбөрийг 2017 оны 5 сард баталсан. "Жендерийн тэгш байдлыг хангах тухай хууль" нь байгаль орчин, аялал жуулчлал зэрэг бусад салбарт жендер тэгш байдлыг хангахыг шаардсаны дагуу "Байгаль орчны салбарын жендерийн стратеги 2014-2030"-г боловсруулсан байна. Энэ нь эмэгтэй, эрэгтэй хүмүүс, нийгмийн бүлгүүдийн болон орон нутгийн хөгжлийн хэрэгцээнд тулгуурлан, тэгш оролцох, үр ашиг тэгш хүртэх боломжийг хангах замаар ногоон хөгжлийн төлөвлөгөөг дэмжих чухал баримт бичиг болсон билээ.

Хэдийгээр Монгол Улсад жендерийн тэгш байдлыг хангах хууль эрх зүйн орчин харьцангуй сайн бүрдсэн ч тэдгээрийг хэрэгжүүлэхэд саад бэрхшээл тулгарсаар байна. Жишээ нь, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах ажил сул, салбар бүрийн бодлого, хөтөлбөрт жендерийн асуудлыг тусган хэрэгжүүлэх чадавх, аргачлал дутмаг, хариуцлага хязгаарлагдмал, жендерийн байдлаар задлан ялгасан мэдээ, баримтын олдоц, хэрэглээ сул гэх мэт. **Дээрх судалгааны хүрээнд багц зөвлөмж боловсруулсаны зарим нь бидний хийсэн үнэлгээнд хамаатай байна. Тухайлбал: i) REDD+ хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх явцад** болон эмэгтэйчүүдэд чиглэсэн үйл ажиллагаанд талуудын оролцоог хангах шалгуур бий болгох нь тэнцвэртэй оролцоог дэмжих, эрэгтэй, эмэгтэй хүмүүс болон

нийгмийн бүлгүүдэд үр ашиг тэгш хүртэх боломжийг бүрдүүлж өгөхийн зэрэгцээ хөдөлмөр эрхлэлтийн харилцаанд жендерийн хэт ялгаа гарах эрсдлийг бууруулахад дэмжлэг болох юм, ii) Аймаг, сумын түвшинд **жендерийн мэдрэмжтэй, нийгмийн бүлгүүдийг тэгш хамруулсан талуудын оролцоог хянах арга хэрэгсэл, мэдээлэл солилцох (мэдээллийг ангилах)** суваг шаардлагатай бөгөөд энэ сувгаар цаашид Сөрөг нөлөөллөөс сэргийлэх мэдээллийн систем (СНСМС)-д мэдээлэл дамжуулна, iii) **Нийгмийн бүлгүүдийг тэгш хамруулах, Байгаль орчны салбарын жендерийн стратегийг хэрэгжүүлэх удирдамжийг** боловсруулж, холбогдох албан хаагчдыг сургах шаардлагатай зэрэг болно.

6.1.4 СНСЗ D:

(Талуудын, тухайлбал, уугуул болон орон нутгийн иргэдийн бүрэн бөгөөд үр дүнтэй оролцоог хангах [REDD+-ийн үйл ажиллагаанд])

Хавсралт 3.4-т СНСЗ D-н хүрээнд тодорхойлогдсон үр ашиг ба эрсдэлд хамаарч болох БХЖ-г харуулсан ба үүнд:

* Ойн цэвэрлэгээ хөтөлбөр (2014);
* Ойн тухай хууль (2012);
* Төрөөс ойн талаар баримтлах бодлого (2015);
* Төрийн болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны тухай хууль (2005);
* Захиргааны хууль (2016)
* Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн тухай хууль (1997);
* Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хууль (2013) зэрэг багтана.

СНСЗ D-тэй холбоотой дөрвөн бүрэлдэхүүн хэсгийн шаардлагыг хангахын тулд эрх зүйн шинэчлэл хийх шаардлага тулгарч магадгүй. Нэгдүгээрт, холбогдох оролцогч талуудыг тодорхойлох тухайд оролцогч талуудын оролцоог тусгасан зүйл, заалтуудыг Ойн тухай хуульд нэмж тусгах (шаардлагатай байна. Энэ асуудлыг 6.1.3-р зүйлд тодорхойлсон (СНСЗ С). Ойн менежмент дэх хувийн хэвшлийн үүргийг нэмэгдүүлэхэд хувийн хэвшлийн тарьсан модыг баталгаатай худалдаж авах асуудал мөн хамаатай. Энэ зөвлөмжийг 6.1.1-р зүйлд тодорхойлсон (СНСЗ А).

СНСЗ D-ийн эрх зүйн шинэчлэл шаардагдаж магадгүй хоёр дахь бүрэлдэхүүн хэсэг нь шийдвэр гаргахад оролцох эрхийг тодорхойлох ба хэрэгжүүлэхтэй холбоотой. Үүнд СНСЗ С-ийн хүрээнд 6.1.2-р зүйлд тодорхойлсон ашгийн хуваарилалт ба маргааныг шийдвэрлэх журам хэрэгтэй тухай асуудал юм. Процедурын эрхтэй холбоотой өөр нэг асуудал бол ойн гэрчилгээний асуудал (гэрчилгээ олгох газрыг хэрхэн сонгосон, нутгийн иргэдтэй хэрхэн зөвшилцсөн гэх мэт). **Ойн гэрчилгээ олгох талбайн шалгаруулалтын**

нээлттэй, ил тод байдлыг хангах үүднээс Ойн тухай хуулийн холбогдох журмыг шинэчлэх зөвлөмж гаргасан. Уг шинэчлэл нь “экосистемийн үйлчилгээний төлбөр” эсвэл мод үржүүлгийн аж ахуй, агро-ойн аж ахуй зэрэг ойн салбарын бусад санаачилга хэрэгжүүлэх талбайн сонголтонд хамаатай байж болно. Тэдгээр шинэчлэл нь мөн зөвшөөрөл хүссэн аж ахуйн нэгжүүдийн зүгээс орон нутгийн иргэдийн нийгмийн ашгийг хангах явдлыг баталгаажуулж өгөх ёстой.

СНСЗ D-ийн хүрээнд анхаарал шаардаж магадгүй гурав дахь бүрэлдэхүүн хэсэг нь холбогдох оролцогч талуудыг төлөөлж буй этгээдүүдийн эрх зүйн чадамж ба хариуцлагын асуудал юм. Үүний холбогдох зөвлөмж бол оролцогч талуудын оролцоог тусгасан зүйл заалтуудыг нэгтгэх явдал юм. Энэ асуудлыг 6.1.3-р зүйлд тодорхойлсон (СНСЗ С).

СНСЗ D-ийн анхаарал татах дөрөвдүгээр буюу сүүлчийн бүрэлдэхүүн хэсэг нь “REDD+ үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт тавих үйл явцад талуудын оролцоог хангах механизм эсвэл суурь бий болгох” явдал юм. Энд Ойн тухай хууль болон бусад журмыг хэрэгжүүлэхэд учирч буй гол хүндрэл бол хяналт хангалтгүй байгаа явдал мөн гэж үзэв. Одоогийн байдлаар ойн хяналт ба эргүүлийг ойн нөхөрлөлүүд Байгаль орчны хяналтын байцаагчид (МХЕГ)-тай хамтран гүйцэтгэж байна. Хэдийгээр хуулийн хэрэгжилтэд хяналт тавихад орон нутгийн иргэд болон иргэний нийгмийн оролцоог хангах тухай тусгасан, дээрээс нь иргэний нийгмийн зүгээс хяналт тавихад оролцож байгаа тохиолдлууд байгаа боловч урамшуулал эсвэл санхүүжилтийн эх үүсвэрийн талаар тодорхой заалт байхгүй. **Тиймээс тус хууль эсвэл холбогдох журмыг шинэчилж урамшууллын талаар тусгасан заалтуудыг хэрэгждэг болгох зөвлөмж гаргасан. Өөр нэгэн зөвлөмж гаргасан нь ойн дагалт баялаг бэлтгэлд тавих хяналтын үйл ажиллагаанд иргэний нийгмийн оролцоог хангах тухай юм.**

6.1.5 СНСЗ Е:

(/REDD+-ийн/ Үйл ажиллагаа нь байгалийн ой, биологийн олон янз байдлыг хамгаалах асуудалтай нийцсэн байх ба REDD+-ийн үйл ажиллагаануудыг байгалийн ойг хувиргахад ашиглах бус харин байгалийн ой болон түүнийг экосистемийн үйлчилгээг хамгаалахад чиглэсэн урамшуулал бий болгох, мөн нийгэм, байгаль орчны бусад үр ашгийг сайжруулахад ашиглах)

Хавсралт 3.5-т СНСЗ Е-н хүрээнд тодорхойлогдсон үр ашиг ба эрсдэлд хамаарч болох хамгийн тохиромжтой БХЖ-г харуулсан ба үүнд:

* Ойн тухай хууль (2012);
* Төрөөс ойн талаар баримтлах бодлого (2015);
* Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль (1994);

* Газрын тухай хууль (2002)
* Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн тухай хууль (1997);
* Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль(2012)
* Холбогдох олон улсын конвенц, үндэсний хөтөлбөрүүд (НҮБ-ын Цөлжилт, газрын доройтолтой тэмцэх Конвенц).

СНСЗ Е-тэй холбоотой гурван бүрэлдэхүүн хэсгийн шаардлагыг хангахын тулд эрх зүйн шинэчлэл хийх шаардлага тулгарч болох юм. Нэгдүгээрт, REDD+ үйл ажиллагааг боловсруулж, ач холбогдлоор нь эрэмбэлж, хэрэгжүүлэх явцад **унанги мод бэлтгэх, ойн арчилгааны огтлолт хийх зөвшөөрөл олгох квотын системтэй** холбоотой эрх зүйн шинэчлэл хийх шаардлагатай байна. Өмнө хийсэн үнэлгээнээс харахад, одоогийн квотын систем нь шинжлэх ухааны үндэслэлтэй мэдээлэлд суурилаагүй, ойн дагалт баялгийг ашиглах тухай ойн менежментийн төлөвлөгөөнүүдэд хатуу заасан мод бэлтгэлийн аргачлалд нийцэхгүй байна гэж үзсэн. **Тиймээс уг системийг шат шатны батлагдсан ойн менежментийн төлөвлөгөөнүүдэд нийцүүлж өөрчлөхийг зөвлөсөн болно.** Мөн менежментийн төлөвлөгөөний чанарыг сайжруулах замаар ойн тогтвортой менежментийн зарчмуудыг тодорхой тусган, байгаль орчин, нийгмийн нэгдсэн шалгуур үзүүлэлтүүдийг багтаахыг зөвлөж байна.

Хоёрдугаарт, СНСЗ Е-ийн өөр нэгэн чухал бүрэлдэхүүн хэсэг нь REDD+ үйл ажиллагааг төлөвлөж, хэрэгжүүлэх газрыг сонгож, хэрэгжүүлэхдээ байгаль орчны болон нийгмийн ашгийг сайжруулахтай холбоотой урамшууллыг нэвтрүүлэх боломжуудыг тодорхойлж ашиглах явдал юм. Үүнд гурван журмыг шинэчлэхийг зөвлөсөн болно. Эхнийх нь СНСЗ А-ийн 6.1.2-р зүйлд авч үзсэн хувийн хэвшлийн тарьсан модыг “улсад буцаан худалдан авах”-тай холбоотой бөгөөд энэхүү механизмын хэрэгжилтийг сайжруулснаар ойн нөхөн сэргээлт болон хүлээгдэж буй ашгийг (жишээ нь ойн экосистемийн үйлчилгээг хангах) дэмжихэд тус болох юм. Хоёрдугаарт, эдийн засгийн хөгжилд чухал шаардлагатай байгалийн баялгийг хамгаалахыг анхаардаг **Эко системийн үйлчилгээний төлбөрийн тухай хууль боловсруулах зөвлөмж гаргасан.**

Гуравдугаарт, эко аялал жуулчлалын хөгжлөөс үүдэн гарч болзошгүй нийгэм, байгаль орчны эрсдлийг бууруулах, ашгийг нэмэгдүүлэхийн тулд **олон улсын эко аялал жуулчлалын стандартуудыг сурталчлах, нэвтрүүлэхтэй холбоотой журам болон удирдамж боловсруулахыг зөвлөсөн**.

Эцэст нь хэлэхэд, СНСЗ Е-ийн анхаарал татсан өөр нэгэн бүрэлдэхүүн хэсэг бол REDD+ үйл ажиллагааг боловсруулж, эрэмбэлж хэрэгжүүлэхдээ нийгмийн сөрөг нөлөөллөөс зайлсхийх, тэдгээрийг бууруулах явдал юм. Үүнд “Ойн тухай хууль” ба “Газрын тухай хууль”-ийн зөрчлийг (СНСЗ А-ийн 6.1.1-р зүйл) арилгахтай холбоотой мөн

ойн нөхөрлөлийн санхүүжилтийг сайжруулахтай (СНСЗ С-ийн 6.1.3-р зүйл) холбоотой шаардагдаж болзошгүй эрх зүйн шинэчлэл хамаарна.

6.1.6 СНСЗ F:

(Хувирах эрсдлийг тооцох, сэргийлэх үйл ажиллагаа)

Хавсралт 3.6-т СНСЗ F-н хүрээнд тодорхойлогдсон үр ашиг ба эрсдэлд хамаарч болох хамгийн тохиромжтой БХЖ-г харуулсан ба үүнд:

* Ойн тухай хууль (2012);
* Төрөөс ойн талаар баримтлах бодлого (2015);
* Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль (2012);
* Газрын тухай хууль (2002)
* Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх журам (2013);
* Байгаль орчныг хамгаалах тухай хууль (2012) багтана.

Одоогоор энэ зарчмын хүрээнд хууль эрх зүйн шинэчлэл хийх зөвлөмж гараагүй. Гэхдээ өмнө дэвшүүлж байсан, газрын тухай хууль болон ойн тухайн хуулийн хоорондоо зөрчилтэй заалттай холбоотой асуудал нь СНСЗ F болон G –д хамаарч байна.

6.1.7 СНСЗ G:

Хүлэмжийн хийн ялгаралт өөр газар шилжих явдлыг бууруулах үйл ажиллагаа

Хавсралт 3.7-т СНСЗ G-н хүрээнд тодорхойлогдсон үр ашиг ба эрсдэлд хамаарч болох хамгийн тохиромжтой БХЖ-уудыг харуулсан ба үүнд:

* Ойн тухай хууль (2012);
* Төрөөс ойн талаар баримтлах бодлого (2015);
* Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль (2012);
* Газрын тухай хууль (2002);
* Ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээний ажлыг төлөвлөх, зохион байгуулах, санхүүжүүлэх, таримал ойг үнэлэх, улсын ойн санд худалдан авах, өмчлүүлэх журам (2013).

СНСЗ G-тэй холбоотой хоёр бүрэлдэхүүн хэсгийн шаардлагыг хангахын тулд эрх зүйн шинэчлэл хийх шаардлага тулгарч магадгүй.

Нэгдүгээрт, Үндэсний стратеги, үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулах, батлах, шинэчлэхтэй холбоотой зарчмын шаардлагын тухайд **хууль бус мод бэлтгэлтэй**

холбоотой орлогын тодорхой хувийг санхүүгийн бус урамшууллын санд төвлөрүүлэхийг зөвшөөрсөн шинэ хууль эсвэл журам боловсруулахыг зөвлөсөн болно. Мөн хууль бус мод бэлтгэлийг мэдээлсэн иргэдэд татварын хөнгөлөлт эдлүүлж болох юм. Энэ нь хууль бус мод бэлтгэлийг нөхцөлдүүлдэг хүчин зүйлс өөр газарт шилжихээс сэргийлнэ.

Хоёрдугаарт, орон нутаг, бүс нутаг болон улсын хэмжээнд тодорхой REDD+ үйл ажиллагаанаас үүдэлтэй хүлэмжийн хийн ялгаралт өөр газар шилжих явдлыг бууруулах үйл ажиллагааг боловсруулж, тэргүүлэх зэргийг тогтоон, хэрэгжүүлэхдээ REDD+ үйл ажиллагаа нь иргэдийн амьжиргаанд үзүүлж болох нөлөөллийг анхаарч холбогдох хууль эсвэл журмыг шинэчлэн ойн нөхөрлөлүүдийн ойтой холбоотой үйл ажиллагаанаас орж ирсэн орлогын эрх мэдлийг нэмэгдүүлэх шаардлагатай байж магадгүй. Энэ зөвлөмжийг 6.1.3-р зүйлд тодорхойлсон (СНСЗ С).

6.2 БХЖ-тай шууд холбоогүй бусад чухал асуудлууд

Энэхүү үнэлгээний гол зорилго нь Монгол Улсын бодлого, хууль, журмын одоогийн системийг шалгаж REDD+ хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцад зарчмуудыг хэрхэн тусгаж, хэрэгжүүлэхэд нөлөө үзүүлж болзошгүй хийдэл, сул талуудыг үнэлэх явдал гэдэг нь тодорхой. Хэдий тийм боловч үнэлгээ хийх явцад хэлэлцүүлэгт оролцогчдын зүгээс одоогийн БХЖ-тай шууд холбоогүй эсвэл шинээр БХЖ боловсруулах хэрэгцээтэй байгаа талаар хэд хэдэн асуудал дэвшүүлсэн. Тэдгээр асуудлууд яваандаа REDD+ -ийн БАХ-ний хэрэгжилт болон сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчмуудыг хэрэгжүүлэхэд нөлөөлж болох тул тэдгээр асуудлыг товчхон авч үзэх нь чухал.

Дэвшүүлсэн асуудлуудыг дараах байдлаар гурван бүлэгт хуваажболно. Үүнд: (i) ойн зэргэлдээ амьдардаг эсвэл орлого нь ойгоос шалтгаалдаг иргэдийн амьжиргааг сайжруулах; (ii) экологийн мэдлэгийг дээшлүүлэх; (iii) санхүүжилт ба урамшуулал зэрэг болно.

Оролцогч талуудтай явуулсан бүх хэлэлцүүлгийн үеэр **REDD+-ийн үйл ажиллагаанууд нь амьжиргааг дэмжих боломжтой** талаар хөндсөн ба энэ асуудал нь **Канкуны СНСЗ Е-тэй** холбоотой юм**.** Дараах саналуудыг гаргасан болно:

* Модон бүтээгдэхүүний салбарт нэмүү өртөг шингээх асуудал дээр төвлөрсөн мэргэжлийн сургалтын төвүүд байгуулах. Тэдгээр төвүүд нь ялангуяа эмзэг бүлгийн ажилгүй иргэдийг сургахад анхаарч, бизнес эрхлэх эмэгтэйчүүдэд бизнесийг хөгжүүлэх, удирдан зохион байгуулах, санхүү, төслийн менежмент, хэрэгжилтийн талаар сургалт явуулдаг байх нь зүйтэй.

* Орон нутгийн захиргаанууд орлогын өөр эх үүсвэрийг таниулж байгалийн баялгийн ашиглалтаас хамаарах хамаарлыг бууруулах арга хэмжээ авах шаардлагатай.

* Жижиг бизнес, хоршоо, нөхөрлөлийг тоног төхөөрөмж, барилга байгууламж, технологи худалдан авах бололцоогоор хангах үүднээс техникийн болон хөрөнгө оруулалтын зээлийн дэмжлэгийг сайжруулах хэрэгтэй.
* Агро-ойн аж ахуйн талаарх стратеги боловсруулах нь зүйтэй.

Оролцогч талууд мөн REDD+ хөтөлбөрийн хэрэгжилтээс хүлээгдэж буй үр ашгийг сайжруулах, өөрөө үр ашиг болж болох тул экологийн мэдлэгийг сайжруулах хэрэгцээ байгааг олон удаа дурьдсан. МХЕГ зэрэг хууль хэрэгжүүлэгч байгууллагуудын зэрлэг ан амьтан, ургамлын арилжаа болон ерөнхий экологийн мэдлэгийг дээшлүүлэх хэрэгтэй гэж үзсэн. Мөн ойн нөхөрлөлүүдэд хортон шавжны менежмент, ойн нөхөн сэргээлт болон ойн менежментийн төлөвлөлтийн талаар илүү мэдээлэл хэрэгтэй байгаа нь тод харагдсан. Ерөнхийдөө мэдээллийг, ялангуяа олон улсын хэмжээнд тайлан өгөхөөр бүрдүүлсэн мэдээллийг оролцогч талуудад (тэр дундаа алслагдсан орон нутгийн) үр дүнтэй хүргэх хэрэгцээ байна гэж үзсэн.

Санхүүжилт болон холбогдох урамшууллын асуудал оролцогч талуудын хэлэлцүүлгийн гол сэдэв байв. Орон нутгийн хөгжлийн сангуудын санхүүжилтийг ил тод болгох шаардлагатай. Мөн одоогийн урамшууллын систем нь орон нутгийн иргэдэд ойн менежменттэй холбоотой зөрчлийг мэдээлэх сонирхол төрүүлэх эсэх талаар хэлэлцэв. Урамшууллын санхүүжилтийг ойн баялаг ашиглалтын төлбөрийн тодорхой хувиар бүрдүүлж, мэдээлэл өгсөн иргэдэд олгох урамшууллыг шуурхай боловсруулж, нууцлалыг хадгалах санал гарсан. Үүнээс гадна, бичил санхүүжилтийн асуудлыг зохицуулсан БХЖ байхгүй байгаа нь үр дүн тогтворгүй байх, хүлэмжийн хийн ялгарал өөр газар шилжих зэрэг үр дагаварт хүргэж болно. **Хөтөлбөрөөс бичил санхүүжилт болон амжиргааг дэмжих үйл ажиллагааны шалгуур үзүүлэлт, удирдамжийг боловсруулах зэргээр эдгээр эрсдлийг авч үзээд БАХ боловсруулахдаа тусгах нь зүйтэй.**

6.3 Канкуны зарчмуудын хэрэгжилт ба одоогийн БХЖ-ын хэрэгжилт

Үнэлгээ хийх явцад дөчин найман БХЖ-ыг хамааралтай гэж тодорхойлсон. Тэдгээрийн жагсаалтыг Хавсралт 2-т харуулсан болно. Тэдгээр БХЖ-ын 9 нь 6.1-р зүйлд хийсэн шинжилгээний дүнд дэвшүүлж буй арван БАХ-г хэрэгжүүлэхтэй холбоотой үүсч болох эрсдэл ба үр ашгийг зохицуулахад хамгийн их хамааралтай гэж үзсэн. Дээрх 9 БХЖ-ын хамгийн их хамааралтай гэж үзсэн дөрөвт нь хэрэгжилтийн нарийвчилсан шинжилгээ хийсэн.

БХЖ тус бүр дээр тэдгээрийг хэрэгжүүлэхтэй холбоотой дутагдал, сул талын үнэлгээг хийсэн болно. Ерөнхийдөө хэрэгжилтийн талаар үнэлгээ хийх ажил нь БХЖ-ын заалтуудыг үнэлэх ажилтай харьцуулахад илүү цаг хугацаа шаардсан ажил байсан ба учир

нь өөрсдийн хариуцсан БХЖ-ын талаар нарийн мэдлэгтэй төрийн албан хаагчидтай уулзалт хийх шаардлагатай болж байв.

Хэрэгжилттэй холбоотой хоёр асуудал нилээд анхаарал татаж байсан бөгөөд үнэлгээний явцад шалгасан бүх БХЖ-д нийтлэг, элбэг тохиолдож байсан. Энэ нь санхүүжилт ба мэдлэг/чадавхтай боловсон хүчний хүрэлцээний асуудал юм. Түүхий эдийн үнэ буурснаас хойш Монгол Улсын Засгийн газар ерөнхийдөө санхүүгийн бэрхшээлд ороод байгаа. Улсын төсөв хүрэлцэхээ больж, хууль зүйн түвшинд дэмжигдсэн зарим хөтөлбөрүүд (жишээ нь Ойн цэвэрлэгээ хөтөлбөр) хэрэгжээгүй байна. REDD+ хөтөлбөр нь олон нийтийн байгууллагуудын хэрэгжүүлж болох нэмэлт үйл ажиллагаа, чиг үүргийг харгалзан үзэх шаардлагатай. Үүний тулд одоогийн байгаа чиг үүргийнх нь хүрээнд багтаан санхүүжилтийн шинэлэг механизмуудыг хэрэгжүүлэх хувилбаруудыг судлах хэрэгтэй. Тухайлбал, хувийн хэвшлийг оролцуулах мөн одоогийн байгаа санхүүжилтийн урсгалыг дахин зохион байгуулах (шинээр хөрөнгө бүрдүүлэхийн оронд) зэрэг байж болно.

Техникийн дэмжлэг болон концессийн зээлийг голдуу тодорхой төслүүдэд олгодог. Гэсэн хэдий ч засгийн газар Дэлхийн банктай хэлэлцээр хийж, Хөгжлийн бодлогын зээл (ХБЗ) олгох хүсэлт гаргаж болох ба уг зээлийг тохиролцсон салбарын өөрчлөлтийн хариуд нэгдсэн төсөвт дэмжлэг үзүүлэх хэлбэрээр олгодог. Одоогоор Дэлхийн банкны зээлийн 40% ХБЗ-ээс бүрдэх ба Дэлхийн банк Вьетнам болон Мозамбикт ногоон хөгжил ба уур амьсгалын өөрчлөлтийн чиглэлээр ХБЗ олгосон жишиг байна.

Хэрэгжилтийн өөр нэгэн нийтлэг чухал асуудал бол ойн идэвхтэй бөгөөд тогтвортой менежмент явуулах чадавхи сул байгаа явдал юм. Энэ нь талуудад нийтэд нь хамаатай асуудал мэт харагдаж байгаа боловч ойн нөхөрлөлүүдийн түвшинд сургалт дутмаг, төрийн албан хаагчдын дунд ойтой холбоотой техникийн мэдлэг/чадавхи дутмаг зэрэг тодорхой асуудлууд байна. Чадавхийн асуудал нь тодорхой хэмжээнд сургалт явуулах санхүүжилт байхгүйтэй бас холбоотой.

Мөн зөвхөн тухайн БХЖ-д хамаарах хэрэгжилтийн тодорхой асуудлууд байна.

<u>Ойн тухай хууль</u>

Ойн тухай хуулийг 2012 онд шинэчлэн найруулж 2015 онд нэмэлт өөрчлөлт оруулсан. Тэдгээр нэмэлт өөрчлөлт нь хамтарсан менежмент болон иргэдийн оролцоонд анхаарсан ба ойн нөхөрлөлүүдэд тодорхой хэмжээний эрх үүрэг олгосон. Одоогийн байдлаар нийт 1282 ойн нөхөрлөл байгаа бөгөөд тэдгээрт 3.5 сая га ой хамрагдаж байна. Ойн нөхөрлөл бүр аймгийн байгаль орчин, аялал жуулчлалын газраар батлуулсан менежментийн төлөвлөгөөтэй байх ёстой. Өнөөдрийн байдлаар 900 ойн нөхөрлөл менежментийн төлөвлөгөөтэй байна.

Ойн нөхөрлөлүүд нь “Ойн цэвэрлэгээ”-нд оролцох эрхтэй. Уг хуулийн 3.1.15 дахь хэсэгт: “ойн цэвэрлэгээ” гэж ойн түймэр, хөнөөлт шавж, өвчинд нэрвэгдсэн, хүчтэй салхи, их цасанд өртөн амьдрах чадваргүй болж үхжиж унасан хуурай мод, гишүү, мөчир, мод бэлтгэлийн талбайн үлдэгдлийг цэвэрлэх замаар ойг хамгаалах, ойн төлөв байдлыг сайжруулахад чиглэсэн арга хэмжээг хэлнэ гэж заасан байна.

Хэдийгээр ойн нөхөрлөлүүд ойн менежментэд үүрэг гүйцэтгэх боловч хуулинд зааснаар тэдэнд ойгоос мод огтлох эрх байхгүй. Мэдээж энэ нь зарим ойн нөхөрлөл болон сумтай мод бэлтгэх гэрээ байгуулсан мэргэжлийн ойн аж ахуйнуудын хооронд зөрчил үүсгэдэг. Зарим ярилцлагаас харахад **хуулинд ойн нөхөрлөлүүд болон ойн мэргэжлийн байгууллагуудын үүргийг бүрэн тодорхой заагаагүй** байгаа нь хэрэгжилтэд сөргөөр нөлөөлж ойн нөхөрлөлүүд ойгоос үр ашиг хүртэх чадварыг бууруулж байна. Нэмж тэмдэглэхэд ойн менежментийн төлөвлөгөөтэй байх ёстой ба төлөвлөгөөг аймгууд баталдаг. **Эдгээр өөр өөр менежментийн төлөвлөгөө нь (өөрөөр хэлбэл ойн нөхөрлөл болон ойн мэргэжлийн байгууллага)** хоорондоо сайн уялдахгүй нь элбэг бөгөөд ингэснээр ойн менежментэд бас нөлөөлж болох юм.

Ойн нөхөрлөл болон ойн мэргэжлийн байгууллага хоорондын зөрчил түгээмэл биш. Зарим нөхөрлөлүүд бусдыг бодвол илүү бизнес хандлагатай тул ойн мэргэжлийн аж ахуй шиг болох эрмэлзэлтэй байдаг. Тэдгээр нөхөрлөлийн хувьд одоогийн хуулинд тусгагдсан ойн цэвэрлэгээний урамшуулын системийг санхүүжилтийн асуудал шийдэгдсэн үед хэрэгжүүлж эхлэх ёстой. Засгийн газар хуулийг шинэчлэх замаар **ойн нөхөрлөлийг хоёр хэлбэрээр тодорхойлох** асуудлыг авч үзэх ёстой. Эхний хэлбэрт хамаарах нөхөрлөл нь малчид нүүдэлчдээс голчлон бүрдсэн, тусгай хамгаалалтай газар нутагт байрлах ба эдгээр нөхөрлөлүүдийн одоогийн мөрдөж байгаа хязгаарлагдмал эрхийг энэ бүс нутагт хэвээр хадгалах нь зүйтэй, нөгөөх нь илүү бизнес хандлагатай хэлбэр бөгөөд тэдгээрт хязгаарлагдмал хүрээнд мод тарих, огтлох эрх олгож болох юм. Ингэснээр ойн нөхөрлөлүүд ойн үр ашгийг илүүтэйгээр хүртэх бололцоог дэмжихийн зэрэгцээ тэдгээрийн тогтвортой ойн менежмент явуулах чадавхид анхаарах юм. Тус зөвлөмж **Канкуны Зарчим В-д** хамгийн их хамааралтай.

Өөр нэгэн тодорхой бус зүйл байгаа нь ойн дагалт баялаг бэлтгэх хэмжээг хэрхэн тогтоох явдал юм. Одоогийн байдлаар орон нутгийн иргэдийн төлөөлөгчдийн хурал аймгаас гаргаж өгсөн дээд хязгаарт үндэслэн нэг жилд огтлох модны хэмжээг тогтоодог. Гэвч тэдгээр тогтоосон хэмжээ нь 6.1.5 (СНСЗ Е)-д дурьдсанчлан ойн мэргэжлийн байгууллага болон нөхөрлөлүүдийн менежментийн төлөвлөгөөтэй зөрчилдөх нь элбэг. **Сумын ойн менежментийн төлөвлөгөөнд заасан хэмжээг хэтрүүлэхгүйн тулд, холбогдох ойн нөхөрлөл нь мод бэлтгэлийн хэмжээг иргэдийн төлөөлөгчдийн хуралд өргөн барьж шалгуулан, батлуулах** шаардлагатай байгааг харуулж байна. Мод бэлтгэх, унанги модыг цэвэрлэх хэмжээ нь судалгаанд түшиглэсэн буюу өөрөөр хэлбэл тухайн бүс

нутгийн ойн нөхцөлд бодит үнэлгээ хийсэн үр дүнд тулгуурлах ёстой. Тус зөвлөмж **Канкуны Зарчим В-д** хамгийн их хамааралтай.

Эцэст нь хэлэхэд, Ойн тухай хуулийн зарим заалтад **хууль бусаар мод бэлтгэх үйл ажиллагаанаас хураагдсан эд хөрөнгийг улсын нэгдсэн төсөвт** төвлөрүүлэх тухай тусгагдсан. Мөн тус хуулинд тэдгээр эд хөрөнгийг байгаль орчны үйл ажиллагаанд зарцуулна гэж заасан. Гэсэн хэдий ч энэ заалт тэр болгон хэрэгждэггүй нь харагдаж байна. Хэрэв хураагдсан эд хөрөнгийг ингэж хуваарилж, үр дүнтэй хяналт тавьж чадсан бол энэ нь ойн нөхөрлөлүүд болон ой цэвэрлэх санаачилгуудын санхүүжилтийн эх үүсвэр болох байв.

Ойн цэвэрлэгээ хөтөлбөр

Ойн цэвэрлэгээ хөтөлбөр[7] (ОЦХ) нь гурван зорилготой: (i) ойн нөхцөл байдлыг сайжруулах, (ii) ойн нөхөрлөл болон мэргэжлийн аж ахуйнуудын чадавхийг сайжруулах, (iii) ойн менежментийн арга барилын талаар сургалт явуулах. ОЦХ-т ойн насны ангилалаас шалтгаалан дөрвөн ангилал тогтоосон ба засгийн газар тэдгээр ангилалд үндэслэн ой бүхий газар үйл ажиллагаа явуулдаг аж ахуйнуудаас авах татварын хэмжээг тодорхойлдог. ОЦХ-т уг хөтөлбөрийн хүрээнд 64 сая $м^3$ унанги болон босоо хуурай мод бэлтгэж болно гэж заасан.

ОЦХ-эй холбоотой хамгийн том асуудал нь төр одоо болтол улсын **төсвөөс хангалттай санхүүжилт** хуваарилж чадахгүй байгаа явдал юм. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхийн тулд 14 тэрбум төгрөг шаардлагатай гэж тооцоолсон. Эдийн засгийн хямрал болоогүй байх үед ойн цэвэрлэгээ хөтөлбөрт жилд 300-400 сая төгрөг жил бүр төсөвлөдөг байв. Санхүүжилт авсан тохиолдолд ойн нөхөрлөлүүд ойн цэвэрлэгээнээс орлого олж, хямд үнээр өөр мод худалдан авах нөхцөл бүрдэнэ. ОЦХ-ийн хэрэгжилт хангалтгүй байгаа нь тус хөтөлбөртэй холбоотой БАХ-ээг авч хэрэгжүүлэх боломжид сөргөөр нөлөөлж байгаа бөгөөд сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчмуудын өнцгөөс авч үзвэл ойн нөхөрлөлүүд болон ойн бүтээгдэхүүнээс үр ашиг хүртэх боломжид бас нөлөөлнө. Түүний зэрэгцээ Монгол орны REDD+ хөтөлбөр нь унанги мод цэвэрлэх, ойн дагалт баялгийг ашиглах үйл ажиллагааг өргөжүүлэхтэй холбоотойгоор нүүрстөрөгчийн шингээлт буурах болон бусад эрсдэл дагалдан бий болдог гэдгийг анхаарч байх шаардлагатай.

Үр ашиг, эрсдлийн үнэлгээний зөвлөжмийг боловсруулах үеэр эдгээр эрсдэл, тэдгээрийг даван туулах арга хэмжээний талаар нарийвчлан хэлэлцсэн. Товчилбол, унанги мод болон бусад төрлийн ойн бүтээгдэхүүнийг цуглуулах, бэлтгэх явдал цаашид нэмэгдэх магадлал их тул нотлох баримт цуглуулж, БАХ-г хэрэгжүүлсэнээр үүсэх нөхцөл байдлыг тодорхой зураглаж харуулах шаардлагатай (ийм мэдээ баримт олдохгүй бол үнэлгээ хийж мэдээлэл цуглуулах). Ингэснээр, санал болгож буй мод бэлтгэлийн үйл ажиллагааны мөн

[7] Цэвэрлэгээ гэдэг нь сийрэгжүүлэх, унанги модыг зайлуулахыг хэлнэ.

чанарыг сайн ойлгож, түүнээс урган гарах нүүрстөрөгчийн шингээлт нэмэгдэх үр дүн, бусад эерэг үр нөлөө, эрсдэл зэргийг талаар тодорхой төсөөлж, Монгол орны ойд тохирсон арга хэмжээг боловсруулах юм. Мэдээлэл цуглуулах болон судалгаа хийхдээ цаашид мод бэлтгэлийг нэмэгдүүлэхээр төлөвлөж байгааг давхар үнэлэх нь зүйтэй бөгөөд энэ өсөлтөөс үүдэн урт хугацааны туршид нүүрстөрөгчийн шингээлттэй холбоотой бий болох эерэг, сөрөг үр дагавар, биологийн төрөл зүйл, экосистемийн үйлчилгээнд учрах эерэг, сөрөг нөлөөг үнэлж, улмаар ашиглалт, хамгаалалтыг тэнцвэржүүлэх хувилбаруудыг тодорхойлох шаардлагатай.

<u>Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль, Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн тухай хууль ба менежментийн төлөвлөлт</u>

Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийг анх 1994 онд баталсан ба 2010 онд нэмэлт өөрчлөлт оруулсан юм. Тус хуулинд 2018 онд дахин нэмэлт өөрчлөлт оруулж Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн тухай хуультай нэгтгэхээр ажиллаж байна. Шинэ хуулийн төсөлд тусгай хамгаалалттай газар нутгийн тогтвортой санхүүжилтийн талаар илүүтэйгээр тусгаж, ТББ-д ногдох менежментийн хариуцлагыг нэмэгдүүлнэ. Монгол улсад 102 тусгай хамгаалалттай газар нутаг байгаа бөгөөд тэдгээрт 27.9 сая га газар нутаг хамрагдаж байна. Дөрвөн төрлийн тусгай хамгаалалттай газар нутаг байдаг ба бүгд өөрийн гэсэн менежментийн төлөвлөгөөтэй. Хоёр төрлийн төрлийн тусгай хамгаалалттай газар нутгийг орон нутгийн түвшинд хамгаалдаг бөгөөд шинэ хууль батлагдсанаар энэ байдал өөрчлөгдөж менежментийг нь улсын түвшинд хариуцдаг болно.

Ярилцлага хийх явцад болон семинарын үеэр удаа дараа хөндөгдсөн нэг асуудал **бол байгалийн нөөц тус бүрийн менежментийн төлөвлөгөөг салангид боловсруулах** хандлага байдаг бөгөөд хоорондоо уялдаа холбоогүй эсвэл хэрэгжүүлэх зохицуулалт байдаггүй. Тухайлбал усны хагалбар газар, сав газрын менежментийн төлөвлөгөө, газар ашиглалтын төлөвлөгөө, ойн менежментийн төлөвлөөнд энэ хамаатай. Тэдгээр төлөвлөгөөг нэгтгэн зангидах эсвэл зохицуулалтыг сайжруулах үүднээс **байгалийн баялгийн менежментийн нэгдсэн агентлаг** бий болгох шаардлагатай байж магадгүй.

7. БУСАД САНАЛ, ДАРААГИЙН АЛХАМ

Энэхүү БХЖ-ын үнэлгээний дүнд Монгол улсад өргөн цар хүрээтэй БХЖ-ууд үйлчилж байгаа хэдий ч эрх зүйн системд дутагдлууд байгаа бөгөөд REDD+ БАХ-ний сөрөг нөлөөллөөс хангалттай сэргийлсэн гэж үзэхийн тулд тэдгээр дутагдлыг залруулж, БХЖ-д тусгах шаардлагатай гэдэг нь харагдсан. Одоогийн эдийн засгийн орчин нөхцөлд БХЖ-г хэрэгжүүлэх боломж байгаа эсэх нь мөн чухал бөгөөд санаа зовоож байгаа асуудал юм.

7.1 Хууль эрхзүйн хүрээнд шинэчлэл хийх

Мөн 6-р хэсэгт БХЖ-ын хийдэл, сул талуудыг залруулахтай холбоотой хэд хэдэн зөвлөмж танилцуулсан болно. Зөвлөмж болгож буй эдгээр шинэчлэлийг хэрэгжүүлэхэд хамгийн тохиромжтой "нөлөөллийн цэгийг" тогтоох асуудал нээлттэй хэвээр байна. Ихэнх улс оронд санал болгож буй шинэчлэлүүдийг хэрэгжүүлэхийн тулд хэсэгчлэн хуваах замаар буюу тодорхой хууль, журмыг шинэчлэх болсон үед л хэрэгжүүлэх боломжтой. Харин тохиолдлоор Монгол улсын хувьд энэхүү үнэлгээнд хамрагдсан БХЖ-уудад нилээд өргөн цар хүрээгээр нэмэлт, өөрчлөлт оруулах сайхан боломж тохиогоод байна. Хууль зүйн яам Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг (GIZ)-ийн санхүүжилтээр 10 жилийн хугацаатай, байгалийн баялгийн менежмент болон байгаль орчны бүх хуулийг шалгаж, шинэчлэх төсөл хэрэгжүүлж дуусч байна. Хоёр үе шаттай уг төсөл нь нийтдээ 19 хуулийг шалгасан ба тус бүр дээр нь нэмэлт өөрчлөлт боловсруулсан. Нийт нэмэлт өөрчлөлтийн төсөл 2018 эхээр бэлэн болох бөгөөд УИХ-ын хаврын чуулган дээр танилцуулна гэж найдаж байгаа аж. Энэ нь санал болгож буй REDD+ -тэй холбоотой БХЖ-ын шинэчлэлийг дэвшүүлэх туйлын таатай боломж бөгөөд дэвшүүлэх гэж буй нэмэлт өөрчлөлтийн төсөлд БХЖ-ыг шинэчлэх зөвлөмжүүдийг багтаахын тулд БОАЖЯ-ны хуулийн хэлтэстэй яриа хэлэлцээ эхлүүлэх зөвлөмжийг Хөтөлбөр хэрэгжүүлэх нэгжид гаргаж өгсөн болно.

Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль 2018 онд мөн шинэчлэгдэж Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн тухай хуулийг нэгтгэх гэж байгаа тул энэ нь нарийвчилсан үнэлгээ хийх явцад дээрх хоёр хуулинд хамааралтай гэж тодорхойлсон БХЖ-ын шинэчлэлийн зөвлөмжийг багтаах боломж юм.

7.2 Сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчмуудыг үндэсний нөхцөлд нийцүүлж хэрэгжүүлэх аргачлалаа цаашид боловсронгуй болгох талаар

БХЖ-уудыг шинэчилж, батлуулах нь мэдээж ойрын ирээдүйн чухал ажил мөн. Түүнээс гадна тайлбарлавал зохих гурван "дараагийн алхам" байна. Нэгдүгээрт, Зураг 1-тэй холбогдуулан дахин хэлэхэд БХЖ-ын үнэлгээг гүйцэтгэсэн нь Монгол улсад СНСЗ-уудыг хэрэгжүүлэх ажлын чухал бүрэлдэхүүн хэсэг юм. Энэ ажлыг 2017 оны 11 сарын 29 өдрийн Техникийн ажлын хэсгийн уулзалтаар санаачилсан бөгөөд тус уулзалтын үеэр оролцогчдод Канкуны зарчим тус бүрийн агуулгыг дэлгэрэнгүй танилцуулсан. Хүснэгт 6-д дээрх зарчмуудын агуулга, элементүүдийг харуулсан. Зарчим бүрийн агуулга болох элементүүдийг уг хүснэгтэд жагсаасан ба өмнө нь тодорхойлсон үр ашиг болон эрсдэлтэй холбож өгсөн. Хамааралтай БХЖ-ыг мөн хүснэгтэд оруулж, СНСЗ-тай холбоотой баганыг оролцогчдоор бөглүүлсэн бөгөөд энэ нь үндэсний нөхцөлд нийцүүлж СНСЗ-уудыг тодорхойлсон ажил болох юм.

Хүснэгт 6: Канкуны зарчмуудыг Монгол орны нөхцөлд нийцүүлэн тодорхойлох нь

Сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчмын элементүүд (тухайн зарчмыг үндэсний нөхцөлд нийцүүлж буулгах гол бүрэлдэхүүн хэсэг гэж ойлгох) →	**Монгол оронд REDD+-ийн хүрээнд хэрэгжүүлэхээр санал болгосон бодлого, арга хэмжээнүүдийн үр ашиг, эрсдлийн үнэлгээнээс тодорхойлсон гол үр ашиг, эрсдлүүд** →	**Эрсдэл, үр ашигтай холбоотой БХЖ-ууд (СНСЗ-уудтай холбоотой БХЖ-ын үнэлгээнд тулгуурлан сонгосон)** →	**Тухайн СНСЗ-ыг Монгол орны үндэсний нөхцөлд хэрхэн тайлбарлахыг бичнэ**

Сөрөг нөлөөллөөс сэргийлэх Канкуны зарчмуудыг Монгол орны нөхцөлд нийцүүлэн тодорхойлох ажлын үр дүнгийн тайланг тусад нь гаргасан.

Хоёр дахь "дараагийн алхам" бол БХЖ-ын үнэлгээг шаардагдах СНСЗ-ын мэдээллийн системийг бий болгож хөгжүүлэхэд ашиглахтай холбоотой. СНСЗ-ын мэдээллийн систем нь REDD+ СНСЗ-ыг хэрхэн холбогдох хууль журамд тусгаж хэрэгжүүлж буй мэдээллийг НҮБУАӨСК ба REDD-ийн вэб сайтад илгээх төрөл бүрийн мэдээллийн эх сурвалж болон одоогийн системүүдийг нэгтгэсэн систем юм. БХЖ нь СНСЗ-ын мэдээллийн системийн суурь болох бөгөөд ийм мэдээллийн системтэй байхыг НҮБУАӨСК-ын конвенцийн зүгээс шаарддаг. СНСМС нь Үндэсний хөтөлбөр болон Үйл ажиллагааны төлөвлөгөөний цөм хэсэг болох юм.

7.3 СНСЗ-уудыг тусгаж, хэрэгжүүлэх бусад алхмууд

Хууль, эрх зүйн шинэчлэл хийх, БХЖ-уудын хэрэгжилтийг сайжруулах нь ихэвчлэн урт удаан хугацааны үйл явц байдаг. Энэхүү БХЖ-ын үнэлгээгээр Монгол орны REDD+ хөтөлбөрт зориулсан олон зөвлөмж боловсруулсан бөгөөд эдгээр зөвлөмжийг хууль эрх зүйн шинэчлэл шаардахгүйгээр эсвэл эрх зүйн шинэчлэлийн нэмэлт болгон хэрэгжүүлж болох юм. Зөвлөмжүүд нь REDD+-ийг хэрэгжүүлэх явцад СНСЗ-уудыг бодлого, хууль, журамд тусган хэрэгжүүлэхэд чиглэсэн байх бөгөөд эдгээрийг цаашид үндэсний REDD+ хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэхэд анхаарч тусгана. Санал болгосон зөвлөмжүүдийг бүгдийг нь тоочихгүйгээр цөөн жишээ дурьдвал:

- Гол БХЖ-уудыг хэрэгжүүлэх болон REDD+-ийн тодорхой БАХ-нүүдийг чиглүүлэх **удирдамжийг** боловсруулах (хялбаршуулж ашиглах) шаардлагатай. Тухайлбал, байгаль орчны салбарын жендерийн стратегийг хэрэгжүүлэх удирдамж, REDD+-ийн үйл ажиллагаанд талуудын оролцоог хангах шалгуур, нийгэм, байгаль орчинд ээлтэй тогтвортой бичил зээл, амьжиргааг дэмжих арга хэмжээ хэрэгжүүлэх удирдамж зэргийг дурьдаж болно.

- Одоогийн мөрдөж байгаа БХЖ-уудын хүрээнд REDD+-ийг хэрэгжүүлэх, үйл ажиллагааг нь хянах, СНСМС боловсруулахад **иргэний нийгмийн байгууллагуудын гүйцэтгэх үүргийг** хөхиүлэн дэмжих;

- **Тендерийн үнэлгээний ил тод байдлыг хангах** програм хангаж, тусгай арга хэрэгслийг ашиглахыг дэмжих буюу REDD+-ийг хэрэгжүүлэхэд тендерийн үйл явц яаж хэрэгжих ёстойг тодорхойлох;

- REDD+-ийн БАХ болон үндэсний хөтөлбөрийн хүрээнд **мэдлэг дээшлүүлэх, чадавхи бэхжүүлэх ажлыг** тусган хэрэгжүүлэх, тухайлбал, техникийн сургалтын төвүүдийн бааз суурийг бэхжүүлэх, эмзэг, нийгмийн хувьд орхигддог бүлгүүдэд чиглэн, үндэсний болон орон нутгийн байгууллагуудтай хамтран ажиллаж ажилтнуудын экологийн мэдлэгийг дээшлүүлэх зэрэг болно.

ХАВСРАЛТ 1: КАНКУНЫ ЗАРЧМУУД

Сөрөг нөлөөллөөс сэргийлэх Канкуны зарчмууд (НҮБ-ын УАӨСК-ийн Шийдвэр. 1/Талуудын 16-р бага хурал)

"*REDD+ үйл ажиллагааг хэрэгжүүлэх явцдаа дараах зарчмуудыг дэлгэрүүлж, дэмжвэл зохино:*

(a) Тухайн үйл ажиллагаа нь ойн үндэсний хөтөлбөр, холбогдох олон улсын гэрээ, хэлэлцээрүүдийн зорилгод хувь нэмэр оруулахуйц буюу эсвэл тэдгээрт нийцсэн байна;

(b)) Хууль эрхзүй, бие даасан байдлыг харгалзан үзсэн ил тод, үр дүнтэй үндэсний ойн засаглалын бүтэцтэй байх ;

(c) Олон улсын өмнө хүлээсэн үүрэг, үндэсний нөхцөл байдал, хууль тогтоомж, мөн НҮБ-ын Ерөнхий Ассемблейн батлсан Уугуул иргэдийн эрхийн тухай НҮБ-ын Тунхгийг харгалзан үзэж, уугуул иргэдийн болон орон нутгийн нөхөрлөлийн гишүүдийн мэдлэг, эрхийг хүндэтгэх;

(d) Энэ шийдвэрийн 70, 72 дугаар хэсэгт заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ талуудын, тухайлбал, уугуул болон орон нутгийн иргэдийн бүрэн бөгөөд үр дүнтэй оролцоог хангах;

(e) Үйл ажиллагаа нь байгалийн ой, биологийн олон янз байдлыг хамгаалах асуудалтай нийцсэн байх ба уг шийдвэрийн 70 дугаарт заасан [REDD+] үйл ажиллагаануудыг байгалийн ойг хувиргахад ашиглах бус харин байгалийн ой болон түүнийг экосистемийн үйлчилгээг хамгаалахад чиглэсэн урамшуулал бий болгох, мөн нийгэм, байгаль орчны бусад үр ашгийг[1]сайжруулахад ашиглах;

(f) Хувирах эрсдлийг тооцох;

(g) Хүлэмжийн хийн ялгаралт өөр газар шилжих явдлыг бууруулах."

[1] НҮБ-ын Уугуул иргэдийн эрхийн тунхаглалд тусгагдсан уугуул иргэд болон орон нутгийн оршин суугчдын тогтвортой амьжиргаа болон ойгоос үл хамаарах байдлыг хангах шаардлага болон Олон улсын эх дэлхийн өдрийг харгалзан үзэж

Эх сурвалж: НҮБ-ын УАӨСК-ийн Шийдвэр.1/Талуудын 16-р бага хурал

ХАВСРАЛТ 2: ҮНЭЛГЭЭНД ХАМРАГДСАН БХЖ

Бодлого

1. Төрөөс ойн талаар баримтлах бодлого (2015)
2. Ойн цэвэрлэгээ хөтөлбөр (2014)
3. “Монгол мал” үндэсний хөтөлбөр (2010)
4. “Ус” үндэсний хөтөлбөр (2010)
5. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үндэсний хөтөлбөр (2016)
6. Ногоон хөгжлийн бодлого (2014)
7. Биологийн олон янз байдлын тухай үндэсний хөтөлбөр (2015)
8. Цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөр (2010)
9. Аялал, жуулчлалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр (2015)
10. Тусгай хамгаалалттай газар нутгийн үндэсний хөтөлбөр (1998)
11. Уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний хөтөлбөр (2011)
12. “Шинэ бүтээн байгуулалт” дунд хугацааны зорилтот хөтөлбөр (2010)

Хууль

1. Байгаль орчныг хамгаалах тухай хууль (1995)
2. Ойн тухай хууль (2012)
3. Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль (1994)
4. Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн тухай хууль (1997)
5. Усны тухай хууль (2012)
6. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль (2011)
7. Жижиг, дунд үйлдвэрийн тухай хууль (2007)
8. Газрын тухай хууль (2002)
9. Төсвийн тухай хууль (2011)
10. Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хууль (2009)
11. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль (2012)
12. Байгалийн ургамлын тухай (1995)
13. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай (2012)
14. Эрүүгийн хууль (2015)

15. Ургамал хамгааллын тухай хууль (2007)
16. Аялал жуулчлалын тухай хууль (2000)
17. Хувиргасан амьд организмын тухай хууль (2007)
18. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай (2008)
19. Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль (2000)
20. Эрчим хүчний тухай хууль (2001)
21. Авилгын эсрэг хууль (2016)
22. Төсвийн ил тод байдлын тухай хууль (2014)
23. Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хууль (2001)
24. Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль (2012)
25. Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль (2011)
26. Татварын ерөнхий хууль (2008)
27. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль (2006)
28. Төрийн болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны тухай хууль (2005)
29. Шилэн дансны тухай хууль (2014)
30. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль (2012)
31. Төрийн хяналт шалгалтын тухай хууль (2003)
32. Засгийн газрын тусгай сангийн тухай хууль (2006)
33. Жендерийн тэгш байдлыг дэмжих тухай хууль (2011)
34. Захиргааны хууль (2016)
35. Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх тухай хууль (1995)
36. Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комиссын тухай хууль (2000)

<u>Дүрэм/Журам</u>

1. Ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээний ажлыг төлөвлөх, зохион байгуулах, санхүүжүүлэх, таримал ойг үнэлэх, улсын ойн санд худалдан авах, өмчлүүлэх журам (Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд, Сангийн сайдын хамтарсан тушаалаар батлагдсан, Дугаар А-96\71).

2. “Ойн дагалт баялгийг хамгаалах, зохистой ашиглах журам (БОАЖЯ-ны сайдын тушаалаар батлагдсан. 2016 он, Дугаар А\133)
3. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам (Засгийн газрын 2014 оны 14-р тогтоол)

Дараах бодлого болон 8 хуулийг дэвшүүлж буй 10 БАХ-ний хэрэгжилтээс учирч болзошгүй эрсдэл, гарах магадлалтай үр ашгийг зохицуулахад хамгийн өндөр ач холбогдолтой гэж үзсэн. Үүнд:

* Төрөөс ойн талаар баримтлах бодлого (2015)
* Ойн тухай хууль (2012)
* Газрын тухай хууль (2002)
* Байгаль орчныг хамгаалах тухай хууль (1995)
* Авлигын эсрэг хууль (2006)
* Төсвийн ил тод байдлын тухай хууль (2014)
* Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль (2011)
* Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль (2012)
* Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль (1994)

зэрэг болно.

ХАВСРАЛТ 3: БОДЛОГО, ХУУЛЬ, ЖУРМУУДЫН ҮНЭЛГЭЭ[8]

СНСЗ-уудыг Монголд хэрэгжүүлэх үүднээс СНСЗ-уудтай холбоотой БХЖ-уудыг үнэлж, тэдгээрт тусгагдаагүй болон цаашид сайжруулах асуудлыг тодорхойлох үнэлгээ хийсэн бөгөөд уг үнэлгээний ажлын явцаас хураангуйлан авч үзүүлэв. (2018 оны 4 сарын байдлаар)

ХАВСРАЛТ 3.1

Зарчим А: Үйл ажиллагаа нь үндэсний ойн хөтөлбөр, холбогдох олон улсын конвенц, гэрээ хэлэлцээрийн зорилгыг дэмжсэн, тэдгээрт нийцсэн байна.

Сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчмын элементүүд	**Гол үр ашиг, эрсдлүүд** Монгол оронд REDD+-ийн хүрээнд хэрэгжүүлэхээр санал болгосон бодлого, арга хэмжээнүүдийн үр ашиг, эрсдлийн үнэлгээнээс тодорхойлсоноор	**СНСЗ-уудыг тусгаж, хэрэгжүүлэхтэй холбоотой БХЖ-ууд** (СНСЗ-уудтай холбоотой БХЖ-ын үнэлгээнд тулгуурласан)	**Цаашид сайжруулах шаардлагатай асуудлууд** Тухайн СНСЗ-ыг Монгол улсын БХЖ-уудад илүү сайн тусгаж хэрэгжүүлэхийн тулд юуг сайжруулах ёстой талаар
Байгаль орчныг хамгаалах талаар олон улсын хэмжээнд хүлээсэн үүрэг амлалтуудад нийцсэн, үндэсний хэмжээнд мөрдөж байгаа биологийн олон янз байдлыг хамгаалах бодлогод хувь нэмэр оруулах (Үндэсний биологийн олон янз байдлын стратеги, Үйл ажиллагааны төлөвлөгөөг оруулаад) болон бусад байгаль	<u>Үр ашиг:</u> - Ойн экосистемийн үйлчилгээг бүрдүүлж, биологийн олон янз байдлын амьдрах орчин болон тэдний нүүдэл, шилжилтэнд ач тустай - Хүн ам, үйлдвэр, хөдөө аж ахуйн усан хангамж, нөөц нэмэгдэнэ - Байгалийн нөөцийн төлбөрийн орлого, зарцуулалт сайжирна. Байгаль хамгаалал, байгаль орчны менежментэд ач холбогдолтой - Хөрсний доройтол, цөлжилт багасаж хөрсний үржил шим, чийгшил сайжирна.	Рамсарын Конвенц, Усны тухай хууль (22.1 дэх заалт)-д усны нөөцийг хамгаалах онцгой болон, эрүүл ахуйн бүс тогтоохыг хуульчилсан. "Ус" үндэсний хөтөлбөр/УИХ-н 2010 оны 24-р тогтоолын хавсралт/-ийн 3.4.2 –т ус хамгаалах, нөөцлөх, хаягдал усыг дахин ашиглах санаачлагыг дэмжих зорилт дэвшүүлсэн байна. Биологийн олон янз байдлын үндэсний хөтөлбөр (Засгийн газрын 2015 оны 325 дугаар тогтоолын хавсралт) - ийн 4.4.5 дахь хэсэгт “ойн менежментийг сайжруулснаар монгол орны ойн ойрхог чанарыг 9 хувьд	Байгаль хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтийн санг тойрсон хуулийн заалтуудыг тодорхой болгож тус сангийн санхүүжилтийг орон нутгийн төсвөөс салгах шаардлагатай. Үүний тулд Байгаль орчныг хамгаалах тухай хууль болон Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах шаардлага гарна.

[8] Жич: Үнэлгээний хүснэгтийг бүрэн эхээр нь тусад нь Excel маягтаар боловсруулсан.

орчин, байгалийн нөөцийн менежментийн бодлогын зорилтуудад хувь нэмэр оруулна	- Хөрш орнуудтай ой болон байгаль орчны бусад асуудлаар хамтран ажиллах боломж нэмэгдэнэ. <u>Эрсдлүүд:</u> - Эко-системийн төлбөрийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор усны үнэ өсвөл хууль бусаар усны эх үүсвэр бий болгох явдал гарч, гүний усны ачаалал нэмэгдэх, усан цахилгаан станцын тоо (эко-системийн төлбөр бүрдүүлэхийн тулд) нэмэгдэх эрсдэлтэй - Ойн нөөцийг даацаас нь хэтрүүлэн (хэтрүүлж огтлох г.м) ашиглах эрсдэл үүсч болзошгүй. Энэ нь яваандаа нүүрстөрөгч, биологийн төрөл зүйл, экосистемийн үйлчилгээнд сөргөөр нөлөөлнө	хүргэж, түүний доторх биологийн олон янз байдлыг хамгаалах" зорилт дэвшүүлсэн. Тусгай хамгаалалттай газар нутгийн үндэсний хөтөлбөр НҮБ-ын Цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөр, Цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөр Ойн тухай хуулийн хэрэгжилтийг сайжруулах, хууль бус мод бэлтгэлтэй тэмцэх талаарх Санкт Петрбургийн тунхаг (1996).	
Үндэсний ойн хөтөлбөрүүдийн зорилтуудтай нийцсэн буюу тэдгээрийг нэмэн баяжуулсан байна.	Үр ашиг: - Ой дахь унанги, хатсан модны хэмжээ буурсанаар хөнөөлт шавжийн хэт олшролыг багасгах, гал түймрийн эрсдлийг бууруулах боломжтой - Ойн өсөлт, гарц нэмэгдэнэ. Нөгөө талаар ойн байгалийн сэргэн ургалт, ойжуулалт сайжирна - Хууль бус мод бэлтгэлтэй холбоотой гэмт хэрэг буурна - Ойн тогтвортой менежментийн талаархи олон нийт, иргэд, албан хаагчдын ойлголт болон тэдгээрийн чадавхи дээшилнэ	ТОтББ/2015 он/: 3.5.3-т “Эрдэм шинжилгээний байгууллага, их дээд сургуулийн дэргэд мод боловсруулах үйлдвэрлэлийн дэвшилтэт технологи боловсруулах, нэвтрүүлэх, дамжуулах нэгж, инкубаторын төв, өндөр технологийн жижиг дунд үйлдвэр байгуулахыг төрөөс дэмжих" гэж заасан. Энэ нь оролцогч талуудын болон салбарын чадавхийг бэхжүүлсэнээс үүдэх үр ашигтай холбоотой юм. 2014 онд батлагдсан Ойн цэвэрлэгээ хөтөлбөрийн 2.1 дэх хэсэгт "2.1.	Улсын төсвөөс хангалттай санхүүжилт хуваарилах замаар “Ойн цэвэрлэгээ” хөтөлбөрийг хэрэгжүүлж, ойн нөхөрлөлүүд ойн цэвэрлэгээнээс орлого олж, хямд үнээр өөр мод худалдан авах нөхцөл бүрдэнэ. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхийн тулд 14 тэрбум төгрөг шаардлагатай гэж тооцоолсон. (Ой дахь унанги, хатсан модны хэмжээ буурсанаар хөнөөлт шавжийн хэт олшрол багасах, ойн өсөлт/гарц

	- Хууль дүрмийн хэрэгжилтийн талаархи хяналт шалгалт, хууль сахиулалт хангагдана. Жнь, Ойн цэвэрлэгээ хөтөлбөр, хөнөөлт шавжтай тэмцэх, нөхөн сэргээлт, ил тод байдал сайжрах гэх мэт - Төрөл бүрийн модон бүтээгдэхүүн болон нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, нийлүүлэлт нэмэгдэнэ; гадаадаас модны импорт багасна. Эрсдлүүд: - ААНБ, нөхөрлөлүүдийн хооронд мод бэлтгэл, цэвэрлэгээтэй холбоотой маргаан зөрчил үүснэ - Ойн хөнөөлт шавжтай тэмцэх ажил үр ашиг муутай хэрэгжих, Төр засаг, болон хувийн хэвшлийн зүгээс (өөрсдийн эдийн засгийн ашиг сонирхлын хүрээнд) шавжтай тэмцэх төсвийг нэмэгдүүлэх сонирхол их байдаг - Шинээр ойн зам байгуулах нь ойд нэвтрэх боломжийг нэмэгдүүлж, улмаар хууль бус, тогтвортой бус мод бэлтгэл, ойн дагалт баялгийн хууль бус ашиглалтыг нэмэгдүүлэх эрсдэлтэй	Монгол орны ойг цэвэрлэж, Монгол орны ойг цэвэрлэж эрүүлжүүлэх, төлөв байдлыг сайжруулах, түймэр, хөнөөлт шавжийн хөнөөлөөс урьдчилан сэргийлэх, ойг нөхөн сэргээх, ойн цэвэрлэгээгээр гарсан модоор түлш, ахуйн хэрэгцээний тодорхой хэсгийг хангах, шахмал хавтан, шахмал түлш, барилгын материал болон бусад эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйлдвэрийг модон түүхий эдээр хангаж, модны ашиглалтын түвшинг дээшлүүлэх, ойн анги, ойн нөхөрлөл, ойн мэргэжлийн аж ахуйн нэгжийг чадавхжуулахад энэхүү хөтөлбөрийн зорилго оршино" гэж заасан (REDD+-ийг хэрэгжүүлсэнээр хөнөөлт шавьжны тархалт буурах үр ашигтай холбоотой) Ойн тухай хууль (2012 оны 5 сарын 17)-ийн 28 -р зүйлд ойн өсөлт бүтээмжийг нэмэгдүүлэх АЦО-г хийх, түүнийг санхүүжүүлэх заалт тусгагдсан (ойн өсөлт, бүтээмж нэмэгдэх үр ашигтай холбоотой).	нэмэгдэх, үндэсний ойн тулгуур бодлого, хөтөлбөрүүдэд REDD+ хөтөлбөрийн үзүүлэх дэмжлэгийн үндэсний СНСЗ-ыг тусгах зэрэг үр ашгийг сурталчлах) Хэдий тийм боловч, REDD+-ийн хүрээнд хэрэгжүүлэхээр санал болгосон БАХ-нүүд болон ойн цэвэрлэгээний хөтөлбөрийг бүрэн хэрэгжүүлэх нь эргээд урт хугацаанд нүүрстөрөгчийн шингээлттэй холбоотой болон бусад үр дүнд сөргөөр нөлөөлөх магадлалтай. (Жишээ нь: Унанги модыг ихээр огтлох нь биологийн төрөл зүйл болон экосистемийн үйлчилгээнд нөлөөлнө г.м). Төрөөс мод бэлтгэлийг цаашид хэт нэмэгдүүлсэнээр ямар үр дагавар гарч болох талаар баримт, нотолгоо цуглуулах шаардлагатай гэж үр ашиг, эрсдийн үнэлгээний явцад санал болгосон (ийм мэдээлэл олдохгүй бол үнэлгээ хийх шаардлагатай). Ингэснээр мод бэлтгэлийг нэмэгдүүлэх талаар илүү тодорхой ойлголттой болж мөн

			нүүрстөрөгчийн шингээлт болон бусад үр дүн, эрсдлийн талаар тодорхой мэдээлэлтэй болж улмаар монгол орны ойд тохирсон арга хэмжээг боловсруулахад дөхөм болно.
Тогтвортой хөгжлийн зорилтуудад нийцсэн, үндэсний хэмжээнд ядуурлыг бууруулахад хувь нэмэр оруулна.	Үр ашиг: - Тусгай хамгаалалттай газар нутагт болон эргэн тойронд амьдарч буй орон нутгийн иргэд болон аж ахуйн нэгжүүдийн амьжиргаа дээшилж, орлого нэмэгдэнэ (аялал жуулчлал, ойн модон бус бүтээгдэхүүн зэргээс) - Нөхөрлөлүүдийн материаллаг бааз суурь нэмэгдэж, орон нутгийн хөгжлийн санд дэмжлэг үзүүлнэ - Тодорхой бүс нутагт ойд түшиглэсэн эко аялал жуулчлал хөгжсөнөөр орон нутгийн иргэдийн амжиргаа дээшилж, орон нутгийн төсөвт орлого нэмэгдэнэ. - Орон нутгийн иргэд, ойн нөхөрлөл, ААНБ-ын ойн салбар, боловсруулах үйлдвэр, ойн дагалт баялаг ашиглах, аялал жуулчлалын салбарт ажил эрхлэлт нэмэглэж, орлого дээшилж, амьжиргаа сайжирна. - Сайжруулсан, эрчимжүүлсэн мал аж ахуй хөгжиж махны чанар, хүнсний аюулгүй байдал сайжирна - Орон нутагт орох хөрөнгө оруулалт нэмэгдсэнээр орон нутгийн иргэдийн амьжиргаа,	Ядуурлыг бууруулах үндэсний хөтөлбөр; Монгол Улсын Тогтвортой хөгжлийн хэтийн төлөв-2030 Энэ СНСЗ-тай холбоотой бусад БХЖ-ууд: -УИХ - ын 1998 оны 29 дүгээр тогтоолоор баталсан Тусгай хамгаалалттай нутгийн Үндэсний хөтөлбөр (1998 он) - ийн 3.5.3. тусгай хамгалалттай газар нутгийн орчны бүс нутгийг экологийн баримжаатай тогтвортой хөгжлийн загвар нутаг болгон хөгжүүлнэ" гэж заасан. Тусгай хамгаалалттай газрын орчны бүсийн тухай хуулийн (1997.10.23) 7-р зүйлд "7.1-д Зөвлөл нь тусгай хамгаалалттай газрын орчны бүсийг хөгжүүлэх, нутгийн иргэдийн ахуй амьдралыг дэмжих зорилго бүхий орчны бүсийн сан" байгуулах, "7.4.2-т нутгийн иргэдийн ахуй амьдралыг дэмжих, жижиг үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэхэд тусламж, дэмжлэг үзүүлэх, төсөл хэрэгжүүлэх" - д сангийн хөрөнгийг зарцуулахаар хуульчилсан (хамгаалалттай газар нутагт болон түүний эргэн тойронд байгаа нутгийн	Нөхөрлөлийн менежментийн орчны бүсийн зөвлөлийн дэмжлэгийг өргөжүүлж орлогын өөр эх үүсвэрийг (агро ойн аж ахуй, ХАА г.м) хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх санхүүжилтийн хэмжээг нэмэгдүүлэх (орон нутгийн иргэд болон аж ахуйн нэгжүүдэд Тогтвортой хөгжлийн зорилтууд болон бусад хөтөлбөрийн дэмжлэгийн хүрээнд) Ойн тухай хууль болон Газрын тухай хуульд байгаа ой бүхий газарт мал бэлчээхтэй холбоотой заалтууд нь хоорондоо зөрчилдөж байна. Дээрх хоёр хуулийг шинэчилж зулзган ой бүхий газарт мал бэлчээхийг хориглох шаардлагатай. Ойн нөхөрлөлүүдийг эко аялал жуулчлалын салбарт оролцуулж ажиллуулахыг зөвшөөрсөн заалтыг ойн тухай

	үйлчилгээ, дэд бүтэц сайжирч, эдийн засгийн бусад салбарыг хөгжүүлэх боломж бүрдэх ач холбогдолтой - Түлшний хэрэглээний хандлагыг сайжруулахад дэмжлэг болно. Үүнд: шахмал түлш, био түлш зэрэг бусад түлш орлох бүтээгдэхүүний хэрэглээ болон эрчим хүчний хэмнэлтийг сурталчлахад дөхөм болно <u>Эрсдлүүд:</u> - Бэлчээрийн менежментийг сайжруулж, хуурай газартай холбоотой БАХ-г хэрэгжүүлсэнээр бэлчээрийн газар хомсдож болзошгүй - Мод боловсруулахад зарцуулах эрчим хүчний хэрэглээ өснө - Шинэ төрлийн эрчим хүчний хэрэглээнд шилжихээс илүүтэй түлшний модны хэрэглээнд найдах явдал нэмэгдэнэ	иргэд, аж ахуйн нэгжүүдийн орлогыг нэмэгдүүлэх үр ашигтай холбоотой). Энэ нь Тусгай хамгаалалттай газар нутагт болон эргэн тойронд амьдарч буй орон нутгийн иргэд, аж ахуйн нэгжүүдийн орлогыг нэмэгдүүлэх үр ашигтай холбоотой. 1/. Байгаль орчныг хамгаалах тухай хууль (1995)- ийн 51-р зүйлд "1. Нөхөрлөл нь үйл ажиллагаагаа санхүүжүүлэх, гишүүддээ дэмжлэг үзүүлэх зорилгоор дундын сан байгуулж болно", "4. Дундын санг байгалийн нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх, ажлын байр бий болгох, нөхөрлөлийн гишүүдийн амьжиргааг дэмжих, байгалийн гамшигийн улмаас учирсан хохирлыг багасгах, нөхөрлөлийн гишүүдийн хурлаас тогтоосон бусад үйл ажиллагааг санхүүжүүлэхэд зарцуулна." гэж тус тус заасан. Энэ нь нөхөрлөлүүд болон орон нутгийг хөгжүүлэх сангийн материаллаг баазыг бэхжүүлэх үр ашигтай холбоотой. 1\. Ойн тухай хууль (2012) -д ойжуулсан, ойн үр бэлтгэх зориулалтаар тусгаарласан болон тарьц, суулгац ургуулсан мод үржүүлгийн талбайд мод бэлтгэх, мал бэлчээхийг хориглосон. Газрын тухай хууль (2002)-ийн 52-р зүйлд " 52.3. Ойн сан бүхий газрыг зохих хууль тогтоомжийн дагуу бэлчээрт ашиглаж болно" гэж	хуулийн холбогдох журманд шинээр тусгах хэрэгтэй.

		тусгагдсан. Тиймээс нөхөн сэргээлт хийх болон мал бэлчээхийг хязргаарласан талбайтай холбоотой зөрчил үүсэх эрсдэл байгааг эдгээр хуульд тусгаагүй байна.	
Уур амьсгалын өөрчлөлтийн чиглэлээр олон улсын өмнө хүлээсэн үүр амлалттай нийцсэн, уур амьсгалын өөрчлөлтийн талаарх (уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, түүнд дасан зохицох стратегийг хамруулсан) үндэсний зорилтод хувь нэмэр оруулна.	<u>Үр ашиг:</u> - Агро ойн аж ахуйг хөгжүүлсэнээр амьжиргааны эх үүсвэрийн төрөл нэмэгдэж, экосистемийн үйлчилгээ сайжирсанаар орон нутгийн иргэдийн уур амьсгалын өөрчлөлтийг даван туулах чадвар дээшилнэ. - Хөрсний доройтол, цөлжилт багасаж хөрсний үржил шим, чийгшил сайжирна. <u>Эрсдлүүд:</u> - Уур амьсгалын өөрчлөлт нь байгалийн аясаар сэргэн ургах боломжийг хязгаарлаж, хуурай газартай холбоотой БАХ-г хэрэгжүүлсэнээр дасан зохицох чадавхийг нэмэгдүүлэхэд оруулах хувь нэмрийг бууруулна. - Ойн нөөцийг даацаас нь хэтрүүлэн (хэтрүүлж огтлох г.м) ашиглах эрсдэл үүсч болзошгүй. Энэ нь яваандаа нүүрстөрөгч, биологийн төрөл зүйл, экосистемийн үйлчилгээнд сөргөөр нөлөөлнө	Уур амьсгаын өөрчлөлтийн үндэсний хөтөлбөр (УИХ- н 2011 оны 02 дугаар тогтоолын хавсралт) - н 3 дахь хэсэгт ой болон бусад ургамлын нөөцийг уур амьсгалын өөрчлөлтөд нийцүүлэн хамгаалах зорилтууд дэвшүүлсэн байна. Энэ нь уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, газрын доройтлыг бууруулах үр ашиг болон уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэн ой, мод бэлттгэл, нүүрс төрөгчийн шингээлт буурахтай холбоотой эрсдлүүдтэй хамаатай. Монгол Улсаас уур амьсгалын өөрчлөлтийг бууруулахад оруулах зорилтот хувь нэмэр (2016). Энэ СНСЗ-тай холбоотой өөр 2 БХЖ байна. Ойн тухай хууль,(2012.05.17) - н 30-р зүйлд"30.3. Тал хээр, говь цөлийн бүсийг ойжуулах, гол горхи, булаг шандын эх, бэлчээр тариалангийн талбайг хамгаалах зорилгоор ногоон зурвас байгуулах хөтөлбөр, төслийг улсын төсөв, бусад эх үүсвэрийн хөрөнгөөр хэрэгжүүлнэ" гэж хуульчилсан. ТОтББ-ын 3.2.4-р зүйлд ”Монгол оронд агро-ойн	Агро ойн аж ахуйн үйл ажиллагааг дэмжихэд зориулсан хөнгөлөлттэй зээлийн хөтөлбөр хэрэгжүүлэх хууль эрхзүйн орчин бий болгох шаардлагатай.

		аж ахуйн үндэс суурийг тавих" зорилт дэвшүүлсэн (энэ нь агро-ойн аж ахуйг хөгжүүлсэнээр нутгийн иргэдийн амьжиргаа, экосистемийн үйлчилгээ дээшлэх, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадварыг дээшлүүлэх үр ашигтай холбоотой).	
Олон улсын эрх зүйн баримт бичгийн дагуу хүлээсэн, Олон улсын хөдөлмөрийн байгууллагын 169 дүгээр тогтоол зэрэг хүний эрхийг хангахтай холбоотой тулгуур үүрэг амлалтад нийцсэн байна.	Үр ашиг: - Мод бэлтгэл, мод боловсруулах салбарт мөн мод модон эдлэл, агро ойн аж ахуйн бүтээгдэхүүн, дагалт баялийн ашиглалт, аялал жуулчлал зэргээс ажлын байр нэмэгдэж, орон нутгийн иргэд, аж ахуйн нэгж, ойн нөхөрлөлүүдийн орлого өснө - Мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний нэмүү өртгөөр бүтсэн үйлдвэрлэл нэмэгдсэнээр малчид тариаланчдын орлого амьжиргаа дээшлэнэ. - Ойд зам барих явцад ажлын байр нэмэгдэнэ мөн ойд зам тавьсанаар худалдаа үйлчилгээ эрхлэгч болон бусад хүмүүст эдийн засгийн эерэг үр нөлөө авчирч нийгмийн үйлчилгээ сайжирна. Эрсдлүүд: - Мал аж ахуйгаас шинэ амьжиргааны хэлбэрт шилжсэнээр уламжлалт нүүдлийн соёл алдагдана - Тусгай хамгаалалттай газар нутгийг тэлэх нь хөгжлийн бусад бодлоготой зөрчил үүсгэж уламжлалт амьдралын хэв маяг,	Монгол Улсын Үндсэн хууль Хүний эрхийн түгээмэл тунхаглал Үндэсний хүний эрхийн Комиссын тухай хууль Бусад ОУ-ын конвенцууд: - Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт (1966): - Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт (1966); Хүүхдийн эрхийн конвенц (1989); Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих олон улсын конвенц; Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль; Ажил олгох үйлчилгээ эрхэлж буй байгууллагуудын мөрдөх ёстой багц шаардлага байдаг (Му-ын Үндэсний стандарт: 6620). Энэ СНСЗ-тай холбоотой 2 өөр БХЖ байна. Тусгай хамгаалалттай газар нутгийг тэлэх нь уламжлалт амьдралын хэв маягт дарамт үүсгэх,	Нөхөрлөлийн менежментийн орчны бүсийн зөвлөлд өгөх дэмжлэгийг нэмэгдүүлж, орлогын өөр эх үүсвэрийг (агро ойн аж ахуй, ХАА г.м) хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх үндсэн хөрөнгийн хэмжээг ихэсгэх

	соёлын өв уламжлалд дарамт учруулж болзошгүй - Ой болон байгалийн нөөцийг ашиглах боломж буурах буюу баялгийг хүртэх боломж тэгш бус байх нь ойгоос хамаарч аж амьдралаа залгуулдаг зарим иргэдийн амьжиргаанд сөргөөр нөлөөлж болзошгүй (зөвшөөрөлтэй болон хууль бус мод бэлтгэл эрхэлдэг, ан хийдэг, ойн дагалт баялаг ашигладаг хүмүүс г.м.) - Нийтийн хэрэгцээний болон бэлчээрийн зориулалтаар ашиглах газрын хэмжээ багасах нь малчдын амьжиргаанд нөлөөлнө - Агро ойн аж ахуй нь бэлчээрийн мал аж ахуйгаас ашиг багатай байвал нутгийн иргэдийн амжиргаа доройтно -Иргэдэд экосистемийн үйлчилгээний шинэ төрлийн татварын дарамт нэмэгдэнэ	уламжлалыг хамгаалах зорилгоор Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн тухай хуулийг (1997) баталсан. Энэ нь тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээг тэлсэний улмаас уламжлал, соёлд сөрөг нөлөө учрах эрсдлийг бууруулахад чиглэсэн. Хэдий тийм боловч Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн УИХ-н бүрэн эрхийг тодорхойлсон 25 - р зүйлд " 2/ Засгийн газрын өргөн мэдүүлснээр газар нутгийг тусгай хамгаалалтад авах тухай шийдвэр гаргах, эдгээр газрыг улсын тусгай хамгаалалттай газар нутгийн тодорхой ангилалд хамааруулах, дархан цаазат болон байгалийн цогцолборт газрын хилийн заагийг батлах, өөрчлөх." гэж тусгагдсан	

ХАВСРАЛТ 3.2

Зарчим В: Хууль эрхзүй, бие даасан байдлыг харгалзан үзсэн ил тод, үр дүнтэй үндэсний ойн засаглалын бүтэцтэй байх

Сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчмын элементүүд	**Гол үр ашиг, эрсдлүүд** Монгол оронд REDD+-ийн хүрээнд хэрэгжүүлэхээр санал болгосон бодлого, арга хэмжээнүүдийн үр ашиг, эрсдлийн үнэлгээнээс тодорхойлсоноор	**СНСЗ-уудыг тусгаж, хэрэгжүүлэхтэй холбоотой БХЖ-ууд** (СНСЗ-уудтай холбоотой БХЖ-ын үнэлгээнд тулгуурласан)	**Цаашид сайжруулах шаардлагатай асуудлууд** Тухайн СНСЗ-ыг Монгол улсын БХЖ-уудад илүү сайн тусгаж хэрэгжүүлэхийн тулд юуг сайжруулах ёстой талаар
Хууль, тогтоомжийн хэрэгжилт	<u>Үр ашиг</u>: --Ой болон боловсруулах салбарын байгаль орчин, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны стандарт, журмууд сайжирна - Хууль сахиулах, хяналт шалгалт сайжирна. Хууль бус мод бэлтгэлтэй холбоотой гэмт хэрэг буурна (татвараас зайлсхийх, ангийн худалдаа, мансууруулах бодисын худалдаа гм.) - Мод, мөн ойн дагалт баялаг бэлтгэх, боловсруулахтай холбоотой журмуудыг сайжруулах боломж бүрдэнэ - Ойн цэвэрлэгээ хөтөлбөр, хортон шавж устгах, ойг нөхөн сэргээхтэй холбоотой хөтөлбөрүүдийн хяналт сайжирч, ил тод байдал дээшилнэ. <u>Эрсдлүүд:</u> - Ойн нөхөрлөл, иргэдийн чадавхийг бий болгох, бэхжүүлэх, үйл ажиллагааг нь хянах, хуулийн	Захиргааны ерөнхий хууль (2015) нь төрийн байгууллага, албан тушаалтнуудыг шинээр гаргасан шийдвэрийн талаар сонсгол хийх, уг шийдвэрийн нөлөөнд өртсөн иргэдийн санл бодлыг сонсож байх тухай шинэ журмыг тусгасан. Хэдий ийм заалттай боловч төрийн байгууллагууд зарим нөхцөлд талуудын саналыг төлөвлөгөөндөө заавал тусгаж, өөрчлөх албагүй гэж заасан байна. Мөн уг хуулиар төрийн байгууллагуудыг хоорондоо бичгээр санал солилцож мэргэжлийн туслалцаа авах боломжийг бүрдүүлсэн нь төрийн байгууллагуудын хоорондын харилцааг сайжруулах алхам болсон. Хуульд санал, зөөвлөмж өгөх хугацаа, тодорхой журмын талаар санал хүргүүлэх, асуудал шийдвэрлэх, шийдвэр гаргахад төр ба иргэний гүйцэтгэх үүрэг,	Төрийн хяналт шалгалтын тухай хууль болон Зөрчлийн тухай хуульд хяналт шалгалтыг Улсын мэргэжлийн хяналтын байгууллага хэрэгжүүлнэ гэж заасан. Мөн торгууль, төлбөр ногдуулах эрхтэй гэсэн байна. ИНБ-ууд зөвхөн хяналт тавихад оролцох үүрэгтэй юу?

	хэрэгжилтийг хангах, байгаль хамгаалах зардал нэмэгдэнэ - Нөхөн сэргээлт хийх болон мал бэлчээхийг хязргаарласан талбайтай холбоотой зөрчил үүсэх -Эко-системийн төлбөрийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор усны хууль бус/тогтворгүй хэрэглээ нэмэгдэх, жишээ нь гүний усны ачаалал нэмэгдэх, усан цахилгаан станцын тоо нэмэгдэх эрсдэлтэй - Унанги модыг ашиглахын тулд санаатайгаар гал тавих зөрчил гарч болзошгүй. Цэрэг, цагдаагийн ангиуд өөрсдийнхөө хэрэгцээнд зориулж мод бэлтгэх, ан агнах явдал ихсэнэ. Аялал жуучлалын газруудад ойн баялагаас нийлүүлэх Санаачилсан ажлуудыг хэрэгжүүлэх мэргэшсэн төрийн албан хаагчдын ажлын байр тогтворгүй байх эрсдэлтэй	шийдвэрийн талаар мэлээлэх арга хэрэгсэл зэргийг зааж өгөх замаар төр, олон нийтийн эрх зүйн харилцааг хуульчилж өгсөн байна. Зөрчлийн тухай хууль 2003 оны Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 9.3.1-р заалтад “Мэргэжлийн хяналтын байгууллага нь хуульд заасны дагуу хууль тогтоомж болон нийтээр дагаж мөрдөх эрх зүйн бусад актын биелэлтэд хяналт тавих" гэж тусгагдсан. Байгаль орчныг хамгаалах тухай хууль (1995 он) 26 -р зүйлд "2. Хил, гааль, мал эмнэлэг, эрүүл ахуй, халдвар судлал, уул уурхайн зэрэг хяналтын байцаагч буюу хуульд зааснаар энэхүү хяналтыг хэрэгжүүлэх үүрэг бүхий ажилтанд байгаль орчны улсын байцаагчийн эрх олгож, хяналтын үүрэг гүйцэтгүүлж болно." гэж тусгагдсан	

Байгууллагын эрх үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай нөөц, чадавх/хүний нөөц, боловсон хүчний туршлага чадвар/	Үр ашиг: - Аж ахуйн нэгжээс авах татвар, мод бэлтгэлийн төлбөр, түлшний мод бэлтгэх зөвшөөрлийн хураамж зэргээс орон нутгийн төсөвт орох орлогог нэмэгдэнэ - Хөрөнгө оруулалтаар нөхөрлөлийн материаллаг бааз суурь нэмэгдэж, улмаар орон нутгийн хөгжлийн санд дэмжлэг үзүүлнэ - Эко аялал жуулчлалаас орох орлогоос ой болон эко- системийн менежментэд илүү зарцуулдаг болно -Байгалийн баялаг ашигласны төлбөрийн орлого, зарцуулалт сайжирна. Байгаль хамгаалал, байгаль орчны менежментэд ач холбогдолтой - Салбар хоорондын (төр, хувийн хэвшил, нөхөрлөлүүд) болон төрийн агентлагуудын (ой, ХАА, газрын менежментийн нэгж, хууль сахиулах байгууллага) хамтын ажиллагаа сайжирна - Ойн цэвэрлэгээ, менежмент, тогтвортой ашиглалт сайжирсанаар түймэр хөнөөлт шавжийн эрсдэл буурч, ойн замтай болсоноор түймрийг унтраах, хөнөөлт шавжтай тэмцэх ажил үр дүнтэй болно Эрсдлүүд: - Ойн нөхөрлөл, иргэдийн чадавхийг бий болгох, бэхжүүлэх, үйл ажиллагааг нь хянах, хуулийн хэрэгжилтийг хангах, байгаль хамгаалах зардал нэмэгдэнэ.	Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль (2012 он) -н 13 -р зүйлд байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах хөрөнгө нь байгалийн нөөц ашигласны төлбөрөөс олсон нийт орлоготой тэнцүү байна гэсэн байна. Мөн 13.4-т “ Энэ хуулийн 13.1-т заасан төлбөрийн орлогоор санхүүжүүлж хэрэгжүүлэх байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээний төлөвлөгөөг Засаг даргын өргөн мэдүүлснээр аймаг, нийслэл, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал батална." гэж тусгасан 2012 онд батлагдсан Ойн тухай хуулийн хэд хэдэн заалтад нөхөн сэргээлтийн ажлыг хэрхэн санхүүжүүлэх тухай заасан байна Мөн уг хуулийн 30.3-т “Тал хээр, говь, цөлийн бүсийг ойжуулах, гол, горхи, булаг, шандын эх, бэлчээр, тариалангийн талбайг хамгаалах зорилгоор ногоон зурвас байгуулах хөтөлбөр, төслийг улсын төсөв, бусад эх үүсвэрийн хөрөнгөөр хэрэгжүүлнэ." гэж тусгагдсан бол 28-р зүйлд арилжааны огтлолтой холбоотой арга хэмжээ, ойн өсөлт бүтээмжийг нэмэгдүүлэх санхүүжилтийн талаар заасан. Хуулийн 4.2 болон 39.4 дэхь хэсэгт	Байгаль хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтийн санг тойрсон хуулийн заалтуудыг тодорхой болгож тус сангийн санхүүжилтийг орон нутгийн төсвөөс салгах шаардлагатай. Үүний тулд Байгаль орчныг хамгаалах тухай хууль болон Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах шаардлага гарна. Байгалийн нөөцийн төлбөрийн тухай хуульд хуримтлагдсан төлбөрийн орлогыг байгаль хамгаалах үйл ажиллагаанд зарцуулаагүй албан тушаалтнуудад оноох хариуцлагын талаарх заалт нэмж оруулах шаардлагатай. Тиймээс олон төрлийн үрээр тарьсан таримал ойг тодорхой хугацаа өнгөрсний дараа улс, хувийн хэвшлээс баталгаатай худалдаж авах боломжийг бүрдүүлэх тухай заалтыг дараах журамд оруулахыг зөвлөж байна**:** Ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээний ажлыг төлөвлөх, зохион байгуулах,

	- Улсын болон орон нутгийн төсөвт ачаалал бий болно. Байгальд ээлтэй аргаар хөнөөлт шавжтай тэмцэх, нөхөн сэргээлт хийх, зам арчлах, хамгаалах, эргүүл хийх, багаж тоног төхөөрөмж - Дэд бүтэц тааруу, алслагдсан газарт хөрөнгө оруулалт шаардлатай тул зарим БАХ-г хэрэгжүүлэхэд зардал их гарна - Мэргэжлийн төрийн албан хаагчийн тогтворгүй байдал сөргөөр нөлөөлнө	сэргэн ургалтыг дэмжих, санхүүжилт олгох тухай заасан бөгөөд одоогийн байдлаар (i) “иргэд болон байгууллагууд өөрийн хөрөнгөөр зориудаар тарьж ургуулсан ой модыг өмчилж болно" мөн (ii) иргэд болон байгууллагууд тарьсан таримал ойг төрөөс худалдан авна” гэсэн хоёр сонголт байна. Гэхдээ хувийн хэвшлийг өргөн цар хүрээтэй нөхөн сэргээлтэд оролцуулахыг дэмжих тухай заалт үгүйлэгдэж байна. Төрийн албаны тухай хууль (2002 он) - н 4-р зүйлд "4.2.5.төрийн алба мэргэшсэн, тогтвортой байх; 4.2.6.төрийн албан хаагчаас бүрэн эрхээ хэрэгжүүлэх нөхцөл, баталгааг төр хангах;" гэж тусгагдсан. Энэ нь тухайн хууль, журмыг хэрэгжүүлэх мэргэшсэн албан хаагчдын ажиллах хугацаа, ажлын байр хангалтгүй байх эрсдэлтэй холбоотой. Тусгай хамгаалалттай газар нутгийн санхүүжилтийн талаар тусгасан 2 БХЖ байна. Тусгай хамгаалалттай газрын орчны бүсийн тухай хуулийн (1997.10.23) 7-р зүйлд "7.1-д Зөвлөл нь тусгай хамгаалалттай газрын орчны бүсийг хөгжүүлэх, нутгийн иргэдийн ахуй амьдралыг дэмжих зорилго бүхий орчны бүсийн сан"	санхүүжүүлэх, таримал ойг үнэлэх, улсын ойн санд худалдан авах, өмчлүүлэх журам (Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд, Сангийн сайдын хамтарсан тушаалаар батлагдсан, Дугаар А-96\71). Үүнээс гадна, байгалийн сэргэн ургалт илүү сайн газрыг сонгон үйл ажиллагаа явуулах замаар төсвийн ачааллыг бууруулах тухай заалт бүхий шинэ журам боловсруулах нь зүйтэй.

		байгуулах талаар заасан. Тусгай хамгаалалттай хамгаалалттай газар нутгийн тухай хууль (1994 он)- н 6-р зүйлд ТХГН-н санхүүжилтийн эх үүсвэр нь "1/. улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт;2/ аялал, жуулчлалын болон бусад ажил, үйлчилгээний орлого;3/ иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хандив, тусламж; 4/ тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдийн учруулсан хохирлын нөхөн төлбөрийн орлого." байхаар тусгагдсан байна.	
Ойн менежментийн төлөвлөгөө болон мэдээлэл цуглуулах ажлыг зохих ёсоор гүйцэтгэх институцын чадавхи	<u>Үр ашиг:</u> -Ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, нутгийн иргэд, албан хаагчдын ойн менежмент, мод боловсруулах, тогтвортой ашиглах, нөхөн сэргээлт хийх, хамгаалах, дагалт баялаг ашиглах талаарх мэдлэг, ур чадвар сайжирна - Шинэ техник, технологи нэвтрүүлж шинэ чадвар эзэмшсэнээр ойн тогтвортой менежмент, нөхөн сэргээлтийг (тэр дундаа заган ойн) хэрэгжүүлэх чадавх сайжирч, ой эзэмшигч нөхөрлөлүүд болон ойн ангийн хамтын ажиллагааны ур чадвар, хүний нөөцийн чадавх дээшилнэ - Ойн цэвэрлэгээ хөтөлбөр зэрэг	Менежментийн төлөвлөгөө боловсруулах эрх, ойн нөхөрлөлүүдийн эрхийн талаар Ойн тухай хуулийн (2012) 13.1.27-д заасан. Мөн тус хуулийн 3.1.6-д “ойн менежментийн төлөвлөгөө" гэж тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж дэх, эсхүл эзэмшлийн ойг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээхэд чиглэгдсэн ойн аж ахуйн арга хэмжээний хүрээнд гүйцэтгэх ажлыг цогц байдлаар, тодорхой үе шаттайгаар тусгаж, төлөвлөсөн баримт бичгийг хэлнэ” гэж заасан байна. Ойн тухай хуульд ойн менежментийн төлөвлөгөө дараах 5 төрөл байна гэжээ. Үүнд: 1. Улсын ойн менежментийн төлөвлөгөө. 2.	Ойн мэргэжлийн байгууллагуудыг гэрчилгээжүүлэх үндэсний стандарыг тусгай журам гарган бий болгох шаардлагатай. Ойн нөхөрлөлүүдийг ойн менежмент болон нөөцийн ашиглалтын үйл ажиллагаанд оролцуулах зөвлөмж мөн үүнтэй хамаатай. Ойн тухай хуулийг шинэчилж орон нутгийн иргэдийг ойн хяналт болон эргүүлд оролцуулах боломж бүрдүүлэх шаардлагатай. Дараах заалтуудыг

	суурь хөтөлбөрүүд болон хөнөөлт шавжтай тэмцэх, нөхөн сэргээлтийн хяналт, хэрэгжилт сайжирч ил тод байдал хангагдана - Оролцогч талуудын оролцоо, төсөв нэмэгдсэнээр засаглал, ойн салбарын үйл ажиллагааны ил тод байдал, хяналтын бүтэц (тухайлбал, хөнөөлт шавжтай тэмцэх, нөхөн сэргээлт, эргүүл, ТХГН-ын менежмент) сайжирна. Төсвийг зориулалтын бус зарцуулалтыг цаг алдалгүй илрүүлж, таслан зогсоох боломж бүрдэнэ - Гэрчилгээ авсан компаниуд болон гэрчилгээ олгох үзүүлэлтийн талаарх мэдээллийн сан бий болно - Ойн үрийн бүсчлэлийг тогтоосноор ойн нөхөн сэргээлтийн ажлын үр дүн сайжирна - Байгаль орчны менежмент, байгаль хамгаалах үйл ажиллагааны санхүүжилт, хөрөнгө нэмэгдэнэ <u>Эрсдлүүд</u>: - Ойн нөөцийг даацаас нь хэтрүүлж ашиглах (хэт их сийрэгжүүлэх, мод, түлшний мод болон дагалт баялгийг хэт их бэлтгэх г.м) нь ойн дороитолд хүргэж нүүрстөрөгчийн хуримтлал, экосистемийн үйлчилгээ, биологийн төрөл зүйлд сөргөөр нөлөөлнө. Мод бэлтгэлийн бааз, ойн зам зэрэг нь биологийн төрөл зүйлд сөргөөр нөлөөлнө	Аймаг, нийслэлийн ойн менежментийн төлөвлөгөө. 3. Сум, дүүргийн ойн менежментийн төлөвлөгөө. 4. Ойг гэрээгээр эзэмшиж байгаа аж ахуйн нэгжүүдийн ойн менежментийн төлөвлөгөө. 5. Ойн нөхөрлөлүүдийн ойн менежментийн төлөвлөгөө. Төлөвлөгөөг (5 түвшний) шат шатны байгууллагаас эрх бүхий байгууллагын дэмжлэгтэйгээр боловсруулах бөгөөд төлөвлөгөөний төрлөөс хамаарч өөр өөр байдлаар батлана. 2015 оны ТОтББ-ын 3.3.1-р заалтад уг бодлогын үндсэн зорилгын нэг нь Монгол улсын ойн өнөөгийн нөхцөл байдалд нарийвчилсан үнэлгээ хийж ой хамгаалал, нөхөн сэргээлт ба зохистой хэрэглээний зориулалтаар тогтвортой ойн менежмент бий болгох гэж заасан (нотлох баримт дээр тулгуурлан төлөвлөлт хийх суурийг бүрдүүлж өгнө) гэж заасан. Энэ нь үнэлгээ, нотолгоонд суурилах, ойн тогтвортой менежментийн чадавхийг сайжруулах замаар ойн нөөцийг тогтвортой ашиглахтай холбоотой үр ашгийг бий болгох суурийг бүрдүүлж өгсөн. Мөн ТОтББ-ын 3.3.7-т “олон улсын жишигт нийцсэн ойн мэргэжлийн байгууллагын итгэмжлэлийн	анхааралдаа авах: (а) Орон нутгийн иргэдэд түшиглэсэн хяналтыг сайжруулж, мэдээлэл өгсөн тохиолдолд урамшуулал олгох систем бий болгох; (б) мод бэлтгэлийн хяналтад иргэний нийгмийн болон бусад оролцогч талуудын (жишээ нь судлаачид) оролцоог хангах; (в) Шалгалт явуулахад иргэний нийгмийн оролцоог хангах.

	- Ойн зам баригдаж ойд нэвтрэх боломж нэмэгдсэнээр тогтвортой бус, хууль бус ан агнуур, дагалт баялгийн хэт ашиглалт ихсэнэ - Хяналтын тогтолцоо сул байснаас үр дүн муутай арга хэмжээнд үргүй зардал гаргаж болзошгүй, жишээ нь ойн хөнөөлт шавьжтай тэмцэх ажил хангалтгүй, ойжуулсан заган талбайн арчилгаа дутмаг г.м - Тодорхой бүс нутаг эсвэл ойн төрөлд агро ойн аж ахуйн загвар сайн тохирохгүйн улмаас жигд хамрагдахгүй, хэрэгжихгүй байх эсвэл тогтвортой байдал дутагдаж болно	үндэсний стандартыг бий болгож, 2020 он гэхэд ойн нөөцийг зөвхөн итгэмжлэл авсан аж ахуйн нэгж, байгууллага ашигладаг тогтолцоонд шилжих" гэж тусгагдсан (мэдээллийн сан бий болгох үр ашигтай холбогдоно). Энэ нь ойн тогтвортой менежментийн чадавхийг хангалттай бүрдүүлэх тухай ойлголттой холбоотой, мөн ойн нөхөрлөл болон бизнесийн бус үйл ажиллагаа явуулдаг нэгжүүд, мэргэжлийн байгууллагуудад ойн менежментийн болон байгалийн нөөцийг ашиглах үйл ажиллагаанд оролцоход нь тулгарч болох бэрхшээлийн талаар тусгасан байна. Ойн салбарын чадавхыг бэхжүүлэх, сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэхтэй холбоотой хэд хэдэн БХЖ байна. Ойн нөхөрлөл болон нутгийн иргэдийн чадавхийг бэхжүүлэх талаар СНСЗ D-ийн хүрээнд нарийвчлан хэлэлцсэн. ТоТББ (2015)-ын 3.5.4-т “ойн мэргэжлийн их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн материаллаг баазыг бэхжүүлэх, багш нарын чадавхыг дээшлүүлэх ажилд бүх талын дэмжлэг, туслалцаа үзүүлэх, улмаар ойн мэргэжилтэн, мэргэжлийн ажилтан, ажилчин бэлтгэх шаталсан сургалттай тогтолцоо бий болгох” гэж заасан байна. Ойн цэвэрлэгээ	

		хөтөлбөр (2014)-ийн 3.3.3-т “ойн цэвэрлэгээний ажлыг гардан гүйцэтгэх менежер, мэргэжлийн ажилчин бэлтгэх, давтан сургах” талаар мөн хөтөлбөрийн 5.7-д “Ойн судалгаа, хөгжлийн төв” улсын төсөвт үйлдвэрийн газар “Ойн цэвэрлэгээ” хөтөлбөртэй холбоотой хууль тогтоомж, түүний хэрэгжилтийг сурталчлах, нутгийн захиргааны удирдлагуудад тодорхой мэдлэг эзэмшүүлэх ажлыг зохион байгуулна” гэж тус тус заажээ.	
Авилгын эрсдэл	<u>Үр ашиг:</u> - Өөр өөр салбарын төрийн байгууллагуудын хамтын ажиллагаа сайжирна (ой, газар, хөдөө аж ахуй г.м) - Мод бэлтгэх боломж нэмэгдэх, нутгийн иргэд, төрийн байгууллага, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа сайжирсанаар хувийн хэвшлийн салбарыг дэмжихэд ойн салбарын гүйцэтгэх үүрэг дээшилнэ. - Улсын төсвийн орлого, зарлагын талаарх иргэд, иргэний нийгмийн байгууллагуудын мэдлэг сайжирна. <u>Эрсдлүүд:</u> - Төрийн захиргааны шат бүрт авилга гарах (тендер шалгаруулах үйл явцад, талбай сонгоход, эрх мэдлээ хэтрүүлэн ашиглах, төсвийн хөрөнгийг зүй бусаар зарцуулах г.м)	2006 оны Авилгын эсрэг хуулийн 27-р зүйлийн 27.1-р заалтад “Авлигатай тэмцэхэд олон нийтийг идэвхтэй оролцуулах, тэдний санал бодлыг хүргэх, авлигын нөхцөл байдал, авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар зөвлөмж өгөх зорилго бүхий орон тооны бус олон нийтийн зөвлөл Авлигатай тэмцэх газрын дэргэд ажиллана” гэж заасан. 2005 оны Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай (цаашид "ТбОНӨХБАҮХАТХууль" гэх) хуулийн- н 6.1-р заалтад "Худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална" гэж	(i) ТбОНӨХБАҮХАТ Хуулинд тендерийн шалгуурыг ил тод болгох тухай заалт оруулах шаардлагатай. (ii) Тендерийн явцад хүний оролцоог аль болох багасгахын тулд програм хангамж боловсруулах шаардлагатай. (iii) Иргэний нийгмийг ойн нөхөн сэргээх үйл ажиллагаа болон хяналтад оролцуулан авилгатай тэмцэж болно. Энэ асуудлыг Ойн тухай хуулинд тусгаж өгөх шаардлагай байж болзошгүй. (iv) ТбОНӨХБАҮХАТ Хуулийн зохицуулалтыг шинэчилж тендерийн материалууд орон нутгийн

	- Ойн нөөцийг хэт ашиглах эрсдэл, жишээ нь орон нутгийн иргэд, төрийн байгууллага тогтвортой мод бэлтгэлийн зохистой хэмжээг тооцож үзэхгүйгээр зөвшөөрөл олгох, өрхийн хэрэгцээний модны зөвшөөрлөө өөрөөр ашиглах г.м - Монголын болон хөрш орнуудын цэрэг, цагдаагийн байгууллагуудын дунд авилга нэмэгдэх - Аж ахуйн нэгж, ойн нөхөрлөлүүдийн дунд ойн нөөцийн хэт ашиглалттай холбоотой зөрчил, нутгийн иргэдийн зүгээс ойн нөөцийг ашиглах боломж, ашиглалттай гомдол, зөрчил үүснэ - Усан хангамж, ой хамгаалах, нөхөн сэргээлт хийхэд зориулж төлөвлөсөн газрыг ашиглах хүсэлтэй малчид маргаан, зөрчил үүсгэж болзошгүй. Бэлчээрийн менежментийг сайжруулах, хуурай газартай холбоотой БАХ-г хэрэгжүүлсэнээр бэлчээрийн газар хомсдож, одоогийн бэлчээрийн зохион байгуулалттай зөрчилдөж болзошгүй. - Аж нэгжүүд нутгийн иргэдийг үйл ажиллагаандаа оролцуулахгүй байсаны улмаас орон нутгийн иргэдийн цаашид орлого олох боломж хумигдана. - Монополь бий болж орон нутгийн бизнесийн үйл ажиллагаа, жижиг аж ахуйн нэгжүүд шахагдана. Технологийн зардлаас хамааараад	заасан. Мөн тус хуулийн 28.3-т “Шаардлагад нийцсэн тендерүүдийг үнэлэх үндсэн шалгуур нь тендерийн үнэ байна” гэсэн бол 28.4 дэхь заалтад “Захиалагч худалдан авах зөвлөхийн үйлчилгээнээс бусад бараа, ажил, үйлчилгээний онцлогийг харгалзан өөрийн эдийн засгийн үр ашигт нөлөөлөх дор дурдсан хүчин зүйлсээс аль тохирохыг сонгож, мөнгөөр илэрхийлэн тендерийн үнэ дээр нэмж харгалзан тооцож болно: 28.4.1.ажил, үйлчилгээ дуусгах, бараа хүргэх хугацаа; 28.4.2.урсгал зардал, эсхүл зардал болон үр ашгийн тооцоо; 28.4.3.борлуулалтын дараах үйлчилгээ, техникийн туслалцаа; 28.4.4.сэлбэг хэрэгсэл нийлүүлэх болон үнийн талаар гаргах баталгаа; 28.4.5.бараа, ажил, үйлчилгээний чанар, техникийн үзүүлэлт; 28.4.6.энэ хуульд нийцсэн бусад шалгуур үзүүлэлт” гэж заасан байна. Энэ СНСЗ-тай холбоотой өөр БХЖ-ууд байдаг. Тухайлбал 2003 оны Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 9.3.1-р заалтад “Мэргэжлийн хяналтын байгууллага нь хуульд заасны дагуу хууль тогтоомж болон нийтээр дагаж	иргэд болон ойн нөхөрлөлүүдийг заавал оролцуулах тухай заалт оруулах хэрэгтэй.

	жижиг үйлдвэрлэл (өрхийн үйлдвэрлэл г.м)-д бэрхшээл тулгарна.	мөрдөх эрх зүйн бусад актын биелэлтэд хяналт тавих" гэж тусгагдсан. Мөн төрийн өндөр албан тушаалтнуудын эрх үүргийг зохицуулсан хууль хэрэгжиж байна. Энэ хууль нь улс төрийн болон захиргааны албан тушаалтнууд, төрийн болон орон нутгийн өмчид аж ахуйн нэгжийн удирдлага, Үндэсний зөвлөлийн дарга, үндэсний радио, телевизийн захирал, Засгийн газрын нэрийн өмнө ажил гүйцэтгэж байгаа ТББ-ын удирдлага, сонгуульд нэр дэвшигчдэд хамаарна. Төрийн албан тушаалтнуудыг дараах үйлдэл гаргахыг хориглоно. Үүнд: - Албан үүргээ гүйцэтгэж байх хугацаандаа төрийн албан хаагчдад дарамт учруулах, ажилд нь хөндлөнгөөс нөлөөлөх, - Бусдад болон зуучлагч талд шан харамж өгөх, санал болгох - Иргэн, аж ахуйн нэгжид хууль бусаар давуу тал олгох, амлах - Албан үүргээ гүйцэтгэж байх хугацаандаа бусдыг хууль ёсны эрхээ эдлэхэд нь саад учруулах, - Улсын төсөв, хандивын орлогыг зүй бусаар ашиглах - Албан үүргээ гүйцэтгэснийхээ төлөө бусдаас шан харамж шаардах,	

		- Албан тушаалаа урвуулан ашиглах, эрхээ хэтрүүлэх - Өмч хөрөнгө олж авах, өөртөө давуу тал бий болгохын тулд албан тушаалаа урвуулан ашиглах - Хууль бусаар хөрөнгөжих зэрэг болно.	
Ил тод, үр дүнтэй ойн засаглалыг дэмжихэд чиглэсэн үндэсний болон орон нутгийн хэмжээнд хэрэгжиж байгаа бодлого, зохицуулалтууд нь хоорондоо уялдаа холбоо сайтай байх	<u>Үр ашиг:</u> - Тогтвортой ойн менежментийн хууль эрх зүй, төлөвлөлтийн орчин, менежментийн төлөвлөгөөний хэрэгжилт сайжирна -- Өөр өөр салбарын төрийн байгууллагуудын хамтын ажиллагаа сайжирна (ой, газар, хөдөө аж ахуй г.м) - Эрчим хүчний бодлогын хэрэгжилт сайжирч, ой, эрчим хүчний салбарын хамтын ажиллагаа дээшилнэ. <u>Эрсдлүүд:</u> - Ойн нөөцийг даацаас нь хэтрүүлэн (хэтрүүлж огтлох г.м) ашиглах эрсдэл үүсч болзошгүй. Энэ нь яваандаа нүүрстөрөгч, биологийн төрөл зүйл, экосисиемийн үйлчилгээнд сөргөөр нөлөөлнө - Нөхөн сэргээлт хийх болон мал бэлчээхийг хязргаарласан талбайг малын бэлчээрт ашиглах сонирхолтой малчдын зүгээс гомдол, зөрчил гарна - Ойн нөхөн сэргээлт, дэд бүтэц бий болгохтой холбоотойгоор улсын төсөвт ачаалал нэмэгдэнэ.	Захиргааны ерөнхий хууль (2015) нь төрийн байгууллага, албан тушаалтнуудыг шинээр гаргасан шийдвэрийн талаар сонсгол хийх, уг шийдвэрийн нөлөөнд өртсөн иргэдийн санл бодлыг сонсож байх тухай шинэ журмыг тусгасан. Хэдий ийм заалттай боловч төрийн байгууллагууд зарим нөхцөлд талуудын саналыг төлөвлөгөөндөө заавал тусгаж, өөрчлөх албагүй гэж заасан байна. Мөн уг хуулиар төрийн байгууллагуудыг хоорондоо бичгээр санал солилцож мэргэжлийн туслалцаа авах боломжийг бүрдүүлсэн нь төрийн байгууллагуудын хоорондын харилцааг сайжруулах алхам болсон. Ойн тухай хуулийн (2012) 3.1.6-д “ойн менежментийн төлөвлөгөө" гэж тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж дэх, эсхүл эзэмшлийн ойг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээхэд чиглэгдсэн ойн аж ахуйн арга	Ойн тухай хууль болон Газрын тухай хуульд байгаа ой бүхий газарт мал бэлчээхтэй холбоотой заалтууд нь хоорондоо зөрчилдөж байна. Дээрх хоёр хуулийг шинэчилж зулзаган ой бүхий газарт мал бэлчээхийг хориглох шаардлагатай.

	- Салбар хоорондын хамтын ажиллагаа нэмэгдсэний улмаас алслагдсан, орон нутгийн зардал, төсвийн ачаалал нэмэгдэнэ. - Мэргэшсэн төрийн албан хаагчийн ажлын байрны тогтворгүй байдал сөргөөр нөлөөлнө	хэмжээний хүрээнд гүйцэтгэх ажлыг цогц байдлаар, тодорхой үе шаттайгаар тусгаж, төлөвлөсөн баримт бичгийг хэлнэ" гэж заасан байна. Одоогоор мөрдөж байгаа БХЖ-ууд нь салбар дундын хамтын ажиллагаа, уялдаатай байдлыг хангаж чадаагүй. Ялангуяа ойн болон газрын тухай хуульд хоорондоо таарахгүй зөрчилтэй заалт бий. Ойн тухай хууль (2012) -д ойжуулсан, ойн үр бэлтгэх зориулалтаар тусгаарласан болон тарьц, суулгац ургуулсан мод үржүүлгийн талбайд мод бэлтгэх, мал бэлчээхийг хориглосон. Газрын тухай хууль (2002)-ийн 52-р зүйлд " 52.3. Ойн сан бүхий газрыг зохих хууль тогтоомжийн дагуу бэлчээрт ашиглаж болно" гэж заасан.	
Хариуцлагатай байдал	<u>Үр ашиг</u>: - Ойн нөхөрлөлүүдийн гал түймэр, хортон шавжтай тэмцэх ажилд оролцох оролцоо нь сайжирна - Мод бэлтгэл, боловсруулах үйл ажиллагааны үр дүнд (орон нутгийн иргэд, малчид, аж ахуйн нэгжүүд, ойн нөхөрлөлүүдийн) ажлын байр, орлого нэмэгдэнэ - Гэрчилгээжүүлэлт, ойн менежментийн үйл ажиллагааны	Төрөөс ойн талаар баримтлах бодлогын 2.2-т ТоТББ-ыг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална гэж заажээ. Үүнд: 2.2.1.ойн нөхөн сэргээлт, ойжуулалтын хэмжээг өсгөх замаар ойгоор бүрхэгдсэн талбайг нэмэгдүүлэх; 2.2.2.ойн биологийн олон янз байдлыг хадгалах, хамгаалах; 2.2.3.ойн эрүүл ахуй,	Ойн нөхөрлөлүүдийн мод бэлтгэлийн үйл ажиллагаа эрхлэх, ойн нөөцөөс ашиг хүртэх чадавхитай холбоотой зөвлөмж энэ хэсэгт хамаатай байж болох юм.

	талаар шийдвэр гаргахад талуудын оролцоог сайжруулах боломжтой болно - Усны эх үүсвэр нэмэгдэж, ойн дагалт баялгийн ашиглалт сайжирсанаар нутгийн иргэдийн амьдрах нөхцөл орчин дээшилнэ. <u>Эрсдэл</u>: - Орон нутгийн төрийн байгууллага тогтвортой мод бэлтгэлийн зохистой хэмжээг тооцож үзэхгүйгээр зөвшөөрөл олгох - Урамшуулал, экосистемийн үйлчилгээний төлбөрийн шударга бус хуваарилалттай холбоотой асуудал үүснэ. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг зөвхөн хэсэг бүлэг хүмүүс, орон нутгийн засаг захиргаа хүртэх эрсдэлтэй. Байгалийн нөөц багатай орон нутаг ашиг хүртэхгүй үлдэнэ. - ААНБ, нөхөрлөлийн хооронд ойн нөөцийн хүртээмж, ашиглалттай холбоотой маргаан, зөрчил үүснэ	амьдрах чадвар болон бүтээмжийг нэмэгдүүлэх; 2.2.4.ойн экологийн болон эдийн засаг, нийгмийн ач холбогдлыг нэмэгдүүлэх; 2.2.5.ойн бодлого, хууль тогтоомж, бүтэц, зохион байгуулалтыг сайжруулж, сонирхогч талуудын оролцоог хангасан “ойн сайн засаглал”-ыг бий болгох; 2.2.6.ойн нөөцийн зүй зохистой, тогтвортой ашиглалтыг ойг хамгаалах, нөхөн сэргээх ажилтай уялдуулан шинжлэх ухааны үндэслэлтэй зохион байгуулах; 2.2.7. ой, хээрийн түймэр, ойн хөнөөлт шавж, өвчнөөс урьдчилан сэргийлэх, учирсан хохирлыг арилгах үндэсний чадавхтай байх; 2.2.8.ойн баялгийг эзэмшигч, ашиглагч нь хамгаалах үүрэг хүлээж, ойн тогтвортой менежментийг хэрэгжүүлэх нэгж байх зэрэг багтана. Ойн тухай хууль (2012)-д ойн нөхөрлөл болон аж ахуйн нэгжүүд ой хамгаалахад чухал эрх, үүрэгтэй болохыг заасан байна. Тус хуулийн 21.12.2-т “Ойн нөхөрлөл нь эзэмшлийн газраасаа ойн менежментийн төлөвлөгөө, эрхийн бичгийн дагуу бэлтгэсэн мод, ойн дагалт баялгийг ашиглах, хэрэгцээнээс илүү гарсан мод, ойн дагалт баялгийг худалдан борлуулах эрхтэй” гэж заасан. Мөн хуулийн	

		42.1-т 42.1 “Иргэн, ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллага дараах үйл ажиллагаа явуулснаас ойн сан, түүний нөөцөд хохирол учруулсан бол учирсан шууд хохирлыг нөхөн төлнө: 42.1.1.хориглосон үйл ажиллагаа явуулсан; 42.1.2.хууль бусаар мод бэлтгэсэн; 42.1.3.зөвшөөрөлгүйгээр ойн дагалт баялаг түүсэн, бэлтгэсэн; 42.1.4.ойн санд хортой нөлөөлөл үзүүлсэн; 42.1.5.үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх, ашигт малтмал олборлох зэрэг үйл ажиллагаа явуулахдаа ойг устгасан; 42.1.6. хууль бус бусад үйл ажиллагаа явуулсан. 42.2.Энэ хуулийн 42.1-д заасан шууд хохирол болон ойг нөхөн сэргээхэд шаардагдах зардлын нөхөн төлбөрийг байгаль орчны хяналтын улсын байцаагч ногдуулж, төлөлтөд хяналт тавина” гэж заасан.	
Жендерийн тэгш байдал	<u>Үр ашиг:</u> - Мод бэлтгэл, боловсруулах үйл ажиллагааны үр дүнд (орон нутгийн иргэд, малчид, аж ахуйн нэгжүүд, ойн нөхөрлөлүүдийн) ажлын байр, орлого нэмэгдэнэ. Мөн ойн зам барих явцад ажлын байр нэмэгдэнэ.	Тогтвортой хөгжлийн санаачлагуудыг хэрэгжүүлэхэд нийгмийн бүлгүүдийн бүрэн оролцоог хангахыг дэмжсэн дээд түвшний хэд хэдэн бодлогын баримт бичиг гарсан. Тухайлбал, “Монгол Улсын Тогтвортой хөгжлйн хэтийн төлөв -2030”-д	Дээрх судалгааны хүрээнд багц зөвлөмж боловсруулсаны зарим нь бидний хийсэн үнэлгээнд хамаатай байна. Тухайлбал: i) REDD+ хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх явцад болон эмэгтэйчүүдэд

	- Гэрчилгээжүүлэлт, ойн менежментийн үйл ажиллагааны талаар шийдвэр гаргахад талуудын оролцоог сайжруулах боломжтой болно - Ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, нутгийн иргэд, албан хаагчдын ойн менежмент, мод боловсруулах, тогтвортой ашиглах, нөхөн сэргээлт хийх, хамгаалах, дагалт баялаг ашиглах талаарх мэдлэг, ур чадвар сайжирна. - Тусгай хамгаалалттай газар нутгийн менежментэд оролцох талууд нэмэгдсэнээр засаглал, оролцоо сайжирна <u>Эрсдэл</u>: - Эрчүүдэд чиглэсэн ажлын байр нэмэгдэж, жендерийн харьцаа алдагдана. - Зарим айлын амьжиргаанд сөргөөр нөлөөлж болзошгүй. Тухайбал, ан гөрөө хийх, хатсан мод цуглуулах зорилгоор зориудын түймэр тавьдаг, ойн дагалт баялаг ашигладаг, хууль бус мод бэлтгэл ба хууль бус худалдаанд оролцдог, усны эх үүсвэр ашигладаг хүмүүст сөргөөр нөлөөлнө. Ядуурал болон амьдрах орчны бэрхшээлтэй асуудал улам нэмэгдэнэ. Эндээс гарах үр дагавар дүн тэгш бус байна.	тогтвортой хөгжлийн үйл явцад хүн бүрийн оролцоо, хувь нэмэр чухал болохыг онцолсон байна. Мөн “Жендерийн тэгш байдлыг хангах тухай хууль” (2011) нь нийгмийн бүхий л хүрээнд түүний дотор хөдөлмөрийн харилцаанд жендерийн тэгш байдлыг хангах зорилт тавьсан. Жендерийн тэгш байдлыг хангах тухай үндэсний хөтөлбөрийг 2017 оны 5 сард баталсан. “Жендерийн тэгш байдлыг хангах тухай хууль” нь бүх салбарт жендерийн тэгш байдлыг хангахыг шаардсан байна. БОАЖЯ “Байгаль орчны салбарын жендерийн стратеги 2014-2030”-г боловсруулсан.. Энэ нь эмэгтэй, эрэгтэй хүмүүс, нийгмийн бүлгүүдийн болон орон нутгийн хөгжлийн хэрэгцээнд тулгуурлан, тэгш оролцох, үр ашиг тэгш хүртэх боломжийг хангах замаар ногоон хөгжлийн төлөвлөгөөг дэмжих чухал баримт бичиг болсон билээ. МУ-ын Үндсэн хууль, 14-р зүйлд: “1. Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.	чиглэсэн үйл ажиллагаанд талуудын оролцоог хангах шалгуур бий болгох нь тэнцвэртэй оролцоог дэмжих, эрэгтэй, эмэгтэй хүмүүс болон нийгмийн бүлгүүдэд үр ашиг тэгш хүртэх боломжийг бүрдүүлж өгөхийн зэрэгцээ хөдөлмөр эрхлэлтийн харилцаанд жендерийн хэт ялгаа гарах эрсдлийг бууруулахад дэмжлэг болох юм, ii) Аймаг, сумын түвшинд жендерийн мэдрэмжтэй, нийгмийн бүлгүүдийг тэгш хамруулсан талуудын оролцоог хянах арга хэрэгсэл, мэдээлэл солилцох (мэдээллийг ангилах) суваг шаардлагатай бөгөөд энэ сувгаар цаашид Сөрөг нөлөөллөөс сэргийлэх мэдээллийн систем (СНСМС)-д мэдээлэл дамжуулна, iii) Нийгмийн бүлгүүдийг тэгш хамруулах, Байгаль орчны салбарын жендерийн стратегийг хэрэгжүүлэх удирдамжийг боловсруулж, холбогдох албан хаагчдыг сургах шаардлагатай зэрэг болно.

	- Үр ашгийг орон нутгийн (ойн нөхөрлөлд хамрагдаагүй иргэд) иргэд ижил тэгш хүртэхгүй, - Мод бэлтгэлийн суурингийн орчимд архидалт, мансууруулах бодис хэрэглэг зэрэг нийгмийн асуудлууд гарна. - Олон малтай, бизнес эхлүүлэх хөрөнгө бэл ихтэй нутгийн иргэд давуу эрх эдэлж, илүү ашиг хүртэнэ. - Орлого багатай, ядуу иргэд цаг зав хомс, санхүүгийн боломж тааруу учраас төлбөртэй сургалтанд сууж чаддаггүй. - Мэдээлэл зохисгүй байдлаар, тохиромжгүй аргаар түгээгдсэнээс зорилтод бүлгүүд хүрэхгүй байна.	2. Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна” гэж заасан. Мөн Монгол Улс жендерийн болон хүний эрхийнм асуудлаарх олон улсын гэрээ, конвенцид нэгдэн үүрэг хүлээсэн. Тухайлбал, Эмэгтэйчүүдийн эсрэг бүх хэлбэрийн хүчирхийллийг устгах тухай Конвенц (1980)-д нэгдсэн.	
Мэдээлэл авах боломж буюу хүртээмж	<u>Үр ашиг</u>: - Шинэ техник, технологи нэвтрүүлсэнээр ойн тогтвортой менежментийг хэрэгжүүлэх чадавх сайжирч, ой эзэмшигч нөхөрлөлүүд болон ойн ангийн хамтын ажиллагааны ур чадвар, хүний нөөцийн чадавх дээшилнэ - Заган ойн нөхөн сэргээлтээр мэргэшсэн ойн аж ахуйнуудын чадавхи дээшилнэ - Хууль бус мод бэлтгэл, түүнтэй тэмцэж байгаа талаарх мэдээлэл ил тод болсоноор хууль бус мод бэлтгэлтэй тэмцэх ажил сайжирна	Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль (2011 он)-ийн 11-р зүйлд "11.1.Иргэн, хуулийн этгээд нь хүний эрх, эрх чөлөө, үндэсний аюулгүй байдал, байгууллагын хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор хууль тогтоомжид нийтэд мэдээлэхийг хориглосноос бусад дараах мэдээллийг энэ хуулийн 3.1-д заасан байгууллагаас авах эрхтэй" гэж тусгагдсан. Мөн уг хуулийн 11.2-т “Мэдээлэл авах тухай иргэн, хуулийн этгээдийн хүсэлтийг хүлээн авч байгаа энэ хуулийн 3.1-д заасан байгууллагын холбогдох	Энэ хууль нь мэдээллийн хүртээмжийг хангах тухай суурийг сайн тавьж өгч байгаа боловч REDD+ хөтөлбөрийн хүрээнд талуудад (алслагдсан, интернэт холбоо сул газарт байгааг харгалзан) мэдээллийг шуурхай, оновчтой хүргэх арга замын талаар байнга авч үзэх шаардлагатай.

	- Иргэд, ИНБ-уудын улсын төсвийн орлого, зарцуулалтын талаарх мэдлэг дээшилнэ - Ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, нутгийн иргэд, албан хаагчдын ойн менежмент, мод боловсруулах, тогтвортой ашиглах, нөхөн сэргээлт хийх, хамгаалах, дагалт баялаг ашиглах талаарх мэдлэг, ур чадвар сайжирна. - Ойн мэргэжлийн байгууллага, төрийн байгууллага, орон нутгийн иргэдийн заган ойн менежмент, нөхөн сэргээлтийн талаарх мэдлэг, чадавхи нэмэгдэнэ. - Орон нутгийн малчдын бүлэг бэлчээрийн менежментийн тал дээр мэргэшиж чадавхжина. - Гэрчилгээжүүлэлт, ойн менежментийн үйл ажиллагааны талаар шийдвэр гаргахад талуудын оролцоог сайжруулах боломжтой болно <u>Эрсдэл:</u> - Орлого багатай, ядуу иргэд цаг зав хомс, санхүүгийн боломж тааруу учраас төлбөртэй сургалтанд сууж чаддаггүй. - Мэдээлэл зохисгүй байдлаар, тохиромжгүй аргаар түгээгдсэнээс зорилтод бүлгүүд хүрэхгүй байна. - Шударга бус хуваарилалт, зохицуулалтын тодорхой бус байдал, , байгалийн нөөцийн ашиглалт	албан тушаалтан иргэнд энэ хуульд зааснаас бусад шаардлага тавихыг хориглоно” гэжээ. 2015 оны ТОтББодлогоын 3-р хэсэгт 3.5.5-т “олон нийтийн мэдээлэл, сурталчилгааны ажлыг эрчимжүүлэх, ойн экологийн үнэ цэнийг иргэдэд ойлгуулах талаар бүх нийтийг хамарсан ажил өрнүүлэх, ойн салбарын мэдээ, мэдээллийг түгээн дэлгэрүүлэх мэргэжлийн сэтгүүл, студи байгуулахыг төрөөс дэмжих" гэж заасан. Зорилтот бүлгүүдэд мэдээллийг тохиромжтой хэлбэр, сувгаар хүргэж чадахгүйгээс үүдэх эрсдэл байгааг тодорхойлсон. Хүний эрхийг хангах Үндэсний хөтөлбөрийн 2.4.3.5 дахь хэсэгт “Төрөөс үндэстний цөөнхийн эх хэлээрээ сурч боловсрох эрхийг хангаж, тэдний үр хүүхдийн эх хэл, бичиг үсэг, ёс заншил, түүх, соёлын уламжлалыг өвлөн хөгжүүлэх боломжийг сайжруулна” гэж заасан боловч монгол хэлээр ярьдаггүй үндэстний цөөнхийн хүүхдүүдэд эх хэлээр нь сургалт явуулах бэлтгэгдсэн багш, сурах бичиг, сургалтын материал хангалтгүй байгаа бөгөөд үндэстний цөөнхөд	

	зэрэгтэй холбоотойгоор нутгийн иргэд, ойн нөхөрлөлүүдийн дунд маргаан, зөрчил үүснэ. - Аж ахуйн нэгж, ойн нөхөрлөлүүдийн дунд ойн нөөцийн ашиглалттай холбоотой зөрчил үүснэ. Нутгийн иргэдийн зүгээс ойн нөөцийг ашиглах боломж, ашиглалттай гомдол, зөрчил гарна. - Усан хангамж, ой хамгаалах, нөхөн сэргээлт хийхэд зориулж төлөвлөсөн газрыг ашиглах хүсэлтэй малчид маргаан, зөрчил үүсгэж болзошгүй. Бэлчээрийн менежментийг сайжруулах, хуурай газартай холбоотой БАХ-г хэрэгжүүлсэнээр бэлчээрийн газар хомсдож, одоогийн бэлчээрийн зохион байгуулалттай зөрчилдөж болзошгүй.	чиглэсэн боловсролын бодлого байхгүй байна. Олон нийтийн радио, телевизийн тухай хуульд үндэстний цөөнхийн хүнд амд зориулсан нэвтрүүлэг явуулна гэж заасан байдаг ч энэ нь бодит байдалд хангалттай хэрэгжихгүй байна. Монгол Улс нь Олон Улсын хөдөлмөрийн байгууллагын 169 дүгээр буюу “уугуул ба нутгийн омгийн иргэд”-ийн статусын талаарх Конвенцид нэгдээгүй. Тиймээс, уугуул болон омгийн иргэд гэх тодорхойлолтод хамаарах иргэдэд тусгай эрх, хамгаалалт байхгүй байна. Энэ нь цаатан иргэдэд хамгийн их хамаарах юм. Цаатнуудын хоол хүнс ангийн махнаас бүрддэг. Гэтэл тул ангийн тухай хатуу хууль тэдний хоол хүнсээ бэлдэх нөхцлийг харгалзаж үзээгүй. Үндэстний цөөнхийн газар ашиглах, эзэмших эрхийг зохих ёсоор хамгаалаагүй нь Хүний эрхийн түгээмэл тунхагийн 17-д заасан “дангаараа болон бусадтай хамтран өмч эзэмших эрх”-ийг нь зөрчиж байна. Энэ СНСЗ-ын хүрээнд тодорхойлсон өөр нэг эрсдэл нь мэдлэг, ойлголтыг тэр дундаа ойн салбарын талаарх мэдээллийн хүртээмжтэй холбоотой юм. СНСЗ	

		B, E (өөр тусгай элемент нэмэх)-ийн хүрээнд сургалт явуулах, чадавхийг бэхжүүлэхтэй холбоотой БХЖ-ууд энд хамаатай. Тухайлбал Ажил эрхлэлтийн дэмжих тухай хууль (2011), Төрөөс ойн талаар баримтлах бодлого (2015), Ойн цэвэрлэгээ хөтөлбөр (2014) г.м.	
Шийдвэр гаргах үйл явцад оролцох оролцоо (СНСЗ (c), (d)-тэй давхцана)	Үр ашиг: - Тусгай хамгаалалттай газар нутгийн менежментэд оролцох талууд нэмэгдсэнээр засаглал, оролцоо сайжирна - Гэрчилгээжүүлэлт, ойн менежментийн үйл ажиллагааны талаар шийдвэр гаргахад талуудын оролцоог сайжруулах боломжтой болно - Мод бэлтгэх боломж нэмэгдэх, нутгийн иргэд, төрийн байгууллага, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа сайжирсанаар хувийн хэвшлийн салбарыг дэмжихэд ойн салбарын гүйцэтгэх үүрэг дээшилнэ - Гал түймэр, хортон шавжтай тэмцэх ажилд ойн нөхөрлөлүүдийн оролцоо сайжирна. - Мод бэлтгэл, боловсруулах үйл ажиллагааны үр дүнд (орон нутгийн иргэд, малчид, аж ахуйн нэгжүүд, ойн нөхөрлөлүүдийн) ажлын байр, орлого нэмэгдэнэ, ойн зам барих явцад ажлын байр бий болно.	Баримт, нотолгоонд суурилсан шийдвэр гаргахтай холбоотой дараах заалтууд ToТББ (2015)-д тусгагдсан байна: “2.2.6.ойн нөөцийн зүй зохистой, тогтвортой ашиглалтыг ойг хамгаалах, нөхөн сэргээх ажилтай уялдуулан шинжлэх ухааны үндэслэлтэй зохион байгуулах”; “3.3.1.Монгол орны ойн сангийн төлөв байдлыг нарийвчлан тодорхойлж, ойг хамгаалах, нөхөн сэргээх, зохистой ашиглах ойн тогтвортой менежментийг бий болгох”; Талуудтай нээлттэй зөвшилцөх, хэлэлцэхтэй холбоотой заалт бүхий БХЖ-ууд: - Захиргааны ерөнхий хууль (2015) - Иргэдийн төлөөлөгчдийн хурал: Ойн тухай хууль (2012)-ийн 32.1 дэхь хэсэгт “32.1.Ойгоос тухайн жилд бэлтгэх модны дээд хязгаарыг аймаг, нийслэлийн Засаг даргын санал, ой зохион байгуулалтын	

	- Нутгийн иргэд, ойн нөхөрлөлүүдтэй гэрээ байгуулсанаар олон нийтийн дунд мод тарих талаарх мэдлэг, мэдээлэл дээшилнэ <u>Эрсдэл:</u> - Аж нэгжүүд нутгийн иргэдийг үйл ажиллагаандаа оролцуулахгүй байсаны улмаас орон нутгийн иргэдийн цаашид орлого олох боломж хумигдана. - Монополь бий болж орон нутгийн бизнесийн үйл ажиллагаа, жижиг аж ахуйн нэгжүүд шахагдана. Технологийн зардлаас хамааараад жижиг үйлдвэрлэл (өрхийн үйлдвэрлэл г.м)-д бэрхшээл тулгарна. - Зарим БАХ нь аж ахуйн нэгжүүдэд чиглэснээр нутгийн иргэдийн оролцоо, тэдний ирээдүйд үр ашиг хүртэх боломж багасна. - Нутгийн иргэд шинэ төрлийн түлш ашиглах талаар мэдлэг дутмаг, түүнийг ашиглах явдал хангалтгүй байна. Зорилтот бүлгүүдийн дунд сүүлийн үеийн шинэлэг техник, технологи дутмаг байна - Байгалийн болон ойн баялгийн ашиглалтын төлбөр, өөрөөр хэлбэл эко үйлчилгээний төлбөр, мод бэлтгэл, аялал жуулчлалын орлогоос зөвхөн хязгаарлагдмал бүлгийн хувь хүмүүс, аж ахуйн нэгж болон төрийн байгууллагууд үр ашиг хүртэж болзошгүй	баримт бичиг, ойн менежментийн төлөвлөгөөг үндэслэн төрийн захиргааны төв байгууллага аймаг, нийслэл тус бүрээр тогтооно.” гэж заасан. Мөн хуулийн 32.2-т “Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тухайн жилд ойгоос бэлтгэх модны хэмжээг энэ хуулийн 32.1-д заасан хязгаарт багтаан сум, дүүрэг бүрээр тогтооно.” гэжээ. Ойн тухай хууль (2012)-ийн 21.9 дэхь хэсэгт “Энэ хуулийн 21.8-д заасны дагуу бүрдүүлсэн баримт бичиг нь энэ хуулийн 21.7-д заасан шаардлага, 21.8-д заасан бүрдлийг хангасан бол сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж, уг шийдвэрийг үндэслэн сум, дүүргийн Засаг дарга ойн сангийн тодорхой хэсгийг эзэмшүүлэх гэрээ байгуулж, гэрчилгээ олгоно.” гэж заасан. Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн тухай хууль (1997)-ийн 6.1 дэхь хэсэгт **“**Орчны бүсийн хөгжлийг зохицуулах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээхэд нутгийн иргэдийн оролцоог өргөжүүлэх зорилго бүхий орон тооны бус	

	- Орчны бүсийн иргэд санаачлага муутай, зөвхөн ТХГН-аас хамаарах хандлага нэмэгдэнэ. Хууль бус мод бэлтгэлийг бууруулах БАХ нь хууль хэрэгжүүлэх байгууллагуудад чиглэсэн байх тул орон нутгийн иргэдийн оролцоо, санаачлагатай байдал буурч болзошгүй - Шударга бус хуваарилалт, зохицуулалтын тодорхой бус байдал, байгалийн нөөцийн ашиглалтаас үүдэн нөхөрлөлүүдийн дунд газар нутаг, ашиглалтын маргаан, зөрчил үүсэх	орчны бүсийн зөвлөл /цаашид “Зөвлөл” гэх/ ажиллана” гэж заасан. Ойн нөхөрлөлүүдийн ойн менежментийн төлөвлөгөө боловсруулах эрх болон түүний дэлгэрэнгүй тодорхойлолтыг Ойн тухай хууль (2012)-ийн 13-р зүйлийн 13.1.27 дахь хэсэгт зааж өгсөн байна. Энэ нь ойн нөхөрлөлүүдийг үйл ажиллагаанд оролцуулах, ойн арга хэмжээг хэрэгжүүлэх талаарх шийдвэр гаргах үйл явцад нөхөрлөлүүдийг оролцогч тал болгон оролцуулсанаас үүдэх үр дүнтэй холбоотой.	

ХАВСРАЛТ 3.3

Зарчим С: Олон улсын өмнө хүлээсэн үүрэг, үндэсний нөхцөл байдал, хууль тогтоомж, мөн НҮБ-ын Ерөнхий Ассемблейн баталсан Уугуул иргэдийн эрхийн тухай НҮБ-ын Тунхгийг харгалзан үзэж, уугуул иргэдийн болон орон нутгийн нөхөрлөлийн гишүүдийн мэдлэг, эрхийг хүндэтгэх

Сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчмын элементүүд	**Гол үр ашиг, эрсдлүүд** Монгол оронд REDD+-ийн хүрээнд хэрэгжүүлэхээр санал болгосон бодлого, арга хэмжээнүүдийн үр ашиг, эрсдлийн үнэлгээнээс тодорхойлсоноор	**СНСЗ-уудыг тусгаж, хэрэгжүүлэхтэй холбоотой БХЖ-ууд** (СНСЗ-уудтай холбоотой БХЖ-ын үнэлгээнд тулгуурласан)	**Цаашид сайжруулах шаардлагатай асуудлууд** Тухайн СНСЗ-ыг Монгол улсын БХЖ-уудад илүү сайн тусгаж хэрэгжүүлэхийн тулд юуг сайжруулах ёстой талаар
Уугуул иргэд, орон нутгийн иргэд гэдэг нэршлийг тодорхойлох буюу тайлбарлах	<u>Үр ашиг</u>: - Ойн менежмент/гэрчилгээ олгох талаарх шийдвэр гаргах үйл явцад талуудын оролцоог нэмэгдүүлэх боломжтой - Нутгийн иргэдийн байгаль хамгаалах талаарх мэдлэг, хандлагыг дэмжинэ - Орон нутгийн иргэд, төрийн байгууллага болон заган ойн менежментээр мэргэшсэн мэргэжлийн байгууллагуудын заган ойн тогтвортой ашиглалтын талаарх мэдлэг, туршлага нэмэгдэнэ. - Малчдын бүлэг бэлчээрийн менежментийн талаар суралцаж, чадавхжина, нутгийн оролцогч талууд бэлчээрийн менежментэд оролцох оролцоо нэмэгдэнэ. <u>Эрсдэл:</u> - Ойн нөөцийн ашиглалттай холбоотойгоор орон нутгийн	Захиргааны хууль (2016)-д нутгийн иргэдийн бие даан шийдвэр гаргах эрхийг дэмжсэн заалт тусгасан байна. Хэм хэмжээний актын талаар шийдвэр гаргахаас өмнө авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийг заасан (зөвхөн хэм хэмжээний актаар хязгаарласан гэдгийг анхааруулсан). Шинээр хууль, журам боловрсуулж, энэ талаар зөвлөлдөж байх явцад холбогдох талуудад урьдчилж мэдээлэх, мэдээлэл түгээх, санал, гомдол хүлээн авах механизмыг бүрдүүлэхийг хуульчилсан байна. Үндсэн хууль (2013): - 3.1. “Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ”.	Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд антропологийн зориулалт бүхий тусгай хамгаалалттай газар байгуулах тухай заалт оруулж, цаатан иргэдийн эрхийг хамгаалах шаардлагатай. Монголд үндэстний цөөнхийн асуудлыг зохицуулах тусгай хууль байхгүй. Үндэстний цөөнхийн эрхийг Үндсэн хуулийн 14.2 буюу “Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл

	захиргаа, хамгаалалтын захиргаад, орон нутгийн иргэд, ойн нөхөрлөлүүдийн хооронд аж ахуйн үйл ажиллагаа, байгаль хамгаалах зардлын зарцуулалт, ойн нөөцийн хүртээмжтэй холбоотой зөрчил үүснэ. - Аж ахуйн нэгж, ойн нөхөрлөлүүдийн дунд ойн нөөцийн ашиглалттай холбоотой зөрчил, нутгийн иргэдийн зүгээс ойн нөөцийг ашиглах боломж, ашиглалттай холбоотой гомдол, зөрчил үүснэ. - Усан хангамж, ой хамгаалах, нөхөн сэргээлт хийхэд зориулж төлөвлөсөн газрыг ашиглах хүсэлтэй малчид маргаан, зөрчил үүсгэж болзошгүй. Бэлчээрийн менежментийг сайжруулах, хуурай газартай холбоотой БАХ-г хэрэгжүүлсэнээр бэлчээрийн газар хомсдож, одоогийн бэлчээрийн зохион байгуулалттай зөрчилдөж болзошгүй; - Тусгай хамгаалалттай газрыг нэмэгдүүлэх, усны нөөцийн менежментийг хөгжүүлэх нь хөгжлийн бусад бодлогуудтай зөрчилдөж, уламжлалт амьдралын хэв маягт дарамт учруулна - Зарим айлын амьжиргаанд сөргөөр нөлөөлж болзошгүй. Тухайбал, ан гөрөө хийх, хатсан мод цуглуулах зорилгоор зориудын түймэр тавьдаг, ойн дагалт баялаг ашигладаг, хууль	- 62.1 дэхь хэсэгт “Нутгийн өөрөө удирдах байгууллага тухайн аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны нутаг дэвсгэрийн хэмжээний эдийн засаг, нийгмийн амьдралын асуудлыг бие дааж шийдвэрлэхийн хамт улс, дээд шатны нэгжийн чанартай асуудлыг шийдвэрлэхэд хүн амыг зохион байгуулж оролцуулна”. 62.2 дахь хэсэгт “2. Нутгийн өөрөө удирдах байгууллагын эрх хэмжээний асуудлыг дээд шатны байгууллага нь шийдвэрлэж үл болно. Хэрэв нутаг дэвсгэрийн амьдралын тодорхой асуудлыг шийдвэрлэх талаар хууль, төрийн зохих дээд байгууллагын шийдвэрт тухайлан заагаагүй бол нутгийн өөрөө удирдах байгууллага Үндсэн хуульд нийцүүлэн бие даан шийдвэрлэж болно.” 62.3. дахь хэсэгт “Улсын Их Хурал, Засгийн газраас шаардлагатай хэмээн үзсэн тохиолдолд өөрийн бүрэн эрхэд хамаарах зарим асуудлыг шийдвэрлүүлэхээр аймаг, нийслэлийн Хурал, Засаг даргад шилжүүлж болно.” гэж тус тус хуульчилсан. Хүний эрхийг хангах Үндэсний хөтөлбөрийн 2.4.3.5 дахь хэсэгт “Төрөөс үндэстний цөөнхийн эх хэлээрээ сурч боловсрох эрхийг хангаж, тэдний үр хүүхдийн эх хэл, бичиг үсэг, ёс заншил, түүх, соёлын уламжлалыг өвлөн хөгжүүлэх боломжийг сайжруулна” гэж заасан боловч монгол хэлээр ярьдаггүй үндэстний цөөнхийн хүүхдүүдэд эх хэлээр нь сургалт	болно.” гэсэн заалтаар хамгаалсан. Монгол Улсад мөрдөж байгаа хэд хэдэн хуульд тухайлбал, “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль (7.1), Эрүүгийн хууль (5.1)-д үндэстний цөөнхүүдийн тэгш эрхийг баталгаажуулсан. Цаатан иргэд нь цөөхүүлээ бөгөөд өвөрмөц зан заншил, уламжлалыг тээж яваа тул өрөөс цаатан иргэдийг дэмжих талаар тусгайлан анхаарч ирсэн (АХБ. 2015.Үндэстний цөөнхийг дэмжихэд чиглэсэн үйл ажиллагааны төлөвлөгөө).

	бус мод бэлтгэл ба хууль бус худалдаанд оролцдог, усны эх үүсвэр ашигладаг хүмүүст сөргөөр нөлөөлнө. Ядуурал болон амьдрах орчны бэрхшээлтэй асуудал улам нэмэгдэнэ. Эндээс гарах үр дагавар дүн тэгш бус байна. - Газар ашиглалтын хэлбэр өөрчлөгдсөнөөр нутгийн иргэдийн амьжиргааны эх үүсвэр хумигдаж, нүүдэл, шилжилт ихсэнэ.	явуулах бэлтгэгдсэн багш, сурах бичиг, сургалтын материал хангалтгүй байгаа бөгөөд үндэстний цөөнхөд чиглэсэн боловсролын бодлого байхгүй байна. Олон нийтийн радио, телевизийн тухай хуульд үндэстний цөөнхийн хүнд амд зориулсан нэвтрүүлэг явуулна гэж заасан байдаг ч энэ нь бодит байдалд хангалттай хэрэгжихгүй байна. Монгол Улс нь Олон Улсын хөдөлмөрийн байгууллагын 169 дүгээр буюу “уугуул ба нутгийн омгийн иргэд”-ийн статусын талаарх Конвенцид нэгдээгүй. Тиймээс, уугуул болон омгийн иргэд гэх тодорхойлолтод хамаарах иргэдэд тусгай эрх, хамгаалалт байхгүй байна. Энэ нь цаатан иргэдэд хамгийн их хамаарах юм. Цаатнуудын хоол хүнс ангийн махнаас бүрддэг. Гэтэл тул ангийн тухай хатуу хууль тэдний хоол хүнсээ бэлдэх нөхцлийг харгалзаж үзээгүй. Үндэстний цөөнхийн газар ашиглах, эзэмших эрхийг зохих ёсоор хамгаалаагүй нь Хүний эрхийн түгээмэл тунхагийн 17-д заасан “дангаараа болон бусадтай хамтран өмч эзэмших эрх”-ийг нь зөрчиж байна.	
Аливаа үр ашгаас зохих ёсоор хүртэх эрх	<u>Үр ашиг:</u> - Гэрээнд нутгийн иргэдэд урамшуулал олгох заалт тусгасанаар (тарьсан модыг төрөөс улсын санд худалдаж авах г.м) иргэдийн дунд мод тарих сонирхлыг нэмэгдүүлж, эдийн засгийн урамшуулал олгох ач	Ойн тухай хууль (2012), 39.5-д " 39.5. Энэ хуулийн 39.2-39.4, 39.10-т заасан урамшуулал олгох журмыг санхүүгийн болон байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална." гэж заасан боловч урамшууллын журмыг яамнаас хараахан батлаагүй.	Ойн тухай хуулийн хүрээнд үр ашиг хуваарилах, зохицуулах, байгалийн нөөцийн ашиглалттай холбоотой маргааныг зохицуулах тусгай шинэ журам боловсруулах

	холбогдолтой. Ногоон ажлын байр нэмэгдэж, мод тарих үйл ажиллагаа хэрэгжүүлсэн иргэд, аж ахуйн нэгж, ойн нөхөрлөлүүдийн орлого сайжирна. - Бусад төсөл, хөтөлбөрүүдээс орон нутгийн амьжиргааг дэмжих санхүүгийн хөшүүрэг бий болгох боломжтой - Ойн салбарт ажиллаж байгаа аж ахуйн нэгжүүдэд шинэ боломж нээгдэж, ойн аж ахуйн нэгжүүдийн санхүүгийн чадавхи сайжирна, ажлын байр тогтвортой болно - Мод бэлтгэл, дагалт баялаг, түлээний модны зөвшөөрлийн хураамж мөн эко-аялал жуулчлал, мод боловсруулах үйл ажиллагаанаас орон нутгийн төсөвт орох орлого нэмэгдэнэ - Мод бэлтгэсэн аж ахуйн нэгж өөрийн зардлаар дахин ойжуулалт хийх ёстой тул ойжуулалтын талбай нэмэгдэнэ - Мод бэлтгэл, мод боловсруулах, дагалт баялгийн ашиглалт, агро-ойн аж ахуйн үйл ажиллагааны үр дүнд орон нутгийн иргэд, аж ахуйн нэгжүүд, ойн нөхөрлөлүүдийн ажлын байр, орлого нэмэгдэнэ - Мал аж ахуйн бүтээгдэхүүний нэмүү өртгийн сүлжээ сайжирсанаар малчид, тариаланчдын орлого, амьжиргаа дээшилнэ	Ойн тухай хууль (2012)-д нөхөрлөл, аж ахуйн нэгж болон бусад этгээдэд ойн нөөцийг ашиглах, үр ашиг хүртэхийг зөвшөөрсөн хэд хэдэн заалт байдаг. Тухайлбал хуулийн 21.12.2 дахь хэсэгт "эзэмшлийн газраасаа ойн менежментийн төлөвлөгөө, эрхийн бичгийн дагуу бэлтгэсэн мод, ойн дагалт баялгийг ашиглах, хэрэгцээнээс илүү гарсан мод, ойн дагалт баялгийг худалдан борлуулах;" эрхтэй гэж тусгагдсан. Мөн хуулийн 35.2 дахь хэсэгт " Зохих зөвшөөрөл авсан иргэн ахуйн зориулалтаар, түүнчлэн ойн санг гэрээгээр эзэмшигч ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллага эзэмшлийнхээ талбайд энэ хуулийн 3.1.15-д заасан ойн цэвэрлэгээ хийх замаар, зохих зөвшөөрөл авсан ойн нөөц бүхий аймаг, сумын иргэд уламжлалт бүтээгдэхүүн үйлдвэрлэх зориулалтаар мод бэлтгэж болно." гэж заажээ. Ойн цэвэрлэгээ хөтөлбөр нь үр ашиг, урамшуулал, ойн салбарын ажил эрхлэлттэй холбоотой. Ойн цэвэрлэгээ хөтөлбөрийн 5.4 дэхь хэсэгт "Ойн цэвэрлэгээний ажлыг ойн мэргэжлийн аж ахуйн нэгж болон ойн санг гэрээгээр эзэмшигч нөхөрлөл, ажилгүй иргэдийг оролцуулан гүйцэтгэнэ." гэсэн боловч уг хөтөлбөр бүрэн хэрэгжээгүй. Үүнээс гадна, ОЦХ (2014)-ийн 6-р зүйлд “ажилгүй оршин суугчдыг байнгын ажлын байраар хангах” заалт орсоноос өөр ойн нөхөрлөлийн гишүүн бус иргэдийг ойн цэвэрлэгээ хөтөлбөрөөс үр ашиг хүртэхийг дэмжсэн	шаардлагатай. Энэ журамд ойн нөхөрлөлийн менежментийн төлөвлөгөөнд орон нутгийн иргэдийн оролцооны талаар болон үр ашгийн хуваарилалтыг нийтээрээ зөвлөлдсөний үндсэн дээр хийдэг байх заалтыг тусгасан байх шаардлагатай. Урамшууллын системийг сайжруулах. Урамшууллын хэмжээг нэмэгдүүлэх (жишээ нь эргүүл хийх, зөрчлийг мэдээлэх) мөн хүмүүст урамшууллыг тэр дор нь олгодог систем бий болгох. Урамшууллын санхүүжилтийг ойн баялаг ашиглалтын төлбөрийн тодорхой хувиас бүрдүүлвэл зохино. Төр улсын төсөвт хангалттай санхүүжилт тусгах замаар Ойн цэвэрлэгээ хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж ойн нөхөрлөлүүд ойн цэвэрлэгээнээс орлого олж, бусад модыг хямд үнээр худалдаж авах боломжтой болгох хэрэгтэй. Ойн цэвэрлэгээ хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд 14 тэрбум

	- Түлшний модны нийлүүлэлт нэмэгдэж түлшний модны үнэ буурна - Амьжиргааны эх үүсвэрийн төрөл нэмэгдэж, экосистемийн үйлчилгээ сайжирсанаар нутгийн иргэдийн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадвар дээшилнэ - Эмийн ургамал, түлээний мод зэрэг дагалт баялгийн нийлүүлэлт нэмэгдэнэ. Мод бэлтгэл, дагалт баялаг, эмийн ургамлыг бэлтгэх журмыг сайжруулах боломж бүрдэнэ. <u>Эрсдлүүд:</u> - Ой болон байгалийн нөөцийг ашиглах боломж буурах буюу баялгийг хүртэх боломж тэгш бус байх нь ойгоос хамаарч аж амьдралаа залгуулдаг зарим иргэдийн амьжиргаанд сөргөөр нөлөөлж болзошгүй (зөвшөөрөлтэй болон хууль бус мод бэлтгэл эрхэлдэг, ан хийдэг, ойн дагалт баялаг ашигладаг хүмүүс г.м.) - Үр ашгийг орон нутгийн (ойн нөхөрлөлд хамрагдаагүй иргэд) иргэд ижил тэгш хүртэхгүй - Орон нутгийн иргэдийн ажлын ачаалал хариуцлага нэмэгдэнэ - ТХГН-ийн захиргаад, орон нутгийн захиргаа, нутгийн иргэд, ойн нөхөрлөлүүдийн дунд амьжиргааны арга хэмжээ, байгаль хамгаалах орлогын зарцуулалт, ойн нөөцийн	эрх зүйн механизм байхгүй (Ойн нөхөрлөлийн гишүүн бус иргэд үр ашиг тэгш хүртэж чадахгүй байх гэсэн эрсдэлтэй холбоотой). Ойн нөхөн сэргээлт хийхэд зориулсан урамшууллын санхүүжилтийг хэрхэн зохицуулах талаар Ойн тухай хууль (2012)-д хэд хэдэн заалт тусгагдсан (4.2 болон 39.4 дэхь хэсэг). Дараах хоёр хувилбарыг хуульчилсан байна. Үүнд: (i) Хууль тогтоомжид заасан журмын дагуу иргэн өөрийн өмчлөлийн болон эзэмшлийн газартаа, ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллага эзэмшлийн газартаа өөрийн хөрөнгөөр зориудаар тарьж ургуулсан ой модыг өмчилж болно, (ii) ойн нөхөрлөл болон бусад этгээдийн өөрийн хөрөнгөөр бойжуулсан таримал ойг зохих журмын дагуу төрөөс худалдан авах буюу бусад хэлбэрээр урамшуулна гэжээ. Хэдий тийм боловч, ой модыг нөхөн сэргээхэд хувийн хэвшлийг өргөнөөр оролцуулахыг дэмжсэн заалт дутагдалтай байна. Төсвийн тухай хууль (2011)-ийн 63.1 дэхь хэсэгт " Баг, хорооны Засаг дарга Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх дараалал, арга замын талаар баг, хороодод олон нийтийн нээлттэй санал асуулга явуулна.” гэжээ.	төгрөг шаардагдан гэж тооцоолсон. БАХ-г хэрэгжүүлсэнээр нүүрстөрөгчийн шингээлтийг нэмэгдүүлэхтэй холбоотой болон бусад үр дүнд нөлөөлөх үр ашиг, эрсдлийн талаар бүрэн ойлголттой болно. Хувийн хэвшлээс бүх ойн төрлийн зулзаган модыг тодорхой хугацааны дараа баталгаатай буцаан худалдаж авдаг болгохын тулд дараах журмыг шинэчлэх шаардлагатай: “Ойжуулалт, ойн аж ахуйн үйл ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, санхүүжүүлэх, таримал ойг үнэлэх, улсын ойн санд худалдан авах, өмчлүүлэх журам” (Сангийн сайд болон Байгаль Орчин Аялал Жуулчлалын Яамны сайдын хамтарсан тушаалаар баталсан, Дугаар А-96\71). Түүнээс гадна төсвийн ачааллыг бууруулах (мөн хувийн хэвшлийн оролцоог сайжруулах) үүднээс байгалийн сэргэн ургалт илүү тохиромжтой нутаг

	ашиглахтай холбоотой зөрчил үүснэ -Түлшний мод бэлтгэхийг хянах арга хэмжээний үр дүнд нийлүүлэлт багасвал түлшний үнэ өснө. - Иргэдэд шинэ төрлийн татварын дарамт үүсэх эрсдэл (экосистемийн үйлчилгээний төлбөр) -Хүйсийн зохистой харьцаа алдагдаж болзошгүй. - Эрэгтэйчүүдэд чиглэсэн ажлын байр нэмэгдсэнээр хүйсийн харьцаа алдагдана.	Нөхөрлөл, хоршоодын талаар Байгаль орчны хамгаалах тухай хууль (1995)-ийн 51.1-д “Нөхөрлөл нь үйл ажиллагаагаа санхүүжүүлэх, гишүүддээ дэмжлэг үзүүлэх зорилгоор дундын сан байгуулж болно.”, 51.4-д “Дундын санг байгалийн нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх ажлын байр бий болгох, нөхөрлөлийн гишүүдийн амьжиргааг дэмжих, байгалийн гамшгийн улмаас учирсан хохирлыг багасгах, нөхөрлөлийн гишүүдийн хурлаас тогтоосон бусад үйл ажиллагааг санхүүжүүлэхэд зарцуулна.” гэж заасан. Орон нутгийн хөгжлийн сангаас гадна ТХГН-ийн орчны бүсийн тухай хууль (1997 оны 10 сарын 23)-ийн 7.1 дэхь хэсэгт "Зөвлөл нь тусгай хамгаалалттай газрын орчны бүсийг хөгжүүлэх, нутгийн иргэдийн ахуй амьдралыг дэмжих зорилго бүхий орчны бүсийн сан /цаашид "сан" гэх/-г байгуулж болно."; 7.4.2 дахь хэсэгт “Тус сангийн хөрөнгийг нутгийн иргэдийн ахуй амьдралыг дэмжих, жижиг үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэхэд тусламж, дэмжлэг үзүүлэх, төсөл хэрэгжүүлэх зэрэгт зарцуулна” гэж заасан. Жендерийн тэгш байдлыг хангах тухай хууль (2011)-ийн 11.1-т жендэрээр ялгаварлан гадуурхахыг хориглосон боловч жендерийн харьцааны талаар заагаагүй байна.	талбайн тэргүүлэх зэргийг тогтоох журам эсвэл удирдамж шинээр боловсруулах хэрэгтэй Нөхөрлөлийн менежментийн орчны бүсийн зөвлөлийн дэмжлэгийг өргөжүүлж орлогын өөр эх үүсвэрийг (агро ойн аж ахуй, ХАА г.м) хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх санхүүжилтийн хэмжээг нэмэгдүүлэх (орон нутгийн иргэд болон аж ахуйн нэгжүүдэд Тогтвортой хөгжлийн зорилтууд болон бусад хөтөлбөрийн дэмжлэгийн хүрээнд)

Нутгийн иргэдийн газар, нутаг, байгалийн нөөцөө өөрсдөө бие даан ашиглах эрхийг хүлээн зөвшөөрөх	Үр ашиг: - Мод бэлтгэл, мод боловсруулах, дагалт баялгийн ашиглалт, агро-ойн аж ахуйн үйл ажиллагааны үр дүнд орон нутгийн иргэд, аж ахуйн нэгжүүд, ойн нөхөрлөлүүдийн ажлын байр, орлого нэмэгдэнэ. - Талуудыг гэрчилгээ олгох, ойн менежментийн үйл ажиллагаанд талуудын оролцоог дээшлүүлэх боломжтой болно. - Бэлчээрийн менежмент сайжирч, эрчимжсэн мал аж ахуй хөгжинө. Махны чанар дээшилж, хүнсний аюугүй байдал сайжирна - Иргэдийн байгаль орчны талаарх мэдлэг, хандлага, ойг хамгаалах талаарх хандлага, хууль тогтоомжийн талаарх мэдлэг сайжирна. Байгаль хамгаалах уламжлалт мэдлэгийг түгээн дэлгэрүүлнэ. Эрсдлүүд: - Усны эх үүсвэрүүдийг нэмж хамгаалалтад авснаар малчдад газар ашиглахтай холбоотой бэрхшээл учирна - ААНБ, нөхөрлөлийн хооронд мод бэлтгэлтэй холбоотой зөрчил үүснэ, иргэдтэй ойн нөөцийг ашиглах боломж, ашиглалттай холбоотой зөрчилдөж болзошгүй - Ой хамгаалах, нөхөн сэргээлт хийхэд зориулж төлөвлөсөн газрыг ашиглах хүсэлтэй малчид маргаан,	Үндсэн хуулийн 6-р зүйлд газар болон газрын баялаг болон түүнийг төр эзэмших талаар заасан байна: " 1. Монгол Улсад газар, түүний хэвлий, ой, ус, амьтан, ургамал болон байгалийн бусад баялаг гагцхүү ард түмний мэдэл, төрийн хамгаалалтад байна. 2. Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн өмч мөн. 3. Бэлчээр, нийтийн эдэлбэрийн ба улсын тусгай хэрэгцээнийхээс бусад газрыг зөвхөн Монгол Улсын иргэнд өмчлүүлж болно. Энэ нь газрын хэвлийг өмчлөхөд хамаарахгүй. Иргэд хувийн өмчийнхөө газрыг худалдах, арилжих, бэлэглэх, барьцаалах зэргээр гадаадын иргэн, харьяалалгүй хүний өмчлөлд шилжүүлэх, түүнчлэн төрийн эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр бусдад эзэмшүүлэх, ашиглуулахыг хориглоно. 4. Төр газрын эзэнд газартай нь холбогдсон үүрэг хүлээлгэх, улсын тусгай хэрэгцээг үндэслэн нөхөх олговортойгоор газрыг солих буюу эргүүлэн авах, уг газрыг хүн амын эрүүл мэнд, байгаль хамгаалал, үндэсний аюулгүй байдлын ашиг	Ой бүхий газарт мал бэлчээхтэй холбоотой Ойн тухай хууль болон Газрын тухай хуулийн заалтууд хоорондоо зөрчилдөж байна. Дээрх хоёр хуулийг шинэчилж зулзган ой бүхий газарт мал бэлчээхийг хориглох шаардлагатай. Нийгмийн бүлгүүдийн тэгш оролцооны талаарх тайлангаас: Хэдийгээр газар, өмч хөрөнгө эзэмших тэгш эрхтэй байхыг Үндсэн хууль, Иргэний хууль, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулиар баталгаажуулсан боловч нийт өмч, хөрөнгийн эзэмшлийн байдлыг авч үзэхэд эмэгтэйчүүд эрэгтэйчүүдтэй ижил хэмжээний хөрөнгө эзэмшиж чадахгүй байна. Хөдөө орон нутагт өрхийн өмч хөрөнгийн ихэнхи (58.5%) нь нөхрийн нэр дээр, 10.7% нь эхнэр, нөхрийн нэр дээр цуг, ердөө 8.5% нь эхнэрийн нэр дээр бүртгэлтэй байна. Хот, хөдөөгийн 8,000 оролцогчдоос авсан судалгаагаар өмчилсөн газрын 30% нь

	зөрчил үүсгэж болзошгүй; Бэлчээрийн менежментийг сайжруулах, хуурай газартай холбоотой БАХ-г хэрэгжүүлсэнээр бэлчээрийн газар хомсдоно; - Тусгай хамгаалалттай газрыг нэмэгдүүлэх, усны нөөцийн менежментийг тэлэх нь хөгжлийн бусад бодлогуудтай зөрчилдөж, уламжлалт амьдралын хэв маягт дарамт учруулна - Ой болон байгалийн нөөцийг ашиглах боломж буурах буюу баялгийг хүртэх боломж тэгш бус байх нь ойгоос хамаарч аж амьдралаа залгуулдаг зарим иргэдийн амьжиргаанд сөргөөр нөлөөлж болзошгүй (зөвшөөрөлтэй болон хууль бус мод бэлтгэл эрхэлдэг, ан хийдэг, ойн дагалт баялаг ашигладаг хүмүүс г.м.) - Нийтийн хэрэгцээний болон бэлчээрийн зориулалтаар ашиглах талбайн хэмжээ багасч, малчын амьжиргаанд нөлөөлнө - Модны эрэлт өссөнөөр түүхий эдийн үнэ өснө. Түлшний модны нийлүүлэлт буурсанаар үнэ нь өснө. - Нутгийн иргэд унанги мод ашиглах сонирхлоор зориуд түймэр тавих эрсдэл нэмэгдэнэ. Ойд зам тавих нь (хүний үйл ажиллагаанаас үүдсэн) түймрийн эрсдлийг	сонирхолд харшаар ашиглавал хураан авч болно.” Нийгмийн бүлгүүдийн тэгш оролцооны талаарх тайланд “Үндсэн хууль (1992), Газрын тухай хууль (2002), Ойн тухай хууль (2012), Төрөөс ойн талаар баримтлах бодлого (2015), Байгаль орчныг хамгаалах тухай хууль (1995)-д нутгийн иргэд ой, ойн нөөцийг албан бусаар эзэмших эрхийг хуульчилаагүй байна. Гагцхүү Ойн тухай хууль (2012)-ийн 4.6-д ойн сангийн тодорхой хэсгийг нутгийн иргэдэд (ойн нөхөрлөл) эзэмшүүлэхийг зөвшөөрсөн байна. Газрын тухай хууль (2002)-ийн 52.1-д нутгийн малчдад бэлчээрийн газар ашиглуулах (ойд мал бэлчээх тухай мөн орсон) талаар хуульчилсан байхаас гадна хадлан хадахыг зөвшөөрсөн боловч эрхийг нь албан ёсны блгож баталгаажуулаагүй. Сүүлийн үед хийсэн судалгаагаар хөдөө орон нутагт сайн бэлчээр, байгалийн нөөц ашиглахын тулд эрх мэдэл, хөрөнгө, улс төрийн нөлөө, танил талаа ашиглах явдал их байгааг харуулжээ. Монгол Улсад бэлчээрийн тухай хууль байхгүй боловч Газрын тухай хуульд дээр дурьдсан газар ашиглалтын тухай заалтуудаас гадна өөр заалтуудыг тусгасан байна. Газрын тухай хууль (2002)-ийн 52.2-т " Зуслан, намаржаа болон отрын бэлчээрийг баг, хот айлаар хуваарилж нийтээр ашиглана. Тухайн жилийн бэлчээрийн гарц, иргэдийн саналыг харгалзан өвөлжөө, хаваржааны бэлчээрийг	эмэгтэйчүүдийн нэр дээр бүртгэлтэй, өв залгамжлуулж байгаа газрын 27.2% нь эмэгтэйчүүдэд ногдож байна. Жендерийн талаарх уламжлалт ойлголт, өмч хөрөнгө эзэмших талаарх эмэгтэйчүүдийн ойлголт сул байгаа нь жендерийн тэгш байдлыг хангахад саад болж буй хүчин зүйлс юм. Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд антропологийн зориулалт бүхий тусгай хамгаалалттай газар байгуулах тухай заалт оруулж, цаатан иргэдийн эрхийг хамгаалах шаардлагатай. Ойн тухай хуулийн 20.1.4 дэх заалтын илүү нарийвчлан шинэчилж сайжруулах нь зүйтэй (талуудын өгсөн зөвлөмжийн дагуу).

	нэмэгдүүлж, зориудаар тавьсан түймэр хяналтаас гарна.	малаас чөлөөлөх, мал оруулах хугацааг сум, дүүргийн Засаг дарга тогтоож, баг, хорооны Засаг дарга, иргэд мөрдөж хэрэгжүүлнэ. Өвөлжөө, хаваржааны тодорхой нутаг бэлчээрийг талхлагдахаас хамгаалах, нөхөн сэргээх зорилгоор тухайн бүс нутгийн онцлог, бэлчээр ашиглаж ирсэн уламжлал, газрын даац, чадавхийг харгалзан, багийн иргэдийн Нийтийн Хурлын саналыг үндэслэн сумын Засаг дарга малчдад болзол, гэрээний дагуу хэсэг бүлгээр ашиглуулж болно.” гэж заасан. Ойн тухай хууль болон Газрын тухай хуулийн зарим заалт тодорхой бус байгаа нь газар, байгалийн баялаг эзэмших эрхэнд нөлөөлж болзошгүй. Газрын тухай хууль (2002)-ийн 52.3-т " Ойн сан бүхий газрыг зохих хууль тогтоомжийн дагуу бэлчээрт ашиглаж болно." гэсэн бол Ойн тухай хууль (2012)-д ойжуулсан, тарьц суулгац ургуулж байгаа талбайд мал бэлчээхийг хориглосон. Усан хангамж, усны нөөцийн ашиглалтын талаарх маргаантай холбоотой эрсдлийг шийдвэрлэх талаар Усны тухай хууль (2012)-ийн 23-р зүйлийн 1-т “Ган, цөлжилт, хуурайшилтын үеийн тэнцвэрийг хангах ажлыг бүх шатны Засаг дарга сав газрын захиргаатай хамтран зохион байгуулна” гэж зохицуулсан. Тусгай хамгаалалттай газар нутгийн үндэсний хөтөлбөр (1998)-ийн 3.4 дэхь	

		хэсэгт “Байгалийн унаган төрхийг хадгалах, экологийн тэнцлийг хангах, байгалийн баялгийг арвижуулах, байгаль, түүх, соёлын өвийг хамгаалах зорилгоор байгалийн бүс, бүслүүрийн үндсэн шинж, иж бүрдлийг төлөөлсөн, экологийн онцгой ач холбогдол бүхий газар нутгаар тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг өргөжүүлж, нийт улсын нутаг дэвсгэрийн 30-аас доошгүй хувьд хүргэх” зорилт дэвшүүлсэн." Ойн тухай хууль (2012)-д нөхөрлөл, аж ахуйн нэгж болон бусад этгээдэд ойн нөөцийг ашиглах, үр ашиг хүртэхийг зөвшөөрсөн хэд хэдэн заалт байдаг. Тухайлбал хуулийн 21.12.2 дахь хэсэгт "эзэмшлийн газраасаа ойн менежментийн төлөвлөгөө, эрхийн бичгийн дагуу бэлтгэсэн мод, ойн дагалт баялгийг ашиглах, хэрэгцээнээс илүү гарсан мод, ойн дагалт баялгийг худалдан борлуулах;" эрхтэй гэж тусгагдсан. Мөн хуулийн 35.2 дахь хэсэгт " Зохих зөвшөөрөл авсан иргэн ахуйн зориулалтаар, түүнчлэн ойн санг гэрээгээр эзэмшигч ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллага эзэмшлийнхээ талбайд энэ хуулийн 3.1.15-д заасан ойн цэвэрлэгээ хийх замаар, зохих зөвшөөрөл авсан ойн нөөц бүхий аймаг, сумын иргэд уламжлалт бүтээгдэхүүн үйлдвэрлэх зориулалтаар мод бэлтгэж болно." гэж заажээ. Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 6.2-т “Хуульд өөрөөр заагаагүй бол Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгж, байгууллага,	

		гадаадын иргэн, хуулийн этгээд байгалийн баялгийг зохих төлбөр, хураамжийг төлж, гэрээ, тусгай зөвшөөрөл буюу эрхийн бичгийн дагуу ашиглаж болно.”	
Уугуул болон нутгийн иргэдийн уламжлалт мэдлэг, соёлын өв, оюуны өмчийг хүлээн зөвшөөрч, хамгаалах	<u>Үр ашиг</u>: - Орон нутгийн иргэдийн байгаль хамгаалах уламжлалт хандлага, мэдлэгийг дэмжиж, түгээн дэлгэрүүлнэ - Мод бэлтгэл, мод боловсруулах, дагалт баялгийн ашиглалт, агро-ойн аж ахуйн үйл ажиллагааны үр дүнд орон нутгийн иргэд, аж ахуйн нэгжүүд, ойн нөхөрлөлүүдийн ажлын байр, орлого нэмэгдэнэ. - Зарим газарт эко-аялал жуулчлал хөгжиж, орон нутгийн иргэдийн амьжиргаа сайжирч, орон нутгийн төсвийн орлого нэмэгдэнэ - Амьжиргааны эх үүсвэрийн төрөл нэмэгдэж, экосистемийн үйлчилгээ сайжирсанаар нутгийн иргэдийн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадвар дээшилнэ - Ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, нутгийн иргэд, албан хаагчдын ойн менежмент, мод боловсруулах, тогтвортой ашиглах, нөхөн сэргээлт хийх, хамгаалах, дагалт баялаг ашиглах талаарх мэдлэг, ур чадвар сайжирна - Эмийн ургамал, түлээний мод зэрэг дагалт баялгийн нийлүүлэлт	Үндсэн хууль (2013)-ийн 7-р зүйл: " 1. Монголын ард түмний түүх, соёлын дурсгалт зүйл, шинжлэх ухаан, оюуны өв төрийн хамгаалалтад байна. 2. Иргэний туурвисан оюуны үнэт зүйл бол зохиогчийнх нь өмч, Монгол Улсын үндэсний баялаг мөн." Соёлын өвийн тухай хууль. БОАЖЯ Генетикийн нөөцийн тухай хуулийн төслийг боловсруулж байгаа бөгөөд олон нийттэй зөвлөлдөх уулзалтыг захион байгуулж байна. Энэхүү хуулийн төсөл хараахан бэлэн болоогүй. REDD+ БАХ-нүүд болон СНСЗ-уудыг тусгаж, хэрэгжүүлэхтэй хамаатай байж болох тул хуулийн төслийг нягталж үзэх шаардлагатай. Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль (1994) болон Орчны бүсийн тухай хуульд тусгай хамгаалалттай газар нутгийн ойр орчимд амьдарч байгаа иргэдийн уламжлалт амьдралын хэв маягийг дэмжихтэй холбоотой хэд хэдэн заалт байна. Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 17.2-т " Хязгаарлалтын бүсэд мал аж ахуй эрхэлж болно." гэж	

	нэмэгдэнэ. Мод бэлтгэл, дагалт баялаг, эмийн ургамлыг бэлтгэх журмыг сайжруулах боломж бүрдэнэ. <u>Эрсдлүүд</u>: - Хамгаалалттай газар нутгийг тэлснээр уламжлалт амьдралын хэв маягт дарамт учруулахаас гадна уламжлалыг хамгаалах одоогийн хууль журмуудтай зөрчилдөж болзошгүй - Мод бэлтгэлийн суурингийн орчимд архидалт, мансууруулах бодисын хэрэглээ зэрэг нийгмийн асуудлууд гарах эрсдэл - Генетикийн өөрчлөлт, мутацийн эрсдэл (шинэ сортын үр гаргах явцад) - Жуулчид ой болон байгалийн бусад хэсэгт ихээр нэвтрэх, байгалийн баялгийг аялал жуулчлалын салбарыг дэмжихэд ашиглах (модоор барилга барих, дагалт баялгийг ашиглах г.м). - Нийтийн хэрэгцээний болон бэлчээрийн зориулалтаар ашиглах талбайн хэмжээ багасч, малчын амьжиргаанд нөлөөлнө - Газар ашиглалтын хэлбэр өөрчлөгдсөнөөр нутгийн иргэдийн амьжиргааны эх үүсвэр хумигдаж, нүүдэл, шилжилт ихсэнэ.	заасан. Орчы бүсийн тухай хууль (1997 оны 10 сарын 23)-д уламжлалт амьдралын хэв маягт дарамж учруулахаас зайлхийж, уламжлалыг хадгалах зорилготой юм. (Хамгаалалттай газар нутгийг тэлснээр уламжлалт соёлд дарамт учрах эрсдэлтэй холбоотой). Генетикийн нөөцийн ашиглалттай холбоотой БХЖ-ууд. Байгалийн ургамлын тухай хууль (1995)-ийн 13.2-т " Эм бэлтгэн найруулах ажил, үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллага ховор болон элбэг ургамлыг эмийн үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглаж болно.”, мөн хуулийн 13.4-т " Ургамлын үндэс, үндэслэг иш, булцууны 50 ба түүнээс дээш хувийг үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах тохиолдолд тухайн ургамлыг тарималжуулсан байна." гэж заасан. Уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний хөтөлбөр (2011), 2.4.3 дахь хэсэгт " хүлэмжийн хийн ялгаралтыг багасгах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох үйл ажиллагаанд шинжлэх ухааны ололт, байгальд ээлтэй дэвшилтэт технологийг тууштай нэвтрүүлэх, үндэсний уламжлал, зан заншилтай хослуулсан байх" гэж тусгасан байна.	

Сайн дурын үндсэн дээр бус, эдийн засгийн үйл ажиллагаа явуулах шаардлагатай болсоны улмаас нутгийн иргэдийг нүүлгэн шилжүүлсэн тохиолдолд нөхөн төлбөр болон бусад үйлчилгээ авах эрх	<u>Үр ашиг:</u> - Иргэдийн байгаль орчны талаарх уламжлалт мэдлэг, хандлагыг дэмжиу, түгээн дэлгэрүүлнэ - Мод бэлтгэл, мод боловсруулах, дагалт баялгийн ашиглалт, агро-ойн аж ахуйн үйл ажиллагааны үр дүнд орон нутгийн иргэд, аж ахуйн нэгжүүд, ойн нөхөрлөлүүдийн ажлын байр, орлого нэмэгдэнэ. - Бэлчээрийн менежмент сайжирч, эрчимжсэн мал аж ахуй хөгжинө. Махны чанар дээшилж, хүнсний аюугүй байдал сайжирна <u>Эрсдлүүд</u>: - Зарим айлын амьжиргаанд сөргөөр нөлөөлж болзошгүй. Тухайбал, ан гөрөө хийх, хатсан мод цуглуулах зорилгоор зориудын түймэр тавьдаг, ойн дагалт баялаг ашигладаг, хууль бус мод бэлтгэл ба хууль бус худалдаанд оролцдог, усны эх үүсвэр ашигладаг хүмүүст сөргөөр нөлөөлнө. Ядуурал болон амьдрах орчны бэрхшээлтэй асуудал улам нэмэгдэнэ. Эндээс гарах үр дүн тэгш бус байна. - Газар ашиглалтын хэлбэр өөрчлөгдсөнөөр хүн амын амьжиргаа буурч, шилжилт хөдөлгөөн ихсэнэ. - Хамгаалалттай газар нутгийг тэлснээр уламжлалт амьдралын хэв маягт дарамт учруулахаас гадна	Газар болон байгалийн нөөц ашиглах боломжийг нь хязгаарлаж, сөрөг нөлөө учруулсан тохиолдолд нөхөн төлбөр олгох тухай БХЖ байхгүй. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, Ашигт малтмалын тухай хуулийг нягталж үзэх шаардлагатай. Аливаа үйл ажиллагаа, БХЖ-ын нөлөөнд өртөж болзошгүй хүмүүстэй уулзаж, зөвлөлдөж байх шаардлагыг бусад СНСЗ-ын элементүүдийн хүрээнд авч үзсэн байна (Захиргааны ерөнхий хууль, гомдол барагдуулах журам г.м). Ойн тухай хууль болон Газрын тухай хуулийн зарим заалт тодорхой бус байгаа нь газар, байгалийн баялаг эзэмших эрхэнд нөлөөлж болзошгүй. Газрын тухай хууль (2002)-ийн 52.3-т " Ойн сан бүхий газрыг зохих хууль тогтоомжийн дагуу бэлчээрт ашиглаж болно." гэсэн бол Ойн тухай хууль (2012)-д ойжуулсан, тарьц суулгац ургуулж байгаа талбайд мал бэлчээхийг хориглосон. Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль (1994) болон Орчны бүсийн тухай хуульд тусгай хамгаалалттай газар нутгийн ойр орчимд амьдарч байгаа иргэдийн уламжлалт амьдралын хэв маягийг дэмжихтэй холбоотой хэд хэдэн заалт байна. Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 17.2-т " Хязгаарлалтын бүсэд мал аж ахуй эрхэлж болно." гэж	Үндэсний REDD+ Стратегид энэ СНСЗ-ыг тусгаж, хэрэгжүүлэх журмыг боловсруулж, ашиглах талаар харгалзаж үзэх шаардлагатай. Иргэдийг хүйтний улиралд хүчээр нүүлгэн шилжүүлэхийг хориглосон хуулийн заалт хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа. Хүйтний улиралд албадан нүүлгэн шилжүүлэх гэж байгаа иргэдэд нөхөн олговор олгох болон бусад үйлчилгээ үзүүлэхтэй холбоотойгоор холбогдох хуулиудыг сайжруулах шаардлагатай. Ой бүхий газарт мал бэлчээхтэй холбоотой Ойн тухай хууль болон Газрын тухай хууль хоорондын зөрчил юм. Дээрх хоёр хуулийг шинэчилж зулзган ой бүхий газарт мал бэлчээхийг хориглох шаардлагатай.

	уламжлалыг хамгаалах одоогийн хууль журмуудтай зөрчилдөж болзошгүй - Хөнөөлт шавжтай тэмцэх ажлыг гүйцэтгэж буй хүмүүсийн эрүүл мэнд, аюулгүй байдалд эрсдэл учирч болзошгүй (харшил, өндөр ууланд авирах г.м)	заасан. Орчны бүсийн тухай хууль (1997 оны 10 сарын 23)-д уламжлалт амьдралын хэв маягт дарамж учруулахаас зайлхийж, уламжлалыг хадгалах зорилготой юм. (Хамгаалалттай газар нутгийг тэлснээр уламжлалт соёлд дарамт учрах эрсдэлтэй холбоотой).	

ХАВСРАЛТ 3.4

Зарчим D: Оролцогч талууд, тухайлбал, нутгийн иргэд, орон нутгийн иргэдийн бүрэн бөгөөд үр дүнтэй оролцоог хангах

Сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчмын элементүүд	**Гол үр ашиг, эрсдлүүд** Монгол оронд REDD+-ийн хүрээнд хэрэгжүүлэхээр санал болгосон бодлого, арга хэмжээнүүдийн үр ашиг, эрсдлийн үнэлгээнээс тодорхойлсоноор	**СНСЗ-уудыг тусгаж, хэрэгжүүлэхтэй холбоотой БХЖ-ууд** (СНСЗ-уудтай холбоотой БХЖ-ын үнэлгээнд тулгуурласан)	**Цаашид сайжруулах шаардлагатай асуудлууд** Тухайн СНСЗ-ыг Монгол улсын БХЖ-уудад илүү сайн тусгаж хэрэгжүүлэхийн тулд юуг сайжруулах ёстой талаар
REDD+-ийн тодорхой үйл ажиллагаанд нөлөөлөх, эсвэл нөлөөнд өртөж болзошгүй оролцогч талуудыг тодорхойлох	<u>Үр ашиг</u>: - Хувийн хэвшлийг дэмжихэд ойн салбарын үүрэг оролцоо сайжирч, мод бэлтгэх шинэ боломж бүрдэж, нутгийн иргэд, захиргаа болон хувийн хэвшлийн хамтын ажиллагаа сайжирна -Ойн нөхөрлөлүүд ойн түймэр болон хөнөөлт шавжтай тэмцэх үйл ажиллагаанд оролцох идэвхи дээшилнэ - Мод бэлтгэл, боловсруулах үйл ажиллагааны үр дүнд (орон нутгийн иргэд, малчид, аж ахуйн нэгжүүд, ойн нөхөрлөлүүдийн) ажлын байр, орлого нэмэгдэнэ. Ойн зам барих чиглэлээр нарийн мэргэжлийн ажлын байр нэмэгдэнэ - Ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, нутгийн иргэд, албан хаагчдын ойн менежмент, мод боловсруулах, тогтвортой ашиглах, нөхөн сэргээлт хийх, хамгаалах, дагалт баялаг	Ойн салбарын үйл ажиллагаанд талуудыг оролцуулахыг дэмжсэн олон БХЖ байгаа бөгөөд тэдгээр талууд гэж хэн болохыг зааж өгсөн байна. Төрөөс ойн талаар баримтлах бодлого (2015)-ын 3.4.2-т " ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээнд хувийн болон аж ахуйн нэгж, байгууллагаас оруулах хөрөнгө оруулалтыг дэмжих хөшүүрэг, механизмыг бий болгох." зорилт дэвшүүлсэн байна. Ойн тухай хууль (2012), 4.4.2-т " сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлын саналыг үндэслэн ойн сангийн тодорхой хэсгийг тогтоосон хугацаа, нөхцөл, болзолтойгоор гэрээний дагуу ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагын эзэмшил, ашиглалтад шилжүүлнэ" гэсэн бол ойн ангийн гүйцэтгэх үүргийг заасан 18.3.6 дахь хэсэгт " ойн сангийн тодорхой хэсгийг эзэмшигч ойн нөхөрлөл, аж ахуйн	Оролцогч талуудын ойн менежментийн оролцооны талаар тусгасан заалтуудыг нэгтгэж тусад нь журам гаргах. Ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээний ажлыг төлөвлөх, зохион байгуулах, санхүүжүүлэх, тарималойг үнэлэх, улсын ойн санд худалдан авах, өмчлүүлэх журам (БОНХ- ийн сайд, Сангийн сайдын хамтарсан тушаал No. А-96\71 2013 он)-д хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдийн тарьсан бүх төрлийн (залуу ойг) тарималойг улс баталгаатай эргүүлэн худалдан авдаг байх талаар заалт оруулах нь зүйтэй. Үүнээс гадна, төсвийн ачааллыг

	ашиглах талаарх мэдлэг, ур чадвар сайжирна - Орон нутгийн иргэд, төрийн байгууллага болон заган ойн менежментээр мэргэшсэн мэргэжлийн байгууллагуудын заган ойн тогтвортой ашиглалт, нөхөн сэргээлтийн талаарх мэдлэг, туршлага нэмэгдэнэ. - Орон нутгийн малчдын бүлэг бэлчээрийн менежментийн талаар туршлагатай болж чадавхжина. - Ойн хамгаалалт, менежментэд орон нутгийн иргэдийн оролцоог нэмэгдүүлснээр ойн төлөв байдал, экосистемийн үйлчилгээ сайжирна - Тусгай хамгаалалттай газар нутгийн менежментэд талуудыг оролцуулсанаар засаглал, оролцоо сайжирна - Гэрчилгээ олгох, ойн менежментийн үйл ажиллагаанд талуудын оролцоог дээшлүүлэх боломжтой болно. <u>Эрсдлүүд</u>: - Хувийн аж ахуй нэгж байгууллагын зүгээс орон нутгийн иргэдийн оролцоог хангаагүйгээс, орон нутгийн иргэдийн олох орлого буурна. - Монополь байдал үүсэж, орон нутгийн хувиараа аж ахуй эрхлэгч, жижиг үйлдвэр, цехийн үйл ажиллагаа зах зээлээс шахагдана. Технологийн үнэ, өртгөөс	нэгж, байгууллагад мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх;" гэж заасан. Зарим БХЖ нь тодорхой үйл ажиллагаанд оролцох талуудын оролцооны талаар тусгайлан заасан байна. Ойн цэвэрлэгээний хөтөлбөр (2014)-ийн 5.4 дэхь хэсэгт Ойн цэвэрлэгээний ажлыг ойн мэргэжлийн аж ахуйн нэгж болон ойн санг гэрээгээр эзэмшигч нөхөрлөл, ажилгүй иргэдийг оролцуулан гүйцэтгэнэ гэж заасан. Энэ нь оролцогч талууд, ойн нөхөрлөл, жижиг аж ахуйн нэгжүүдэд боломж бүрдүүлж өгсөн заалт юм (өмнө тодорхойлсон үр ашиг, эрсдлүүдтэй холбоотой). Ойн тухай хууль (2012)-ийн 27.3-т " Ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллага гэрээний дагуу эзэмшиж байгаа ойн сангийн тодорхой хэсгийг хөнөөлт шавж, өвчнөөс хамгаалах арга хэмжээг өөрийн хөрөнгөөр хэрэгжүүлнэ." гэжээ. Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн тухай хуульд орчны бүсийн зөвлөлийн статусыг хуульчилж, уг зөвлөл нь олон талын төлөөллөөс бүрдсэн байх ёстой гэсэн шаардлага тавьсан байна. Бусад оролцооны төрлийн талаар мөн заасан заалтууд байна. Тухайлбал Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (2005)-ийн 7.1.2-т 7^{1}.2.Сум, дүүргийн төсвийн хүрээнд худалдан авах	бууруулахын тулд байгалийн сэргэн ургалт илүү үр дүнтэй байх газруудыг сонгож мод тарихыг зөвшөөрсөн шинэ журам буюу эсвэл удирдамж боловсруулах шаардлагатай. Ойн тухай хууль (2012)-д ойн менежментийн хэд хэдэн чиглэлээр талуудын оролцоог хангах тухай заалт тусгасан байгаа нь эдгээр заалтуудыг нэгтгэн нэг журамд оруулахад дэмжлэг болох юм. Оролцогч талуудын ойн менежментийн оролцооны талаар тусгасан заалтуудыг нэгтгэж тусад нь журам гаргах. Төр хувийн ААНБ-ын материаллаг бааз суурийг бэхжүүлэхийн тулд концессийн зээлийг дэмжих хэрэгтэй. Орон нутгийн захиргаа орлогын өөр эх үүсвэр бий болгож байгалийн баялгийн хамаарлыг бууруулах арга хэмжээ авах шаардлагатай.

	шалтгаалан жижиг үйлдвэрлэгч шахагдана (өрхийн үйлдвэрлэл г.м) - Зарим БАХ байгууллагуудад чиглэсэн байх тул орон нутгийн иргэдийн оролцоо, үр ашиг буурах эрсдэлтэй - Ойн нөхөрлөл эсвэл орон нутаг бүр шинэ замтай болж чадахгүй, замын хүрэлцээ муу байж болзошгүй. - Мал ихтэй, илүү гарааны хөрөнгөтэй нутгийн зарим иргэд, айл өрхүүд бэлчээрийн нутаг, агро ойн аж ахуйн БАХ-ээс илүү ашиг хүртэнэ - Аж ахуйн нэгж, ойн нөхөрлөлүүдийн дунд ойн нөөцийн ашиглалттай холбоотой зөрчил үүсч, нутгийн иргэдийн зүгээс ойн нөөцийг ашиглах боломж, ашиглалттай холбоотой гомдол гаргана - Усан хангамж, ой хамгаалах, нөхөн сэргээлт хийхэд зориулж төлөвлөсөн газрыг ашиглах хүсэлтэй малчид маргаан, зөрчил үүсгэж болзошгүй. Бэлчээрийн менежментийг сайжруулах, хуурай газартай холбоотой БАХ-г хэрэгжүүлсэнээр бэлчээрийн газар хомсдож, одоогийн бэлчээрийн зохион байгуулалттай зөрчилдөж болзошгүй.	хорин сая хүртэлх төгрөгийн өртөгтэй бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг олон нийтийн оролцоотойгоор зохион байгуулж болно." гэжээ. Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хууль (2013)-ийн 1 дүгээр зүйлд "Ойжуулалт, цэцэрлэгжүүлэлт, ойн аж ахуйн үйл ажиллагааны зардлыг нэмүү өртгийн албан татвараас чөлөөлнө" гэж заасан нь ойн аж ахуйн үйл ажиллагаанд оролцох жижиг аж ахуйн нэгж, нөхөрлөлүүдийн чадавхийг бэхжүүлж, үр ашиг хүртэх боломжийг нь бүрдүүлж өгсөн байна.	Ойн нөхөрлөлүүдийн хортон шавжны талаарх мэдлэг, хяналт тавих чадавхийг нь дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх.

Мэдээлэл, зөвлөгөө авах, оролцох, эрх зүйн хувьд эрх тэгш байх зэрэг эрхийг хүндэтгэх, хэрэгжүүлэх	<u>Үр ашиг</u>: - Мод тарих ажилд нутгийн иргэдийг оролцуулсанаар олон нийтэд мэдээлэл илүү ил тод болж, улмаар иргэдийн оролцоотой хяналт сайжирна - Гал түймэр, хөнөөлт шавжтай тэмцэх ажилд ойн нөхөрлөлүүдийн оролцоо сайжирна - Тусгай хамгаалалттай газар нутгийн менежментэд талуудыг оролцуулсанаар засаглал, оролцоо сайжирна - Гэрчилгээ олгох, ойн менежментийн үйл ажиллагаанд талуудын оролцоог дээшлүүлэх боломжтой болно - Хууль бус мод бэлтгэл, хууль бус мод бэлтгэлтэй тэмцэж байгаа талаарх мэдээллийн ил тод байдал сайжирна - Иргэд, ИНБ-ын улсын төсөв, зарцуулалтын талаарх мэдлэг сайжирна <u>Эрсдэл:</u> - Мэдээллийн оновчгүй байдлаар түгээснээр зорилтот бүлэгт мэдээдэл хүрэхгүй байх эрсдэлтэй - Шударга бус хуваарилалт, зохицуулалтын тодорхой бус байдал, байгалийн нөөцийн ашиглалтаас үүдэн нөхөрлөлүүд, орон нутгийн иргэдийн хооронд газар нутаг, ашиглалтын өрсөлдөөн, зөрчил үүсэх	Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль (2011)-д иргэд, аж ахуйн нэгжүүдийн мэдээлэл авах эрхийн талаар тодорхой заасан. СНСЗ В-ийн В8-г үз. Талуудаас өгсөн санал: Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуульд хуулийн этгээд болон иргэдийн н хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор хууль тогтоомжид нийтэд мэдээлэхийг хориглосноос бусад мэдээллийг чөлөөтэй, ил тод, хараат бус байдлаар авах эрхтэй гэж заасан. Шинээр боловсруулж байгаа бодлогын баримт бичиг болон захиргааны хэм хэмжээний актын шийдвэрийн төслийг цахим хуудсандаа 30-аас доошгүй хоног ойлгомжтой байдлаар байрлуулж, холбогдох төрийн ба төрийн бус байгууллага, мэргэжлийн шинжээч, эрдэмтэн, иргэдийн саналыг авах, үндэслэлтэй гэж үзвэл уг саналыг төсөлд тусгахыг мөн хуульчилсан. Гомдол барагдуулах механизмтай холбоотой зарим БХЖ-ын заалтууд энэ СНСЗ-тай хамаатай байна. Жишээ нь, Захиргааны ерөнхий хууль (2015) Хэм хэмжээний актын талаар шийдвэр гаргахаас өмнө авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийг заасан (зөвхөн хэм хэмжээний актаар хязгаарласан гэдгийг анхааруулсан). Шинээр хууль, журам	Ойн тухай хуулийн хүрээнд ашиг хуваарилах, зохицуулах, байгалийн нөөцийн ашиглалттай холбоотой маргааныг зохицуулах тусгай шинэ журам боловсруулах шаардлагатай. Энэ журмын дагуу ойн нөхөрлөлийн менежментийн төлөвлөгөөнд орон нутгийн иргэдийн оролцооны талаар болон үр ашгийн хуваарилалтыг нийтээрээ зөвлөлдсөний үндсэн дээр хийдэг байх заалтыг тусгасан байна. Ойн гэрчилгээ олгох газар нутгийг сонгохдоо нээлттэй байдал, ил тод байдлыг хангахын тулд Ойн тухай хуулийн хүрээнд холбогдох журмыг шинэчлэх шаардлагатай. Тийнхүү шинэчлэхдээ гэрчилгээ хүсч буй ААН-үүд орон нутгийн иргэдэд нийгмийн үр ашиг бүрдүүлэх шаардлагыг тусгаж өгөх хэрэгтэй. Оролцогч талуудад мэдээллийг оновчтой хүргэх орчинг бий болгох. Жишээ нь олон улсын тайлагнах үйл явцыг мэдээллээр хангах г.м.

	- Зарим БАХ нь аж ахуйн нэгжүүдэд чиглэсэн байх тул нутгийн иргэдийн оролцоо, хүртэх үр ашиг хангалтгүй байх - Нутгийн иргэд эрчим хүчний шинэ эх үүсвэрийг ашиглах байдал бага, сүүлийн үеийн технологийн хүрэлцээ хангалтгүй байх	боловрсуулж, энэ талаар зөвлөлдөж байх явцад холбогдох талуудад урьдчилж мэдээлэх, мэдээлэл түгээх, санал, гомдол хүлээн авах механизмыг бүрдүүлэхийг хуульчилсан байна. Байгаль орчинд нөлөөлөлх байдлын үнэлгээний тухай хуульд үнэлгээний шатанд нутгийн иргэдэд мэдээлэл өгч, саналыг нь тусган хэрэгжүүлнэ гэж заасан.	
REDD+-ийн хүрээнд Үндэсний стратеги, үйл ажиллагааны төлөвлөгөө болон бусад холбогдох нийгэм, байгаль орчны СНСЗ-ын арга хэмжээг боловсруулах, тэдгээрийг хэрэгжүүлэх, хяналт тавих үйл явцад талуудыг оролцуулах механизм	<u>Үр ашиг:</u> - Мод бэлтгэх боломж нэмэгдэх, нутгийн иргэд, төрийн байгууллага, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа сайжирсанаар хувийн хэвшлийн салбарыг дэмжихэд ойн салбарын гүйцэтгэх үүрэг дээшилнэ. - Гал түймэр, хөнөөлт шавжтай тэмцэх ажилд ойн нөхөрлөлүүдийн оролцоо сайжирна - Ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, нутгийн иргэд, албан хаагчдын ойн менежмент, мод боловсруулах, тогтвортой ашиглах, нөхөн сэргээлт хийх, хамгаалах, дагалт баялаг ашиглах талаарх мэдлэг, ур чадвар сайжирна - Орон нутгийн иргэд, төрийн байгууллага болон заган ойн менежментээр мэргэшсэн мэргэжлийн байгууллагуудын заган ойн тогтвортой ашиглалт, нөхөн	Байгалийн нөөцийн менежментэд олон талт оролцоог хангахад чиглэсэн хэд хэдэн механизм байдаг. Тухайлбал: - Иргэдийн төлөөлөгчдийн хурал - ТХГН-ийн хамгаалалтын захиргаа - Орчны бүсийн зөвлөл: ТХГН-ийн орчны бүсийн тухай хууль (1997-д орчны бүсийн эрх зүйн статусыг тодорхойлж, зөвлөл нь олон талын төлөөлөгчдөөс бүрдсэн байх ёстой гэж заасан байна. Тус хуулийн 6-р зүйлийн 6.1-т " Орчны бүсийн хөгжлийг зохицуулах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээхэд нутгийн иргэдийн оролцоог өргөжүүлэх зорилго бүхий орон тооны бус орчны бүсийн зөвлөл /цаашид “Зөвлөл” гэх/ ажиллана. “гэж заасан. - Сав газрын захиргаа Ойн нөхөрлөл, ойн мэргэжлийн байгууллагууд ой хамгаалах талаар тодорхой эрх, үүрэг хүлээнэ. Ойн тухай	Оролцогч талуудаас: Хөгжлийн болдлогын тухай хуулийн хүрээнд төрөөс салбар дундын зохицуулалтыг хангах журам боловсруулах шаардлагатай. Ойн тухай хууль болон журмыг хэрэгжүүлэхэд учирч буй гол хүндрэл бол хяналт дутуу явдал юм. Хяналт шалгалтын хариуцлага болон санхүүжилтийг шинэ журам эсвэл дүрмэнд тодорхойлж мөн ойн нөхөрлөлүүд болон орон нутгийн оролцоог тусгах шаардлагатай.

	сэргээлтийн талаарх мэдлэг, туршлага нэмэгдэнэ. - Орон нутгийн малчдын бүлэг бэлчээрийн менежментийн талаар туршлагатай болж чадавхжина, бэлчээрийн менежментэд талуудын оролцох оролцоо сайжирна. - Тусгай хамгаалалттай газар нутгийн менежментэд оролцогч талуудын оролцоог өргөжүүлснээр засаглал болон олон нийтийн оролцоо нэмэгдүүлэх - Гэрчилгээ олгох, ойн менежментийн үйл ажиллагаанд талуудын оролцоог дээшлүүлэх боломжтой болно - Ойжуулалтыг орон нутгийн иргэдээр хийлгэснээр ажлын үр дүн аймаг, сумын хэмжээнд ил тод болж, орон нутгийн иргэдийн оролцоотой хяналтын ажил сайжирна - Хууль бус мод бэлтгэл, хууль бус мод бэлтгэлтэй тэмцэж байгаа талаарх мэдээллийн ил тод байдал сайжирна - Иргэд, ИНБ-ын улсын төсөв, зарцуулалтын талаарх мэдлэг сайжирна <u>Эрсдэл:</u> - Аж нэгжүүд нутгийн иргэдийг үйл ажиллагаандаа оролцуулахгүй байсаны улмаас орон нутгийн	хууль (2012)-ийн 21.12.2 дахь хэсэгт "эзэмшлийн газраасаа ойн менежментийн төлөвлөгөө, эрхийн бичгийн дагуу бэлтгэсэн мод, ойн дагалт баялгийг ашиглах, хэрэгцээнээс илүү гарсан мод, ойн дагалт баялгийг худалдан борлуулах;" эрхтэй гэж тусгагдсан, 31.2 дахь хэсэгт “Сум, дүүрэг, баг, хорооны Засаг дарга мод суулгах талбайг сонгох, хөрс боловсруулах, тарьц суулгацаар хангах, тэдгээрийг услах, арчлах ажлыг ойн мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулж, уг ажилд иргэдийг татан оролцуулна.” гэж заасан байна. Мөн Ойн тухай хууль (2012)-д хяналт тавих талаарх үүрэг хариуцлагын тухай заасан байна. Хуулийн 25.1.1 дэхь хэсэгт “ТББ нь олон нийтийг төлөөлөн ойн тухай хууль тогтоомжийн биелэлтэд олон нийтийн хяналт тавих, үзлэг хийх, илэрсэн зөрчлийг арилгахыг шаардах, уг асуудлыг эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх, гэм буруутай этгээдээс ойн санд учруулсан хохирлыг барагдуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй” гэж заажээ. Мөн Ойн цэвэрлэгээ хөтөлбөрийн 3.1.5 дахь хэсэгт хөтөлбөрт хяналт тавих ажлыг ТББ болон нутгийн иргэд хэрэгжүүлж болно гэсэн байна.	

	иргэдийн цаашид орлого олох боломж хумигдана. - Монополь бий болж орон нутгийн бизнесийн үйл ажиллагаа, жижиг аж ахуйн нэгжүүд шахагдана. Технологийн зардлаас хамааараад жижиг үйлдвэрлэл (өрхийн үйлдвэрлэл г.м)-д бэрхшээл тулгарна. - Зарим БАХ нь аж ахуйн нэгжүүдэд чиглэсэн байх тул нутгийн иргэдийн оролцоо, хүртэх үр ашиг хангалтгүй байх - Аж ахуйн нэгж, ойн нөхөрлөлүүдийн дунд ойн нөөцийн ашиглалттай холбоотой зөрчил, нутгийн иргэдийн зүгээс ойн нөөцийг ашиглах боломж, ашиглалттай холбоотой гомдол, зөрчил үүснэ - Усан хангамж, ой хамгаалах, нөхөн сэргээлт хийхэд зориулж төлөвлөсөн газрыг ашиглах хүсэлтэй малчид маргаан, зөрчил үүсгэж болзошгүй. Бэлчээрийн менежментийг сайжруулах, хуурай газартай холбоотой БАХ-г хэрэгжүүлсэнээр бэлчээрийн газар хомсдож, одоогийн бэлчээрийн зохион байгуулалттай зөрчилдөж болзошгүй. -БАХ хэрэгжсэнээр ТХГН-аас хамаарах хандлага нэмэгдэнэ. Хууль бус мод бэлтгэлийг бууруулах БАХ нь хууль хэрэгжүүлэх		

	байгууллагуудад чиглэсэн байх тул орон нутгийн иргэдийн оролцоо, санаачлагатай байдал буурч болзошгүй. - Үрсэлгээнүүд хатаж,ургахгүй болсоноос болж торгуулт ногдуулах, эсвэл ажлын үр дүн хангалтгүй байснаас шалтгаалж иргэдийн итгэл алдарч, идэвхи санаачилга суларна.		
Санал, гомдол барагдуулах үр дүнтэй механизм	<u>Үр ашиг:</u> - Тусгай хамгаалалттай газар нутгийн менежментэд оролцогч талуудын оролцоог өргөжүүлснээр засаглал болон олон нийтийн оролцоо нэмэгдүүлэх - Гэрчилгээ олгох, ойн менежментийн үйл ажиллагаанд талуудын оролцоог дээшлүүлэх боломжтой болно <u>Эрсдэл:</u> - Талуудын хооронд үр ашиг хуваарилах, зохицуулах, ашиглахтай холбоотой зөрчил үүснэ - ТХГН-ийн захиргаад, орон нутгийн захиргаа, нутгийн иргэд, ойн нөхөрлөлүүдийн дунд амьжиргааны арга хэмжээ, байгаль хамгаалах орлогын зарцуулалт, ойн нөөцийн ашиглахтай холбоотой зөрчил үүснэ - Аж ахуйн нэгж, ойн нөхөрлөлүүдийн дунд ойн нөөцийн	Ойн нөөцийн үр ашгийг хуваарилалт, зохицуулалт, нөөцийн ашиглалтын талаар зөрчил маргаан гарсан тохиолдолд түүнийг шийдвэрлэх тодорхой БХЖ байхгүй байна (байгалийн нөөцийг ашиглах, үр ашиг хүртэхтэй холбоотой эрсдлүүд). Гэхдээ ерөнхий гомдол, санал хүлээж авч шийдвэрлэх БХЖ, механизмууд байдаг. Захиргааны хууль (2016)-д хэм хэмжээний актын талаар шийдвэр гаргахаас өмнө авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийг заасан. Шинээр хууль, журам боловрсуулж, энэ талаар зөвлөлдөж байх явцад холбогдох талуудад урьдчилж мэдээлэх, мэдээлэл түгээх, санал, гомдол хүлээн авах механизмыг бүрдүүлэхийг хуульчилсан байна. Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх тухай хууль (1995) нь иргэдэд	Гомдол барагдуулах тодорхой механизм байгаа боловч эдгээр нь ойн салбартай хэрхэн холбогдож байгаа талаар цаашид судлах шаардлагатай байж болох юм. Ойн нөөцийн үр ашгийг хуваарилалт, зохицуулалт, нөөцийн ашиглалтын талаар зөрчил маргаан гарсан тохиолдолд түүнийг шийдвэрлэх тодорхой БХЖ байхгүй байгаа энэ үед судалгаа маш чухал. REDD+ хөтөлбөрийн зүгээс ярвигтай гэж тодорхойлсон нөхцөл байдал үүсэх үед эдгээр механизм хэрхэн ажиллах вэ? Жишээ нь, Газрын тухай хууль, Ойн тухай хуулийн зөрчилтэй заалтуудыг хэрхэн

	ашиглалт, ойн цэвэрлэгээтэй холбоотой зөрчилзөрчил үүснэ - Хамгаалалттай газар нутгийг тэлснээр уламжлалт амьдралын хэв маягт дарамт учруулахаас гадна уламжлалыг хамгаалах одоогийн хууль журмуудтай зөрчилдөж болзошгүй - Байгалийн нөөц ашиглах, тэгш үр ашиг хүртэх боломжгүй болсноор ойн нөөцөөс (зөвшөөрөлтэй болон хууль бус мод бэлтгэл, ан, дагалт баялгийн ашиглалт г.м) хамаарч амьжиргаагаа залгуулдаг айл өрхөд сөргөөр нөлөөлнө	төрийн байгууллагатай холбоотой асуудлаар өргөдөл, гомдол гаргах арга замыг хуульчилж өгсөн. Аль ч байгууллагад ямар ч төрлийн өргөдөл, гомдол ирж болно. Ирсэн гомдлыг холбогдох байгууллагууд руу нь илгээх ёстой. Өргөдөл гомдлыг баримтжуулж, дүн шинжилгээ хийх үүрэгтэй Өргөдлийн байнгын хороо мөн ажиллаж байна. Иргэд энэ системд гаднаас нэвтэрч санал гомдлоо nlгадна аль шатанд шийдвэрлэгдэж байгаа талаар мэдэх боломжтой. Мөн Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комиссын тухай хууль (2000) болон уг хуулийг хэрэгжүүлэгч байгууллага (Үндэсний комисс) нь хүний эрхийн зөрчилтэй холбоотойгоор аж ахуйн нэгж, байгууллага, иргэдээс ирүүлсэн гомдлыг зохицуулах чиг үүрэгтэй.	шийдвэрлэх вэ гэдэг талаар судлах шаардлагатай. Ойн тухай хуулийн хүрээнд ашиг хуваарилах, зохицуулах, байгалийн нөөцийн ашиглалттай холбоотой маргааныг зохицуулах тусгай шинэ журам боловсруулах шаардлагатай. Энэ журмын дагуу ойн нөхөрлөлийн менежментийн төлөвлөгөөнд орон нутгийн иргэдийн оролцооны талаар болон үр ашгийн хуваарилалтыг нийтээрээ зөвлөлдсөний үндсэн дээр хийдэг байх талаарх заалтыг тусгасан байх шаардлагатай.

ХАВСРАЛТ 3.5

Зарчим Е: Тэдгээр үйл ажиллагаа нь байгалийн ой, биологийн олон янз байдлыг хамгаалах асуудалтай нийцсэн байх ба [REDD+] үйл ажиллагааг байгалийн ойг хувиргахад ашиглах бус харин байгалийн ой болон түүнийг экосистемийн үйлчилгээг хамгаалахад чиглэсэн урамшуулал бий болгох, мөн нийгэм, байгаль орчны бусад үр ашгийг сайжруулахад ашигладаг байх

Сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчмын элементүүд	**Гол үр ашиг, эрсдлүүд** Монгол оронд REDD+-ийн хүрээнд хэрэгжүүлэхээр санал болгосон бодлого, арга хэмжээнүүдийн үр ашиг, эрсдлийн үнэлгээнээс тодорхойлсоноор	**СНСЗ-уудыг тусгаж, хэрэгжүүлэхтэй холбоотой БХЖ-ууд** (СНСЗ-уудтай холбоотой БХЖ-ын үнэлгээнд тулгуурласан)	**Цаашид сайжруулах шаардлагатай асуудлууд** Тухайн СНСЗ-ыг Монгол улсын БХЖ-уудад илүү сайн тусгаж хэрэгжүүлэхийн тулд юуг сайжруулах ёстой талаар
Байгалийн ойн тодорхойлолт (хууль эрх зүйн бүх баримт бичигт байгаа тодорхойлолттой нийцсэн, ойн хүлэмжийн хийн ялгарлын түвшин, Үндэсний стратеги болон үйл ажиллагааны төлөвлөгөөний баримт бичигт нэгэн жигд тодорхойлсон байх) байгалийн ойн орон зайн тархалтын талаарх ойлголт	<u>Үр ашиг:</u> - Эмийн ургамал, түлээний мод зэрэг дагалт баялгийн нийлүүлэлт нэмэгдэнэ. Мод бэлтгэл, дагалт баялаг, эмийн ургамлыг бэлтгэх журмыг сайжруулах боломж бүрдэнэ. - Байгалийн сэргэн ургалт, нөхөн сэргээлтийн арга хэмжээ сайжирсанаар ойн өсөлт бүтээмж дээшилнэ. - Ойн экосистемийн үйлчилгээ сайжирч, биологийн төрөл зүйлийн амьдрах орчин тэлж, амьтдын нүүдэллэх зай талбай нэмэгдэнэ. <u>Эрсдэл:</u> - Байгалийн нөөц ашиглах, тэгш үр ашиг хүртэх боломжгүй болсноор ойн нөөцөөс (зөвшөөрөлтэй болон хууль бус мод бэлтгэл, ан, дагалт	Ойн тухай хууль (2012) (?) 3.1. Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно: 3.1.1. “ой” гэж мод, бут, сөөг болон бусад ургамал, хаг хөвд, амьтан, бичил биетэн шүтэлцэн орших хам бүрдлийн экологи-газарзүйн онцлог нөхцөл бүхий орчныг". Ойн тооллогын удирдамжид 0.3 хүртэлх нягтшил бүхий ойг байгалийн ой гэж тодорхойлсон байна.	Эхний судалгаанаас үзэхэд Монголд байгалийн ойг тодорхойлсон нэгдсэн тодорхойлолт байхгүй байна. Энэ нь нэг талаараа Монголын ой ерөнхийдөө тарималь бус байдагтай нь холбоотой байж болох юм. Ойн тооллогын удирдамжинд байгалийн ойг дараах байдлаар тодорхойлсон байна: Байгалийн ой гэдэг нь шигүү байдлаараа хэмжигддэг, чанарын тодорхой түвшинд хүрээд буцаж доройтдог ой.

	баялгийн ашиглалт г.м) хамаарч амьжиргаагаа залгуулдаг айл өрхөд сөргөөр нөлөөлнө - Генетикийн өөрчлөлт, мутаци явагдана (шинэ сортын үр гаргах явцад)		
REDD+-ийн үйл ажиллагааг боловсруулан эрэмбэлж хэрэгжүүлэхдээ ой болон ойн гаднах орчинд шууд бус газар ашиглалтын өөрчлөлт бий болгох, байгалийн ой, нүүрстөрөгчийн шингээлт, биологийн олон янз байдал болон бусад экосистемийн үйлчилгээнд сөрөг нөлөө учруулахаас зайлсхийх буюу өөрчлөлтийн нөлөөг аль болох бага байлгаж, оронд нь тэдгээрийг хамгаалах үйл ажиллагааг нэн тэргүүнд тавина.	<u>Үр ашиг:</u> - Ойн экосистемийн үйлчилгээ сайжирч, биологийн төрөл зүйлийн амьдрах орчин тэлж, амьтдын нүүдэллэх зай талбай нэмэгдэнэ - Төрөөс таримал ойг худалдан авах зэрэг олон нийтийг дэмжсэн гэрээт урамшууллын арга хэмжээ нь орон нутгийн иргэдийн мод тарих сонирхлыг нэмэгдүүлж, эдийн засгийн үр ашгийг өгнө. Ногоон ажлын байр нэмэгдэж, иргэд, ойжуулах үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, ойн нөхөрлөлүүдийн орлого өснө. - Байгаль орчны менежмент, байгаль хамгаалах үйл ажиллагаанд зарцуулах санхүүжилт, хөрөнгө нэмэгдэнэ. - Түүхий эдийн ашиглалтын түвшин дээшилнэ, үйлдвэрлэлийн төвүүдэд логистик сайжирснаар хаягдлын менежмент сайжирна - Түлшний хэрэглээ, бэлтгэлийн хандлагыг сайжруулна. Шахмал түлш, био түлшний хэрэглээ болон түлшний хэмнэлтийг сурталчлахад	Байгаль орчинд нөлөөлөх байдлыг үнэлгээний тухай хууль (2012)-ийн 7-р зүйлийн 7.2-т “Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээг байгалийн нөөцийг ашиглах, газрын тос болон ашигт малтмал хайх, ашиглах, аж ахуйн зориулалтаар газар эзэмших, ашиглах эрх авах болон төсөл хэрэгжүүлэхээс өмнө хийнэ” гэж заасан байна. Уг хуулийн Хавсралт С-д барилгын ажлын бичиг баримтыг батлахаас өмнө байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгэх шаардлагатай төслүүдийн жагсаалтыг оруулсан байна. Эдгээрийн дотор бүх дэд бүтцийн төсөл, ойн аж ахуйн төсөл багтсан. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ нь мод бэлтгэлийг хэтрүүлэх эрсдлийг зохицуулахад хэрэгтэй. Энэ СНСЗ-ын хүрээнд тодорхойлсон үр ашиг, эрсдлүүдтэй холбоотой, ойн бүтээгдэхүүнийг тогтвортой, зохистой ашиглахыг дэмжиж, хэт ашиглалтаас үүдэлтэй ойн доройтлыг бууруулахад чиглэсэн хэд хэдэн БХЖ байна. Үүнд:	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээтэй холбоотой хуулийн заалтууд нь ойн нөөцийг хэт их ашигласнаас үүдэх сөрөг нөлөөллийн эрсдлийг зохицуулж чадахгүй бол унанги мод, ойн цэвэрлэгээ, арчилгааны квотыг цуцалж шат шатанд батлагдсан ойн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлдэг байхаар холбогдох хууль журмыг шинэчлэх хэрэгтэй. Ойн менежментийн төлөвлөгөөг баримтанд түшиглэж, талуудын оролцоог хангаж, санал болгож буй арга хэмжээнүүдийн боломжит үр ашиг ба эрсдлийг судалж үзсэний үндсэн дээр боловсруулна. Хэдий тийм боловч, REDD+-ийн хүрээнд хэрэгжүүлэхээр

	дөхөм болно Эрсдлүүд: - Модыг хэт ихээр бэлтгэл нь (арчилгааны огтлол, мод бэлтгэл, түлшний мод огтлох явдлыг хэтрүүлсэнээс үүдсэн г.м) ойн доройтол, ойн нүүрстөрөгч, экосистемийн үйлчилгээ, биологийн төрөл зүйлд сөргөөр нөлөөлнө. Мод бэлтгэлийн, замын суурингууд нь биологийн төрөл зүйлд сөргөөр нөлөөлнө - Ашиглах боломж нэмэгдсэнээр тогтвортой бус/хулгайн ан хийх, ойн дагалт баялгийг хэтрүүлэн түүж ашиглах зэрэг эрсдэл бий болно - Шинээр зам тавьснаар тухайн газрын модыг сүйтгэнэ, түүнчлэн ашиглалт нэмэгдсэнээс ойн доройтолд хүргэж болзошгүй - Эко-системийн төлбөрийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор усны үнэ өсвөл хууль бусаар усны эх үүсвэр бий болгох явдал гарч, гүний усны ачаалал нэмэгдэх,усан цахилгаан станцын тоо (эко-системийн төлбөр бүрдүүлэхийн	Төрөөс ойн талаар баримтлах бодлого (2015)-ийн 3.3-т “Ойн тогтвортой менежментийг бий болгон ойгоос гарах бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлж, экологийн болон эдийн засаг, нийгмийн үр ашгийг сайжруулах бодлогын хүрээнд дараах зорилтыг хэрэгжүүлнэ” гэж заасан байна. 3.3.7-р хэсэгт “Олон улсын жишигт нийцсэн ойн мэргэжлийн байгууллагын итгэмжлэлийн үндэсний стандартыг бий болгож, 2020 он гэхэд ойн нөөцийг зөвхөн итгэмжлэл авсан аж ахуйн нэгж, байгууллага ашигладаг тогтолцоонд шилжих” заасан байна. - Ойн цэвэрлэгээ хөтөлбөр (2014) 3.2-т “Ойн цэвэрлэгээгээр бэлтгэгдсэн модоор модны эрэлт, нийлүүлэлтийг хангах, модон түүхий эд, материалын зохих хэсгийг дэвшилтэт техник, технологиор боловсруулж, импорт орлох эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйлдвэрлэлийг дэмжих, модны ашиглалтын түвшинг дээшлүүлэх” гэж заасан байна.	санал болгосон БАХ-нүүд болон ойн цэвэрлэгээний хөтөлбөрийг бүрэн хэмжээнд хэрэгжүүлэх нь эргээд урт хугацаанд нүүрстөрөгчийн шингээлтийг нэмэгдүүлэхэд болон ойн бусад үр ашгийг хүртэхэд сөргөөр нөлөөлөх магадлалтай. (Жишээ нь: Унанги модыг нэмэгдүүлэх, биологийн төрөл зүйл болон экосистемийн үйлчилгээ сайжрах гэх мэт эерэг үр дагавар буурах) Үр ашиг, эрсдийн үнэлгээний явцад санал болгосончлон засгийн газраас мод бэлтгэлийг хэт нэмэгдүүлэхтэй холбоотой гарч болох үр дагаварыг баримтаар нотлох нотолгоог цуглуулах шаардлагатай. (Уг мэдээлэл хэр олдоцтой талаар үнэлгээ хий.) Ингэснээр мод бэлтгэлийн явц, чанарын талаар илүү тодорхой ойлголттой болж

	тулд) нэмэгдэх эрсдэлтэй - Шавжийг хэт устгаснаас экологийн тэнцвэр алдагдах эрсдэлтэй. Биологийн устгалын арга болон түүх аргын зэрлэг амьтан, ургамалд үзүүлэх эрсдлийн түвшин тодорхой бус. - Жуулчид ой болон байгалийн бусад хэсэгт ихээр нэвтрэх, байгалийн баялгийг аялал жуулчлалын салбарыг дэмжихэд ашиглах (модоор барилга барих, дагалт баялгийг ашиглах г.м) - Нөхөн сэргээлт хийсэн газрыг хамгаалж, хашсанаар зэрлэг амьтдын амьдрах орчинд өөрчлөлт орно - Мод боловсруулах салбарын эрчим хүчний хэрэглээ ихсэнэ. - Хамгаалалтгүй газар нутгийн байгаль орчинд учрах сөрөг нөлөө нэмэгдэнэ (сөрөг нөлөө өөр газарт шилжих). Ойгоос бусад экосистем үл хайхран орхигдох эрсдэлтэй - Малын үнэ нэмэгдвэл тоо толгой нь өснө. Усны эх үүсвэр багасч, бэлчээрийн хомсдол бий болно.		мөн нүүрстөрөгчийн шингээлт болон бусад үр ашиг эрсдлийн талаар илүү мэдээлэлтэй болж улмаар монгол орны ойд тохирсон арга хэмжээг боловсруулахад дэм болно.

Ойн хомсдол, доройтол ихээхэн эрчимтэй байгаа үед REDD+-ийн үйл ажиллагаануудаас байгалийн ойг хамгаалах, хадгалах явдлыг урамшуулахад чиглэсэн арга хэмжээнүүдийг илүү сонгон хэрэгжүүлж, байгалийн ойг доройтуулахаас зайлсхийх буюу эрсдлийг бууруулах	<u>Үр ашиг:</u> - Төрөөс таримал ойг худалдан авах зэрэг олон нийтийг дэмжсэн гэрээт урамшуллын арга хэмжээ нь орон нутгийн иргэдийн мод тарих сонирхлыг нэмэгдүүлж, эдийн засгийн үр ашгийг өгнө. Ногоон ажлын байр нэмэгдэж, иргэд, ойжуулах үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, ойн нөхөрлөлүүдийн орлого өснө. - Бусад төсөл, хөтөлбөрүүдээс орон нутгийн амьжиргааг дэмжих санхүүгийн хөшүүрэг бий болгох боломжтой - Ойн салбарт ажиллаж байгаа аж ахуйн нэгжүүдэд шинэ боломж нээгдэж, ойн аж ахуйн нэгжүүдийн санхүүгийн чадавхи сайжирна, ажлын байр тогтвортой болно - Мод бэлтгэл, дагалт баялаг, түлээний модны зөвшөөрлийн хураамж мөн эко-аялал жуулчлал, мод боловсруулах үйл ажиллагаанаас орон нутгийн төсөвт орох орлого нэмэгдэнэ - Мод бэлтгэсэн аж ахуйн нэгж өөрийн зардлаар дахин ойжуулалт хийх ёстой тул ойжуулалтын талбай нэмэгдэнэ - Байгаль орчны менежмент, байгаль хамгаалах үйл ажиллагаанд зориулсан хөрөнгө, төсөв нэмэгдэнэ. - Мод бэлтгэл, мод боловсруулах, дагалт баялгийн ашиглалт, агро-ойн	СНСЗ С2-той зарим талаараа давхацаж байна. Байгалийн ойг хамгаалах үйл ажиллагааг урамшуулахтай холбоотой хэд хэдэн БХЖ байдаг. Төрөөс ойн талаар баримтлах бодлого (2015) 3.4.2-т "Ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээнд хувийн болон аж ахуйн нэгж, байгууллагаас оруулах хөрөнгө оруулалтыг дэмжих хөшүүрэг, механизмыг бий болгох" гэж заасан байна. Монголд экосистемийн төлбөрийн тухай хууль байхгүй (?) боловч ийм хууль, журамтай болох санааг хэд хэдэн бодлогод тусгасан байна. Монгол улсын ногоон хөгжлийн бодлого (2014)-ийн 3.4.7-д "Алслагдсан нутагт бэлчээрийн даацад тохируулан мал аж ахуй эрхэлж, усны эх, булаг, шандыг арчилж тордох зэргээр бэлчээрийн доройтлоос сэргийлэх чиглэлээр санаачилгатай ажиллаж байгаа малчдад экосистемийн үйлчилгээний төлбөрийн урамшуулал олгох механизмыг бүрдүүлэх" гэж заасан байна. Төрөөс ойн талаар баримтлах бодлого (2015)-ын 3.4.4-т "Ойн хүлэмжийн хий шингээх, хүчилтөрөгч ялгаруулах, хөрс, ус болон биологийн олон янз байдлыг хамгаалах зэрэг экологийн ач холбогдлыг үнэлсэн экосистемийн үйлчилгээний төлбөрийг бий болгон мөрдөх" гэж ойн тогтвортой менежментийг хэрэгжүүлэх санхүүгийн эх үүсвэрийн талаар заасан байна.	Эко аялал жуулчлалын олон улсын стандартыг нэвтрүүлэх, хэрэгжүүлэхэд чиглэсэн шинэ дүрэм журам, удирдамж боловсруулах. Төрөөс эко системын үйлчилгээний төлбөрийн тухай хуулийг батлах ёстой гэж оролцогч талууд үзэж байна. Ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээний ажлыг төлөвлөх, зохион байгуулах, санхүүжүүлэх, таримал ойг үнэлэх, улсын ойн санд худалдан авах, өмчлүүлэх журам (БОНХ- ийн сайд, Сангийн сайдын хамтарсан тушаал No. А-96\71 2013 он)-д бүх төрлийн ойд хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдийн тарьсан (залуу ойг) таримал ойг улс баталгаатай эргүүлэн худалдан авдаг байх талаар заалт оруулах нь зүйтэй. Үүнээс гадна, төсвийн ачааллыг бууруулахын тулд байгалийн сэргэн ургалт илүү үр дүнтэй байх газруудыг сонгож мод тарихыг зөвшөөрсөн шинэ

	аж ахуйн үйл ажиллагааны үр дүнд орон нутгийн иргэд, аж ахуйн нэгжүүд, ойн нөхөрлөлүүдийн ажлын байр, орлого нэмэгдэнэ - Мал аж ахуйн бүтээгдэхүүний нэмүү өртгийн сүлжээ сайжирсанаар малчид, тариаланчдын орлого, амьжиргаа дээшилнэ - Амьжиргааны эх үүсвэрийн төрөл нэмэгдэж, экосистемийн үйлчилгээ сайжирсанаар нутгийн иргэдийн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадвар дээшилнэ <u>Эрсдэл:</u> - Зарим айлын амьжиргаанд сөргөөр нөлөөлж болзошгүй. Тухайбал, ан гөрөө хийх, хатсан мод цуглуулах зорилгоор зориудын түймэр тавьдаг, ойн дагалт баялаг ашигладаг, хууль бус мод бэлтгэл ба хууль бус худалдаанд оролцдог, усны эх үүсвэр ашигладаг хүмүүст сөргөөр нөлөөлнө. Ядуурал болон амьдрах орчны бэрхшээлтэй асуудал улам нэмэгдэнэ. Эндээс гарах үр дагавар дүн тэгш бус байна. - Унанги модыг ашиглахын тулд санаатайгаар түймэр тавих явдал нэмэгдэнэ. Ойд нэвтрэх зам нэмэгдсэнээр гал түймрийн эрсдэл ихсэнэ. Зориудаар тавьсан түймэр хяналтаас гарна	Ойн тухай хууль (2012)-ийн 20.1.2-т “Ойн нөхөрлөл байгуулах замаар оршин суугаа газрынхаа ойн санг эзэмших, хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээ авах” гэж,. 39-р зүйлийн 39.10-т “Иргэн, ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллага өөрийн хөрөнгөөр ой, хээрийн түймэр, хөнөөлт шавжтай тэмцсэн тохиолдолд зохих журмын дагуу урамшуулал олгоно” гэж заасан байна. Ойн цэвэрлэгээ хөтөлбөр (2014)-ийн 3.2.1-т “Хот суурин газар, ойгүй болон ойн нөөц багатай аймгуудын түлш, ахуйн хэрэгцээний модны тодорхой хэсгийг цэвэрлэгээнээс гарсан модоор хангах ажлыг зохион байгуулах” гэж заасан байна. Энэ нь ойн нөөцийн хүртээмжтэй холбоотой эрсдэлд хамаарна. Ойжуулалт, ойн аж ахуйн үйл ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, санхүүжүүлэх, таримал ойг үнэлэх, улсын ойн санд худалдан авах, өмчлүүлэх журам” (Сангийн сайд болон Байгаль Орчин Аялал Жуулчлалын Яамны сайдын хамтарсан тушаалаар баталсан, Дугаар А-96\71)-ын 5 дахь хэсэгт ойжуулалтыг дэмжих урамшуулал, үнэлэх, таримал ойг улсын санд хүлээж авах талаар тодорхой заасан. Байгалийн ойн доройтлыг бууруулах талаар: Ургамал хамгаалах тухай хууль	журам буюу эсвэл удирдамж боловсруулах шаардлагатай Эрүүгийн хууль (2015)-ийн 24.7-д зориудаар санаатай түймэр тавьсан гэмт хэрэгт ногдуулах шийтгэлийн талаар: "Ой, хээрийн түймэр санаатай тавьсан бол хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ" гэж заасан.

	- Загийн ургалт нэмэгдсэнээр хортон шавж, загийн үндсээр хооллогч чичүүл ихсэнэ - Түлш мод модон материалаас хамаарах хамаарал нэмэгдэнэ - - Нөхөрлөлийн гишүүн бус иргэд ойн цэвэрлэгээний үр ашгаас тэгш хүртэж чадахгүй. - Эко-системийн төлбөрийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор усны үнэ өсвөл хууль бусаар усны эх үүсвэр бий болгох явдал гарч, гүний усны ачаалал нэмэгдэх,усан цахилгаан станцын тоо (эко-системийн төлбөр бүрдүүлэхийн тулд) нэмэгдэх эрсдэлтэй. - БАХ нь тусгай хамгаалалттай газар нутгаас хэт хамаарах байдлыг нэмэгдүүлнэ.	(2007)-ийн 1-р зүйлийн 1.1-т “Энэ хуулийн зорилт нь бэлчээрийн болон таримал ургамлыг ургамлын өвчин, хөнөөлт шавж, мэрэгч амьтан, хог ургамлаас хамгаалах, түүнтэй тэмцэх, хорио цээр тогтоох, хяналт тавих үйл ажиллагаатай холбогдон төр, иргэн, хуулийн этгээдийн хооронд үүсэх харилцааг зохицуулахад оршино” гэж заасан. Тусгай хамгаалалттай газар нутагт үйл ажиллагаа явуулах санхүүжилтийн талаар дараах хоёр БХЖ-д тусгасан байна. ТХГН-ийн орчны бүсийн тухай хууль (1997)-ийн 7.1 дэхь хэсэгт "Зөвлөл нь тусгай хамгаалалттай газрын орчны бүсийг хөгжүүлэх, нутгийн иргэдийн ахуй амьдралыг дэмжих зорилго бүхий орчны бүсийн сан /цаашид "сан" гэх/-г байгуулж болно гэж заасан. Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль (1994)-ийн 6.2-т “Тусгай хамгаалалттай газар нутгийг хамгаалах ажлыг санхүүжүүлэх хөрөнгө нь: 1/улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт; /Энэ заалтын “төвлөрсөн” гэдэг үгийг 2003 оны 1 дүгээр сарын 2-ны өдрийн хуулиар хассан/ 2/ аялал, жуулчлалын болон бусад ажил, үйлчилгээний орлого; 3/ иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хандив, тусламж; 4/ тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдийн	

		учруулсан хохирлын нөхөн төлбөрийн орлого” зэргээс бүрдэнэ гэж заасан байна. Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль (1994)-ийн 14-р зүйлд “Байгалийн цогцолборт газрыг байгалийн хэв шинж, ургамал, амьтны аймгийн байршил, түүх, соёлын дурсгалыг нь хадгалах шаардлага, аялал, жуулчлал хөгжүүлэх нөхцөл зэргийг харгалзан дараахь бүсэд хуваана: 1/ онцгой бүс; 2/ аялал,жуулчлалын бүс; 3/ хязгаарлатын бүс” гэж заасан байна. Байгаль хамгаалах тухай хууль (1995)-д урамшуулал торгууль шийтгэлийн талаар заасан. Уг хуулийн 54.1 дэхь хэсэгт “Байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх, байгаль орчинд үзүүлэх хортой аюултай нөлөөллийг багасгах дэвшилт арга, хоргүй, аюулгүй, бохирдолгүй, хаягдалгүй технологи нэвүүлсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг төрөөс урамшуулна” гэж заасан байна. Байгаль хамгаалах тухай хууль (1995)-ийн 54.4-р зүйлд “Байгаль орчны хууль тогтоомж зөрчсөн тухай мэдээлэл өгсөн иргэнд зөрчил гаргагчид ногдуулсан торгууль, нөхөн төлбөрийн орлогын дүнгийн 15 хувьтай тэнцэх мөнгөн урамшууллыг олгоно" гэж заасан.	
REDD+-ийн үйл ажиллагааг байгалийн ойг хувиргахад ашиглахгүй байх,	<u>Үр ашиг:</u> - Байгалийн сэргэн ургалт, нөхөн сэргээлтийн арга хэмжээ сайжирсанаар ойн өсөлт бүтээмж дээшилнэ.	Байгалийн ойн тодорхойлолтыг Е1-ээс үз. Монгол орны байгалийн болон таримал ойн ялгаа маш бага байхын зэрэгцээ ойн нөхөн сэргээлтэд голлон анхаардаг тул байгалийн ойг өөр ой болгон хувиргасан	Ой бүхий газарт мал бэлчээхтэй холбоотой Ойн тухай хууль болон Газрын тухай хууль хоорондын зөрчил юм. Дээрх хоёр

үүнд байгалийн ойг таримал ой болгон хувиргах г.м	- Ойн экосистемийн үйлчилгээ сайжирч, биологийн төрөл зүйлийн амьдрах орчин тэлж, амьтдын нүүдэллэх зай талбай нэмэгдэнэ. - Ойн үрийн бүсчлэлийг тогтоосноор ойн нөхөн сэргээлтийн ажлын үр дүн сайжирна. Чанар сайтай үр ойн бүтээмжийг дээшлүүлж, ойн бүтээгдэхүүний чанар дээшилнэ - Ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, нутгийн иргэд, албан хаагчдын ойн менежмент, мод боловсруулах, тогтвортой ашиглах, нөхөн сэргээлт хийх, хамгаалах, дагалт баялаг ашиглах талаарх мэдлэг, ур чадвар сайжирна <u>Эрсдлүүд</u>: - Генийн өөрчлөлт мутаци үүсэх магадлалтай (шинэ үрийн сортыг үржүүлэх явцад) - Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицоход дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн бичил санхүү, амьжиргааны дэмжлэгийг эргээд тогтвортой бус арга барил, жишээлбэл малын тоо толгойг өсгөхөд ашиглах эрсдэлтэй - Ой болон байгалийн нөөцийг ашиглах боломж буурах буюу баялгийг хүртэх боломж тэгш бус байх нь ойгоос хамаарч аж амьдралаа залгуулдаг зарим иргэдийн амьжиргаанд сөргөөр нөлөөлж болзошгүй (зөвшөөрөлтэй	талаарх тайлан гаргахаас илүү байгалийн ойг хэвээр нь хадгалсан тухай мэдээ тайлан өгөх нь илүү хялбар. Талууд байгалийн ойг хувиргах эрсдэл тийм ч их өндөр магадлалтай биш гэж үзлээ. СНСЗ Е6-ийн хүрээнд харин ашиглагдаагүй болон бага ашиглагдаж байсан ойг эрчимтэй ашиглах эрсдэл байгааг тодорхойлсон. Ойн талбайг бэлчээрт ашиглах талаар: 2012 оны Ойн тухай хуулийн 29-р зүйлийн 29.1.5-д “ойжуулсан, ойн үр бэлтгэх зориулалтаар тусгаарласан болон тарьц, суулгац ургуулсан мод үржүүлгийн талбайд мод бэлтгэх, мал бэлчээхийг хориглоно" гэж заасан. Хэдий тийм боловч, 2002 оны 6 сарын 7-ны өдөр батлагдсан Газрын тухай хуулийн 52-р зүйлийн 3-т “Ойн сан бүхий газрыг зохих хууль тогтоомжийн дагуу бэлчээрт ашиглаж болно” гэж заасан. Ойн тухай хууль (2012)-д ойн талбайн ангилал, тус бүрт хэрэгжүүлж болох үйл ажиллагааг зааж өгсөн. Тус хуулийн 5-р зүйлд “Хамгаалалт, ашиглалтын хэлбэр, экологи эдийн засгийн ач холбогдлыг нь харгалзан ойн санг дор дурдсанаар ангилна: 5.1.1.хамгаалалтын бүсийн ой; 5.1.2.ашиглалтын бүсийн ой” гэж заасан байдаг.	хуулийг шинэчилж зулзган ой бүхий газарт мал бэлчээхийг хориглох шаардлагатай.

	болон хууль бус мод бэлтгэл эрхэлдэг, ан хийдэг, ойн дагалт баялаг ашигладаг хүмүүс г.м.) Монголын мод, модон бүтээгдэхүүний эрэлтийг хангахад хэцүү болж, дотоодын ойн нөөцөд дарамт учирна.	Уг хуулийн 8-р зүйлд хамгаалалтын бүсийн ой, түүний дэглэмийг дараах байдлаар зааж өгсөн: “8.1.Хамгаалалтын бүсийн ойд цармын бүслүүрийн ой, тусгай хамгаалалттай газрын болон сургалт, судалгааны зориулалттай ой, ногоон бүс, хориотой зурвасын ой, заган ой, баянбүрдийн ой, 100 га хүртэлх хэмжээний төгөл ой, бут, сөөг, 30 хэмээс илүү налуу газрын ой хамаарна. 8.2.Хориотой зурвасын ойд нуур, рашаан, булаг, шандын ундаргын эргэн тойрон болон голын эргээс хоёр тийш 1000 метрийн доторх ой, улсын чанартай авто болон төмөр замын дагуу хоёр талын 100 метрийн доторх ой хамаарна. 8.3.Усны хагалбар дахь байгаль орчны тэнцлийг хангах, хөрсний эвдрэлээс сэргийлэх зорилгоор цармын бүслүүрийн ойн заагийг төрийн захиргааны төв байгууллага тогтооно. 8.4.Тусгай хамгаалалттай газар нутаг дахь ойн хамгаалалтын дэглэмийг Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулиар зохицуулна.” гэжээ. Хувиргасан амьд организмын тухай хууль (2007)-ийн 1-р зүйлийн 1.1-т “Энэ хуулийн зорилт нь хувиргасан амьд организмыг гарган авах, ашиглах, улсын хилээр нэвтрүүлэх, тус улсын нутаг	

		дэвсгэрт биоаюулгүй байдлыг хангахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино” гэж заасан байна.	
REDD+-ийн үйл ажиллагааг боловсруулах, эрэмбэлж, хэрэгжүүлэхдээ нийгмийн сөрөг нөлөө учруулахаас зайлсхийж, эдийн засаг, нийгмийн сайн сайхан байдал, үр ашгийг дэмжиж, хамгийн эмзэг бүлгийн хүмүүст онцгой анхаарал хандуулна.	Үр ашиг: - Мод бэлтгэл, мод боловсруулах салбарт мөн мод модон эдлэл, агро ойн аж ахуйн бүтээгдэхүүн, дагалт баялаг ашиглах зэргээр ажлын байр нэмэгдэж, орон нутгийн иргэд, аж ахуйн нэгж, ойн нөхөрлөлүүдийн орлого өснө - Тодорхой бүс нутагт эко аялал жуулчлал хөгжсөнөөр иргэдийн амжиргаа дээшилж, орон нутгийн төсвийн орлого өснө - Модон эдлэлийн үйлдвэрлэл, тэр дундаа нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэл нэмэгдэнэ. Модон бүтэгдэхүүний үнэлэмж, чанар нэмэгдсэнээр өндөр үнээр борлуулах боломж нээгдэнэ. - Малын гаралтай бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн үнэ цэнэ нэмэгдсэнээр малчид, тариаланчдын орлого, амьжиргаа дээшилнэ - Ойн зам тавих чиглэлээр ажлын байр нэмэгдэнэ. Зам барьснаар худалдаачид, үйлчилгээ үзүүлэгчид болон бусад хүмүүс эдийн засгийн үр ашиг хүртэнэ, нийгмийн үйлчилгээ илүү хүртээмжтэй болно. - Иргэд, бизнесийн үйл ажиллагаа, экосистемийн усны нөөц/хангамж сайжирна.	Ядуурлыг бууруулахтай холбоотой асуудлаар СНСЗ А3 болон эдийн засгийн үйл ажиллагаатай холбоотой нүүлгэлт, шилжилт хөдөлгөөний талаарх асуудлаар СНСЗ С5-тай давхацаж байна. Ой болон уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах үйл ажиллагааны нийгэм, эдийн засгийн үр дүнг зохицуулах хэд хэдэн БХЖ байдаг. Уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний хөтөлбөр (2011)-ийн 2.4.3-т “Хүлэмжийн хийн ялгаралтыг багасгах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох үйл ажиллагаанд шинжлэх ухааны ололт, байгальд ээлтэй дэвшилтэт технологийг тууштай нэвтрүүлэх, үндэсний уламжлал, зан заншилтай хослуулсан байх” гэж заасан байна. 3.1.2-т “Бэлчээр ашиглах, хөрс хамгаалах, эрчим хүч хэмнэх, үйлдвэрлэл, үйлчилгээний үр ашгийг дээшлүүлэх, ногоон хөгжлийг дэмжих, уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг авах хариу арга хэмжээний тухай зэрэг харилцааг зохицуулсан эрх зүйн орчныг шинээр бүрдүүлэх” гэж заасан байна. Ойн салбарын БХЖ-уудын дунд ойн нөөцийн эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлж, иргэдийн амьжиргааг дэмжих талаар олон заалт орсон байдаг:	Ой бүхий газарт мал бэлчээхтэй холбоотой Ойн тухай хууль болон Газрын тухай хуулийн заалтууд хоорондоо зөрчилдөж байна. м. Дээрх хоёр хуулийг шинэчилж зулзган ой бүхий газарт мал бэлчээхийг хориглох шаардлагатай. Ойтой холбоотой үйл ажиллагаанаас орж ирэх орлогоос ойн нөхөрлөлүүдэд зориулах хуваарилалтыг нэмэгдүүлэхийн тулд холбогдох хууль эсвэл журмыг өөрчлөх. Ойгоос орж ирэх орлогыг ойн менежментийн чиглэлээр зарцуулж ойн нөхөрлөлүүдэд дэд бүтцийн хөгжилд шууд хөрөнгө оруулалт хийх бололцоо олгох. Урамшууллын системийг сайжруулах. Урамшууллын хэмжээг нэмэгдүүлэх (жишээ нь эргүүл хийх, зөрчлийг мэдээлэх) мөн хүмүүст урамшууллыг тэр дор нь олгодог систем бий болгох.

	- Бэлчээрийн менежмент сайжирч, эрчимжсэн мал аж ахуй хөгжин, махны чанар, хүнсний аюулгүй байдал сайжирна. - Модны нийлүүлэлт найдвартай бөгөөд тогтвортой болсноор түүхий эд болон бүтээгдэхүүний (түлшний мод багтана) үнэ тогтворжино. - Унанги мод багассанаар түймрийн эрсдэл, хөнөөлт шавжийн тархалт буурна. Гал түймрээс иргэдийн амь нас, эрүүл мэнд, өмч хохирох явдал буурна. - Амьжиргааг төрөлжүүлж эко системийн үйлчилгээний нийлүүлэлтийг сайжруулснаар орон нутгийн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицоход хувь нэмэр оруулна. - Орон нутгийн иргэд, нөхөрлөлийн гишүүд, ААНБ болон орон нутгийн албан хаагчдын ойн менежмент, мод боловсруулалт, модон материалын тогтвортой ашиглалтын талаарх мэдлэг, ур чадвар нэмэгдэнэ. - Ойн дагалт баялаг, хуурай газрын эмийн ба ашигт ургамлын нөөц нэмэгдэнэ. Эмийн ургамал болон ойн дагалт баялгийг зүй зохистой ашиглах, боловсруулах журмыг сайжруулах боломж бүрдэнэ. <u>Эрсдлүүд</u>: - Ой болон байгалийн нөөцийг	- Төрөөс ойн талаар баримтлах бодлого (2015)-ын 3.3.5 дахь хэсэгт “ойн цэвэрлэгээгээр бэлтгэсэн хатсан болон унанги мод, ойн бусад үлдэгдлийг боловсруулан, төрөл бүрийн модлог хавтан, шахмал болон био түлшний дэвшилтэт технологи бүхий үйлдвэрлэлийг дэмжин хөгжүүлж, ойн нөөцийг эдийн засгийн эргэлтэд оруулах” зорилт дэвшүүлсэн. - Ойн цэвэрлэгээ хөтөлбөр (2014)-ийн 2.1 дэхь хэсэгт " Монгол орны ойг цэвэрлэж эрүүлжүүлэх, төлөв байдлыг сайжруулах, түймэр, хөнөөлт шавжийн хөнөөлөөс урьдчилан сэргийлэх, ойг нөхөн сэргээх, ойн цэвэрлэгээгээр гарсан модоор түлш, ахуйн хэрэгцээний тодорхой хэсгийг хангах, шахмал хавтан, шахмал түлш, барилгын материал болон бусад эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйлдвэрийг модон түүхий эдээр хангаж, модны ашиглалтын түвшинг дээшлүүлэх, ойн анги, ойн нөхөрлөл, ойн мэргэжлийн аж ахуйн нэгжийг чадавхжуулахад энэхүү хөтөлбөрийн зорилго оршино.” гэжээ. Ойн цэвэрлэгээ хөтөлбөр нь унанги модны нөөцийг бууруулах замаар хөнөөлт шавжны тархалтыг хязгаарлах, ойн бүтээгдэхүүний нийлүүлэлтийг сайжруулах, орлого нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлэх (ялангуяа ойн нөхөрлөлүүдэд) үр дүнд чиглэсэн.	Урамшууллын санхүүжилтийг ойн баялаг ашиглалтын төлбөрийн тодорхой хувиас бүрдүүлвэл зохино. Нөхөрлөлийн менежментийн орчны бүсийн зөвлөлийн дэмжлэгийг өргөжүүлж орлогын өөр эх үүсвэрийг (агро ойн аж ахуй, ХАА г.м) хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх үндсэн хөрөнгийг хэмжээг нэмэгдүүлэх Агро ойн аж ахуйн стратегийг боловсруулахдаа үр ашгийг дээшлүүлэх, эрсдлийг бууруулах арга хэмжээг онцгойлон авч үзнэ.

	ашиглах боломж буурах буюу баялгийг хүртэх боломж тэгш бус байх нь ойгоос хамаарч аж амьдралаа залгуулдаг зарим иргэдийн амьжиргаанд сөргөөр нөлөөлж болзошгүй (зөвшөөрөлтэй болон хууль бус мод бэлтгэл эрхэлдэг, ан хийдэг, ойн дагалт баялаг ашигладаг хүмүүс г.м.) - Нийтийн эзэмшлийн газар буюу бэлчээрийн талбай багасах, усны нөөцийн хүртээмж буурах нь малчдын амьдралд сөргөөр нөлөөлнө. - Агро ойн аж ахуй өмнө нь эрхэлж байсан ажлаас нь, тухайлбал мал маллахаас ашиг багатай хүмүүсийн амьжиргаа доройтно. - Иргэдэд экосистемийн үйлчилгээний шинэ төрлийн татварын дарамт нэмэгдэнэ. - Химийн бордооны хэрэглээ нэмэгдэнэ. Тухайлбал, агро ойн аж ахуйд хэрэглэх. - Шавж устгах ажил гүйцэтгэж буй хүмүүсийн эрүүл мэнд, аюулгүй байдалд сөргөөр нөлөөлнө (харшил, өндөрт авирах г.м) - Мод бэлтгэлийн суурингийн орчимд мөн аялал жуулчлалаас үүдэн архидалт, мансууруулах бодисын хэрэглээ зэрэг нийгмийн асуудлууд гарах эрсдэл - Хүмүүс шинэ амьжиргааны эх үүсвэртэй болсноор уламжлалт	Монгол Улсын Ногоон хөгжлийн бодлого (2014)-ын 3.4.1-т ажил эрхлэлтийг дэмжих талаарх төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны талаар тусгасан байна. Үүнд: "Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд байнгын ажлын байрыг нэмэгдүүлж, хөдөлмөрийн насны хүн амын 80-аас дээш хувь нь зохистой хөдөлмөр эрхэлж, баталгаатай орлоготой болох нөхцөлийг бүрдүүлэх" гэж заасан байна. Төрөөс ойн талаар баримтлах бодлого (2015) болон Ойн цэвэрлэгээ хөтөлбөр (2014) нь нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хэрхэн сайжруулах талаар авч үзсэн байна. - Төрөөс ойн талаар баримтлах бодлого (2015)-ын 3.3-т “Ойн тогтвортой менежментийг бий болгон ойгоос гарах бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлж, экологийн болон эдийн засаг, нийгмийн үр ашгийг сайжруулах бодлогын хүрээнд дараах зорилтыг хэрэгжүүлнэ” гэж заасан байна. - "Ойн цэвэрлэгээ" хөтөлбөрийн 3.2-т “Ойн цэвэрлэгээгээр бэлтгэгдсэн модоор модны эрэлт, нийлүүлэлтийг хангах, модон түүхий эд, материалын зохих хэсгийг дэвшилтэт техник, технологиор боловсруулж, импорт орлох эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйлдвэрлэлийг дэмжих, модны ашиглалтын түвшинг дээшлүүлэх” гэж тусгагдсан.	

	нүүдлийн соёл алдагдана. - Мод, модон материалын эрэлт ихэссэнээс түүхий эдийн үнэ өснө, мөн түлшний модны нийлүүлэлт буурч үнэ нь өсч болзошгүй. - Газар ашиглалтын хэлбэр өөрчлөгдсөнөөр амьжиргааны эх үүсвэр хомсдож, орон нутагт шилжилт хөдөлгөөн нэмэгдэнэ.	Ажилт эрхлэлт, чадавхи нэмэгдүүдэх чиглэлээр Ойн цэвэрлэгээ хөтөлбөр (2014)-т дараах заалтыг тусгажээ. ОЦХ-ийн 6 дахь хэсэгт уг хөтөлбөрийг хэрэгжүүлсэнээр хүрэх үр дүнг тодорхойлсон байна: 6.1.6-д “Ойн анги, ойн нөхөрлөл, ойн мэргэжлийн аж ахуйн нэгж, байгууллагууд чадавхжиж, ажилгүй иргэд байнгын ногоон ажлын байраар хангагдан, орон нутгийн төсөвт орох орлогын хэмжээ нэмэгдэж, өрхийн амьжиргаанд бодит дэмжлэг үзүүлнэ” гэжээ. Ойн тухай хууль (2012)-ийн 21-р зүйлийн 21.12.4-т “Ойн нөхөрлөлүүд нь менежментийн талаар явуулах сургалт, семинар, мэргэжил олгох, давтан сургах үйл ажиллагаанд хамрагдах” гэж заасан байна. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль (2011)-ийн 6-р зүйлийн 6.3.2-т “ажлын байран дахь сургалт” нь ажил эрхлэлтийг дэмжих арга хэмжээ мөн гэж хуульчилсан байна. Мөн хуулийн 11.4-р хэсэгт “Энэ хуулийн 11.2-т заасан иргэний сургалтын зардлыг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас бүрэн болон хэсэгчлэн санхүүжүүлнэ” гэж заасан байна. Харин 11.5-р зүйлд “Энэ хуулийн 11.2-т зааснаас бусад иргэн хөдөлмөр эрхлэлтийн сургалтад өөрийн болон аж ахуйн нэгж, байгууллагын зардлаар, Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хуульд заасан	

		Ажилгүйдлийн даатгалын сангийн зардлаар хамрагдаж болно” гэж заасан байна. 12-р зүйлийн 12.8.1-т “Бизнесийн санаа олсон иргэнийг аж ахуй эрхлэх сургалтад хамруулах, төсөл боловсруулахад нь туслах, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах” гэж заасан байна. Тусгай хамгаалалттай газар нутгийн талаарх 2 БХЖ нь мөн ажил эрхлэлтийг дэмжих, иргэдийн амьжиргааг, орлогыг нэмэгдүүлэх, соёл уламжлалыг хадгалахад чиглэсэн. Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн тухай хууль (1994)-ийн 6-р зүйлийн 6.2-т тусгай хамгаалалттай газар нутгийг хамгаалах төсвийг аялал жуулчлал болон бусад үйлчилгээний орлогоос санхүүжүүлнэ гэж заасан. 1997 оны Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн тухай хуулийн 7-р зүйлийн 7.1-т “Зөвлөл нь тусгай хамгаалалттай газрын орчны бүсийг хөгжүүлэх, нутгийн иргэдийн ахуй амьдралыг дэмжих зорилго бүхий орчны бүсийн сан (цаашид "сан" гэх)-г байгуулж болно" гэж тусгагдсан. Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн тухай хууль (1997) нь мөн уламжлалт амьдралын хэв маягт дарамт учрахаас сэргийлэх, уламжлалыг хадгалахыг зорьдог. Хэд хэдэн БХЖ-д аялал жуулчлалыг хөгжүүлэхийг дэмжсэн заалт тусгагдсан байдаг. Аялал жуулчлалын хөгжлөөс	

		шалтгаалж зарим эрсдэл үүсч болохыг мөн тодорхойлсон. Аялал жуулчлалын тухай хууль (2000)-ийн 8-р зүйлд аялал жуулчлалын байгууллагуудын эрх, үүргийг зааж өгсөн. Тус хуулийн 8.2-т " Монгол Улсын нийгэм, эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулах, байгаль орчинд сөрөг нөлөөгүй, хүн амын эрүүл мэнд, уламжлалт зан заншилд харшлахгүй аялал жуулчлалын хэлбэрийг хөгжүүлнэ" гэж заасан байна. Аялал жуулчлалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр (2015)-ийн 2.2.2-т “Аялал жуулчлалыг бүсчлэн хөгжүүлж, нутгийн иргэд болон тусгай хамгаалалттай газар нутагт түшиглэсэн аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэх; 2.3.2. Аялал жуулчлалын үйл ажиллагааг Монгол орны байгалийн унаган төрхийг хадгалах, орчны бохирдлыг багасгах, экологийн тэнцвэрт байдал, хүний эрүүл, аюулгүй орчинд аялах нөхцөлийг хангах, орон нутгийн иргэдийн амьдрах орчинд сөрөг нөлөө үзүүлэхгүй байхаар зохион байгуулах; Агро ойн аж ахуйг хөгжүүлсэнээс үүдэх үр ашиг, эрсдлийг зохицуулах БХЖ дутагдалтай. 2015 оны Төрөөс ойн талаар баримтлах бодлогын 3.2.4-т “Монгол	

		оронд агро-ойн аж ахуйн хөгжлийн үндэс суурийг тавих” гэж заасан. Дэд бүтцийн хөгжилтэй холбоотойгоор үүсэх эрсдэл, үр ашгийг талууд тодорхойлсон. Тухайлбал, ойн зам барих БАХ, орон нутгийн хөгжил зэргээс үүдэх үр ашиг, эрсдэл г.м. Ойн цэвэрлэгээ хөтөлбөр (2014)-ийн 3.1.3-т "Ойн цэвэрлэгээ явуулах шаардлагатай бүсэд ойн замын хайгуул хийх, зураг төсөв боловсруулах, ойн зам барьж байгуулах" Ойн тухай хууль (2012)-ийн 12-р зүйлийн 12.1.4-т “Төрөөс ойн нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх, үржүүлэх болон ойн нөөц бүхий газар нутгийн ашиглалтын бүсийн ойд замын хайгуул хийж, зураг, төсөв боловсруулах, ойн төв зам барьж байгуулах арга хэмжээний зардлыг тухайн жилийн төсөвт тусгах” гэж заасан байна. Гэвч, ойн нөөцийг ашигласны орлогыг ойн дэд бүтцийг хөгжүүлэх үйл ажиллагаанд зарцуулахыг хуульчилсан БХЖ байхгүй. Бэлчээрийн менежмент, усны нөөц, малын чанарыг дээшлүүлэх зэрэгтэй холбоотой үр ашиг олон байна. Эдгээр асуудлыг тусгасан БХЖ хангалтгүйн зэрэгцээ бэлчээрийн менежментийн тухай хууль байхгүй, мал эмнэлгийн стандарт, малын махны экспортыг дэмжихтэй холбоотой бэрхшээл байсаар байна. Монгол мал үндэсний хөтөлбөр (2010)-ийн 2.2-т “Малын үржлийн ажил, үйлчилгээг	

		нийгмийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн боловсронгуй болгож, ашиг шимийн гарц, чанарыг сайжруулан, биологийн төгс чанартай түүхий эд, бүтээгдэхүүн үйлдвэрлэж, зах зээлд өрсөлдөх чадавхийг нэмэгдүүлэх” гэж заасан. Бэлчээр ашиглагчдын бүлэг болон бэлчээрийн менежментийн төлөвлөгөө зэрэг ойн болон бэлчээрийн мал аж ахуйн салбарын хамтын ажиллагаанд маш чухал юм. Малчдыг нутгаас нь нүүлгэн, шилжүүлэх, ойн нөхөн сэргээлтийн ажлын тогтвортой байдлыг хангаж чадахгүй байх зэрэг эрсдлийг зохицуулах БХЖ байхгүй. Ойн тухай хууль (2012)-ийн 29-р зүйлийн 29.1.5-д "Ойжуулсан, ойн үр бэлтгэх зориулалтаар тусгаарласан болон тарьц, суулгац ургуулсан мод үржүүлгийн талбайд мод бэлтгэх, мал бэлчээх”-ийг хориглоно гэсэн хэдий ч Газрын тухай хууль (2002 оны 6 сарын 7)-ийн 52-р зүйлийн 52.3-т “Ойн сан бүхий газрыг зохих хууль тогтоомжийн дагуу бэлчээрт ашиглаж болно” гэж заасан байна. Эрүүл ахуй, аюулгүй байдлын талаарх эрсдлийн талаар зохицуулсан Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хууль (2008)-ийн 5.1-т "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаархи төрийн бодлогын үндэс нь хөдөлмөр эрхэлж байгаа иргэн, ажилтны амь нас, эрүүл мэндийг бүх талаар хамгаалахад чиглэгдэнэ" гэсэн бол	

		12.1. дэхь хэсэгт on химийн хорт ба аюултай бодис, тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл, цацраг, биологийн идэвхт бодистой харьцах талаар тавих шаардлагыг тусгасан байна. Үүнд" Ажил олгогч нь химийн хорт ба аюултай бодис, тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл, цацраг, биологийн идэвхт бодис, түүний нөлөөллөөс ажилтны амь нас, эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авна" гэж заасан байна.	
Таримал болон байгалийн ойг хадгалахад чиглэсэн менежментийн үйл ажиллагаа, биологийн олон янз байдал болон экосистемийн үйлчилгээг нөхөн сэргээхтэй холбоотой арга хэмжээг дэмжих	Үр ашиг: - Ойн өсөлт, бүтээмж дээшилж ойн нөхөн сэргэлт, ойжуулалтын үйл ажиллагаа сайжирна - Экосистемийн үйлчилгээ сайжирсанаар биологийн олон янз байдлын амьдрах, нүүдэллэх орчин сайжрахад үр нөлөөтэй - Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон ойн экосистемийг бий болоход хувь нэмэр оруулна. (дасан зохицох чадвар нь доройтсон газарт анхаарал хандуулна) - Газрын доройтолтой холбоотой экосистемийн үйлчилгээ сайжирч, хөрсний чийг алдагдах, цэвдэг хайлах, хөрсний эвдрэл, элсний нүүдэл, цөлжилт зэрэг багасна. - Усны нөөц нэмэгдсэнээр иргэд, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа, экосистем зэрэгт эерэгээр нөлөөлнө	Монголд мөрдөж байгаа одоогийн хууль тогтоомжийн хүрээнд хамгаалалтын ач холбогдол өндөртэй ойн талаарх ухагдахууныг тусгаагүй байна. Гэхдээ ойн тодорхойлолт экологийн тодорхой шинж чанар бүхий ойн талаар авч үзэж (Е1-ийг үз), ойг ангилсан байгаар доор харуулав. Ойн тухай хууль (2012)-д ойн бүхий газрыг ангилж, тус бүрт нь явуулж болох үйл ажиллагааг зааж өгсөн байна. Хуулийн 5-р зүйлд “Хамгаалалт, ашиглалтын хэлбэр, экологи эдийн засгийн ач холбогдлыг нь харгалзан ойн санг дор дурдсанаар ангилна: 5.1.1.хамгаалалтын бүсийн ой; 5.1.2.ашиглалтын бүсийн ой. /ашиглалтын ойн бүс / гэжээ” Мөн хуулийн 8-р зүйлд хамгаалалтын бүсийн ой ба түүний дэглэмийн талаар заасан.	

	- Төрөөс таримал ойг худалдан авах зэрэг олон нийтийг дэмжсэн гэрээт урамшууллын арга хэмжээ нь орон нутгийн иргэдийн мод тарих сонирхлыг нэмэгдүүлж, эдийн засгийн үр ашгийг өгнө. Ногоон ажлын байр нэмэгдэж, иргэд, ойжуулах үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, ойн нөхөрлөлүүдийн орлого өснө. - Мод бэлтгэл хийсэн этгээд өөрийн зардлаар нөхөн ойжуулалт хийх шаардлагыг биелүүлэх ёстой тул ойжуулалтын талбай нэмэгдэнэ - Хөрш орнуудтай ой болон байгаль орчны бусад асуудлаар хамтран ажиллах харилцаагаа (хууль бус мод бэлтгэлтэй тэмцэх г.м) сайжруулах боломжтой - Байгаль орчны менүжмент, байгаль хамгаалах үйл ажиллагаанд зарцуулах санхүүжилт нэмэгдэнэ <u>Эрсдэл:</u> - Ой болон байгалийн нөөцийг ашиглах боломж буурах буюу баялгийг хүртэх боломж тэгш бус байх нь ойгоос хамаарч аж амьдралаа залгуулдаг зарим иргэдийн амьжиргаанд сөргөөр нөлөөлж болзошгүй (зөвшөөрөлтэй болон хууль бус мод бэлтгэл эрхэлдэг, ан хийдэг, ойн дагалт баялаг ашигладаг хүмүүс г.м.)	“8.1.Хамгаалалтын бүсийн ойд цармын бүслүүрийн ой, тусгай хамгаалалттай газрын болон сургалт, судалгааны зориулалттай ой, ногоон бүс, хориотой зурвасын ой, заган ой, баянбүрдийн ой, 100 га хүртэлх хэмжээний төгөл ой, бут, сөөг, 30 хэмээс илүү налуу газрын ой хамаарна. 8.2.Хориотой зурвасын ойд нуур, рашаан, булаг, шандын ундаргын эргэн тойрон болон голын эргээс хоёр тийш 1000 метрийн доторх ой, улсын чанартай авто болон төмөр замын дагуу хоёр талын 100 метрийн доторх ой хамаарна. 8.3.Усны хагалбар дахь байгаль орчны тэнцлийг хангах, хөрсний эвдрэлээс сэргийлэх зорилгоор цармын бүслүүрийн ойн заагийг төрийн захиргааны төв байгууллага тогтооно. 8.4.Тусгай хамгаалалттай газар нутаг дахь ойн хамгаалалтын дэглэмийг Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулиар зохицуулна.” Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль (1994) мөн хамгаалалтанд авсан газрыг бүсчилсэн байна. Хуулийн 14-р зүйлд “Байгалийн цогцолборт газрыг байгалийн хэв шинж, ургамал, амьтны аймгийн байршил, түүх, соёлын дурсгалыг нь хадгалах шаардлага, аялал, жуулчлал хөгжүүлэх нөхцөл зэргийг харгалзан дараахь бүсэд хуваана: 1/ онцгой бүс; 2/ аялал,жуулчлалын бүс;	

	- Хамгаалалтанд ороогүй газруудад (байгалийн нөөц ашиглалтын ачаалал г.м) сөрөг нөлөөтэй. Ойгоос бусад экосистем орхигдох - Нийтийн хэрэгцээний болон бэлчээрийн зориулалтаар ашиглах газрын хэмжээ багасах нь малчдын амьжиргаанд нөлөөлнө - Хамгаалалтанд ороогүй газруудад (бэлчээрийн даац хэтрэх, бэлчээрийн талбай багасах г.м) сөрөг нөлөөтэй. Сөрөг нөлөө өөр газарт шилжинэ.	3/ хязгаарлалтын бүс.” гэж заасан. Төрөөс ойн талаар баримтлах бодлого (2015)-ийн 3.3.7-д "Олон улсын жишигт нийцсэн ойн мэргэжлийн байгууллагын итгэмжлэлийн үндэсний стандартыг бий болгож, 2020 он гэхэд ойн нөөцийг зөвхөн итгэмжлэл авсан аж ахуйн нэгж, байгууллага ашигладаг тогтолцоонд шилжих" гэж ангилсан байна. Төрөөс ойн талаар баримтлах бодлого (2015)-д ойн бүрхэвчийг нэмэгдүүлэх зорилтыг дэвшүүлсэн бөгөөд 3.2.3-т "Ойгоор бүрхэгдсэн талбайн хэмжээг 2020 онд 8,3 хувьд, 2030 онд 9,0 хувьд тус тус хүргэх" гэж заасан байна. Ойн тухай хууль (2012)-ийн 30-р зүйлийн 30.2-д "Иргэн, ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллага огтолсон нэг модны оронд арав буюу түүнээс дээш тарьц суулгацыг ойд тарьж ургуулж, улсын ойн санд хүлээлгэж өгнө" гэж заасан байна. Харин 31-р зүйлийн 31.1-т "Аймаг, нийслэлийн Засаг дарга бүх нийтээр мод тарих сарын ажлыг жил бүр зохион байгуулж, 16 насанд хүрсэн иргэн бүр нэг, аж ахуйн нэгж, байгууллага таваас доошгүй мод тарьж ургуулах, услах, арчлах бөгөөд өөрийн хүчээр гүйцэтгэх боломжгүй тохиолдолд зардлыг хандивлана" гэж заасан.	

ХАВСРАЛТ 3.6

Зарчим F: Хувирах эрсдлийг тооцох

Сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчмын элементүүд	**Гол үр ашиг, эрсдлүүд** Монгол оронд REDD+-ийн хүрээнд хэрэгжүүлэхээр санал болгосон бодлого, арга хэмжээнүүдийн үр ашиг, эрсдлийн үнэлгээнээс тодорхойлсоноор	**СНСЗ-уудыг тусгаж, хэрэгжүүлэхтэй холбоотой БХЖ-ууд** (СНСЗ-уудтай холбоотой БХЖ-ын үнэлгээнд тулгуурласан)	**Цаашид сайжруулах шаардлагатай асуудлууд** Тухайн СНСЗ-ыг Монгол улсын БХЖ-уудад илүү сайн тусгаж хэрэгжүүлэхийн тулд юуг сайжруулах ёстой талаар
Хүлэмжийн хийн ялгарлын бууралт өөрчлөгдөж болох эрсдлийг үнэлэх, мөн үр дүн өөрчлөгдөх эрсдлийг аливаа юмс байнга хувирч байдаг мөн чанартай болохын нэгэн илрэл гэж үзэх	<u>Үр ашиг</u>: - Хувийн хэвшлийн орлого, иргэдийн амьжиргааг дэмжихэд ойн салбарын гүйцэтгэх үүрэг нэмэгдэнэ. - Орон нутаг дахь хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлсэнээр дэд бүтэц, иргэдийн амьжиргаа, нийгмийн үйлчилгээ болон бусад салбарын хөгжил дээшилнэ. - Мод бэлтгэл, мод боловсруулах, дагалт баялгийн ашиглалт, агро-ойн аж ахуйн үйл ажиллагааны үр дүнд орон нутгийн иргэд, аж ахуйн нэгжүүд, ойн нөхөрлөлүүдийн ажлын байр, орлого нэмэгдэнэ - Ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, нутгийн иргэд, албан хаагчдын ойн менежмент, мод боловсруулах, тогтвортой ашиглах, нөхөн сэргээлт хийх, хамгаалах, дагалт баялаг ашиглах	СНСЗ Е-ийн хүрээнд тодорхойлсон ойн нөөцөөс хүртэх үр ашгийг дээшлүүлэх арга хэмжээнүүд энд бас хамаатай. Уул уурхайн үйл ажиллгаа нэмэгдэх нь ойн нүүрстөрөгчийн шингээлт болон бусад эерэг үр дүнд таагүй нөлөөлөх эрсдэлтэйг өмнөх үнэлгээнээс тодорхойлсон. Ойг тогтвортой ашиглахтай холбоотой хэд хэдэн хуулийн заалт байдаг. Төрөөс ойн талаар баримтлах бодлого (2015)-ийн 3.3.1-т “Монгол орны ойн сангийн төлөв байдлыг нарийвчлан тодорхойлж, ойг хамгаалах, нөхөн сэргээх, зохистой ашиглах ойн тогтвортой менежментийг бий болгох” гэж заасан байна. Ойн тухай хуулийн 25.1.1-т ТББ нь "олон нийтийн нэрийн өмнөөс ойн тухай хууль тогтоомжийн биелэлтэд олон нийтийн хяналт тавих, үзлэг хийх, илэрсэн зөрчлийг арилгахыг шаардах, уг асуудлыг эрх бүхий байгууллагад тавьж	Ойн тухай хуулийг шинэчилж орон нутгийн иргэдийг ойн хяналт болон эргүүлд оролцуулахыг зөвшөөрөх шаардлагатай. Дараах нөхцлийг анхаарах ёстой: (а) Орон нутгийн иргэдийн зүгээс хэрэгжүүлэх хяналтыг сайжруулж мэдээлэл өгсөн тохиолдолд урамшуулал олгох систем бий болгох; (б) мод бэлтгэлийн хяналтад иргэний нийгмийн болон бусад оролцогч талуудын (жишээ нь судлаачид) оролцоог хангах; (в) хяналт, шалгалтад иргэний нийгмийн оролцоог хангах зэрэг болно.

	талаарх мэдлэг, ур чадвар сайжирна Эрсдэл: - Мод бэлтгэл, дагалт баялагийн хэт ашиглалтын улмаас ойн доройтох эрсдэлтэй. - Ихээхэн хэмжээний ой талбайд (шинэ газарт) уул уурхайн үйл ажиллагаа явуулах болсноор ойн нүүрстөрөгчийн шингээлт буурна. - Ойн зам барих нь ойн биологийн төрөл зүйл болон цэвдэгт сөргөөр нөлөөлж (Ойд шууд нэвтрэх боломжтой болсноор, ойн талбайд хуваагдал үүссэнээр) улмаар хүлэгт намгархаг газраас ялгарах хүлэмжийн хий нэмэгдэнэ. - Зориудаар тавьсан түймэр (ойг цэвэрлэх нэг арга юм) хяналтаас гарах. - Загийн ургалт ихэсвэл, түүгээр хооллодог хортон шавьж, чичүүл ихэснэ. - Төрийн бодлого өөрчлөгдөх, төрийн албан хаагчид ойр ойрхон солигдох зэрэг нь REDD+-ийн хэрэгжилтийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлнө. - Үрсэлгээнүүд хатаж,ургахгүй болсоноос болж торгууль ногдуулах, эсвэл ажлын үр дүн хангалтгүй байснаас шалтгаалж иргэдийн итгэл алдарч, БАХ-д	шийдвэрлүүлэх, гэм буруутай этгээдээс ойн санд учруулсан хохирлыг барагдуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргах" эрхтэй гэж заасан. Ойн менежмент болон ашиглалт (Ойн менежмент сул байх, хэт их мод бэлтгэхээс үүдэлтэй эрсдлүүд) холбоотой техникийн стандартыг боловсруулах, чадавхыг бэхжүүлэх талаар олон БХЖ-уудад тусгасан байна. Монгол улсын ногоон хөгжлийн бодлого (2014) 3.5.2-р хэсэгт байгаль орчны "MNS ISO14000" стандартыг ААН-үүдэд нэвтрүүлж, үр ашигтай үйлдвэрлэлд ашиглалтын тэргүүн туршлагыг хэрэгжүүлэх гэж заасан байна. Сөрөг нөлөө шилжих эрсдлийг зохицулахтай нэгэн адил үр дүн хувирах эрсдлийг зохицуулахад ч бас бэлчээрийн тухай БХЖ-ууд хэрэг болно. Бэлчээрийн менежменттэй холбоотой БХЖ нь байхгүй байна. Дараах 2 БХЖ нь бэлчээрийн менежментийн тодорхой хэмжээгээр зохицуулдаг. Нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль (2012)-д тусгасан бөгөөд уг хуулийн Хавсралт В-д "орон нутаг зам барих" зөвшөөрөл авахаас өмнө байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээ хийлгэсэн байх ёстой гэж заасан. Төрөөс ойн талаар баримтлах бодлого (2015)-ын 3.3.3 дахь хэсэгт ойн зам барихыг дэмжиж"Ашиглалтын ой бүхий нутагт ойн замын сүлжээг сэргээн өргөжүүлж, ойн нөөцийг иж бүрэн, зүй зохистой,	Төрөөс ойн талаар баримтлах бодлогын 3.3.1-д заасны дагуу Улсаас Монгол орны ойн сангийн төлөв байдлыг нарийвчлан тодорхойлж, ойг хамгаалах, нөхөн сэргээх, зохистой ашиглах ойн тогтвортой менежментийг бий болгох шаардлагатай. Хууль сахиулах байгууллагын ажилтнуудын экологи болон зэрлэг ан амьтан, ургамлын нөөцийн худалдааны талаарх мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх Бэлчээрийн менежментийн тухай хуулийн төслийг сүүлийн 20 гаруй жилийн туршид хэлэлцэж байгаа боловч одоогийн байдлаар тодорхой үр дүнд хүрээгүй байна. Бидний хэрэгжүүлэх дараагийн гол алхам бол газрын тухай хуулийн 52.3-р заалт "Ойн сан бүхий газрыг холбогдох хууль

	оролцох идэвхи санаачлага суларна. - Бичил зээл болон амьжиргааг дэмжихэд чиглэсэн хөрөнгийг тогтвортой бус үйл ажиллагаанд зарцуулах. Жишээ нь: малын тоо толгойг өсгөхөд г.м - Малын үнэ өсвөл тоо толгой нь нэмэгдэнэ. Ингэснээр усны хомсдолтой газар газрын доройтол бий болно. - Тухайн газарт усны нөөц нэмэгдсэнээр газар тариалан, жижиг бизнесийн үйл ажиллагаа нэмэгдэж улмаар газрын доройтолд хүргэнэ.	тогтвортой ашиглах үйлдвэрлэлийг дэмжих" гэж заасан байна. Төрийн албан хаагчдын ажлын байрны тогтворгүй байдал, улс төрийн томилгооны талаар Төрийн албаны тухай хууль (2002)-ийн 27-р зүйлийн 27.2.2-т "Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Засгийн газар, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Улсын ерөнхий прокурор, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, бүх шатны Засаг даргын бүрэн эрх дуусгавар болох, мөн энэ хуульд заасан улс төрийн албан тушаалтан уг албан тушаалаас өөрчлөгдөх нь төрийн жинхэнэ албан хаагчийг өөрчлөх үндэслэл болохгүй байх" гэж заасан байна. Гэвч бодит байдалд албан хаагчдыг ойр ойрхон	журманд нийцүүлэн бэлчээрийн зориулалтаар ашиглаж болно”-ыг батлах. Үүнээс гадна бэлчээр ашиглагчдын нөхөрлөлүүдтэй хамтрах, бэлчээрийн менежментийн төлөвлөгөөтэй уялдуулах гэх мэт албан бус (БХЖ-ын бус) арга хэмжээг мөн судалж үзэх шаардлагатай.

		солих, улс төрийн томилгоо хийх явдал их гарч байна. Амьжиргааг дээшлүүлэхэд зориулж олгосон санхүүжилт, бичил зээлийг ойн доройтолд хүргэдэг үйл ажиллагаанд ашиглах эрсдлийг зохицуулахад санхүүгийн гэрээ хэлэлцээрийг хянах, хэрэгжүүлэхтэй холбоотой БХЖ-уудыг ашиглаж болно. Хөдөлмөр эрхлэлтийн сангаас жижиг зээл олгох, түүнд батлан даалт гаргах, хүүг нөхөн төлөх, санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам (2016)-ийн 6-р зүйлийн 6.4-т "Аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага, сумын хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан ажилтан улирал тутам нийт зээлдэгчийг хамруулан зээлийг зориулалтын дагуу зарцуулж байгаа эсэхэд хяналт, шалгалт хийнэ" гэж заасан. 6-р зүйлийн 6.8-д " Жижиг зээл, санхүүгийн дэмжлэгийг зориулалтын дагуу зарцуулаагүй, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй нь хяналт, шалгалтаар тогтоогдсон бол хөрөнгийг буруутай этгээдээр нөхөн төлүүлнэ" гэж заасан. Зориудын түймэр тавихаас үүдэх эрсдлийн тухайд, Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх журмын 3.1-д (Засгийн газрын тогтоол 109, 2013 он) "Мод бэлтгэх, ойн арчилгаа, цэвэрлэгээ хийх тохиолдолд талбайн үлдэгдэл, хаягдлыг цэвэрлэхдээ шатаах аргыг хэрэглэхгүй байх" гэж заасан.	

		Ой болон байгаль хамгаалах талаарх мэдлэгийг дээшлүүлэхтэй холбоотой БХЖ-ууд: - Байгаль орныг хамгаалах тухай хууль (1995)-ийн 56-р зүйлд " хэвлэл, мэдээллийн хэрэгслээр экологийн мэдлэг, байгаль орчныг хамгаалах үндэсний уламжлал, зан заншил, хууль тогтоомж сурталчлах" гэж заасан. Мөн урамшууллын талаар 54.4-т " Байгаль орчны хууль тогтоомж зөрчсөн тухай үнэн бодит мэдээллийг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд өгсөн, түүнчлэн зөрчлийг илрүүлсэн, илрүүлэхэд бодитой туслалцаа үзүүлсэн иргэнд зөрчил гаргагчид ногдуулсан торгууль, нөхөн төлбөрийн орлогын дүнгийн 15 хувьтай тэнцэх мөнгөн урамшууллыг сум, дүүргийн Засаг дарга байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос олгоно" гэж заасан. 2015 оны Төрөөс ойн талаар баримтлах бодлогын 3.5.5-д “олон нийтийн мэдээлэл, сурталчилгааны ажлыг эрчимжүүлэх, ойн экологийн үнэ цэнийг иргэдэд ойлгуулах талаар бүх нийтийг хамарсан ажил өрнүүлэх, ойн салбарын мэдээ, мэдээллийг түгээн дэлгэрүүлэх мэргэжлийн сэтгүүл, студи байгуулахыг төрөөс дэмжих” гэж заасан. - Ногоон хөгжлийн бодлого (2014)-ын 3.3.2 дахь хэсэгт " .ойн ус тогтоон барих, нүүрсхүчлийн хий шингээх, голын татмын ус хуримтлуулах, цэвэршүүлэх чадавх зэрэг экосистемийн үйлчилгээг тэтгэн, үр өгөөжийг үнэлж олон нийтэд таниулах,	

		байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх хөрөнгө оруулалтыг 20 хувиар нэмэгдүүлэх"-ээр тусгасан. Тарьц, суулгац ургуулж арчлахтай холбоотой мэргэжлийн байгууллагын гүйцэтгэх үүрэг, хариуцлагын талаар заасан БХЖ байдаг бөгөөд арчилгаа дутмаг байх зэрэг эрсдлийг эдгээр хуулиар зохицуулсан байна. Ойн тухай хууль (2012)-ийн 31-р зүйлийн 31.2-т “Сум, дүүрэг, баг, хорооны Засаг дарга мод суулгах талбайг сонгох, хөрс боловсруулах, тарьц суулгацаар хангах, тэдгээрийг услах, арчлах ажлыг ойн мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулж, уг ажилд иргэдийг татан оролцуулна” гэж заасан байна. Цөлжиттэй тэмцэх үндэсний хөтөлбөр (2010)-ийн 14.3.1-т "Хөрсний элэгдэл, эвдрэлд сөрөг нөлөө багатай ойн зурвас бүхий газар тариалан эрхлэх бодлого, үйл ажиллагааг зохион байгуулах" гэж заасан. Ногоон хөгжлийн бодлого (2014)-ийн 3.1.5-д "Хөрсний үржил шимийг нэмэгдүүлэх, хөрс тордох агротехникийн болон усалгааны хэмнэлттэй, үр ашигтай дэвшилтэт технологи нэвтрүүлэх, ойн зурвас байгуулах замаар газар тариалан эрхлэлтийн улмаас үүсэх газрын доройтлыг бууруулж, үр тариа, төмс, хүнсний ногооны дотоодын хэрэгцээг хангах" зорилт дэвшүүлсэн.	

REDD+ -ийн үйл ажиллагааг төлөвлөх, сонгох болон хэрэгжүүлэхдээ зөвхөн нэг тодорхой газар нутагт үүссэн шууд нөлөөлж буй хүчин зүйлсийг бууруулахад чиглэсэн үйл ажиллагааг сонгох бус харин үүний оронд ойн хомсдол, доройтолд хүргэж буй далд суурь хүчин зүйлс, ойн тогтвортой менежмент, хамгааллын үйл ажиллагаа хэрэгжүүлэх, ойн нүүрстөрөгчийн шингээлтийг нэмэгдүүлэхэд саад болж буй асуудал, газар ашиглалтын өөрчлөлтийг шийдвэрлэхийг зорьж, үйл ажиллагаануудыг үүнд чиглүүлж боловсруулах	<u>Үр ашиг:</u> - Байгаль орчин болон байгаль хамгаалах талаарх иргэдийн мэдлэг, хандлага сайжирна. Байгаль хамгаалах уламжлалыг сэргээх, хэвшүүлэхийг дэмждэг болно - Хатсан болон унанги модыг цэвэрлэснээр түймрийн тохиолдол буурна. - Ойн тогтвортой менежментийн эрхзүйн орчин болон төлөвлөлт сайжирна -Байгаль хамгаалах үйл ажиллагааны санхүүжилт нэмэгдэнэ - Орон нутаг дахь хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлсэнээр дэд бүтэц, иргэдийн амьжиргаа, нийгмийн үйлчилгээ болон бусад салбарын хөгжил дээшилнэ. - Мод бэлтгэл, мод боловсруулах, дагалт баялгийн ашиглалт, агро-ойн аж ахуйн үйл ажиллагааны үр дүнд орон нутгийн иргэд, аж ахуйн нэгжүүд, ойн нөхөрлөлүүдийн ажлын байр, орлого нэмэгдэнэ - Ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, нутгийн иргэд, албан хаагчдын ойн менежмент, мод боловсруулах, тогтвортой ашиглах, нөхөн сэргээлт хийх, хамгаалах, дагалт баялаг ашиглах	Эрсдлийн хүчин зүйлстэй холбоотой асуудлаар СНСЗ F1-тэй давхцаж байна. Хүлэмжийн хийн ялгарал буурсан үр дүн хожим өөрчлөгдөх, сөрөг нөлөө өөр газарт шилжих зэрэг эрсдлийг зохицуулахад бэлчээрийн тухай БХЖ хэрэг болно. Бэлчээрийн ашиглалтыг зохицуулсан БХЖ байхгүй байна. Дараах хоёр БХЖ-д бэлчээрийн менежмент ямар нэг хэмжээгээр тусгагдсан. 2012 оны Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хуулийн 7-р зүйлийн 7.1.4-р заалтад “бэлчээрийг тухайн орон нутгийн малын тоо толгойд тохируулан улирлын хуваарьтай ашиглах” гэж; 2002 оны Газрын тухай хуулийн 52-р зүйлийн 52.2-р заалтад “Зуслан, намаржаа болон отрын бэлчээрийг баг, хот айлаар хуваарилж нийтээр ашиглана. Тухайн жилийн бэлчээрийн гарц, иргэдийн саналыг харгалзан өвөлжөө, хаваржааны бэлчээрийг малаас чөлөөлөх, мал оруулах хугацааг сум, дүүргийн Засаг дарга тогтоож, баг, хорооны Засаг дарга, иргэд мөрдөж хэрэгжүүлнэ” гэж заасан. Бэлчээр ашиглагчдын бүлэг, бэлчээрийн менежментийн төлөвлөгөө зэрэг нь үүнд мөн хамаатай. Монголд хууль бус мод бэлтгэлтэй тэмцэхтэй холбоотой БХЖ хэрэгжиж байна. Төрөөс ойн талаар баримтлах бодлого (2015)-ийн 3.1.4-т “Мод, модон материалын эрэлт нийлүүлэлтийн оновчтой арга хэмжээ авах, хууль зүйн хариуцлагыг чангатгах,	Бэлчээрийн менежментийн тухай хуулийн төслийг сүүлийн 20 гаруй жилийн туршид хэлэлцэж байгаа боловч одоогийн байдлаар тодорхой үр дүнд хүрээгүй байна. Бидний хэрэгжүүлэх дараагийн гол алхам бол газрын тухай хуулийн 52.3-р заалт “Ойн сан бүхий газрыг холбогдох хууль журманд нийцүүлэн бэлчээрийн зориулалтаар ашиглаж болно”-ыг батлах. Үүнээс гадна ойн нөхөрлөлүүдтэй хамтрах, бэлчээрийн менежментийн төлөвлөгөөний уялдаа холбоо гэх мэт албан бус (БХЖ-ын бус) арга хэмжээг мөн судалж байна. Нутгийн иргэдийг эргүүл, хяналтанд оролцуулахтай холбоотойгоор ойн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай. Дараах заалтуудийг тусгахыг зөвлөв. (i) Орон нутгийн иргэдэд түшиглэсэн хяналтыг

	талаарх мэдлэг, ур чадвар сайжирна - Гэмт хэрэг буурна. (татвараас зугтаах, зэрлэг ан амьтдын худалдаа, мансууруулах бодисын хэрэглээ г.м) <u>Эрсдлүүд</u>: - Мод модон материалын хэрэглээ өснө - Ойжуулсан талбайн арчилгаа хийгдэхгүй, уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөл хэт хүчтэй байвал хөрөнгө оруулалт үр дүнгүй, тогтворгүй болно - Иргэдийн дунд түлшний өөр эх үүсвэрийг ашиглахын оронд модыг түлшинд хэрэглэх сонирхол их байна - Модон болон малын гаралтай бусад бүтээгдэхүүний чанар шаардлага хангахгүй байх - Мод бэлтгэл, дагалт баялагийн хэт ашиглалтын улмаас ойн доройтох эрсдэлтэй. - Ихээхэн хэмжээний ой талбайд (шинэ газарт) уул уурхайн үйл ажиллагаа явуулах болсноор ойн нүүрстөрөгчийн шингээлт буурна. - Ойн зам барих нь ойн биологийн төрөл зүйл болон цэвдэгт сөргөөр нөлөөлж (Ойд шууд нэвтрэх боломжтой болсноор, ойн талбайд хуваагдал үүссэнээр) улмаар хүлэгт намгархаг газраас ялгарах хүлэмжийн хий нэмэгдэнэ.	иргэдийн оролцоог урамшуулах зэрэг арга механизмыг хэрэглэх замаар хууль бус мод бэлтгэлийг таслан зогсоох" гэж заасан. Ойн тухай хууль (2012)-ийн 37.3-т “Энэ хуулийн 37.1-д заасан үйл ажиллагааг зохион байгуулж байгаа иргэн, аж ахуйн нэгж нь өөрийн түрээслэгчийн үйл ажиллагаанд хяналт тавьж, эрхийн бичиг болон гарал үүслийн гэрчилгээгүй мод, түүнчлэн хууль бусаар бэлтгэсэн модыг боловсруулах, худалдаалахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах үүрэгтэй" гэж заасан байна. Ойг тогтвортой ашиглах талаарх заалтууд байна. Тухайлбал, Ойн тухай хууль (2012)-ийн 25-р зүйлийн 25.1.1-д “Ойн тухай хууль тогтоомжийн биелэлтэд олон нийтийн хяналт тавих, үзлэг хийх, илэрсэн зөрчлийг арилгахыг шаардах, уг асуудлыг эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх, гэм буруутай этгээдээс ойн санд учруулсан хохирлыг барагдуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргах” гэж заасан. Ойн тухай хууль (2012)-ийн 28-р зүйлийн 28.1-д " Ойн хэвийн өсөлт, хөгжилтийг хангах, бүтээмжийг дээшлүүлэх, ойг түймэр, хөнөөлт шавж, өвчнөөс урьдчилан сэргийлэх, экологийн тэнцлийг хадгалан хамгаалах зорилгоор энэ хуулийн 28.2.1-д заасан арчилгааг зөвхөн ойн мэргэжлийн байгууллага, цэвэрлэгээг ойн мэргэжлийн байгууллагаас гадна ойн нөхөрлөл, аж	сайжруулах, мэдээлэл өгсөн иргэдийг урамшуулах систем бий болгох (ii) Иргэний нийгмийн оролцоотойгоор мод бэлтгэлийн хяналтыг хийх мөн бусад оролцогч талуудыг хамруулах (судлаачид гэх мэт) (iii) Шалгалтыг иргэний нийгмийн оролцоотойгоор хийх Төрөөс Монгол орны ойн төлөв байдлын нарийвчилсан үнэлгээг хийж, төрөөс ойн талаар баримтлах бодлогийн 3.3.1 дэх хэсэгт заасан ойн тогтвортой менежментийн системийг байгуулах. Ой ашиглалтыг нэмэгдүүлэхтэй холбоотой REDD+-ийн БАХ-нүүдэд зориулаад мод бэлтгэлийг нэмэгдүүлснээр урт хугацаанд нүүрстөрөгчийн шингээлтийг нэмэгдүүлэх болон бусад үр ашигт хэрхэн нөлөөлөх талаар

	- Зориудаар тавьсан түймэр (ойг цэвэрлэх нэг арга юм) хяналтаас гарах. - Загийн ургалт ихэсвэл, түүгээр хооллодог хортон шавьж, чичүүл ихэснэ. - Төрийн бодлого өөрчлөгдөх, төрийн албан хаагчид ойр ойрхон солигдох зэрэг нь REDD+-ийн хэрэгжилтийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлнө. - Үрсэлгээнүүд хатаж, ургахгүй болсноос болж торгууль ноогдуулах, эсвэл ажлын үр дүн хангалтгүй байснаас шалтгаалж, иргэдийн илтгэл алдарч, БАХ-д оролцох идэвхи санаачилга суларна. - Бичил зээл болон амьжиргааг дэмжихэд чиглэсэн хөрөнгийг тогтвортой бус үйл ажиллагаанд зарцуулах. Жишээ нь: малын тоо толгойг өсгөхөд г.м - Малын үнэ өсвөл тоо толгой нь нэмэгдэнэ. Ингэснээр усны хомсдолтой газар газрын доройтол бий болно. - Тухайн газарт усны нөөц нэмэгдсэнээр газар тариалан, жижиг бизнесийн үйл ажиллагаа нэмэгдэж улмаар газрын доройтолд хүргэнэ.	ахуйн нэгж, иргэн гэрээгээр хийнэ" гэж заасан. Төрөөс ойн талаар баримтлах бодлого (2015)-ийн 3.3.1-т “Монгол орны ойн сангийн төлөв байдлыг нарийвчлан тодорхойлж, ойг хамгаалах, нөхөн сэргээх, зохистой ашиглах ойн тогтвортой менежментийг бий болгох" гэж заасан. Эрчим хүчний хэрэглээний талаар Төрөөс ойн талаар баримтлах бодлого (2015)-ийн 3.3.8-д "Сум, суурин газрын төсөвт байгууллагуудыг нэгдсэн халаалтад шилжүүлэх, мод орлох түлшний үйлдвэрлэлийг дэмжих, урамшуулах зэргээр түлшний модны хэрэглээг бууруулах" гэж заасан. Цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөр (2010)-ийн 9.5.1.6.-д "Эрчим хүчний бусад эх үүсвэрүүд (ахуйн хэрэглээний хийн түлшний хэрэглээг нэмэгдүүлэх, сум, суурин газрыг эрчим хүчний нэгдсэн сүлжээнд холбох зэрэг)-ийг бий болгосноор гандуу бүс нутгийн мод, бут сөөг, ургамлыг түлшний зориулалтаар ашиглаж байгааг хязгаарлах" гэж тусгасан. Түлшний модны хэрэглээг хязгаарлах талаар Ойн тухай хуулийн 13.1.6, 17.1.4, 18.1.2, 20.1.4-т тусгасан. Ургамал хамгааллын тухай хууль (2007) мөн газрын доройтлын хэд хэдэн хүчин зүйлсийн талаар авч үзсэн байна. Уг хуулийн 1.1 " Энэ хуулийн зорилт нь бэлчээрийн болон таримал ургамлыг	нотолгоо баримтыг цуглуулах шаардлагатай. Мөн модон материал, модны хаягдлыг түлш болгон ашиглахыг нэмэгдүүлэх БАХ-нүүдийг тэнцвэртэй хэрэгжүүлж тэдгээр БХЖ-уудын зорилгыг хангах хэрэгтэй. Хууль сахиулах байгууллагуудын экологийн мэдлэг, зэрлэг ан амьтан, ургамлын арилжааны талаар мэдлэгийг сайжруулах.

		ургамлын өвчин, хөнөөлт шавж, мэрэгч амьтан, хог ургамлаас хамгаалах, түүнтэй тэмцэх, хорио цээр тогтоох, хяналт тавих үйл ажиллагаатай холбогдон төр, иргэн, хуулийн этгээдийн хооронд үүсэх харилцааг зохицуулахад оршино" гэж заасан. Төрөөс ойн талаар баримтлах бодлого (2015)-ийн 3.1.3-д "Ойн түймрийн аюул бүхий үед эргүүл гаргах, түймрийг илрүүлэхэд сансрын мэдээлэл ашиглах, цахим харилцаа, үүрэн холбооны сүлжээ бий болгох ажлыг зохион байгуулан түймрийг шуурхай илрүүлж, унтраах" гэж заасан.	
Үндэсний ойн мониторингийн систем (ҮОМС) болон хиймэл дагуулын газрын мониторингийн систем, үндэсний ойн тооллого, хүлэмжийн хийн тооллого зэргийг төлөвлөж хэрэгжүүлэхдээ REDD+-ийн бодлого, арга хэмжээний үр дүнг хянах, хэмжих, тайлагнах үүрэг гүйцэтгэх, үр дүн хувирч өөрчлөгдөж байгаа талаарх мэдээллийг илрүүлж, мэдээлж байхаар	***Үр дүн хувирах болон сөрөг нөлөө шилжих эрсдлийг нэг элементийн хүрээнд нэгтгэх талаар харгалзаж үз.***		

зохион байгуулсан байна. Үүнийг хэрэгжүүлэх хүний болон техникийн чадавхийг бий болгосон байна.	

ХАВСРАЛТ 3.7

Зарчим G: Хүлэмжийн хийн ялгаралт өөр газар шилжих явдлыг бууруулах

Сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчмын элементүүд	**Гол үр ашиг, эрсдлүүд** Монгол оронд REDD+-ийн хүрээнд хэрэгжүүлэхээр санал болгосон бодлого, арга хэмжээнүүдийн үр ашиг, эрсдлийн үнэлгээнээс тодорхойлсоноор	**СНСЗ-уудыг тусгаж, хэрэгжүүлэхтэй холбоотой БХЖ-ууд** (СНСЗ-уудтай холбоотой БХЖ-ын үнэлгээнд тулгуурласан)	**Цаашид сайжруулах шаардлагатай асуудлууд** Тухайн СНСЗ-ыг Монгол улсын БХЖ-уудад илүү сайн тусгаж хэрэгжүүлэхийн тулд юуг сайжруулах ёстой талаар
Улсын нийт нутаг дэвсгэрийг хамруулсан Үндэсний стратеги болон REDD+-ийн бүх үйл ажиллагааг үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэн тогтмол шинэчилж байх	<u>Үр ашиг</u>: - Байгалийн сэргэн ургалтыг дэмжих ойжуулалт, хийх үйл ажиллагаа нэмэгдсэнээр ойн ургалт бүтээмж сайжирна. - Ойн экосистемийн үйлчилгээг бүрдүүлж, биологийн олон янз байдлын амьдрах орчин болон тэдний нүүдэл, шилжилтэнд ач тустай - Газрын доройтолтой холбоотой экосистемийн үйлчилгээ сайжирч, хөрсний чийг алдагдах, цэвдэг хайлах, хөрсний эвдрэл, элсний нүүдэл, цөлжилт зэрэг багасна. - Хүн ам, үйлдвэр, хөдөө аж ахуйн усан хангамж, нөөц нэмэгдэнэ - Бэлчээрийн менежмент сайжирч, эрчимжсэн мал аж ахуй хөгжинө. Махны чанар дээшилж, хүнсний аюулгүй байдал сайжирна	Үндэсний REDD+ хөтөлбөр болон хүлэмжийн хийн ялгарлын суурь түвшин энд хамаатай. Салбар дундын оролцооны талаар СНСЗ В5-ыг үзнэ үү. REDD+-ийн БАХ-нүүдийн сөрөг нөлөө шилжих эрсдлийг зохицуулах асуудал нь бэлчээрийн менежменттэй холбоотой. Дараах хоёр БХЖ-д бэлчээрийн менежмент ямар нэг хэмжээгээр тусгагдсан. - Хөрс хамгаалах цөлжилтөөс сэргийлэх тухай хууль (2012)-ийн 7-р зүйлийн 7.1.4-д "Бэлчээрийг тухайн орон нутгийн малын тоо толгойд тохируулан улирлын хуваарьтай ашиглах" гэж заасан. - Газрын тухай хууль (2002)-ийн 52-р зүйлийн 52.2-т "Зуслан, намаржаа болон отрын бэлчээрийг баг, хот айлаар хуваарилж нийтээр ашиглана.	Төрөөс Монгол орны ойн төлөв байдлын нарийвчилсан үнэлгээг хийж, төрөөс ойн талаар баримтлах бодлогийн 3.3.1 дэх хэсэгт заасан ойн тогтвортой менежментийн системийг байгуулах. Бэлчээрийн менежментийн тухай хуулийн төслийг сүүлийн 20 гаруй жилийн туршид хэлэлцэж байгаа боловч одоогийн байдлаар тодорхой үр дүнд хүрээгүй байна. Бидний хэрэгжүүлэх дараагийн гол алхам бол газрын тухай хуулийн 52.3-р заалт "Ойн сан бүхий газрыг холбогдох хууль журманд нийцүүлэн бэлчээрийн зориулалтаар ашиглаж болно"-ыг батлах. Үүнээс гадна бэлчээр ашиглагчдын нөхөрлөлүүдтэй хамтрах, бэлчээрийн менежментийн

	Эрсдлүүд: - Хууль бус мод бэлтгэл өөр ой руу болон бусад улс руу шилжих эрсдэлтэй. - Ой болон байгалийн нөөцийг ашиглах боломж буурах буюу баялгийг хүртэх боломж тэгш бус байх нь ойгоос хамаарч аж амьдралаа залгуулдаг зарим иргэдийн амьжиргаанд сөргөөр нөлөөлж болзошгүй (зөвшөөрөлтэй болон хууль бус мод бэлтгэл эрхэлдэг, ан хийдэг, ойн дагалт баялаг ашигладаг хүмүүс г.м.) - Хамгаалалтанд ороогүй бүс нутгийн хүрээлэн буй орчинд сөргөөр нөлөөлж болно (бэлчээрийн ачаалал шилжилт г.м). Ойгоос бусад экосистем орхигдох эрсдэлтэй. - Нийтийн хэрэгцээний болон бэлчээрийн зориулалтаар ашиглах газрын хэмжээ багасах нь малчдын амьжиргаанд нөлөөлнө - Хамгаалалтанд ороогүй бүс нутгийн хүрээлэн буй орчинд сөргөөр нөлөөлж болно (бэлчээрийн даац хэтрэх, хэмжээ нь багасах г.м)	Тухайн жилийн бэлчээрийн гарц, иргэдийн саналыг харгалзан өвөлжөө, хаваржааны бэлчээрийг малаас чөлөөлөх, мал оруулах хугацааг сум, дүүргийн Засаг дарга тогтоож, баг, хорооны Засаг дарга, иргэд мөрдөж хэрэгжүүлнэ. Бэлчээр ашиглагчдын бүлэг болон бэлчээрийн менежментийн төлөвлөгөө зэрэг ойн болон бэлчээрийн мал аж ахуйн салбарын хамтын ажиллагаанд маш чухал юм. Төрөөс ойн талаар баримтлах бодлого (2015)-ийн 3.3.1-т "Монгол орны ойн сангийн төлөв байдлыг нарийвчлан тодорхойлж, ойг хамгаалах, нөхөн сэргээх, зохистой ашиглах ойн тогтвортой менежментийг бий болгох; " гэж заасан.	төлөвлөгөөтэй уялдуулах гэх мэт албан бус (БХЖ-ын бус) арга хэмжээг мөн судлах шаардлагатай.

Үндэсний ойн мониторингийн систем (ҮОМС)-ийг боловсруулж, ажиллуулж, ашиглахдаа орон нутаг, аймаг болон улсын хэмжээнд сөрөг нөлөө шилжиж байгаа талаарх мэдээллийг (газар ашиглалтын өөрчлөлтийг тогтоох г.м) илрүүлэх давтамжийг тохируулж өгсөн байна. Үүнийг хэрэгжүүлэх хүний болон техникийн чадавхыг буй болгосон байна.	***Үр дүн хувирах, сөрөг нөлөө шилжих явдлыг илрүүлэх нэгдсэн элемент байж болох талаар авч үзэх.***	Үүнтэй холбоотой мэдээлэл нт Үндэсний ойн мониторингийн системийн цуглуулах мэдээ, баримт мөн (Хүлэмжийн хийн ялгарлын суурь түвшин ч бас холбоотой байж болно).	ҮОМС нь энэ мэдээллийг баримтжуулан авах боломжтой байхаар төлөвлөж зохион байгуулах. Оролцогч талуудын зүгээс: ҮОМС-ээс гарч байгаа мэдээллийн үнэн зөв байдлыг мэргэжлийн байгууллагуудаас шалгаж байх нь зүйтэй.
REDD+ -ийн үйл ажиллагааг төлөвлөх, сонгох болон хэрэгжүүлэхдээ зөвхөн тодорхой газар нутагт үүссэн шууд нөлөөлж буй хүчин зүйлсийг бууруулахад чиглэсэн үйл ажиллагааг сонгох бус харин үүний оронд ойн хомсдол, доройтолд хүргэж буй далд суурь хүчин зүйлс, ойн тогтвортой менежмент, хамгааллын үйл ажиллагаа хэрэгжүүлэх, ойн нүүрстөрөгчийн	<u>Үр ашиг</u>: - Модны импорт багасна. - Ойн тогтвортой менежментийн эрхзүйн орчин болон төлөвлөлт сайжирна - Байгаль хамгаалах үйл ажиллагааны санхүүжилт нэмэгдэнэ - Иргэдийн байгаль орчны талаарх мэдлэг, хандлага, ойг хамгаалах талаарх хандлага, хууль тогтоомжийн талаарх мэдлэг сайжирна. Байгаль хамгаалах уламжлалыг сэргээнэ. - Унанги модыг цэвэрлэж, огтлол хийсний улмаас түймрийн тохиолдол буурна	СНСЗ F2-той давхцаж байна. Ойн тогтвортой ашиглалтын талаар хуульчилсан хэд хэдэн заалт байдаг. Ойн тухай хууль (2012)-ийн 25-р зүйлийн 25.1.1-д “Ойн тухай хууль тогтоомжийн биелэлтэд олон нийтийн хяналт тавих, үзлэг хийх, илэрсэн зөрчлийг арилгахыг шаардах, уг асуудлыг эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх, гэм буруутай этгээдээс ойн санд учруулсан хохирлыг барагдуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргах” гэж заасан. Ойн тухай хууль (2012)-ийн 28-р зүйлийн 28.1-д " Ойн хэвийн өсөлт, хөгжилтийг хангах, бүтээмжийг дээшлүүлэх, ойг түймэр,	Нутгийн иргэдийг эргүүл, хяналтанд оролцуулахтай холбоотойгоор ойн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай. Дараах заалтуудийг тусгахыг зөвлөв. (i) Орон нутгийн иргэдэд түшиглэсэн хяналтыг сайжруулах, мэдээлэл өгсөн иргэдийг урамшуулах систем бий болгох (ii) Иргэний нийгмийн оролцоотойгоор мод бэлтгэлийн хяналтыг хийх мөн бусад оролцогч талуудыг хамруулах (судлаачид гэх мэт) (iii) Шалгалтыг иргэний нийгмийн оролцоотойгоор хийх

шингээлтийг нэмэгдүүлэхэд саад болж буй асуудал, газар ашиглалтын өөрчлөлтийг шийдвэрлэхийг зорьж, үйл ажиллагааануудыг үүнд чиглүүлэх	- Орон нутаг дахь хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлсэнээр дэд бүтэц, иргэдийн амьжиргаа, нийгмийн үйлчилгээ болон бусад салбарын хөгжил дээшилнэ. - Мод бэлтгэл, мод боловсруулах, дагалт баялгийн ашиглалт, агро-ойн аж ахуйн үйл ажиллагааны үр дүнд орон нутгийн иргэд, аж ахуйн нэгжүүд, ойн нөхөрлөлүүдийн ажлын байр, орлого нэмэгдэнэ - Ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, нутгийн иргэд, албан хаагчдын ойн менежмент, мод боловсруулах, тогтвортой ашиглах, нөхөн сэргээлт хийх, хамгаалах, дагалт баялаг ашиглах талаарх мэдлэг, ур чадвар сайжирна. <u>Эрсдлүүд</u>: - БАХ хэрэгжээгүй газарт түлшний зориулалтаар модыг хууль бусаар ашиглах явдал нэмэгдэнэ (сөрөг нөлөө өөр газарт шилжих эрсдэл) -Иргэд түлшний өөр эх үүсвэр ашиглахын оронд мод түлшинд хэрэглэх сонирхолтой. - Дотоодын мод, модон бүтээгдэхүүний эрэлтийг хангахад хүндрэл үүсч, тус улсын ойн санд ачаалал нэмэгдэнэ	хөнөөлт шавж, өвчнөөс урьдчилан сэргийлэх, экологийн тэнцлийг хадгалан хамгаалах зорилгоор энэ хуулийн 28.2.1-д заасан арчилгааг зөвхөн ойн мэргэжлийн байгууллага, цэвэрлэгээг ойн мэргэжлийн байгууллагаас гадна ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, иргэн гэрээгээр хийнэ" гэж заасан. Төрөөс ойн талаар баримтлах бодлого (2015)-ийн 3.3.1-т "Монгол орны ойн сангийн төлөв байдлыг нарийвчлан тодорхойлж, ойг хамгаалах, нөхөн сэргээх, зохистой ашиглах ойн тогтвортой менежментийг бий болгох;" гэж заасан. Хууль бус мод бэлтгэлийг зохицуулах хэд хэдэн БХЖ байдаг. Төрөөс ойн талаар баримтлах бодлого (2015)-ийн 3.1.4-т "Мод, модон материалын эрэлт нийлүүлэлтийн оновчтой арга хэмжээ авах, хууль зүйн хариуцлагыг чангатгах, иргэдийн оролцоог урамшуулах зэрэг арга механизмыг хэрэглэх замаар хууль бус мод бэлтгэлийг таслан зогсоох" гэж заасан. Ойн тухай хууль (2012)-ийн 37-р зүйлийн 37.3-т "Энэ хуулийн 37.1-д заасан үйл ажиллагааг зохион байгуулж байгаа иргэн, аж ахуйн нэгж нь өөрийн түрээслэгчийн үйл ажиллагаанд хяналт тавьж, эрхийн бичиг болон гарал үүслийн	Төрөөс ойн талаар баримтлах бодлогын 3.3.1-д заасны дагуу Улсаас Монгол орны ойн сангийн төлөв байдлыг нарийвчлан тодорхойлж, ойг хамгаалах, нөхөн сэргээх, зохистой ашиглах ойн тогтвортой менежментийг бий болгох шаардлагатай REDD+-ийн БАХ-ний хүрээнд мод бэлтгэлийг цаашид хэт нэмэгдүүлсэнээр ямар урт хугацаанд нүүрстөрөгчийн шингээлт болон бусад чиглэлээр ямар үр дагавар гарч болох талаар баримт, нотолгоо цуглуулах шаардлагатай. Хууль бус мод бэлтгэлээс орж байгаа орлогын тодорхой хувийг мөнгөн бус орлогийн санд төвлөрүүлэх, хууль бус мод бэлтгэлийн талаар мэдээлэл өгсөн иргэнд татварын урамшуулал олгох тухай шинэ хууль журмыг бий болгох шаардлагатай байна. Модон материалын ашиглалтыг нэмэгдүүлэх, модны хаягдлыг түлшин ашиглах чиглэлээр хэрэгжих БАХ-нүүд болон

	- Хүний хүчин зүйлээс үүдэлтэй түймэр бусад газарт (жишээ нь эргүүл хяналт сул, мэдлэг мэдээлэл муу, хүмүүсийн сахилга бат тааруу бол) шилжих эрсдэлтэй - Мод модон материалын хэрэглээ өснө - Модон болон малын гаралтай, бусад бүтээгдэхүүний чанар шаардлага хангахгүй байх - Мод бэлтгэл, дагалт баялагийн хэт ашиглалтын улмаас ой доройтох эрсдэлтэй. - Ихээхэн хэмжээний ой талбайд (шинэ газарт) уул уурхайн үйл ажиллагаа явуулах болсноор ойн нүүрстөрөгчийн шингээлт буурна. - Ойн зам барих нь ойн биологийн төрөл зүйл болон цэвдэгт сөргөөр нөлөөлж (Ойд шууд нэвтрэх боломжтой болсноор, ойн талбайд хуваагдал үүссэнээр) улмаар хүлэгт намгархаг газраас ялгарах хүлэмжийн хий нэмэгдэнэ. - Загийн ургалт ихэсвэл, түүгээр хооллодог хортон шавьж, чичүүл ихэснэ. - Бичил зээл болон амьжиргааг дэмжихэд чиглэсэн хөрөнгийг тогтвортой бус үйл ажиллагаанд зарцуулах. Жишээ нь: малын тоо толгойг өсгөхөд г.м	гэрчилгээгүй мод, түүнчлэн хууль бусаар бэлтгэсэн модыг боловсруулах, худалдаалахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах үүрэгтэй" гэж заасан. Санкт Петрбургийн тунхаг (2005). Эрчим хүчний хэрэглээний талаар: Төрөөс ойн талаар баримтлах бодлого (2015)-ийн 3.3.8-д "Сум, суурин газрын төсөвт байгууллагуудыг нэгдсэн халаалтад шилжүүлэх, мод орлох түлшний үйлдвэрлэлийг дэмжих, урамшуулах зэргээр түлшний модны хэрэглээг бууруулах " гэж заасан. Цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөр (2010)-ийн 9.5.1.6-д "Эрчим хүчний бусад эх үүсвэрүүд (ахуйн хэрэглээний хийн түлшний хэрэглээг нэмэгдүүлэх, сум, суурин газрыг эрчим хүчний нэгдсэн сүлжээнд холбох зэрэг)-ийг бий болгосноор гандуу бүс нутгийн мод, бут сөөг, ургамлыг түлшний зориулалтаар ашиглаж байгааг хязгаарлах" гэж заасан. Түймэртэй тэмцэх талаар: Төрөөс ойн талаар баримтлах бодлого (2015)-ийн 3.1.3-д "Ойн түймрийн аюул бүхий үед эргүүл гаргах, түймрийг илрүүлэхэд сансрын мэдээлэл ашиглах, цахим харилцаа, үүрэн холбооны сүлжээ бий болгох ажлыг зохион байгуулан	эдгээр БХЖ-уудыг тэнцвэртэй авч үзэх нь зүйтэй. Бэлчээрийн менежментийн тухай хуулийн төслийг сүүлийн 20 гаруй жилийн туршид хэлэлцэж байгаа боловч одоогийн байдлаар тодорхой үр дүнд хүрээгүй байна. Бидний хэрэгжүүлэх дараагийн гол алхам бол газрын тухай хуулийн 52.3-р заалт “Ойн сан бүхий газрыг холбогдох хууль журманд нийцүүлэн бэлчээрийн зориулалтаар ашиглаж болно”-ыг батлах. Үүнээс гадна бэлчээр ашиглагчдын нөхөрлөлүүдтэй хамтрах, бэлчээрийн менежментийн төлөвлөгөөтэй уялдуулах гэх мэт албан бус (БХЖ-ын бус) арга хэмжээг мөн судлах шаардлагатай.

	- Малын үнэ өсвөл тоо толгой нь нэмэгдэнэ. Ингэснээр усны хомсдолтой газар газрын доройтол бий болно. - Тухайн газарт усны нөөц нэмэгдсэнээр газар тариалан, жижиг бизнесийн үйл ажиллагаа нэмэгдэж улмаар газрын доройтолд хүргэнэ.	түймрийг шуурхай илрүүлж, унтраах" гэж заасан. Зориуд түймэр тавих тухай асуудлыг Ойн тухай хуулийн 26-р зүйлээр зохицуулсан. Ургамал хамгаалах тухай хууль (2007)-д мөн газрын доройтлын хэд хэдэн хүчин зүйлсийг авч үзсэн байна: 1-р зүйлийн 1.1-т "Энэ хуулийн зорилт нь бэлчээрийн болон таримал ургамлыг ургамлын өвчин, хөнөөлт шавж, мэрэгч амьтан, хог ургамлаас хамгаалах, түүнтэй тэмцэх, хорио цээр тогтоох, хяналт тавих үйл ажиллагаатай холбогдон төр, иргэн, хуулийн этгээдийн хооронд үүсэх харилцааг зохицуулахад оршино" гэж заасан. Бэлчээрийн ашиглалтыг зохицуулсан БХЖ байхгүй байна. Дараах хоёр БХЖ-д бэлчээрийн менежмент ямар нэг хэмжээгээр тусгагдсан. 2012 оны Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хуулийн 7-р зүйлийн 7.1.4-р заалтад “бэлчээрийг тухайн орон нутгийн малын тоо толгойд тохируулан улирлын хуваарьтай ашиглах” гэж; 2002 оны Газрын тухай хуулийн 52-р зүйлийн 52.2-р заалтад “Зуслан, намаржаа болон отрын бэлчээрийг баг, хот айлаар хуваарилж нийтээр ашиглана. Тухайн жилийн бэлчээрийн гарц, иргэдийн саналыг харгалзан өвөлжөө, хаваржааны	

		бэлчээрийг малаас чөлөөлөх, мал оруулах хугацааг сум, дүүргийн Засаг дарга тогтоож, баг, хорооны Засаг дарга, иргэд мөрдөж хэрэгжүүлнэ” гэж заасан. Бэлчээр ашиглагчдын бүлэг, бэлчээрийн менежментийн төлөвлөгөө зэрэг нь үүнд мөн хамаатай.	
REDD+-ийн тодорхой үйл ажиллагааг орон нутгийн болон үндэсний хэмжээнд хэрэгжүүлсэнтэй холбоотойгоор хүлэмжийн хийн ялгарал нэг газраас нөгөөд шилжих эрсдэл үүсч болох бөгөөд энэ эрсдлийг бууруулахад чиглэсэн үйл ажиллагааг нэн тэргүүнд сонгон авч, боловсруулж, хэрэгжүүлэх ба REDD+-ийн үйл ажиллагаанаас иргэдийн амьжиргаан үзүүлэх нөлөөлөл, ойн болон хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний эрэлт, нийлүүлэлтийг харгалзаж үзэх **REDD+ -ийн үйл ажиллагааг төлөвлөх, сонгох болон	<u>Үр ашиг:</u> - Ойн сангийн тодорхой хэсгийг ойн нөхөрлөлүүд хариуцах болсоноор эргүүл, хамгаалалт сайжирч түймрийн эрсдэл буурна - Хувийн хэвшлийн орлого, иргэдийн амьжиргааг дэмжихэд ойн салбарын гүйцэтгэх үүрэг нэмэгдэнэ. - Орон нутаг дахь хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлсэнээр дэд бүтэц, иргэдийн амьжиргаа, нийгмийн үйлчилгээ болон бусад салбарын хөгжил дээшилнэ. - Мод бэлтгэл, мод боловсруулах, дагалт баялгийн ашиглалт, агро-ойн аж ахуйн үйл ажиллагааны үр дүнд орон нутгийн иргэд, аж ахуйн нэгжүүд, ойн нөхөрлөлүүдийн ажлын байр, орлого нэмэгдэнэ - Ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, нутгийн иргэд, албан хаагчдын ойн менежмент, мод боловсруулах, тогтвортой ашиглах, нөхөн сэргээлт хийх, хамгаалах, дагалт баялаг ашиглах	СНСЗ F1-тэй давхацаж байна. Ойн нөхөрлөл, ойн аж ахуйн нэгж, байгууллагуудын гүйцэтгэх үүрэг, хариуцлагын талаар заасан хэд хэдэн БХЖ байдаг (СНСЗ b, c-г үз). Жишээ нь, Байгаль орчныг хамгаалах тухай хууль (1995)-ийн 6-р зүйлийн 6.2-т "Хуульд өөрөөр заагаагүй бол Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, гадаадын иргэн, хуулийн этгээд байгалийн баялгийг зохих төлбөр, хураамжийг төлж, гэрээ, тусгай зөвшөөрөл буюу эрхийн бичгийн дагуу ашиглаж болно" гэж заасан. Ойн тухай хууль (2012)-ийн 21-р зүйлд ойн нөхөрлөлийн үүрэг, хариуцлагын талаар тусгасан 21.4 дэхь хэсэгт “Ойн нөхөрлөл нь гэрээний дагуу эзэмшиж байгаа ойн сангийн тодорхой хэсгийг ой, хээрийн түймрээс хамгаалах арга хэмжээг өөрийн хөрөнгөөр хэрэгжүүлнэ" гэж заасан. Сөрөг нөлөөлөл шилжих эрсдэл үүсэх эсэх нь ойн тогтвортой менежментийг хэр үр дүнтэй хэрэгжүүлсэнээс	Ойтой холбоотой үйл ажиллагаанаас орж ирэх орлогоос ойн нөхөрлөлүүдэд зориулах хуваарилалтыг нэмэгдүүлэхийн тулд Ойн тухай хууль эсвэл холбогдох журмыг өөрчлөх. Ойгоос орж ирэх орлогыг ойн менежментийн чиглэлээр зарцуулж ойн нөхөрлөлүүдэд дэд бүтцийн хөгжилд шууд хөрөнгө оруулалт хийх бололцоог олгох. Хууль бус мод бэлтгэлээс орж байгаа орлогийн тодорхой хувийг мөнгөн бус орлогийн санд төвлөрүүлэх, хууль бус мод бэлтгэлийн талаар мэдээлэл өгсөн иргэнд татварын урамшуулал олгох тухай шинэ хууль журмыг бий болгох шаардлагатай байна. Малчдын амьжиргааг дэмжих орлогын бусад эх үүсвэрийг бий болгох, эрчимжүүлсэн мал

хэрэгжүүлэхдээ хүлэмжийн хийн ялгарал өөр газарт шилжих эрсдлийг харгалзаж үзэх, тодорхой сонгож авсан REDD+ үйл ажиллагааг хэрэгжүүлэх явцад гарч болох сөрөг нөлөө шилжих эрсдлийг шинжлэх, үүнд сөрөг нөлөө өөр экосистемд шилжих, хүлэрт намгархаг газрыг хувиргаж хөдөө аж ахуйд ашигласантай холбоотой үүсэх эрсдэл, ойгоос өөр бүсэд сөрөг нөлөө шилжих эрсдлийг харгалзаж үзэх	талаарх мэдлэг, ур чадвар сайжирна - Хөрш орнуудтай ойн салбар, байгаль орчны асуудлаар өргөн хүрээнд хамтран аижллах боломж нэмэгдэнэ. <u>Эрсдлүүд</u>: - Агро ойн аж ахуйн загвар нь бүс нутаг бүрт болон бүх төрлийн ойн хэв шинжид сайн тохирохгүй байж болох төдийгүй хэрэгжилт, цар хүрээ газарт байгалийн нөөц илүү байдаг г.м) - Хамгаалалтанд ороогүй бүс нутгийн хүрээлэн нь өөр өөр байхын зэрэгцээ тогтвортой бус байх үр дагавар гарч болно - Орон нутагт шилжилт хөдөлгөөн нэмэгдэнэ (Нөхөн сэргээлтийг дэмжих зорилгоор хамгаалалтанд авах буюу хамгаалалтын бүс тогтоосны улмаас амьжиргааны эх үүсвэр буурсны улмаас) - Бичил зээл болон амьжиргааг дэмжихэд чиглэсэн хөрөнгийг тогтвортой бус үйл ажиллагаанд зарцуулах. Жишээ нь: малын тоо толгойг өсгөхөд г.м - Байгалийн нөөцтэй холбоотой үйл ажиллагааны тухайд БАХ-д тэгш хүртээмжтэй оролцож чадахгүй байх эрсдэл (зарим буй орчинд сөргөөр нөлөөлж болно	хамаарна. Үүнд ойн нөхөрлөлүүдийн үйл ажиллагаа мөн хамаатай. Ойн тогтвортой менежментийн цар хүрээний талаар заасан БХЖ байхгүй байна (?), үндэсний хэмжээний ойн тогтвортой менежмент боловсруулах зөвлөмж гарсан. Монголд хууль бус мод бэлтгэлтэй тэмцэхтэй холбоотой БХЖ хэрэгжиж байна. (СНСЗ F1-ийг үз). Эдгээр БХЖ нь хууль хэрэгжилт сайжирсаны улмаас сөрөг нөлөө өөр газарт шилжих эрсдлийг харгалзаагүй. Амьжиргааны эх үүсвэрүүдийг төрөлжүүлэх, сайжруулахтай холбоотой хэд хэдэн БХЖ байна (СНСЗ А3-ыг үз), тухайлбал Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн тухай хууль (1997 оны 10 сарын 23)-ийн 7.1-р зүйлд "Зөвлөл нь тусгай хамгаалалттай газрын орчны бүсийг хөгжүүлэх, нутгийн иргэдийн ахуй амьдралыг дэмжих зорилго бүхий орчны бүсийн сан байгуулж болно" гэж заасан ба 7.4.2-р зүйлд “Тусгай хамгаалалттай орчны бүсийн санг нутгийн иргэдийн ахуй амьдралыг дэмжих, жижиг үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэхэд тусламж, дэмжлэг үзүүлэх, төсөл хэрэгжүүлэхэд ашиглана” гэж заасан. Уур амьсгалын өөрчлөлтийг даван туулах амьжиргааг бэхжүүлэх	аж ахуй болон газар тариалан (малын тэжээлийн ургамал тарих)-тай холбох. Агро ойн аж ахуйн үйл ажиллагааг дэмжихэд зориулсан хөнгөлөлттэй зээлийн хөтөлбөр хэрэгжүүлэх хууль эрхзүйн орчин бий болгох шаардлагатай. Агро ойн аж ахуйн стратегийг үр ашиг эрсдлийг нэмэгдүүлэх арга хэмжээтэй уялдуулан боловсруулна. Бэлчээрийн менежментийн тухай хуулийн төслийг сүүлийн 20 гаруй жилийн туршид хэлэлцэж байгаа боловч одоогийн байдлаар тодорхой үр дүнд хүрээгүй байна. Бидний хэрэгжүүлэх дараагийн гол алхам бол газрын тухай хуулийн 52.3-р заалт “Ойн сан бүхий газрыг холбогдох хууль журманд нийцүүлэн бэлчээрийн зориулалтаар ашиглаж болно” гэсэн заалтыг цуцлах хэрэгтэй. Иргэдийг хүйтний улиралд хүчээр нүүлгэн шилжүүлэхийг хориглосон хуулийн заалт хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа. Хүйтний улиралд

	(бэлчээрийн даац хэтрэх, хэмжээ нь багасах, сөрөг нөлөө шилжих г.м) - Зарим экосистемийн нэн тэргүүнд чухалчилж, хамгаалах болсноор бусад газарт дарамт, ачаалал нэмэгдэнэ, ойн бус экосистем орхигдоно - Малын үнэ өсвөл тоо толгой нь нэмэгдэнэ. Ингэснээр усны хомсдолтой газар газрын доройтол бий болно. - Тухайн газарт усны нөөц нэмэгдсэнээр газар тариалан, жижиг бизнесийн үйл ажиллагаа нэмэгдэж улмаар газрын доройтолд хүргэнэ. - Хууль бус мод бэлтгэл өөр ой руу болон өөр улс руу шилжих эрсдэлтэй - Ой болон байгалийн нөөцийг ашиглах боломж буурах буюу баялгийг хүртэх боломж тэгш бус байх нь ойгоос хамаарч аж амьдралаа залгуулдаг зарим иргэдийн амьжиргаанд сөргөөр нөлөөлж болзошгүй (зөвшөөрөлтэй болон хууль бус мод бэлтгэл эрхэлдэг, ан хийдэг, ойн дагалт баялаг ашигладаг хүмүүс г.м.) - Хамгаалалтанд ороогүй бүс нутгийн хүрээлэн буй орчинд сөргөөр нөлөөлж болно (бэлчээрийн ачаалал шилжилт	талаар Монгол улсын Ногоон хөгжлийн бодлого (2014)-ийн 3.4.6-т "Байгалийн хүчин зүйл, баялгаас шууд хамаарал бүхий иргэдийн амьжиргааг сайжруулах төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлж, уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөллийг даван туулах чадавхыг бэхжүүлэх" гэж заасан. Ногоон хөгжлийн бодлого (2014)-ийн 3.4.7-д "Алслагдсан нутагт бэлчээрийн даацад тохируулан мал аж ахуй эрхэлж, усны эх, булаг, шандыг арчилж тордох зэргээр бэлчээрийн доройтлоос сэргийлэх чиглэлээр санаачилгатай ажиллаж байгаа малчдад экосистемийн үйлчилгээний төлбөрийн урамшуулал олгох механизмыг бүрдүүлэх" гэж заасан. Агро ойн аж ахуйг хөгжүүлсэнээс үүдэх үр ашиг, эдийн засгийн эрсдлийн тухайд, агро ойн аж ахуйн талаар тусгайлан зохицуулсан БХЖ байхгүй. The Төрөөс ойн талаар баримтлах бодлого (2015)-ийн 3.2.4-т "Монгол оронд агро-ойн аж ахуйн хөгжлийн үндэс суурийг тавих" гэж заасан. Бичил зээл болон амьжиргааг дэмжихэд чиглэсэн хөрөнгийг тогтвортой бус үйл ажиллагаанд зарцуулах эрсдлийн талаар санхүүгийн хэлэлцээрт хяналт тавихтай холбоотой	албадан нүүлгэн шилжүүлэх гэж байгаа иргэдэд нөхөн олговор олгох болон бусад үйлчилгээ үзүүлэхтэй холбоотойгоор холбогдох хуулиудыг сайжруулах шаардлагатай.

	г.м). Ойгоос бусад экосистем орхигдох эрсдэлтэй. - Монгол болон хөрш орны цэрэг, цагдаагийн байгууллагын хооронд авилга нэмэгдэнэ.	БХЖ-ууд байдаг. Хөдөлмөр эрхлэлтийн сангаас жижиг зээл олгох, түүнд батлан даалт гаргах, хүүг нөхөн төлөх, санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам (2016)-ийн 6-р зүйлийн 6.4-т “Аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага, сумын хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан ажилтан улирал тутам нийт зээлдэгчийг хамруулан зээлийг зориулалтын дагуу зарцуулж байгаа эсэхэд хяналт, шалгалт хийнэ” 6-р зүйлийн 6.8-д “Жижиг зээл, санхүүгийн дэмжлэгийг зориулалтын дагуу зарцуулаагүй, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй нь хяналт, шалгалтаар тогтоогдсон бол хөрөнгийг буруутай этгээдээр нөхөн төлүүлнэ” гэж тус тус заасан. Сөрөг нөлөө шилжих эрсдлийг зохицуулахад бэлчээрийн менежментийн БХЖ чухал шаардлагатай. Бэлчээрийн менежментийн БХЖ-уудыг дээр танилцуулсаныг үз. Газрын доройтлоос үүдэх маш олон эрсдэл байж болохыг тодорхойлсон (малчид шинэ, төвлөрсөн газарт нүүж очих г.м). Бэлчээрийн менежментээс гадна газрын доройтол, цөлжилттэй тэмцэх БХЖ-ууд үүнд хамаатай. Гэхдээ эдгээр нь газрын асуудлаар тодорхой зохицуулалт хийх журам биш маш ерөнхий зорилго бүхий хуулиуд юм.	

		- Монгол улсын Ногоон хөгжлийн бодлого (2015)-ийн 3.2.12-д "Эдийн засгийн хурдацтай өсөлт, уур амьсгалын өөрчлөлтийн нөхцөлд хүний үйл ажиллагаанаас байгаль орчинд учруулах хор уршгийг багасгах, арилгах нөхцөлийг бүрдүүлж хуурайшил, газрын доройтол, цөлжилтийн сөрөг үр дагаврыг бууруулах" 3.6.1-д "Уур амьсгалын өөрчлөлтийн хэтийн хандлага, байгалийн нөөц даацад нийцүүлж, хүн амын хэт төвлөрөл үүсэхээс сэргийлсэн, өөрийгөө тэтгэх чадвартай “ногоон”, “ухаалаг” хот, тосгоныг хөгжүүлж, орон нутагт тав тухтай ажиллаж, амьдрах орчин, нөхцөлийг бүрдүүлэх" гэж тус тус заасан. - Цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөр (2010)-ийн 9.5.2.1-д "...Бэлчээрийн даацад тохируулан зохистой ашиглах зорилгоор бэлчээр ашиглагчдын бүлгүүдийн үүрэг, хариуцлагын тогтолцоог бий болгох" 9.5.2.3-д “Орон нутагт малчид, малтай байсан иргэдэд орлогын нэмэлт эх үүсвэр бий болгож байгальд үзүүлэх дарамтыг багасгах” гэж тус тус заасан. Эдийн засгийн үйл ажиллагаа явуулах болсоны улмаас иргэдийг нүүлгэн, шилжүүлэхтэй холбоотой асуудлаар СНСЗ С5-с, нийгэм-эдийн засгийн үр ашиг, эрсдлийн талаар СНСЗ Е-ээс үз. Нутгийн иргэдтэй зөвлөлдөх,	

		уламжлалт амьдралын хэв маягийг хамгаалах, бэлчээр хоорондын нүүдэлтэй холбоотой асуудлыг зохицуулах БХЖ-ууд байдаг. Гэхдээ албадан нүүлгэхтэй холбоотой урамшууллын арга хэмжээний талаар заасан журам байхгүй байна. (?) Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль ба Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай үндэсний хөтөлбөрт экосистемийн тэнцвэрийг хангах талаар тодорхой заасан байна. Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 1-р зүйлд “Энэ хуулийн зорилт нь байгалийн бүс, бүслүүрийн онцлог, өвөрмөц тогтоц, ховор, ховордсон ургамал, амьтан бүхий газар, түүх,соёлын дурсгалт болон үзэсгэлэнт газрын хэв шинжийг хадгалах, хувьсч өөрчлөгдөх зүй тогтлыг судлах,танин мэдэх зорилгоор газар нутгийг тусгай хамгаалалтад авах, ашиглах, түүний унаган төрхийг хадгалах, хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино” 7-р зүйлд “Энэ хуулийн зорилт нь байгалийн бүс, бүслүүрийн онцлог, өвөрмөц тогтоц, ховор, ховордсон ургамал, амьтан бүхий газар, түүх,соёлын дурсгалт болон үзэсгэлэнт газрын хэв шинжийг хадгалах, хувьсч өөрчлөгдөх зүй тогтлыг судлах,танин мэдэх зорилгоор газар нутгийг тусгай хамгаалалтад авах, ашиглах, түүний	

		унаган төрхийг хадгалах, хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино” гэж тус тус заасан байна. Хуулийн 7-26 дугаар зүйлд экосистемийн тогтвортой байдлыг хангах тухай заалтуудыг тусгажээ.	
Хүлэмжийн хийн ялгарал өөр газарт шилжиж байгаа шалтгааныг шинжлэх (тухайлбал REDD+-ийн үйл ажиллагааны хэрэгжилт үр дүнгүй байсан эсвэл тухайн үйл ажиллагааг төлөвлөж боловсруулж байхдаа (орон нутгийн болон үндэсний хэмжээнд) ойн доройтол, хомсдлыг бий болгож буй суурь хүчин зүйлс, ойн тогтвортой менежмент, хамгаалал, ойн нүүрстөрөгчийн шингээлтийг нэмэгдүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэхд саад болж буй зүйлсийг шийдвэрлэхийг зориогүй байсны улмаас г.м)	<u>Үр ашиг:</u> - Ойн цэвэрлэгээ хөтөлбөр зэрэг суурь хөтөлбөрүүд болон хөнөөлт шавжтай тэмцэх, нөхөн сэргээлтийн хяналт, хэрэгжилт сайжирч ил тод байдал хангагдана - Оролцогч талуудын оролцоо, төсөв нэмэгдсэнээр засаглал, ойн салбарын үйл ажиллагааны ил тод байдал, хяналтын бүтэц (тухайлбал, хөнөөлт шавжтай тэмцэх, нөхөн сэргээлт, эргүүл, ТХГН-ын менежмент) сайжирна. Төсвийг зориулалтын бус зарцуулалтыг цаг алдалгүй илрүүлж, таслан зогсоох боломж бүрдэнэ - Хөрш орнуудтай ой болон байгаль хамгаалах бусад асуудлаар өргөн хүрээнд (хууль бус мод бэлтгэлтэй тэмцэх г.м) хамтран ажиллах боломж нэмэгдэнэ. <u>Эрсдэл</u>:	Төрийн хяналт шалгалтын тухай хууль (2003)-ийн 9-р зүйлийн 9.3.1-т "Мэргэжлийн хяналтын төв байгууллага хуульд заасны дагуу хууль тогтоомж болон нийтээр дагаж мөрдөх эрх зүйн бусад актын биелэлтэд хяналт тавих эрхтэй" гэж заасан. Энэ хэсэгт Хяналт, үнэлгээний системийн аргачлалыг голчлон баримтлах бөгөөд зарим талаараа ҮОМС-ийн үйл ажиллагаатай давхацна.	Зөрчлийн тухай хуулиар аймгийн байгаль орчны газруудийн хяналт тавих эрхийг хязргаарласан бөгөөд хууль зөрчсөн үйлдэлд хариуцлага ноогдуулах эрхгүй болж байна. Зөвхөн мэргэжлийн хяналтийн газраас хариуцлага хүлээлгэж, торгууль ноогдуулна. Төрийн хяналт шалгалтын тухай хууль болон зөрчлийн тухай хуулинд улсын мэргэжлийн хяналтын газраас хяналт шалгалт явуулж хариуцлага, торгууль ноогдуулна гэж заасан бөгөөд иргэний нийгмийн байгууллагууд нь зөвхөн хяналтанд оролцох эрхтэй байх ажээ.

	- Хууль бус мод бэлтгэл өөр ой руу болон өөр улс руу шилжих эрсдэлтэй - Ой болон байгалийн нөөцийг ашиглах боломж буурах буюу баялгийг хүртэх боломж тэгш бус байх нь ойгоос хамаарч аж амьдралаа залгуулдаг зарим иргэдийн амьжиргаанд сөргөөр нөлөөлж болзошгүй (зөвшөөрөлтэй болон хууль бус мод бэлтгэл эрхэлдэг, ан хийдэг, ойн дагалт баялаг ашигладаг хүмүүс г.м.) - Хамгаалалтанд ороогүй бүс нутгийн хүрээлэн буй орчинд сөргөөр нөлөөлж болно (бэлчээрийн ачаалал шилжилт г.м). Ойгоос бусад экосистем орхигдох эрсдэлтэй. - Монгол болон хөрш орны цэрэг, цагдаагийн байгууллагын хооронд авилга нэмэгдэнэ.		

ХАВСРАЛТ 4: REDD+-ИЙН СӨРӨГ НӨЛӨӨЛЛӨӨС СЭРГИЙЛЭХ ЗАРЧМУУДТАЙ ХОЛБООТОЙ ҮНДЭСНИЙ ГОЛ БОДЛОГО, ХУУЛЬ, ЖУРМУУД, ТЭДГЭЭРИЙГ БОЛОВСРОНГҮЙ БОЛГОХ ТАЛААРХ ЗӨВЛӨМЖҮҮД

Хамгийн чухал БХЖ	**Тус БХЖ-д холбоотой зарчмын үр ашиг, эрсдлүүдийн жишээ**	**Сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчмуудыг дэмжихтэй уялдуулан уг БХЖ-ыг сайжруулах зөвлөмж**
Ойн тухай хууль (2012)	**Эрсдлүүд** Ой хамгаалах, нөхөн сэргээлт хийхэд зориулж төлөвлөсөн газрыг ашиглах хүсэлтэй малчид маргаан, зөрчил үүсгэж болзошгүй. Бэлчээрийн газар хомсдож болзошгүй. Ойн нөхөн сэргээлт, дэд бүтэцтэй холбоотой өндөр зардал улсын төсөвт ачаалал нэмнэ. Ойн нөхөрлөлүүдийг чадавхижуулах, хяналт шалгалт хийх, хуулийн хэрэгжилтийг хангуулах, ой хамгаалах зардал өснө. Орон нутгийн иргэд ойн нөөцийг хэт ашиглана. Үр ашиг хуваарилах, зохицуулах, нөөцийн ашиглалтын талаар янз бүрийн оролцогч талуудын хооронд зөрчил үүснэ. Орон нутгийн захиргаа тогтвортой мод бэлтгэлийн хэмжээг харгалзан үзэхгүйгээр мод бэлтгэх зөвшөөрөл олгох. **Үр ашиг** Ойн өсөлт, бүтээмж, гарц нэмэгдэнэ.	(i) Ойн тухай хууль болон Газрын тухай хуульд ой бүхий газрыг малын бэлчээрт ашиглахтай холбоотой хоорондоо зөрчилдсөн заалтууд байж болзошгүй. Энэ хоёр хуульд нэмэлт өөрчлөлт оруулж мод нь ургаж гүйцээгүй залуу ойд мал бэлчээхийг хориглосон заалтыг тодорхой болгож өгөх нь зүйтэй. (ii) Ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээний ажлыг төлөвлөх, зохион байгуулах, санхүүжүүлэх, таримал ойг үнэлэх, улсын ойн санд худалдан авах, өмчлүүлэх журам (БОНХ- ийн сайд, Сангийн сайдын хамтарсан тушаал No.A-96/71)-д бүх төрлийн ойд хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдийн тарьсан (залуу ойг) таримал ойг улс баталгаатай эргүүлэн худалдан авдаг байх талаар заалт оруулах нь зүйтэй. Үүнээс гадна, төсвийн ачааллыг бууруулахын тулд байгалийн сэргэн ургалт илүү үр дүнтэй байх газруудыг сонгож мод тарихыг зөвшөөрсөн шинэ журам буюу эсвэл удирдамж боловсруулах шаардлагатай. (iii) Одоогийн мөрдөж байгаа хууль тогтоомжид арчилгаа, цэвэрлэгээний огтлолоор бэлтгэсэн модыг зах зээлд нийлүүлэхийг дэмжсэн эдийн засгийн урамшуулал тусгагдаагүй байна. (iv) Ойн тухай хуульд орон нутгийн иргэдийг эргүүл, хяналтад оролцуулдаг байх тухай нэмэлт өөрчлөлт оруулах хэрэгтэй. Үүнд дараах заалтуудыг авч үзнэ: (а) Нутгийн иргэдэд түшиглэсэн хяналтыг сайжруулж, мэдээлэл өгсөн этгээдэд урамшуулал өгдөг систем бий болгох; (б) Иргэний нийгмийн болон холбогдох талуудын (жишээ нь судлаачид) оролцоотойгоор мод бэлтгэлийн үйл явцад хяналт тавьдаг байх; (в) Иргэний нийгмийн оролцоотойгоор хяналт шалгалт хийж байх г.м. (v) Ойн тухай хуулийн холбогдох журмуудад магадлан итгэмжлэх ойг сонгох үйл явцыг нээлттэй, ил тод байлгах тухай заалтуудыг нэмэлт

Хамгийн чухал БХЖ	Тус БХЖ-д холбоотой зарчмын үр ашиг, эрсдлүүдийн жишээ	Сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчмуудыг дэмжихтэй уялдуулан уг БХЖ-ыг сайжруулах зөвлөмж
	Ойн нөхөрлөлүүд илүү их ашиг тус хүртэх учир менежментийн төлөвлөгөөгөө дагах сонирхолтой, санхүүгийн хувьд илүү боломжтой болох учраас ойн тогтвортой менежментийн төлөвлөгөө (заган ойг оруулаад) -ний хэрэгжилт сайжирна. Түлээний модны нийлүүлэлт өсөж, үнэ буурна. Модон бүтээгдэхүүний үйлдвэрлэл, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний нэр төрөл нэмэгдэнэ. модон бүтээгдэхүүний найдвартай байдал, чанар сайжирч, үнэ цэнэтэй болно.	өөрчлөлтөөр оруулах нь зүйтэй. Мөн гэрчилгээг авагч талд нутгийн иргэдийн нийгмийн асуудалд анхаарах тухай заалт оруулна. (vi) Ойн тухай хууль болон бусад хууль тогтоомжийн хэрэгжилтийн гол сул тал нь хяналт хангалтгүй байгаатай холбоотой байна. Хяналт тавих үүрэг, санхүүжилтийг шинэ журам, дүрэмд тодорхой зааж өгч, ойн нөхөрлөл болон орон нутгийн иргэдийн оролцоог хангах талаар тусгах нь зүйтэй. (vii) Хууль болон бусад холбогдох журамд ойн аж ахуйн үйл ажиллагааны дүнд бий болсон хөрөнгө, санхүүжилтээс ойн нөхөрлөлүүд илүү хүртэх боломж олгосон заалт оруулах нь зүйтэй. Ойгоос олсон орлогыг ойн менежмент, ойн нөхөрлөлүүдэд зарцуулж, дэд бүтцийг сайжруулах шууд хөрөнгө оруулалт болгон ашигладаг байх нь зүйтэй. (viii) Унанги мод бэлтгэх болон арчилгаа, цэвэрлэгээний огтлол хийх квотыг цуцалж, зохих шатны удирдах газраас баталж өгсөн ойн менежментийн төлөвлөгөөнд заасан хэмжээг мөрддөг байх талаар холбогдох журамд өөрчлөлт оруулах шаардлагатай. (ix) Монголын үндэсний модон бүтээгдэхүүний гэрчилгээжүүлэлтийн стандартыг олон улсын жишигт хүргэн сайжруулах, тухайлбал Ойн магадлан итгэмжлэлтийн зөвлөл (Forest Stewardship Council) зэрэг ОУ-ын байгууллагын шаардлагад нийцүүлэх нь зүй.
Ойн цэвэрлэгээ хөтөлбөр (2014)	**Үр ашиг** Модон бүтээгдэхүүний үйлдвэрлэл, нийлүүлэлт нэмэглэнэ. Унанги модыг цэвэрлэж, идэвхитэй менежмент хийснээр ойн нөхөн сэргэлт, бүтээмж сайжирна. **Эрсдэл** Үр ашиг хуваарилах, зохицуулах, нөөцийн ашиглалтын талаар янз бүрийн	(i) Төрөөс хангалттай санхүүжилт олгох замаар “Ойн цэвэрлэгээ хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг хангавал ойн нөхөрлөлүүд ойг цэвэрлэх үйл ажиллагаанаас орлого олж, бусад модыг хямд үнээр худалдан авах боломжтой болно. “Ойн цэвэрлэгээ” хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд 14 тэрбум төгрөг шаардлагатай гэж тооцсон. (ii) Мод боловсруулах жижиг аж ахуй нэгжүүдийг татварын уян хатан бодлогоор дэмжих нь зүйтэй (мод боловсруулах үйлдвэрүүдийг татвараас чөлөөлөх талаарх журам хангалтгүй). (iii) Үр ашиг, эрсдлийн үнэлгээнээс гарсан зөвлөмжид онцолсоны дагуу нотлох баримтуудыг цуглуулж, нэгтгэн боловруулж, цаашид мод бэлтгэлийн арга хэмжээг хэрэгжүүлсэнээр үүсч болох нөхцөл байдлыг тодорхой

Хамгийн чухал БХЖ	Тус БХЖ-д холбоотой зарчмын үр ашиг, эрсдлүүдийн жишээ	Сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчмуудыг дэмжихтэй уялдуулан уг БХЖ-ыг сайжруулах зөвлөмж
	оролцогч талуудын хооронд зөрчил үүснэ. Ойн цэвэрлэгээнээс орон нутгийн иргэд (ойн нөхөрлөлийн бус) тэгш ашиг хүртэж чадахгүй. Цэвэрлэгээ, мод огтлолт ихэссэнээр ойн төлөв байдал, биологийн төрөл зүйлд сөргөөр нөлөөлж болзошгүй.	зураглаж харуулах шаардлагатай (ийм мэдээ баримт олдохгүй бол үнэлгээ хийж мэдээлэл цуглуулах). Ингэснээр, санал болгож буй мод бэлтгэлийн үйл ажиллагааны мөн чанарыг сайн ойлгож, түүнээс урган гарах нүүрстөрөгчийн шингээлт нэмэгдэх үр дүн, бусад эерэг үр нөлөө, эрсдэл зэргийг талаар тодорхой төсөөлж, Монгол орны ойд тохирсон арга хэмжээг боловсруулах юм.
Төрөөс ойн талаар баримтлах бодлого (2015)	**Үр ашиг** Ойн менежмент, тогтвортой ашиглалтын талаарх мэдлэг, ур чадвар дээшилнэ. Заган ойн нөхөн сэргээлтийн талаар мэргэшсэн ойн мэргэжлийн байгууллагуудын чадавхи сайжирна. Мод бэлтгэх, боловсруулах салбарт орон нутгийн иргэд, ААНБ, ойн нөхөрлөлүүдийн ажлын байр нэмэгдэж, орлого өснө. Ой бүхий газарт дэд бүтэц сайжирна. Олон нийт, оролцогч талуудын оролцоотойгоор ойг хамгаалах үр дүн, хяналт мониторинг сайжирна. **Эрсдэл** Төрийн болон хувийн хэвшлийн байгууллагууд хөнөөлт шавжтай тэмцэх арга хэмжээний төсвийг нэмэгдүүлэх сонирхолтой байх	(i) Ойн аж ахуйн нэгж, байгууллагуудад Магадлан итгэмжлэлийн гэрчилгээ олгох үндэсний стандартыг хэрэгжүүлэх удирдамж боловсруулах (ii) Төрөөс ойн талаар баримтлах бодлогын 3.3.1-д заасны дагуу Улсаас Монгол орны ойн сангийн төлөв байдлыг нарийвчлан тодорхойлж, ойг хамгаалах, нөхөн сэргээх, зохистой ашиглах ойн тогтвортой менежментийг бий болгох шаардлагатай.

Хамгийн чухал БХЖ	Тус БХЖ-д холбоотой зарчмын үр ашиг, эрсдлүүдийн жишээ	Сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчмуудыг дэмжихтэй уялдуулан уг БХЖ-ыг сайжруулах зөвлөмж
	Мод бэлтгэл, ойн нөөцийн ашиглалт ихэссэнээр ойн төлөв байдал, биологийн төрөл зүйлд сөргөөр нөлөөлж болзошгүй.	
Газрын тухай хууль (2002)	**Үр ашиг** REDD+-ийн БАХ-нүүд нь газрын доройтол, цөлжилтийг бууруулахад хувь нэмэр оруулна. **Эрсдэл** Ой хамгаалах, нөхөн сэргээлт хийхэд зориулж төлөвлөсөн газрыг ашиглах хүсэлтэй малчид маргаан, зөрчил үүсгэж, бэлчээрийн газар хомсдож болзошгүй REDD+-ийн БАХ-нүүд нь бэлчээрийн менежементийн зохицуулалтуудтай зөрчилдөж болзошгүй.	(i) Ойн тухай хууль болон Газрын тухай хуульд ой бүхий газрыг малын бэлчээрт ашиглахтай холбоотой хоорондоо зөрчилдсөн заалтууд байж болзошгүй. Энэ хоёр хуульд нэмэлт өөрчлөлт оруулж мод нь ургаж гүйцээгүй залуу ойд мал бэлчээхийг хориглосон заалтыг тодорхой болгож өгөх нь зүйтэй.
Байгаль орчныг хамгаалах тухай хууль	**Үр ашиг** Байгаль хамгаалах мэдлэг, хандлагыг дээшлүүлж, байгаль хамгаалах уламжлалыг сэргээнэ. Хуулийн хэрэгжилт, хууль сахиулах байдал, зохицуулалт сайжирна. **Эрсдэл** Орон нутгийн иргэдийн хариуцлага, ачаалал нэмэгдэнэ (эргүүл хийх, хамтын менежмент г.м). Зарим газарт байгалийн нөөцийг хэт ашиглах эрсдэлтэй (төсвийн орлогыг бүрдүүлэхийн тулд)	(i) Байгаль хамгаалах сангийн талаарх хууль эрх зүйн заалтуудад байгаль хамгаалах санд орон нутгийн төсвөөс гадна тусдаа санхүүжилт олгож байх талаар тодорхой оруулсан байх нь зүйтэй.

Хамгийн чухал БХЖ	Тус БХЖ-д холбоотой зарчмын үр ашиг, эрсдлүүдийн жишээ	Сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчмуудыг дэмжихтэй уялдуулан уг БХЖ-ыг сайжруулах зөвлөмж
Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн тухай хууль (1997)	**Үр ашиг** Тусгай хамгаалалттай газар нутаг орчмын иргэд, ААНБ-ын орлого нэмэгдэж амьжиргаа сайжирна (аялал жуулчлал, ойн дагалт баялгийн ашиглалтаас). Орон нутгийн иргэд, ойн нөхөрлөлүүдийг оролцоо нэмэгдсэнээр ТХГН/орчны бүсэд байгаль хамгаалах үйл ажиллагаа сайжирна. **Эрсдэл** БАХ нь зарим хүмүүсийн амьжиргаанд сөргөөр нөлөөлж болзошгүй. Ан хийх, унасан мод түүх зорилгоор гал тавьдаг хүмүүс, ойн дагалт баялаг ашигладаг хүмүүс, мод бэлтгэл, худалдаанд оролцдог хүмүүс, усны нөөц ашиглагчид гм. Ядуурал, амьдралын нөхцөл муудах зэрэг асуудлууд үүснэ. Үр ашгийг тэгш бус хуваарилах эрсдэл бий. Тусгай хамгаалалттай газар нутгийн захиргаа, иргэд, ойн нөхөрлөлүүдийн дунд ойн нөөц ашиглахтай холбоотой зөрчил үүсч болзошгүй.	(i) Нутгийн иргэдийн амьжиргааны эх үүсвэрийг төрөлжүүлэхэд (агро ойн аж ахуй, хөдөө аж ахуйн үйл ажиллагаа г.м) дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн орчны бүсийн хамтын менежментийн зөвлөлийн эргэлтийн хөрөнгийг нэмэгдүүлж, өргөтгөх дэмжлэг шаардлагатай байна.
Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль	**Үр ашиг** Зарим газарт эко аялал жуулчлал хөгжинө. Энэ нь орон нутгийн иргэдийн	(i) Эко аялал жуулчлалын олон улсын стандартад нийцсэн менежментийг хэрэгжүүлэхэд чиглэсэн журам, удирдамж боловсруулах шаардлагатай. Энэ нь аялал жуулчлалын шинэ бүтээгдэхүүнийг бий болгоход түлхэц болно.

Хамгийн чухал БХЖ	Тус БХЖ-д холбоотой зарчмын үр ашиг, эрсдлүүдийн жишээ	Сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчмуудыг дэмжихтэй уялдуулан уг БХЖ-ыг сайжруулах зөвлөмж
	амьжиргааг дээшлүүлэх, орон нутгийн төсвийг нэмэгдүүлэх ач холбогдолтой. ТХГН-ийг албан ёсоор тэлэх нь олон нийтийн оролцоог идэвхжүүлж, олон оролцогч талуудыг тусгай хамгаалалттай газар нутгийн менежментэд оруулах боломжтой болно. **Эрсдэл** ТХГН-ийг өргөтгөх нь зарим хөгжлийн бодлого/газар ашиглалтын асуудлуудтай зөрчилдөж болзошгүй.	
Аль нэг тодорхой БХЖ-тай холбоогүй зөвлөмжүүд	**Үр ашиг** Ойн менежмент, тогтвортой ашиглах талаар мэдлэг, ур чадвар сайжирна. Хуулийн хэрэгжүүлэлт, хэрэгжилт, зохицуулалт сайжирна. Олон нийт, оролцогч талуудын оролцоотой ойн менежемнтийн үр дүн, хяналт сайжирна. **Эрсдэл** Үр ашиг хуваарилах, зохицуулах, нөөцийн ашиглалтын талаар янз бүрийн оролцогч талуудын хооронд зөрчил үүснэ. БАХ нь зарим хүмүүсийн амьжиргаанд сөргөөр нөлөөлж болзошгүй. Ан хийх, унасан мод түүх зорилгоор гал тавьдаг	(i) Модон эдлэл, бүтээгдэхүүний салбарт өртөг шингэсэн үйлдвэрлэлийг дэмжихэд чиглэсэн мэргэжил, аргазүйн сургалтын төвүүдийг байгуулах ба эдгээр төвд ажилгүй болон бусад эмзэг бүлгийн иргэдийг сургахад анхаарч, бизнес эрхлэхийг зорьж байгаа эмэгтэйчүүдэд бизнесийн хөгжил, менежмент, санхүү, төслийг удирдах, хэрэгжүүлэх талаар сургалт явуулах шаардлагатай. (ii) Хууль сахиулах бүх байгууллагын ажилтнуудын экологийн болон зэрлэг ан амьтан, ургамлын худалдааны талаарх мэдлэгийг дээшлүүлэх хэрэгтэй. (iii) Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилт, зарцуулалтыг ил тод болгох (iv) Хоршоод болон ойн нөхөрлөлүүдийн гишүүдийн амьжиргааг дээшлүүлэх төслүүдийг дэмжих (v) Ойн нөхөрлөлүүдийн хөнөөлт шавжтай тэмцэх талаарх мэдлэгийг дээшлүүлж, хөнөөлт шавжийг хянах үйл ажиллагаанд нөхөрлөлүүдийг дэмжин оролцуулах (vi) Урамшууллын системийг сайжруулна. Урамшууллын хэмжээг өсгөж (тухайлбал, эргүүл хийсэн, хууль зөрчсөн талаар мэдээлэл өгсөн этгээдийг урамшуулах), урамшууллыг шуурхай олгодог байх механизмыг бүрдүүлэх нь

Хамгийн чухал БХЖ	Тус БХЖ-д холбоотой зарчмын үр ашиг, эрсдлүүдийн жишээ	Сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчмуудыг дэмжихтэй уялдуулан уг БХЖ-ыг сайжруулах зөвлөмж
	хүмүүс, ойн дагалт баялаг ашигладаг хүмүүс, мод бэлтгэл, худалдаанд оролцдог хүмүүс, усны нөөц ашиглагчид гм. Ядуурал, амьдралын нөхцөл муудах зэрэг асуудлууд үүсч болзошгүй. Үр ашиг нь тэгш бус хуваарилагдаж болзошгүй гэх мэт. Ойн нөхөрлөлүүдийг чадавхижуулах, хяналт шалгалт хийх, хуулийн хэрэгжилтийг хангуулах, ой хамгаалах зардал өснө. Төрийн байгууллагын янз бүрийн түвшинд эрх мэдлээ урвуулан ашиглах болон авилгын эрсдэл үүсч болзошгүй.	зүйтэй. Ойн нөөц ашигласны хураамжийн орлогын тодорхой хувийг уг урамшууллын санхүүжилтийг бүрдүүлэхэд зориулж болно. (vii) Төрөөс хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдийн материаллаг баазыг нь сайжруулахад зориулж хөнгөлөлттэй зээл олгохыг дэмжих (viii) Талуудад мэдээллийг шуурхай хүргэх орчныг бий болгоно. Тухайлбал, олон улсын тайлан, мэдээллийн системд мэдээлэл оруулах г.м. (ix) Нутгийн иргэд, иргэний нийгмийн хяналтыг сайжруулах (x) Орон нутгийн захиргаанаас орлогын өөр өөр эх үүсвэрийг бий болгох талаар арга хэмжээ авч хэрэгжүүлж, байгалийн нөөцийн ашиглалтаас хараат байх явдлыг бууруулах (xi) Яамдад зориулж, салбарын бодлого хөтөлбөрүүдэд нийгмийн бүлгүүдийн тэгш оролцоо, жендерийн тэгш байдлыг хангах зарчмыг тусгах тухай удирдамж боловсруулах шаардлагатай. Үүнд Байгаль орчны салбарын жендерийн стратегийг загвар болгож болно.
Авилгын тухай хууль (2006) болон Төрийн болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны тухай хууль (2005)	**Эрсдэл** Төрийн байгууллагын янз бүрийн түвшинд эрх мэдлээ урвуулан ашиглах болон авилгын эрсдэл үүсч болзошгүй. Хувийн хэвшлийн байгууллагууд орон нутгийн иргэдийн оролцоог хангаагүйгээс тэдний ирээдүйд орлого олох боломжууд буурна.	(i) Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд тендерийн шалгуурыг ил тод байлгахыг шаардсан заалт оруулах шаардлагатай. (ii) Тендер шалгаруулах үйл явцад хүний нөлөө, оролцоог аль болох хязгаарлах тусгай программ хангамж боловсруулах шаардлагатай. (iii) Ойн нөхөн сэргээлтийн үйл ажиллагаанд хяналт тавихад иргэний нийгмийн төлөөллийг оролцуулах замаар авилгаас зайлсхийж болно. Энэ талаар Ойн тухай хуулийн хүрээнд тусгай журам гаргах шаардлагатай болж магадгүй. (iv) Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн холбогдох журамд тендерийн бичиг баримт материалд орон нутгийн иргэд болон ойн нөхөрлөлүүдийг заавал оролцуулсан байх тухай заалт оруулах

Хамгийн чухал БХЖ	Тус БХЖ-д холбоотой зарчмын үр ашиг, эрсдлүүдийн жишээ	Сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчмуудыг дэмжихтэй уялдуулан уг БХЖ-ыг сайжруулах зөвлөмж
Шинээр боловсруулах шаардлагатай БХЖ-ууд	**Эрсдэл** БАХ нь зарим хүмүүсийн амьжиргаанд сөргөөр нөлөөлж болзошгүй. Тухайлбал, ан хийх, унасан мод түүх зорилгоор гал тавьдаг, хууль бусаар болон зөвшөөрлийн дагуу ойн дагалт баялаг ашигладаг, мод бэлтгэдэг, худалдаанд оролцдог хүмүүс, усны нөөц ашиглагчид гм. Ядуурал, амьдралын нөхцөл муудах зэрэг асуудлууд үүсч болзошгүй. Үр ашиг тэгш бус хуваарилагдаж болзошгүй Ойн нөхөрлөлүүдийг чадавхижуулах, хяналт шалгалт хийх, хуулийн хэрэгжилтийг хангуулах, ой хамгаалах зардал өснө. **Үр ашиг** Ойн менежмент/гэрчилгээ олгох талаарх шийдвэр гаргалтанд талуудын оролцоо нэмэгдэх боломжтой.	(i) Экосистемийн төлбөрийн тухай хууль боловсруулах (ii) Хууль бусаар бэлтгэсэн модыг хурааж борлуулснаас орсон орлогын тодорхой хэсгийг мөнгөн бус урамшууллын санд шилжүүлэхийг зөвшөөрсөн шинэ хууль буюу эсвэл журам бий болгох шаардлагатай. Үүнээс гадна хууль бус мод бэлтгэлийн талаар мэдээл өгсөн хүмүүст татварын хөнгөлөлт үзүүлж болно. (iii) Ойн менежментэд талуудын оролцоог хангахтай холбоотой одоогийн заалтуудыг тусгай журам болгон нэгтгэх нь зүйтэй.

ХАВСРАЛТ 5. ЗӨВЛӨМЖҮҮДИЙН ЭРЭМБЭЛСЭН НЬ

2017 оны 11 сарын 29 өдрийн ТАХ-ийн уулзалтын үеэр БХЖ-ын зөвлөмжүүдийг дэлгэрэнгүй танилцуулсан. Зөвхөн тэргүүлэх зэргийн гэж үзсэн БХЖ-д хамаарах зөвлөмжүүдийг хянах үүднээс оролцогчдыг дараах байдлаар бүлэг болгон хуваалаа:

* Бүлэг 1: Ойн тухай хууль
* Бүлэг 2: Ойн цэвэрлэгээ хөтөлбөр ба Төрөөс ойн талаар баримтлах бодлого
* Бүлэг 3: Газрын тухай хууль ба ба Байгаль орчныг хамгаалах тухай хууль
* Бүлэг 4: Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн тухай хууль ба Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль
* Бүлэг 5: Аль нэгэн тодорхой БХЖ-тэй холбоогүй зөвлөмжүүд
* Бүлэг 6: Авилгын эсрэг хууль ба Төрийн болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны тухай хууль

Бүлэг болгонд дараах асуултыг тавьсан:

(i) Зөвлөмжүүдийг эрэмбэлж болох уу?

(ii) Та зөвлөмжүүдтэй санал нийлж байна уу эсвэл тэдгээрийг өөрчлөх санал байна уу?

(iii) REDD+ үйл ажиллагааны үр ашгийг дээшлүүлж эрсдлийг бууруулахтай холбоотойгоор тухайн БХЖ-тай хамаатай нэмэлт зөвлөмж боловсруулах уу?

Бүлэг 1 (Ойн тухай хууль)

<u>Зөвлөмжүүдийг эрэмбэлсэн нь</u>

Хүснэгт 3-т Бүлэг 1-ийн оролцогчид дэвшүүлсэн БХЖ-ын зөвлөмжүүдийг эрэмбэлсэн үр дүнг харуулав. Ойн тухай хууль болон Газрын тухай хуулинд тусгагдсан ой бүхий газар нутагт мал бэлчээх асуудлаас гарч болзошгүй зөрчлийг нэн тэргүүнд шийдвэрлэх ёстой асуудал гэж үзсэнийг эндээс харж болно. Мөн удаах дөрвөн байрт эрэмбэлэгдсэн тэргүүлэх асуудлууд хувийн хэвшлийн оролцоог бүрдүүлэх нөхцлийг сайжруулах, санхүүжилтийг шийдэх зэрэгтэй холбоотой байгаа нь харагдаж байна.

Хүснэгт А5.1: Ойн тухай хуулийн хийдлийг залруулах, сайжруулах зөвлөмжүүдийн жагсаалт

Зэрэг	Асуудал	Нэмэлт тайлбар, зөвлөмж
1	Ойн тухай хууль болон Газрын тухай хуулийн зөрчил	
2	Унанги мод бэлтгэх, арчилгааны огтлолт хийх квотын системийг халж холбогдох түвшинд баталсан ойн менежментийн төлөвлөгөөнд нийцүүлэн явуулах	Ойн менежментийн бодитой төлөвлөгөө боловсруулах
3	Улс хувийн хэвшлээс тарьмал ойг тодорхой хугацааны дараа баталгаатай буцаан худалдаж авдаг байх	Байгалийн сэргэн ургалт, таримал ойг худалдан авахыг санхүүжүүлэх болон хүлээн авахыг дэмжих арга хэмжээг төлөвлөх журам боловсруулах
4	Ойтой холбоотой үйл ажиллагаанаас орж ирэх орлогоос ойн нөхөрлөлүүдэд зориулах хуваарилалтыг нэмэгдүүлэхийн тулд Ойн тухай хууль эсвэл холбогдох журмыг өөрчлөх. Ойгоос орж ирэх орлогыг ойн менежментийн чиглэлээр зарцуулж ойн нөхөрлөлүүдэд дэд бүтцийн хөгжилд шууд хөрөнгө оруулалт хийх бололцоог олгох.	
5	Хяналтын санхүүжилт ба хариуцлагыг шинэ журам эсвэл ажлын удирдамжид тодорхойлж ойн нөхөрлөл болон орон нутгийн иргэдийн оролцоог хангах ёстой.	
6	Ойн тухай хуулийг шинэчилж орон нутгийн иргэдийг ойн хяналт шалгалт болон эргүүлд оролцуулахыг дэмжин ажиллах шаардлагатай	
7	Олон улсын хэмжээнд, ойн гэрчилгээг баталгаажуулдаг олон улсын зөвлөл “Forest Stewardship Council” хүлээн зөвшөөрдөг болгохын тулд үндэсний модон бүтээгдэхүүний гэрчилгээ олгох стандартыг сайжруулах хэрэгтэй.	
8	Ойн мэргэжлийн байгууллагад зөвшөөрөл олгохдоо нээлттэй, ил тод байдлыг хангахын тулд Ойн тухай хуулийн хүрээнд холбогдох журамд нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай.	
9	Ойн арчилгааны огтлолт хийж түүнээс гарсан модыг зах зээлд нийлүүлэхийг дэмжих эдийн засгийн урамшууллын тухай журам хэрэгтэй.	Ойн тухай хуулинд магадлан итгэмжлэлийн талаар заалт нэмж оруулж бусад холбогдох дүрэм, журамд тусгах.

Бүлэг 2 (Ойн цэвэрлэгээ хөтөлбөр ба Төрөөс ойн талаар баримтлах бодлого)

Бүлэг 2 “Ойн цэвэрлэгээ хөтөлбөр” ба Төрөөс ойн талаар баримтлах бодлоготой холбоотой цоорхой, сул талыг залруулахтай холбоотой зөвлөмжүүдтэй ажилласан. Тус

бүлгийн гишүүд Төрөөс ойн талаар баримтлах бодлогын хүрээнд Ойн цэвэрлэгээ хөтөлбөртэй холбоотой нэн тэргүүнд шийдвэрлэх асуудал бол Монгол улсын ойн одоогийн төлөв байдалд нарийвчилсан үнэлгээ хийх явдал гэж үзсэнийг Хүснэгт А5.2-с харж болно. Энэ нь Төрөөс ойн талаар баримтлах бодлогын 3.3.1-т аль хэдийнэ тусгагдсан.

Хүснэгт А5.2: Төрөөс ойн талаар баримтлах бодлого болон Ойн цэвэрлэгээ хөтөлбөрийг сайжруулах талаарх зөвлөмжүүдийн жагсаалт

Төрөөс ойн талаар баримтлах бодлого		
Эрэмбэлсэн зэрэг	**Асуудал**	**Нэмэлт тайлбар, зөвлөмж**
1	Монгол улсын ойн өнөөгийн нөхцөл байдалд нарийвчилсан үнэлгээ хийх саналыг төр хүлээн авч Төрөөс ойн талаар баримтлах бодлогын 3.3.1-д тусгасан тогтвортой ойн менежментийн системийг бий болгох шаардлагатай.	
2	Ойн мэргэжлийн байгуулагуудад зөвшөөрөл олгох үндэсний стандартыг хэрэгжүүлэх ажлын удирдамжийн төслийг боловсруулах шаардлагатай байна.	
Ойн цэвэрлэгээ хөтөлбөр		
1	Мод боловсруулах жижиг аж ахуйн нэгжүүдийг дэмжихийн тулд уян хатан татварын бодлого боловсруулах.	
2	Төр улсын төсөвт хангалттай санхүүжилт тусгах замаар Ойн цэвэрлэгээ хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж ойн нөхөрлөлүүд ойн цэвэрлэгээнээс орлого олж, өөр мод хямд үнээр худалдаж авах боломжтой болгох хэрэгтэй. Ойн цэвэрлэгээ хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд 14 тэрбум төгрөг шаардагдана гэж тооцоолсон.	Оролцогч талуудын тэгш оролцоог хангаж болохуйц нөхцөл бүрдүүлэн.

Ойн цэвэрлэгээ хөтөлбөрийн хувьд мод боловсруулах жижиг үйлдвэрүүдийг татварын шинэ бодлогоор дэмжих нь ойн цэвэрлэгээ хөтөлбөрт улсын төсвөөс хангалттай санхүүжилт хуваарилахаас ч чухал гэж оролцогчид үзжээ.

Бүлэг 3 (Газрын тухай хууль ба ба Байгаль орчныг хамгаалах тухай хууль)

Газрын тухай хуультай холбоотой нэг л зөвлөмж гаргасан (Газрын тухай хууль болон Ойн тухай хуулийн зөрчилтэй заалтын талаар) ба Байгаль орчныг хамгаалах тухай хуульд Байгаль орчны санд хөрөнгө хуваарилах талаар нэг зөвлөмж дэвшүүлэв. Тиймээс гаргасан зөвлөмжүүдийг эрэмбэлэх шаардлага байгаагүй нь тодорхой. Гэхдээ дараах гурван зөвлөмжийг нэмж гаргасан. Үүнд:

(i) Ойн тухай хуулийн 29-р зүйлд байгалийн сэргэн ургалтын талбайд хамгаалалтын хашаа суурилуулах тухай заасныг хэрэгжүүлэх.

(ii) Ховор төрлийн модтой газар нутагт аялал жуулчлал хөгжүүлэх хэрэгтэй.

(iii) Байгалийн баялаг ашигласны төлбөрийн тухай хууль болон Төсвийн тухай хуулийг хооронд нь уялдуулах шаардлагатай зэрэг орно.

Бүлэг 4 (Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн тухай хууль ба Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль)

Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн тухай хууль ба Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулин дээр ажилласан оролцогчид Бүлэг 3-тай адил хууль тус бүрийн дагуу гарсан нэг л зөвлөмжийг нягталж үзсэн. Гэхдээ оролцогчид өөр хэдэн санал гаргасан байна. Нэгдүгээрт, тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийг удирдахаар байгуулагдсан зөвлөлүүдийг сайжруулж, идэвхжүүлж, дэмжих шаардлагатай. Тэдгээрийн санхүүжилтийн арга ил тод байх ёстой ба ойн нөхөрлөлүүдтэй хамтран сургалт зохион байгуулж орон нутгийн иргэдэд орчны бүсийн зөвлөлийн үүргийн талаар мэдлэгийг нь дээшлүүлэх ёстой. Хоёрдугаарт, Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн тухай хуулийн байгаль орчны нөлөөллийн үнэлгээний тухай тусгасан 9-р зүйлийг зохих ёсоор хэрэгжүүлэх шаардлагатай. Гуравт, орчны бүсүүдэд аялал жуулчлалыг хөгжүүлэхэд илүү хүч чармайлт гаргах шаардлагатай байна гэжээ.

Бүлэг 5: Аль нэгэн тодорхой БХЖ-тай холбоогүй зөвлөмжүүд

Оролцогчид аль нэгэн тодорхой БХЖ-тай холбоогүй 10 зөвлөмжийг нэг бүрчлэн эрэмбэлэлгүйгээр тэдгээрийг гурван бүлэгт хуваасны Хүснэгт А5.3-т харуулав.

Хүснэгт А5.3: Тодорхой БХЖ-тай холбоогүй зөвлөмжүүдийн жагсаалт

Хэсэг I
Орон нутгийн хөгжлийн сангийн орлого, зарлагын ил тод байдлыг хангах. Жилд хоёр удаа тусад нь тайлагнах ёстой.
Орон нутгийн захиргаа орлогын өөр эх үүсвэр бий болгож байгалийн баялгийн хамаарлыг бууруулах арга хэмжээ авах шаардлагатай.
Урамшууллын системийг сайжруулах. Урамшуулын хэмжээг нэмэгдүүлж урамшууллыг цаг алдалгүй олгодог механизм бий болгох. Ой баялаг ашигласан төлбөрийн тодорхой хувийг тэдгээр урамшууллыг санхүүжүүлэхэд зориулах ёстой.
Ойн нөхөрлөлүүдийн түймэр, хөнөөлт шавьжны талаарх мэдлэгийг сайжруулж орон нутгийн оршин суугчдыг хөнөөлт шавьжны тархалтыг хязгаарлах үйл ажиллагаанд татан оролцуулах.
Хэсэг II
Оролцогч талууд болон холбогдох талуудад мэдээллийг шуурхай хүргэх систем бий болгох
Хууль сахиулах байгууллагуудын түймэр, мод бэлтгэл, экологи, зэрлэг ан амьтан, ургамлын худалдааны талаар мэдлэгийг сайжруулах.
Өртөг шингэсэн модон бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжихийн тулд мэргэжлийн болон техникийн сургалтын төвүүд байгуулах шаардлагатай. Тэдгээр сургалтын төвүүд ажилгүйчүүд болон бусад эмзэг бүлгийн иргэдийг сургахад анхаарах хэрэгтэй.
Хоршоо болон ойн нөхөрлөлүүдийн гишүүдийн амьжиргааг дээшлүүлэх төслүүдийг сурталчлах.
Аж ахуйнуудын чадавхи, тоног төхөөрөмжийн нийлүүлэлтийг сайжруулах зориулалтаар улсаас хөнгөлөлттэй зээл олгохыг дэмжих.
Хэсэг III
Орон нутгийн иргэд болон иргэний нийгмийн зүгээс хяналтыг сайжруулах

Энэ бүлэг мөн дэвшүүлсэн арван зөвлөмж дээр нэмж санал гаргасан. Тус бүлэг зөвлөмж (ii)-т буюу “хууль хэрэгжүүлэгч байгууллагуудын зэрлэг ан амьтан, ургамлын арилжаа болон экологийн ерөнхий мэдлэгийг дээшлүүлэх” гэсэн зөвлөмж дээр түймэр болон мод бэлтгэлтэй холбоотой асуудлуудыг нэмж оруулах нь зүйтэй гэж үзсэн. Зөвлөмж (iii) буюу “орон нутгийн хөгжлийн сангуудын санхүүжилтийг ил тод болгох” зөвлөмж дээр мөн санхүүгийн тайлангийн системийг илүү ил тод болгох шаардлагатай гэж бүлгээс санал гаргасан. Эцэст нь зөвлөмж (vi) буюу “урамшууллын системийг сайжруулах” зөвлөмжийн ерөнхий утгыг хуулинд тусгах шаардлагатай гэж санал гаргажээ.

Бүлэг 6 (Авилгын эсрэг хууль ба Төрийн болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны тухай хууль ба шинэ БХЖ)

Тус бүлэг Хавсралт 4-т жагсаасан дөрвөн зөвлөмж дундаас дараах зөвлөмжийг нэн чухал гэж эрэмбэлсэн:

i) Төрийн болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны тухай хуулинд тендерийн шалгуурын ил тод байдлыг хангах тухай заалт шаардлагатай.

(ii) Тендерийн явцад хүний оролцоог аль болох багасгахын тулд програм хангамж боловсруулах шаардлагатай.

Тус бүлэг авилгатай тэмцэх гол зам бол ил тод байдал гэж санал нэгдсэн. Оролцогчид мөн зөвлөмж (iv) буюу “тендерийн бичиг баримтад орон нутгийн иргэд ба ойн нөхөрлөлүүдийг заавал оролцуулах тухай” зөвлөмжийг дэлгэрүүлж орон нутгийн санал, санаачилгыг албан ёсоор тендерийн баримтад тусгах гэж санал оруулсан. Шинээр шаардагдаж магадгүй БХЖ-ын хувьд оролцогчид Экосистемийн үйлчилгээний төлбөрийн тухай хууль шинээр батлагдах гэж байгаа ба оролцогч талуудын оролцоог тусгасан одоогийн зөрүүтэй заалтуудыг жинэ журам болгон нэгтгэх гэж байгаа талаар мэдэлсэн.

MINISTRY OF ENVIRONMENT AND TOURISM

REDD+ MONGOLIA

http://www.reddplus.mn **REDD+ in Mongolia** **REDD+ in Mongolia** **REDD+ in Mongolia**

UN-REDD PROGRAMME

Монгол орны UN-REDD Хөтөлбөр

Хаяг: Улаанбаатар 15160, Чингэлтэй дүүрэг, Нэгдсэн үндэстний гудамж 5/2, Засгийн газрын II байр

Утас: +976-7711-7750

И-мэйл: info@unredd.mn

Вэбсайт: www.reddplus.mn